



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-17
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	18-174

1.“Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	18-21
2.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/	21-131
3.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	131-174

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 17-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 70 гишүүн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Т.Аубакир, Д.Батлут, Х.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Л.Гантөмөр, Б.Дэлгэрсайхан, М.Мандхай, Ч.Номин, О.Номинчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, А.Ундраа, Ч.Ундрам, Г.Хосбаяр, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Т.Мөнхсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, А.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан, Д.Энхтүвшин;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Д.Батбаяр, Х.Баттулга, С.Одонтуяа;

Хоцорсон: Н.Алтанхуяг-07 минут, Ц.Баатархүү-04 минут, Б.Батбаатар-07 минут, Н.Батсүмбэрэл-6 цаг 10 минут, Б.Батцэцэг-12 минут, Э.Болормаа-03 минут, С.Ганбаатар-24 минут, Д.Ганбат-09 минут, Д.Ганмаа-02 минут, Т.Доржханд-10 минут, Б.Жаргалан-07 минут, Д.Жаргалсайхан-24 минут, Б.Заяабал-09 минут, Ж.Золжаргал-04 минут, Г.Лувсанжамц-01 минут, С.Лүндэг-5 цаг 22 минут, Б.Мөнхсоёл-03 минут, П.Мөнхтулга-28 минут, П.Наранбаяр-04 минут, Н.Номтойбаяр-20 минут, Э.Одбаяр-03 минут, Б.Пунсалмаа-09 минут, П.Сайнзориг-07 минут, Ц.Сандаг-Очир-14 минут, Н.Учрал-48 минут, Дав.Цогтбаатар-01 минут, Дам.Цогтбаатар-03 минут, Б.Чойжилсүрэн-21 минут, Ж.Энхбаяр-1 цаг 46 минут, С.Эрдэнэбат-1 цаг 02 минут.

Нэг. “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 17
Бүгд: 79
78.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:08/

Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай, Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нар тус тус танилцуулав.

Тайлан, санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Л.Энх-Амгалан, Б.Баярбаатар, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, О.Батнайрамдал, Ж.Ганбаатар, Ж.Батжаргал, Г.Дамдинням, С.Замира, Б.Энхбаяр, Б.Түвшин, Ц.Идэрбат, Г.Очирбат, Э.Батшугар, З.Мэндсайхан, М.Нарантуяа-Нара, С.Бямбацогт, П.Ганзориг, Б.Найдалаа, Х.Ганхуяг, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Д.Пүрэвдаваа, Б.Мөнхсоёл, Б.Батбаатар, Дав.Цогтбаатар, Э.Болормаа, П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Б.Жаргалан, Д.Ганбат, С.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 53 минутаас 16 цаг 15 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Батнайрамдал, Г.Дамдинням, Б.Түвшин, Э.Батшугар, Д.Бум-Очир, Ц.Даваасүрэн, Б.Найдалаа, Х.Ганхуяг, Г.Лувсанжамц, Д.Ганбат, Б.Заяабал, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	44
Бүгд:	100

56.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Боловсролын яамны Төрийн нарийн

бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Баярмаа, О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, Г.Дамдинням, Д.Энхтуяа, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Дав.Цогтбаатар, П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, С.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын

гаргасан, Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.52 дахь заалтын “төлөвлөлтийг баталж,” гэсний дараа “идэвхтэй болон идэвх багатай улирлаар ялгаатай бодлого” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтын “бизнесийн орчин,” гэсний дараа “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 45
Бүгд: 96
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.10 дахь заалт нэмэх:

“1.3.10.Бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 37
Бүгд: 96
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.16 дахь заалтын “бэрхшээлийг арилгах,” гэсний дараа “хүний нөөцийн тулгамдсан асуудлыг гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс

бүрэн чөлөөлөх бодлогоор дэмжиж, шаардлагатай” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.18, 1.3.19, 1.3.20 дахь заалт нэмэх:

“1.3.18.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгааны ажлыг зохион байгуулна.

1.3.19.Бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, тухайлсан салбаруудын татварын ачааллыг бууруулах бодлогыг боловсруулж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

1.3.20.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх чиглэлд хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 37
Бүгд: 96
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг соёрхон батлуулах арга хэмжээний хэрэгжилт” гэсний “Суурь түвшин”-ний “-” гэснийг “10” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 41
Бүгд: 96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2.1 дэх дэд заалтын “Гоц халдварт өвчний голомт” гэсний “Суурь түвшин”-ний “100”

гэснийг “128” гэж, 1.2.3.1 дэх дэд заалтын “бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт төслийг үргэлжлүүлэх” гэснийг “дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.3 дахь дэд заалтын “төслийг хэрэгжүүлэх” гэсний дараа “/Дарханы арьс ширний цогцолбор болон бусад/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг ашиглалтад оруулж байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “15” гэснийг “30” гэж, “Зорилтот түвшин”-ний “20” гэснийг “55” гэж, 1.5.2.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “60” гэж, 1.5.2.6 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “30” гэснийг “20” гэж, 1.5.2.8 дахь дэд заалтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Бусад эх үүсвэр” гэснийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, 1.5.2.12, 1.5.2.13 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “75” гэснийг “35” гэж, 1.5.2.15 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж, 1.5.2.16 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “40” гэж, 1.5.2.18 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96

55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтад холбогдох мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 43

Бүгд: 96

55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.4.Эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх үндсэн бичиг баримт болох нэгдсэн сүлжээний дүрэм, түүнтэй холбоотой менежментийн тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нэгдсэн сүлжээний дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Бусад эх үүсвэр” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 36

Бүгд: 96

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.5.Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нам хүчдэлийн стандартыг шинэчлэн боловсруулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилт”-д “600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 38

Бүгд: 96

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “99,800.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 39
Бүгд: 96
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.1.4 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “69” гэж, 1.8.3.2 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “40” гэж, 1.8.3.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34.927,9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 39
Бүгд: 96
59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.12.1.1 дэх дэд заалтын “GIS,” гэснийг “газар зүйн мэдээллийн систем,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот

байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “2.1.2.7.Хөвсгөл аймагт “Хөх баавгайн үүр” төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилт”-д “3,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.23.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.24.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалгын ажлыг оршин суугчдын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 42
Бүгд: 96
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1.8 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “720” гэснийг “240” гэж, 2.3.1.10 дахь дэд заалтын “Санхүүжилт”-ийн “200,000.0” гэснийг “165,000.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 38
Бүгд: 96
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.1.1 дэх дэд заалтын “Шинээр байгуулах нийгмийн эрүүл мэндийн төв”-д харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 37
Бүгд: 96

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.11 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “90” гэснийг “0” гэж, 3.1.5.1 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “≥150” гэснийг “100” гэж, 3.2.1.1 дэх дэд заалтын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн барилга шинээр барих, ашиглалтад оруулах” гэснийг “Стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулах” гэж, мөн дэд заалтын “Ашиглалтад орох цэцэрлэг”-ийн “Суурь түвшин”-ний “34” гэснийг “35” гэж, мөн дэд заалтын “Шинээр баригдах цэцэрлэг” гэснийг “Цэцэрлэгийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “27” гэснийг “28” гэж, “Санхүүжилт”-ийн “35,616.1” гэснийг “38,189.4” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 41
Бүгд: 96

57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.1.2.13.Улаанбаатар хотод 2 дугаар шатны эрүүл мэндийн төвийг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “13,500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96

55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.4 дэх дэд заалтын “Ашиглалтад орох сургууль”-ийн Зорилтот түвшин”-ний “25” гэснийг “26” гэж, “Шинээр барих сургууль” гэснийг “Сургуулийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “36” гэснийг “41” гэж, “Санхүүжилт”-ийн “121,152.8” гэснийг “135,005.7” гэж, мөн заалтын “Шинээр барих дотуур байр” гэснийг “Дотуур байрны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “15” гэснийг “0” гэж, “Санхүүжилт”-ийн “21,734.9” гэснийг “25,414.8” гэж, мөн заалтын “Шинээр барих спорт заал” гэснийг “Спорт заалны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “0” гэж, 3.2.1.7 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “25,000” гэснийг “30.3” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 42
Бүгд: 96
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.9 дэх дэд заалтад харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 41
Бүгд: 96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.4.1.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “23.7” гэж, 3.4.2.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “14.2” гэж, 3.5.1.3 дахь дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.09” гэж, “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.5” гэж, 3.5.1.4 дэх дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.43” гэж, Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.5.1.5.Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн дэмжих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “8,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1 дэх заалтын “Зэвсэгт хүчний” гэсний дараа “үүрэг” гэж нэмж, 4.6.1.7 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “3” гэснийг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Шууд хөрөнгө оруулалт” гэснийг “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 38

Бүгд: 96

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Тэргүүлэх чиглэлийн үр дүн”-ийн 3 дахь заалтын “Үндэсний статистикийн хороо” гэснийг “Нэгдсэн Үндэстний Байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 39

Бүгд: 96

59.4 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-гийн 1.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “2.8” гэснийг “3.5” гэж, 1.9 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.2 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “11-13” гэснийг “12” гэж тус тус өөрчилж, 1.10 дахь заалтад харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 45

Бүгд: 96

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.1 дэх заалтын “Зүрх судасны өвчин, хорт хавдрын өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/”-нд харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо” гэснийг “Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /30-70 нас/” гэж, “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “973.9” гэснийг “41.8” гэж, “Зорилтот түвшин” “779.1” гэснийг “41.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 37

Бүгд: 96

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Бага боловсролын

чанарын үнэлгээний дундаж”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж /Монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/”, “Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж” гэсэн шалгуур үзүүлэлтийн “Мэдээлэл цуглуулах давтамж”-д харгалзах мөр тус бүрийн “Жилд нэг удаа” гэснийг “Гурван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж”-д харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшсэн 18 настай хүн ам”-ын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “77.1” гэснийг “81” гэж, “Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “60” гэснийг “48.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “66” гэснийг “50” гэж, “Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “71” гэснийг “50.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “76” гэснийг “52” гэж, 3.3 дахь заалтын “Хүүхдийн эрхийн индекс”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 3.8 дахь заалтын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 4.2 дахь заалтын “Суурь он”-ны “2017” гэснийг “2019” гэж, “Суурь түвшин”-ний “63.1” гэснийг “64.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 40
Бүгд: 96
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.2 дахь заалтын “хөрөнгийн өгөөж /ROA/” гэсний дараа “, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж нэмж, “Зорилтот түвшин”-ний “4” гэснийг “77” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 45
Бүгд: 96

53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, Суурь түвшин”-ний “2.5” гэснийг “3.5” гэж, 1.4.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “50” гэснийг “229” гэж, “Хүрэх түвшин”-ний “100” гэснийг “200” гэж, 1.7.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “20” гэснийг “40” гэж, 1.8.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “2” гэж, мөн заалтын “Мэдээллийн эх сурвалж”-ийн “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэснийг “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж, 1.9.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “13” гэснийг “17.8” гэж, 1.10.1 дэх заалтын “Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ”-ний “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “10” гэснийг “17” гэж, “Зорилтот түвшин”-ний “15” гэснийг “19” гэж, “Дахин хог хаягдлын эзлэх хувь”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “15.7” гэснийг “21.1”, “Зорилтот түвшин”-ний “19” гэснийг “27” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 44

Бүгд: 96

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 1.8 дахь хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-ийн “Хүлээн авах” гэсний дараа “Идэвхтэй улиралд хүлээн авах” гэж нэмж, мөн хэсгийн “Суурь түвшин”-ний “0.6” гэснийг “0.38” гэж, “Зорилтот түвшин”-ний “1.5” гэснийг “0.9” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-д “Идэвх сул улиралд хүлээн авах гадаад жуулчид” гэж, “Суурь түвшин”-нд “0.22” гэж, “Зорилтот түвшин”-д “0.6” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 46

Бүгд: 96

52.1 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.11.2 дахь заалтын “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” гэснийг “Ашиглалтад өртөмтгий ургамлын ашиглалтын нөөцийг тогтоож, амьтны ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ” гэж, “Ургамлын зүйл”-ийн “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “7702” гэснийг “5” гэж, “Зорилтот түвшин”-ний “7702” гэснийг “2” гэж, мөн заалтын “Амьтны зүйл” гэснийг “Сэргээн болгон сэлгэн нутагшуулсан амьтны зүйл” гэж, “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “756” гэснийг “7”, “Зорилтот түвшин”-ний “756” гэснийг “7” гэж, 1.11.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Зорилтот түвшин”-ний “10” гэснийг “5” гэж, 1.11.4 дэх заалтын “Мэдээллийн цуглуулах давтамж”-ийн “Жилд нэг удаа” гэснийг “Таван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 44

Бүгд: 96

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 4.2.1 дэх заалтын “Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “21” гэснийг “20” гэж, мөн заалтын “Давтан шинжилгээ”-ний “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “549” гэснийг “916” гэж, “Зорилтот түвшин”-ний “440” гэснийг “800” гэж, 4.3.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “76.5” гэснийг “78.4” гэж, 4.6.2 дахь заалтын “Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газар”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “12”, “Зорилтот түвшин”-ний “6” гэснийг “10” гэж, мөн заалтын “Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэг”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “5” гэснийг “6” гэж, мөн заалтын “Хөрсний чанарын стандартаас давсан бохирдолтой цэгийн тоо”-ны “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 44

Бүгд: 96

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн бүтэц, нэр томъёо, найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 41

Бүгд: 96

57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 55

Бүгд: 96
42.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 55
Бүгд: 96
42.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.

Бусад. Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан энэ өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Австралийн Холбооны Улсын Парламентын Сенатын Ерөнхийлөгч Сюзен Лаянс тэргүүтэй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирснийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулж, талархал илэрхийлэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцөөж, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 8 цаг 59 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 10 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая 10 цаг болсон байна. Чуулганы хуралдаанаа эхлүүлье. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс далан гишүүн ирж, ирц 55.6 хувьтайгаар чуулганы хуралдаан эхэлж байна аа.

Чуулганы хуралдааны ирцтэй холбоотой асуудал бас яригдаж байгаа олон нийтийн зүгээс чуулган цагтаа эхэлдэг байх ёстой, чуулганы хуралдаандаа Улсын Их Хурлын гишүүд идэвхтэй оролцдог байх ёстой гэдэг шаардлагыг тогтмол тавьж байгаа. Тэгэхээр энэ тогтмол шаардлага тавьж байгаа нөхцөлийг хангах чуулганы үйл ажиллагааг нээлттэй ил тод байх нөхцөл боломжийг хангах зорилгоор Их Хурлын Тамгын газрын зүгээс 1 дүгээрт чуулганы хуралдааны үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг тусгайлсан танхимд орж чуулганы үйл ажиллагаатай бүрэн танилцаж байх боломжийг нээлттэй болгосон. Зураг авах, бичлэг хийх тусдаа асуудал. Сэтгүүлчид яг энэ чуулган дотоод уур амьсгалтай холбоотой асуудлаар сонирхох, Улсын Их Хурлын гишүүдийн чуулганы хуралдаанд оролцож байгаа байдал, оролцож байгаа идэвх санаачилга гээд олон зүйлүүдийг дотор нь орж мэдрэх тэр боломжийг гаргаж өгье гэсэн. Ийм зорилго агуулсан.

Хоёр дахь зүйл нь энэ Улсын Их Хурал дээр явагдаж байгаа маш олон төрлийн үйл ажиллагаа байна. Байнгын хорооны хурал, Улсын Их Хурлын нэгдсэн чуулган ажлын хэсгүүдийн хурал зэрэг энэ хурлын үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийнхнийг чөлөөтэй оролцох боломжоор нь нээж өгч байгаа. Хэвлэл мэдээлэлд нээлттэй байна гэдэг ойлголт өөрөө оролцоог нь бүрэн хангаж өгснөөр бий болно гэж байгаа юм. Түүнээс нэг зураг дардаг бичлэг хийх төдийгөөр нээлттэй гэдэг ойлголт байж болохгүй юм гэж байгаа юм. Тэгэхээр ажлын хэсгийн дотоод үйл ажиллагаа нь асуудлыг Улсын Их Хурал ямар нөхцөлөөс хэрхэн шийдвэрлэж байна вэ гэдгийг хэвлэл мэдээллийнхэн илүүтэйгээр ойлгож олон нийтэд мэдээлэх том үүргээ гүйцэтгэж байх нөхцөл нь хангагдах юм гэж ингэж үзэж байгаа юм.

Хоёр дахь зүйл нь өнөөдрөөс эхлээд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдааны ирцийг parliament.mn сайтаар дамжуулаад байнгын шууд мэдээлдэг болж байгаа. Нэг ёсондоо өнөөдрийн чуулганы хуралдаанд ирсэн гишүүдийн нэрс ирснээр ирээгүй тасалсан, өвчтэй, чөлөөтэй нь яг тэр бүртгэлээрээ тогтмол бүртгэгдээд явна. Чуулганыхаа хуралдаанд хоцроод ирсэн бүртгэл ч гэсэн тэр дээрээ тогтмол гараад явдаг болсон гэдгийг та бүхэндээ хэлж танилцуулъя аа.

Ингээд өнөөдрийн 17-ны өдрийн хурал нээгдсэнийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганы хур нэгдсэн хуралдаанаар 3 асуудлыг хэлэлцэхээр байна.

Нэгдүгээрт, Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна аа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай танилцуулна аа. Индэрт урьж байна.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 16.3 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна аа.

Уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, П.Сайнзориг нар Тусгай хяналтын дэд хороо нь төрийн нууцтай холбоотой асуудлуудыг хэлэлцдэг тул Дэд хорооны бүрэлдэхүүн цомхон 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх нь зүйтэй гэсэн горимын санал гаргасан.

Горимын саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр нарыг Монгол Улсын Их Хурлын Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат, Очирбатын Амгаланбаатар нарыг дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахаар ирүүлсэн саналаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 79 гишүүн оролцож, 62 гишүүн дэмжсэнээр 78.5 хувиар тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, 27.7 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1.Очирбатын Амгаланбаатар,

2.Дашдондогийн Ганбат,

3.Дамдины Цогтбаатар,

4.Баттөмөрийн Энхбаяр,

5.Жадамбын Энхбаяр.

2.Энэ тогтоолыг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд оръё.

10.09 цаг

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье ээ. Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барилаа. Цар тахлаас эхлэн геополитикийн хурцадмал байдлаар даамжирсан хүндрэлийг Монгол Улс амжилттай даван туулж, эдийн засаг, санхүүгийн зах зээл сүүлийн 2 жилийн хугацаанд бүрэн сэргээд байна аа.

Цаашид эдийн засагт гарч буй энэхүү эерэг үр дүнг бэхжүүлж эдийн засгийн сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн төсөв мөнгө санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал болж байна. Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж эдийн засаг эхний хагас жилд 5.6 хувиар өслөө. Цалин, тэтгэвэр зэрэг өрхийн орлогын өсөлтийг дагаад хувийн хэрэглээ тэлж нийт эрэлтийг дэмжиж байна аа. Өнгөрсөн өвөл тохиосон зудын улмаас ХАА-н салбар эхний хагаст 26.7 хувиар ахисан хэдий ч бусад салбарт өсөлт өсөлтийн эрч сайн байна. Уул уурхай ХАА-гаас

бусад салбарын үйлдвэрлэл эхний хагас жилд 10.3 хувиар өслөө. Монголбанкны төсөөллөөр эдийн засгийн өсөлт энэ онд зургаа орчим хувьд хадгалагдаж ирэх онд төсвийг тэлэх бодлого Оюу Толгойн үйлдвэрлэл эрчимжих зэрэг нөлөөллөөр эдийн засаг 7-гоос 8 хувиар өсөхөөр ийм төсөөлөл гарч байна аа. Инфляцыг бууруулж эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч инфляц сүүлийн 5 сарын турш зорилтын орчимд тогтвортой хадгалагдлаа.

Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, төсвийн төлөв сулрах, гадаад инфляц өсөх зэргээс шалтгаалан ирэх онд инфляц нэмэгдэх хэдий ч зорилтын дээд интервалд хадгалагдах ийм хүлээлттэй байна аа. Ирэх оны төлөвлөсөн бүтээн байгуулалтуудыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай. Дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх нь эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш, инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлтэйг энд дурдахыг хүсэж байна. Иймээс инфляцын зорилтыг хангахад мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлж нийлүүлэлтийн доголдол үүсэхгүй байхад анхаарч ажиллах нь чухал гэж Монголбанк харж байгаа. Гадаад эрэлтийн таатай нөхцөл байдал үргэлжилж экспортын орлого нэмэгдэж байна. Үүний үр дүнд гадаад валютын нөөц энэ оны 3 дугаар сард түүхэн дээд түвшин болох 5.2 тэрбум долларт хүрч өсөхөд Монголбанк Хятадын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 50 хувийг төлж барагдууллаа.

Төлбөрийн тэнцэл гадаад валютын нөөцийн эерэг өөрчлөлтүүдээс шалтгаалан манай улсын зээлжих зэрэглэл нэмэх бий болж сайжирсны зэрэгцээ төгрөгийн ханш сүүлийн нэг жил гаруй хугацаанд тогтвортой байна аа. Төлбөрийн тэнцлийн цаашдын төлөв нь эрдэс бүтээгдэхүүний үнэ худалдааны түнш орнуудын нөхцөл байдал ирэх оны төсвийн төлөвөөс ихээхэн хамаарахаар байна. Экспорт сайн байгаа хэдий ч манай улсын худалдааны төв гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл үргэлжлэхээр байна. Энэ нь манай экспортын зарим бүтээгдэхүүний үнэ буурахад нөлөөлөх хандлагатай байна аа.

Эдийн засгийн идэвхжил сайн үед төсвийн зардал огцом тэлж дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтууд эхлэхээр байгаа нь импорт валютын төлбөртэй үйлчилгээний зардлыг тэлж валютын нэмэлт гарах урсгалыг бий болгож төлбөрийн тэнцлийг муудах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй гэж Монголбанкны зүгээс харж байгаа. Иймд улсын санхүүгийн нөөц чадавхыг сулруулахгүй байхад онцгойлон анхаарсан макро бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлж аливаа хөгжлийн төслүүдийг эрэмбэлэн боломжит гадаад эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай гэж Монгол банкны зүгээс үзэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл нь нам тогтвортой инфляцын орчныг бүрдүүлэх банкны салбарын гадаад хөрөнгө оруулалтыг татах уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлох тогтвортой санхүүжилтийн дэд бүтцийг бэхжүүлэх банк санхүүгийн салбарт ирж болзошгүй эрсдэлээс сэргийлэх төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн сангийн эрх зүйн орчныг сайжруулахад ч зэрэгт чиглэхэд онцгойлон анхаарч боловсрууллаа.

Тогтвортой бага инфляц нь иргэдийн бодит орлогыг хамгаалж эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулж, тогтвортой өсөлтийг хангах суурь болдог. Монголбанк ирэх 2 жилд инфляцыг зургаа + -2 нэгж хувийн интервал тогтворжуулж дунд хугацаандаа буюу 2027 оноос зорилтыг 5 хувь болгож бууруулахад мөнгөний бодлогын үйл ажиллагааг чиглүүлэхээр тусгалаа.

Үүнийг амжилттай хэрэгжүүлэхэд Засгийн газрын дэмжлэг төсвийн сахилга бат ихээхэн чухал үүрэгтэй байх болно. Монголбанк сүүлийн 2 жилд гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрэх боломжийг нээж хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр нэлээн идэвхтэй ажиллаж байна аа.

Цаашид банкны салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж хууль эрх зүйн орчин зохицуулалтыг боловсронгуй болгоход мөн анхаарч ажиллах болно. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий түүний сөрөг нөлөөг бодитойгоор үүрч буй манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, дасан зохицох, чадавхаа нэмэгдүүлэх нь улам бүүр чухал болж байна аа. Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нарийвчилсан тоон мэдээллийг цуглуулах банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн шинжилгээний аргачлалыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна аа.

Ингэснээр уур амьсгалын өөрчлөлт, банк санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө, болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллана аа. Төлбөрийн систем зээлийн мэдээллийн үйлчилгээг техник, технологийн хурдтай, хөгжилтэй нийцүүлэн сайжруулах, мөнгөний захын дэд бүтцийг олон улсын жишгийн дагуу хөгжүүлэх шаардлага бий болж байна аа. Иймээс ирэх онд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох дотоодын мөнгөний захын хөгжлийг дэмжихэд анхаарч ажиллахаар зорилоо. Цаашид эдийн засагт гарч буй эерэг үр дүнг бэхжүүлэхийн зэрэгцээ болзошгүй эрсдэлээс сэргийлж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн дунд урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ ээ.

Монгол банкны мөнгөний бодлого үйл ажиллагаа, эдийн засагт гарч буй өөрчлөлтийг бататгах инфляцын дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бий болгоход чиглэнэ ээ.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуу танилцуулна аа. Индэрт урья.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Ч.Лодойсамбуу: Монголбанкнаас төв банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн саналыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн саналд эдийн засгийн сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн мөнгө санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг дунд хугацаанд 3-аас 7 хувийн интервалд 2027 оноос 5 хувь болгон тогтворжуулахад мөнгөний бодлогын үйл ажиллагааг чиглүүлэх төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй байдлаар уян хатан бат тогтох зарчмыг тууштай баримталж, валютын захад ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, санхүүгийн дэд бүтэц, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, банкнуудын зохистой харь засаглал эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлэх, ногоон, тогтвортой санхүүжилтийн зээл, түүнтэй холбоотой тоон мэдээллийг цуглуулж уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх, зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг баримтлан Монголбанкнаас ирүүлсэн саналыг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар Гадаад валютын албан нөөцийн өсөлт, бууруулалтын шалтгаан, Төв банкны үнэт цаасны үлдэгдлийн талаар бодлогын хүү болон бизнес эрхлэгчдэд олгох зээлийн хүүг хэрхэн бууруулах талаар, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн хэрэгжилтийн явц байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг Хөнгөлөлттэй төсөл төсөл хөтөлбөрт зориулан олгосон зээл ипотекийн зээл олголтын төрлийг анхаарч анх удаа байр авч байгаа иргэн гэр хороололд эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барьсан иргэдэд олгох зээлийн хүртээмжийг сайжруулахад анхаарах, Ирээдүйн өв сангийн нөөцийн хуримтлалын тодорхой хэсгийг алтаар хадгалах зохицуулалтыг хийх.

Мөн Банкны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал ОУВС-ийн зөвлөмж, 2025 онд Оюу Толгой төслийн бүтцийн шинэчлэл болон иргэдийн финтек уламжлалт зээлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батшугар Зээлийн хүүг бууруулахад Актив удирдлагын компани байгуулах нь чухал бөгөөд хууль эрх зүйн орчныг бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц ипотекийн зээлийн иргэдийн орлогод нийцүүлэх асуудлыг Засгийн газрын бодлогын зорилтод тусган ажиллах, орлогод нийцсэн орон сууц буюу гэр хорооллын дэд төвүүдэд хэрэгжих төслүүдэд зээл олгох, 2 болон 3-аас дээш хүүхэдтэй өрхүүд ипотекийн зээл авахад дэмжлэг үзүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд зээлийн хүүг бууруулах стратегийн бодлого болон заавал байлгах төгрөгийн нөөцийн өөрчлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа гадаадын хөрөнгө оруулалттай банкны эрх зүйн зохицуулалт болон тус банк орж ирснээр зээлийн хүү буурах эсэх талаар, хэрэглээний зээлийн болон их

өгөгдлийн тодорхойлолтын талаар, төсөв мөнгөний бодлогыг уялдуулах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх эсэх талаар, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлд ажлын байр нэмэгдүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх талаар тусгасан эсэх, энэ чиглэлээр хийгдсэн ажлын үр дүн шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдуулан арилжааны банкнуудаар олгогдож байгаа зээлийн шалгуур үзүүлэлт болон гадаадын хөрөнгө оруулалттай банканд тавигдах шалгуур, банк, санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийн талаар тус тус асуулт асууж санал хэлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лодойсамбуу гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Э.Батшугар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дарга МАН-ын бүлгийн 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцлээ. Улсын улсын гадаад валют албан нөөц сүүлийн 2 жилд эрчимтэй нэмэгдэж 5.2 тэрбум ам.доллар хүрсэн юм. Төгрөгийн ханш тогтворжсон, Хятадын Ардын банкны своп хэлцлийн зээлээс 2023 онд 1.5 тэрбум юань буюу 210 сая ам доллар, 2024 онд 4.5 тэрбум юань буюу 620 сая ам.доллар, Засгийн газрын Хуралдай бондын төлбөр 177 сая ам доллар тус тус төлсөн.

Монгол Улс эдийн засгийн чадавх гадаад секторын үзүүлэлтээ сайжруулж өрийн дарамтаа багасгасан учир олон улсын байгууллагууд зээлжих зэрэглэлийг 10 жилийн дараа дахин сайжруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл Эс Эн Пи Агентлаг Би плас болон Эерэг фитч агентлаг, Би плас болон тогтвортой болгон тус тус дээшлүүлсэн. Цар тахал геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан хүндрэлийг давж эдийн засгаа хурдтай сэргээхэд Засгийн газар Монголбанкнаас хамтран хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд болон нүүрсний экспортын орлого нь нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Дотоод эдийн засгийн талдаа цалин, тэтгэвэр болон төсвийн зардал тэлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг тэтгэж байгаа ч импорт болон инфляцыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэл дээр эрсдэл авчирч байна аа. Иймээс эдийн засгийн

өсөлтийг тогтворжуулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн төсөв мөнгөний бодлого хэрэгжүүлэх нь чухал юм.

МАН-ын мөрийн хөтөлбөр Хамтарсан Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд эдийн засгийн өсөлтийг цаашид тогтвортой хадгалах өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх нь ирэх оны эдийн засгийн бодлогын гол зорилго болж байгаа. Монголбанк эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэгдсэн мөнгө санхүүгийн бодлогын шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр Мөнгөний бодлогын баримт бичиг тусгасан сайшаалтай байна аа. Үндсэн чиглэлийн төсөл нэгд мөнгөний болон макро зохистой бодлого банкны салбарын тогтвортой байдал, санхүүгийн захын дэд бүтэц түүний институцийг бэхжүүлэх хүрээнд нийт 11 зорилт тусгасан байна аа.

Ирэх онд банк санхүүгийн орчны хуулиудад өөрчлөлт оруулан уялдаа холбоог сайжруулж, давхардлыг арилгаж, шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл үйлчилгээг дэмжих зээлийн мэдээллийн үйл ажиллагааг нь олон улсын жишигт нийцүүлэх, санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр ажиллах хэрэгтэй.

Монгол Улсын Их Хурлын дарга болон эрхэм гишүүд ээ,

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт ихээр өртдөг орнуудын нэг ээ. Уур амьсгалын өөрчлөлт эдийн засаг, санхүүгийн салбарт хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, нарийвчилсан шинэ мэдээлэл цуглуулах банкны салбарын уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ анх удаа хийж ажлыг Монголбанк ирэх онд хийхээр төлөвлөж байна аа. Энэ нь банк санхүүгийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөг нэмэгдүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох чадвараа сайжруулах чиглэлд чухал алхам болгохыг хэлмээр байна Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн гишүүдийн зүгээс Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөлтэй холбоотой асуулт асууж дараах чухал санал гаргасныг анхаараад ажиллах хэрэгтэй.

Үүнд Арилжааны банкны зээлийн хүүг үе шаттай бууруулах зорилтуудын хэрэгжилтийг хангах, мөн үүнтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэдийн арилжааны банк, ББСБ болон цахим орчинд давхардсан зээлийн эрсдэлийг бууруулахад анхаарч иргэд өрийн дарамтад орохоос сэргийлэх, орон нутагт олгох ипотекийн зээлийн хэмжээг зорилтын хэрэгжилтийг хангах, ХАА-н салбарт малчид тариаланчдыг дэмжих, шинэ хоршоо хөдөлгөөний хүүгийн татаастай хөнгөлөлттэй зээлийг үргэлжлүүлэх, орон нутгийн иргэд ААН-үүдийн бизнесийн зээлийг нэмэгдүүлэхэд Монголбанкнаас бодлогын дэмжлэг үзүүлэх, хэрэглээний болон бизнесийн зээлийн зохистой харьцаа харгалзах, Монгол Улсад гадаад хөрөнгө оруулалттай банк байгуулах ажил удааширч байгаад анхаарч ажиллах, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээг тэлж ханшны огцом савлагаатай холбоотой санхүүгийн үүсгэмэл бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогыг Монгол Улсад бүрэн оруулдаг болох, гадаад валют албан нөөцийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх, хамгаалах, жижиг, дунд бизнес эрхлэгчид зориулсан санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, геополитикийн нөхцөл байдалд хүндэрч байгаатай холбоотойгоор импортын газрын тосны бүтээгдэхүүний төлбөр тооцоог хүндрэлгүй бага шуурхай хийх зэрэг асуудлыг анхаарч үйл ажиллагаанд тусгахыг зөвлөж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас боловсруулан өргөн барьсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн талаар Улсын Их Хурлын дахь АН-ын бүлгийн санал, дүгнэлтийг танилцуулъя аа.

Төв банкны үндсэн үүрэг нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах явдал хэмээн хуульд заасан бөгөөд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын гол зорилго нь эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжиж иргэдийн бодит орлогыг хамгаалах буюу үнийн өсөлтийг хяналтдаа байлгах явдал байдаг аа. Гэтэл төсөлд инфляцыг дунд хугацаанд 5 хувьдаа нэмэх хасах нь 2 орчимд тогтворжуулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж мөн 2027 оноос 5 хувь болгон бууруулна гэсэн нь богино хугацаанд инфляцын эсрэг явуулах тодорхой хэмжигдэхүйц бодлогын зорилт болж чадахгүй байна аа. Олон улсын санхүүгийн байгууллагууд ирэх онд Монгол Улсын инфляцын түвшнийг 7.2-оос 9.5 хувийн хооронд байна гэж олон улсын байгууллагууд таамагласан. Мөн төсвийн зардал асар ихээр тэлсэн, эрчим хүч, дулааны үнэ нэмэгдэж байгаа зэргээс үүдэлтэйгээр ирэх онд үнийн өсөлт ч энэнээс өндөр байх магадлалтай. Гэтэл Монголбанкны зүгээс инфляцын эсрэг бодлогоо ийм бодит бус ерөнхий байдлаар тодорхойлж байгаа нь нэг талаас хариуцлагаас зайлсхийсэн нөгөө нөгөөтээгүүр улс төрийн нөлөөлөлгүй хараат бус мөнгөний бодлого хэрэгжих чадваргүй байна гэж үзэхэд хүргэж байна аа. Хэдхэн хоногийн өмнө гаргасан ОУВС-ийн шинжээчдийн дүгнэлт ч үүнийг батална аа.

Уг дүгнэлтэд импортын барааны үнийн өсөлт саарснаар инфляц тогтворжиж тогтворжиж байгаа мэт боловч хэрэглээний зээлийн өсөлт өндөр хэвээр төсвийн хэт тэлэх бодлого хэрэгжиж байгаа тул инфляц эргэн өсөх хүлээлттэй байгаа. Ийнхүү мөнгөний бодлогыг сулруулах нөхцөл байдал үүсээгүй байдал Монголбанк 9 дүгээр сардаа бодлогын хүүгээ бууруулсан явдал гэж үзсэн. Дотоодын мэргэжилтнүүдийн зүгээс ч Монголбанкны дээрх шийдвэр нь орон нутгийн сонгууль угтсан улс төрийн шийдвэр гэж үзэхээс өөр аргагүйг дотоодын мэргэжилтнүүд дүгнэсэн.

Төв банкны хуулийн 10 дугаар зүйлд Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж өргөн барихдаа мөнгөний бодлогод нөлөөлж болох төгрөгийн ханшны өөрчлөгдөх хандлага санхүүгийн зах зээлд нөлөөлж болох хүчин зүйлсийн талаарх төсөөллийг тусгасан байна гэж заасан. Гэтэл үндсэн чиглэлийн төсөлд төгрөгийн ханшны гадаад валютын эсрэг өөрчлөгдөх хандлага түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ ханшийн талаар бодлогын зорилт агуулаагүй зөвхөн төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан болгох зарчмыг баримтална гэсэн нэг ийм ерөнхий тодорхой бус жил бүр давтагддаг зорилгыг эргэн дэвшүүлжээ. Манай улс импортын хэрэглээний хамаарал өндөр юуны улмаас гадаад валютын ханш өрх гэрийн амьжиргаанд шууд хүчтэй нөлөөлдөг. Валютын орох урсгал хязгаарлагдмал эдийн засгийн хувьд ханшийг тогтмол барих боломж байхгүй ээ. Гэхдээ ханш огцом савлахгүйгээр жигд

хяналттайгаар хэлбэлзэж гадаад секторын цочир нөлөөг зөөлрүүлэх бодлого зайлшгүй шаардлагатай.

Монголбанк энэ талаар алсыг харсан бодлого дэвшүүлэхээс зайлсхийсэн атлаа 2024 он гарсаар 4.7 тэрбум гаруй америк долларын буюу уул уурхайн компаниудаас авсан доллароо тэр чигт нь буцаан зах зээлд нийлүүлж гадаад валютын ханшийг интервенцийн аргаар л барьж ирсэн. Эдийн засгийн суурь нөхцөлтэйгөө нийцээгүй улс төрийн шалгуур хангасан ийм бодлого эцсийн цэгтээ хүрэхээр гэнэт хяналтаас огцом гарч илүү ноцтой байдал үүсдэгийг саяхны түүхүүд харуулна. 20 21 оны сонгуулиудыг өнгөртөл интервенц хийж тогтоож барьж байсан валютын ханш тэрний дараа 30 гаруй хувиар савлаж байсан түүх магадгүй удахгүй бий болно.

Валютын ханшийн энэхүү хэтийдсэн оролцооны улмаас экспортын орлого нэмэгдсээр байгаа ч гадаад валютын албан нөөц нэмэгдэхүйц буурах хандлагатай байна аа.

Өнөөдрийн байдлаар манай улс 4.7 тэрбум ам.долларын нөөцтэй байгаа нь мөнгөн дүнгээрээ 10 жилийн өмнөхөөс нэмэгдсэн юм шиг боловч 4 сар хүрэхгүй хугацааны импортын хэрэглээг хангаж байгаагаараа бараг дурдсан үзүүлэлт юм аа. Импортын өсөлт нүүрсний үнийн уналт давхцаж буйгаас жилийн өмнө 600 гаруй сая долларын ашигтай байсан төлбөрийн тэнцэл эхний 7 сарын байдлаар 136 сая долларын алдагдалтай болжээ. Цаашид энэ алдагдал гүнзгийрч ханш инфляцаар дамжин эдийн засагт сөргөөр нөлөөлөх өндөр магадлалтайг үүнээс хамгаалах хэмжээний валютын нөөцтэй болох боломжийг Монгол Улс ашигласангүй ээ.

Төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж буй импортын өсөлт нь төсвийн зардлын болон хэрэглээний зээлийн өсөлтөөр тэтгэгдэж байна аа. Хэрэглээний зээлийн хэмжээ энэ оны эхний хагас жилийн байдлаар 38 хувиар нэмэгдэж нийт олгосон зээлийн 3-ны 1-д нь хүрчээ. Өнгөрсөн нэг жилийн дотор банкн дахь иргэдийн зээлийн үлдэгдэл 44 хувь, ББСБ дахь иргэдийн зээлийн үлдэгдэл 53 хувиар тус тус нэмэгдэж, эдгээрийн давхцалтай зээл авч байгаа иргэдийн тоо 26 хувиар нэмэгджээ. Энэ бүх тоо баримтаас харахад айл өрхүүдийн өрийн дарамт нэмэгдэж амьдрал доошилж байгаа санхүүгийн секторын тоо баримтууд харуулж байна аа.

Жилийн өмнө баталсан 2024 он оны мөнгөний бодлогод эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж заасан. Гэвч энэ зорилт хэрэгжээгүй мөнгөний бодлого иргэдийн амьдрал бизнест үр нөлөөгүй үзүүлээгүй болохыг дээрх тоонууд харуулж байна. 2025 онд энэ алдаа давтагдахгүйн тулд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэн батлахдаа дээр дурдсан асуудлуудыг нухацтай хэлэлцэн сайжруулах, Монголбанкны хараат бус мэргэжлийн түвшинд ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх талаар онцгойлон анхаарах шаардлагатайг сануулан хэлье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийг уншиж танилцуулъя. Бядрангийн Лхагвасүрэн, Монголбанкны ерөнхийлөгч, Доожавын Ган-Очир

Монголбанкны ерөнхий эдийн засагч, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын арга захирал, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль эрх зүйн газрын захирал, Дамдинжавын Даваасүх Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал, Цэдэвсүрэнгийн Нарандалай Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал.

Д.Амарбаясгалан: Ингээд мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье үү. 36 гишүүн асуулт асуухаар нэрээ өгсөн байна. Мөнхсоёл гишүүнээр ингээд тасаллаа. Эрэмбэлэгдэнэ ээ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууя.

Л.Энх-Амгалан: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая аа.

Хэд хэдэн зүйлийг бид нар энэ мөнгөний бодлоготойгоо уялдуулж бодлогоо тодорхой болгох ийм зайлшгүй шаардлага байна гэж би харж байгаа юм.

Нэгдүгээр асуудал мэдээж энэ ипотекийн зээлийн нэг үндэсний тогтолцоо урт хугацаанд нэг ийм үндэсний тогтолцоог бий болгоход Монголбанк оройлон манлайлан оролцох ёстой л гэж би ойлгож байгаа. Тэгээд өчигдөр Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн Байнгын хороон дээр өгч байгаа хариултаас харахад би буруу ойлгоогүй бол Монголбанк ер нь ипотекийнхоо энэ зээлийн хөтөлбөрөөс гарах гээд байгаа юм шиг тийм хариулт өгөөд байгаа байхгүй юу. Би бол энэ буруу гэж бодож байгаа. Тэгэхээр одоо бол үндсэндээ жилд 20 мянган айлын орон сууц борлогдож байгаа. Эндээс 3-ны 1 нь арилжааны ипотеكتэй, 3-ны 1 нь манай зээлийн 6, 8 хувийн ипотектэй, 3-ны 1 нь 30 хувиа төлчхөөд байхад ипотекийнхоо яг нөгөө очерт үлдэж байгаа 2, 3 жил очер хүлээж байгаа нэг ийм иргэд байна. Тийм учраас бид нар энэ ипотекийн зээлийн хүртээмжийг 1 дүгээрт нэмэх, 2 дугаарт зорилтот бүлэг рүүгээ хандуулахад зайлшгүй энэ мөнгөний бодлого гол үүрэг рольтой байх ёстой гол механизм байх ёстой гэж би ойлгоод байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэлээр 2025 оны мөнгөний бодлого дээрээ тусгаж байгаа гол зүйлүүд чинь яг юу юу байна вэ гэдэг асуудал 1 дүгээрт.

Хоёрдугаар асуудал бол энэ зээлийн хүүг бууруулах тухай асуудал бид нар их олон жил ярьж байгаа юм аа. Бид нар нэг асуулт асуудаг. Та бүхэн яг л эргээд нэг ийм стандарт нөгөө тал еэвэнгийн үлгэр гэдэг шиг нэг ийм хариулт өгөөд сурчихсан. Тэгэхээр Их Хурлын дарга Монголбанканд дээр очиж ажиллахад хэд хэдэн ийм зээлийн хүү бууруулах ийм боломжуудыг олж харсан байна лээ. Боломжуудыг. Энэ та нарын байгуулж байгаа эрсдэлийн сангийн асуудал. Дахиад дээрээс нь энэ гадаадаас орон сууцын, Монголын орон сууцын ипотекийн корпорац ингээд доллар оруулж ирэхэд орон сууцынхаа нөгөө ипотекийн зээлийн хүүгээ бууруулах бодлого нь бид нарт 1 дүгээр зорилго байх ёстой. Тэгэхэд та бүхэн ингээд энэ орж ирж байгаа долларуудыг нөгөө монгол төгрөг рүү шилжүүлэх своп ханшууд чинь 4 хувийн зардал гаргадаг юм байна. Зардал авдаг юм байна. Та бүхэн мөнгө хүүлж байна гэсэн үг байхгүй юу нэг талаараа.

Тэгэхээр иймэрхүү байдлаар ингээд нэг ийм бид нар нэг бүтээлчээр зээлийн хүүг бууруулах энэ асуудал дээрээ Монголбанк нэлээн тийм одоо явж байгаа тэр механизмаасаа нэг жаахан өөрөөр харах ийм хэрэгцээ шаардлага байна уу гэж харж байгаа юм. Ийм боломж байна гэж би харж байгаа. Тэгэхээр яг энэ чиглэлээр

яг Монголбанкны 2025 онд мөнгөний бодлого дээрээ барих бодлогууд нь өнөөдөр яг юу байх юм бэ? Зээлийн хүү буурах боломж байна шүү дээ байна. Тэгэхээр зээлийн хүүг бууруулахад ингээд макро эдийн засгийн үзүүлэлтүүд чухал. Тэгэхдээ ийм ерөнхий байдлаар бид нар асуугаад ерөнхий байдлаар та бүхэн бид нарыгаа нэг ийм молигодсон маягаар хариулт өгөөд ингээд суумааргүй байна. Энэ дээр тодорхой шийдлүүд бодлогын шийдлүүд байгаа гэж би харж байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр та нэг ард иргэддээ маш тодорхой бөөрөнхийлөхгүй бид нар яг ингэж харж байна, шийдлээ яг ингэж харж байна. Энэ шийдлийг хийхэд эрх зүйн магадгүй тодорхой зохицуулалтууд шаардлагатай байж магадгүй. Энэ эрх зүйн зохицуулалтууд нь яг ямар зохицуулалтууд байх ёстой гэж та бүхэн харж байгаа юм. Энийг надад маш нэг тодорхой хэлж хариулж өгөөч гэж би хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн. 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Энэ 2019 онд Банкны тухай хуульд орсон Төв банкны тухай хуульд орсон өөрчлөлтөөр Монголбанкныг тухайлсан иргэн ААН тухайлсан салбарт ингэж зээл гаргах ийм үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байгаа. Тэр утгаараа 2013 оноос хэрэгжүүлж байсан ипотекийн хөтөлбөрийг Монголбанк хууль, эрх зүйн, эрх зүйн хувьд хэрэгжүүлэх боломжгүй болсон. Тэгээд 2020 онд Ковид цар тахалтай холбоотойгоор ковидын ийм түр хууль гарч ирээд энүүгээрээ Монголбанкныг ипотекийн зээл олгоод яв гээд ингээд явж байгаа. Тэгээд өнгөрсөн онд Улсын Их Хурлаас баталсан Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тогтоол дотор Засгийн газарт шилжүүлтлээ энд ипотекийн хөтөлбөрийг Монголбанк ингээд үргэлжлүүлж гэдгээрээ ингээд өнөөдөр ингээд үргэлжлүүлээд явж байна. 1.2 их наядын зээлийг энэ онд ингээд гаргахаар ингээд төлөөлөөд явж байгаа юм. Тэгээд үндэсний орон сууцын, Орон сууцжуулалтын тухай хууль гараад Үндэсний орон сууцын корпорац байгуулагдах юм бол энэ хөтөлбөр өөрөө шилжих гэж байгаа юм. Тэрнээс биш Монголбанк үйл ажиллагаанаас нь бүрэн гарах тухай асуудал биш. Монголбанк бол одоо оролцоод нэгэнт өөрийн Монголбанкны эх үүсвэр өөрөө эргэлтийн сан болоод ингээд явж байгаа учраас мэдээж оролцоод явна. Банк хоорондынх нь энэ хяналт шалгалтыг хийгээд явна. Энэ бүх ажил бол хийгдээд явна.

Зөвхөн Монголбанк өнөөдөр өөрөө энийг ганц мөнгө гаргаад явдаг байгууллага биш болох л тэр л асуудал байгаа юм. Тэгэхлээр энэ бол ерөөсөө Монголбанк гарах тухай асуудал биш илүү харин зах зээлийнх нь тогтолцоонд шилжсэн зөв хэлбэр рүү орох тал руу нь л энэ шилжилт явагдах юм л гээд. Зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр яах вэ Монголбанк бол зээлийн хүүгийн зээлийн хүү ямар юмнаас бүтэж байна. Энэ хүү байгаагийн өндөр байгаагийн шалтгаан нь юу байна гээд судалгаагаа танилцуулж байсан. 60 хувь нь зээлийн хүүгийн бүтцийн 60 хувь нь эх үүсвэрийн хүү буюу хадгаламжийн хүү байгаа. Өнөөдөр бол зээлийн дундаж хүү банкны системээр 17 хувь, хадгаламжийн хүүгийн дундаж нь 11.5 хувьтай л ийм байгаа. Тэгэхээр мэдээж эхний ээлжид бол эх үүсвэрийн хүү буурч байж зээлийн хүү буурах нөхцөл бүрдэх буюу буурах нөхцөл бүрдэнэ.

Дараагийн нэг том хэсэг нь бол эрсдэлийн сан буюу банкн дээр байгаа юмуу зээл, найдваргүй зээлийг барагдуулж шийдвэрлэж байгаа байдал байгаа юм. Тэгэхлээр Иргэний хууль дээр барьцаа хөрөнгийг шилжүүлэхдээ заавал шүүхийн

шийдвэрийн дагуу шилжүүлдэг гэдэг ийм зохицуулалттай. Тэр утгаараа бол өнөөдөр банкн дээр байгаа муу зээлүүдийн дийлэнх хэсэг нь шүүх дээр 5-аас 7 жил болдог. Энэ хүрээндээ бол зээлийн эргэн төлөлт ч орж ирдэггүй, зээлийн хүү ч орж ирдэггүй. Дээр нь барьцаа хөрөнгө нь ч гэсэн эдийн засгийн эргэлтэд ордоггүй учраас энэ өөрөө эргээд банкны зардлыг нэмэгдүүлдэг ийм шалтгаан болдог.

Нөгөө 2 бүтэц нь бол банкны өөрийнх нь урсгал зардал буюу цалин, энэ гэрэл цахилгааны үнэ ч гэдэг юм уу ингээд явж байгаа. Өөр нэг хэсэг нь бол дижитал буюу цахим хувьсгалд зориулж гаргаж байгаа нэлээн томоохон хөрөнгө оруулалтууд нь эзэлдэг юм. Тэгэхээр бол өчигдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр Батшугар гишүүн асууж байна.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ, Лхагвасүрэн ерөнхийлөгч өө яг ийм байгаад байгаа байхгүй юу. Та нөгөө яг өгдөг л хариултаа л өгч байна. Зээлийн хүүг бууруулахад жишээ нь та сая яриад байна шүү дээ. Нийт нөгөө зардал нь бол мэдээж мөнгөний эх үүсвэрийн зардал байгаа тэрийг ойлгож байна 60 хувь нь мөнгөний эх үүсвэр. Одоо иргэн талаасаа ингээд харахаар ипотекийн зээл авчихсан байж байгаа энэ иргэдийг чинь сарын эргэн төлөлт нь 500-аас 800 мянган төгрөгийн сарын эргэн төлөлт хийж байгаа иргэдийн чинь. Тэгээд эргэн төлөлтийн чинь бараг 80, 90 хувь нь дандаа зээлийн үндсэн зээл нь төлөгддөггүй. Дандаа зээлийн хүүнүүд байгаад байгаа байхгүй юу зээлийн хүүнүүд. Тэгэхээр бид нар иргэддээ ийм байдлаар үндсэн зээлийнх нь зээл нь барагддаггүй мөртөө дандаа зээлийнх нь хүүг ингээд төлөөд байдаг нэг ийм хэлбэр. Жишээ нь юу гэдэг юм 80-аас 150 сая төгрөгийн ипотекийн зээл авчихсан хүн чинь буцаад 300-аас 400 сая төгрөгийн л төлж байна шүү дээ. Бодитойгоор. Тэгээд тэр үндсэн тэр нөгөө нэг яг энэ үндсэн зээл нь нь төлөгддөггүй хүүгий нь бууруулах тэр чиглэл рүү яг бид нар бодитой ямар алхмууд хийх юм бэ л гэж.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Энх-Амгалан гишүүний асуултад тодруулъя. Тийм яах вэ би сая ерөнхий нөгөө банкнаас олгодог зээлийн бүтээгдэхүүнийг ярьсан. Саяын яг тухайлан ипотекийн зээл дээр бол хөнгөлөлттэй 6 хувийн зээл явж байгаа. Тэгээд энэ 30 жилийн хугацаанд тэнцүү хуваариар төлнө гэдэг энэ бүтээгдэхүүнийх нь онцлог байгаад байгаа юм. Тэгэхлээр тэр онцлог нь бол өөрөө тэр зээл нь өндөр төлөөд хүү өндөр төлж байгаадаа асуудал нь биш. Угаасаа л 30 жилээр 6 хувиар бодоод нэг дүн гаргаад тэр дүнгээ 10 хувь 10 сарын жилдээ 12 сар, 30 жилийнхээ хугацаанд нь ингээд 180-аар ингээд хуваагаад үзэхлээр нэг л дүн байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ тэр хүлээж авч байгаа тогтмол дүнгээ хэдэн хувийг нь үндсэн ерөөс нь хасаж байна хэдэн хувийг нь зээлийн хүүнд нь суутгаж байна гэдэг л ялгаа байгаад байгаа юм. Тэгэхлээр 30 жилийн хугацаанд ижилхэн дүн явж байгаа ч гэсэн энэ оны хугацааныхаа эцэст яг л адилхан ялгаа байхгүй. Угаасаа л бүтэц нь өөрөө 2 юмны л ижилхэн нийлбэр учраас.

Д.Амарбаясгалан: Дахиж тодруулах юм уу? Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна аа.

Н.Наранбаатар: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе ээ.

Тэгэхээр ипотекийн зээлийг 13 оноос хойш одоо өнөөдрийг хүртэл ингээд хөтөлбөр хэрэгжээд явж байх хугацаанд 127 мянган зээлдэгчид 8.6 их наяд төгрөгийн зээл гаргасан байна гэж танилцуулга дээр байна. 2013 онд анх олгохдоо 30 мянган зээлдэгч хамарч байсан бол 2023 онд буюу өнгөрсөн жил 8.8, энэ оны эхний хагас жилд 6.6 гээд ингээд буураад явчихсан байгаа юм. Тэгэхээр энэ бууралтын гол шалтгаан юу байна. Эх үүсвэр багасаад байна уу, аль эсвэл эрэлт багасаад байна уу гэдэг. Бодит амьдрал дээр хөдөө орон нутагт очоод ажиллаж байхад эрэлт өндөр байна аа. Ипотекийн зээлд хамрагдах сонирхолтой хүсэлтээ өгсөн иргэд бол маш олон байгаа. Хөдөө орон нутагт ялангуяа төрийн албанд ажиллах боловсон хүчний хүрэлцээ хангамж их муу байгаа. Үүний гол шалтгаан нь бол энэ орон сууцтай л холбоотой байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг бид өнгөрсөн онд мөнгөний бодлого батлахдаа уг нь бодлого барьж ажиллахаар бид ярилцсан.

Тухайлбал хөдөө орон нутагт шилжиж байгаа өрхөд 3 хувийн ипотекийн зээл олгох, анх удаа орон сууц худалдаж авч байгаа иргэдэд орон нутагт ипотекийн зээл олгох үүний хажуугаар гэр хороололд хувийн орон сууц барьж байгаа иргэдэд ипотекийн зээл олгохоор бид нар ярьж байсан. Тэгэхээр энэний хэрэгжилт ямар байгаа вэ? 2024 онд хэчнээн иргэд шилжиж очиж энэ ипотекийн 3 хувийн хүүтэй зээлд хамрагдав? Мөн хэчнээн иргэд хувийн гэр хороололд байгаа хувийн орон сууцдаа ипотекийн зээл авав гэдэг дээр нэг тооцоо судалгаа юу байна? 2025 онд эх үүсвэр ямар байх вэ? Хаанаас ямар ямар эх үүсвэрээс ипотекийн зээлийг олгохоор төлөвлөж байгаа вэ? Нийт хэмжээ хэд байх вэ? Орон нутаг руу нэлээн бид нар бодлого барьж байгаа. Ахиухан шиг ипотекийн зээлийг хуваарилъя гэсэн ийм бодлого барьж байгаа.

Тэгэхээр 2025 оноос орон нутаг руу хэчнээн хэмжээний ипотекийн зээлийг хуваарилахаар болж байна вэ гэдэг дээр тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ 2024 онд он гарснаас хойш бол нийтдээ 1 их наяд 130 тэрбум төгрөгийн зээлийг 9693 зээлдэгчид яг өнөөдрийн байдлаар ингээд олгоод байна. Энэ дүн маань бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулах юм бол бараг 2 дахин өссөн гэж хэлж болохоор дүн байгаа. Таны тодруулах гэж байгаа тэр орон нутагт гэдэг нь бол энэ 3 хувийн хүүтэй зээл хэдэн зээлдэгчид олгосон бэ гэвэл 2613 гэсэн тоо өнөөдөр бидэнд байгаа юм. Улаанбаатарт олгож байгаа зээлийн бараг 37 хувь нь гэр хорооллоос орон сууцанд шилжиж байгаа ийм зээл байгаа. Өнгөрсөн онд төрийн мөнгөний бодлогыг батлахдаа энэ орон сууцын зээлийг хот хөдөөд тэнцвэртэй олгохоор ингэж шийдвэрлэсэн байгаа. Тэрний дагуу бол бид нар ингээд сүүлийн тооцоо үзэх юм бол нийт олгосон өрхийнхөө тоогоор бол 50, 50 хувь болсон. Мөнгөн дүнгээрээ бол орон нутагт нь 44 хувь, Улаанбаатарт 56 хувьтай ийм хувьтай байгаа. Ирэх онд бол ерөнхийдөө бас яг энэ хэмжээнээсээ 1.2 их наяд гэж хамгийн багадаа ингэж төлөвлөж байгаа.

Энх-Амгалан сайд Барилга, хот байгуулалтын яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам гээд хамтраад ерөнхийдөө бас энэ ипотекийн зээлийг илүү сайжруулъя хүртээмжийг нэмэгдүүлье гэдгээрээ яригдаж байгаа. Эх үүсвэрийг

яаж нэмэгдүүлэх вэ гэхлээр Монголбанк бол угаасаа хуулиараа эргэн төлөлтөөсөө өгч байгаа учраас энэ хэмжээтэй 500 тэрбум, хуримтлалын сангаас 500 тэрбум орж ирж байгаа. Банк өөрийн оролцоо гэдгээрээ 200 тэрбум байгаа. Тэгэхээр ингээд 1.2. Энийг нэмэгдүүлэх нэг боломж нь банкны эх үүсвэр байгаа. Банкны эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд энэ 6 хувийн гэдэг хөнгөлөлттэй хөтөлбөрөөсөө арай илүү өөр хүү байвал ялгавартай хүү байвал нэмэгдэх боломж байгаа. Тэгэхлээр бол хотын төв буюу бүс төвлөрөл ихтэй газрын ипотекийн зээл бол одоо 8, 10 хувь ч гэдэг юм уу арай ялгавартай хүү тогтоогдож орвол эх үүсвэрийн хэмжээ бүүр 2 их наяд руу ирэх боломж байгаа гэж бид нар тооцоо хийсэн. Энэ нь бол өөрөө өнөөдөр банкнуудын нөгөө өөрийн нөхцөлөөр олгож байгаа зээлээс харагдаж байгаа. Арилжааны банкнууд бол өөрийн нөхцөлөөр олгож байгаа жил зээл нь дунджаар 12-оос 14 хувийн хүүтэй чөлөөтэй ингээд олгогдоод явж байгаа учраас энэ хөнгөлөлттэй хүүнээсээ арилжааны хүү рүү ойртох тусмаа эх үүсвэр сайн нэмэгдэж хүртээмж сайжрах юм байна л гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Яах вэ тодруулж асуухаасаа илүү санал байна л даа. Ипотекийн зээл гэдэг тухайн өрхийн орон сууцад оруулж амьдрал нийгмийн баталгааг нь дээрдүүлэхээс гадна бас чухал үүрэг нь төвлөрлийг сааруулах нэг том үүрэг байгаа тийм ээ. Хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх мөн утааг бууруулах гэх мэтчилэн цаанаа эдийн засгийн их томоохон үр дагаврууд олон асуудлуудыг шийдэх ийм эдийн засгийн хөшүүрэг учраас цаашдаа хөдөө орон нутагт олгох энэ хувь хэмжээг нь нэмэгдүүлэх нь зүйтэй байна аа. Үүнийг дагаад нийгмийн тулгамдаж байгаа бидний толгойны өвчин болсон олон асуудлууд давхар шийдэгдээд явах ийм бодит нөхцөл байдал нь энэ хөдөө орон нутагт ажиллаад явж байхад харагдаж байна аа. Үүн дээр та бүхэн цаашдаа анхаарч ажиллахыг хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярмагнай Баярбаатар гишүүн асуулт асууна.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Ипотекийн зээлийг ч гишүүн болгон л асуух байлгүй. Зүгээр энэ зээлийн эргэн төлөлт дээр энэ ард түмнээ бодсон ийм эрх зүйн зохицуулалтыг Монголбанк санаачлаад хийж болдоггүй юм уу? Эхлээд хүү нь төлөгддөг дараа нь үндсэн зээл нь төлөгдөж эхэлдэг олон жил энэ зээлийн хүүг сая Энх-Амгалан гишүүн ч гэсэн ярьж байна. Тэгээд зээлийн хүү буурах асуудал өөрөө их чухал байгаад байгаа юм л даа. Инфляц өндөр байсан ч зээлийн хүү өндөр байж байдаг. Инфляц буурсан ч зээлийн хүү өндөр байж байдаг. Тэгээд өнөөдөр яг ний нуугүй хэлэхэд танил талгүй ипотекийн зээлийг чинь олж авч чадахгүй л байгаа шүү дээ. Ард түмэн тэгээд энэ ард түмний эрх ашгийг хангах ёстой байтал тэгээд арилжааны банкнуудын эрх ашгийг илүү хангаад яваад байгаа ер нь зөв юм уу буруу юм уу? Уг нь Монголбанк одоо энэ ийм талын шийдвэрүүдийг гаргаж энэ тал дээр нэлээн бодлого гаргаж ажиллах болов уу гэж би хараад байдаг. Гэтэл орж ирж танилцуулж байгаа зүйлүүд нь болохоор нэг тийм өөр зүйлүүд яваад байгаа асуудал. Тэгээд энэ дээр нэг ийм ер нь энэ бодлогоо нэг шинэчлэхгүй юм уу гэдэг асуудал дээр би нэг асуулт байна.

Хоёрт энэ өргөн хэрэглээний барааны үнэ сүүлийн 2, 3 сар нэг жоохон тогтвортой байлаа л даа. Тэгээд инфляцын өсөлт чинь ерөөсөө энэнтэй л хамааралтай байгаад байгаа юм. Жишээлбэл улаан буудайн гурилын асуудал 2022 оноос хойш үнийн өсөлтийг үзэхээр бид нар 100 хувь гадаадаас нийлүүлдэг

шатахуун 63 хувиар өссөн байна. Гэтэл бид нар дотооддоо 100 хувь хангадаг улаан буудайн гурилын үнэ 96 хувиар өсчихсөн байж байгаа байхгүй юу. Уул нь чөлөөт зах зээлийн системд энэ төр оролцооморгүй л байгаа юм. Гэтэл энэ дотооддоо 100 хувь хангаж байгаа улаан буудайн гурилын үнэ нь 96 хувь өснө гэдэг чинь өөрөө 100 хувь импортоор оруулж байгаа бензинээсээ дахиад 30 хувь, 30 гаруй хувиар давчихсан. Дээр нь энэ тариалан эрхлэгчдийг дэмжихгүй бол одоо тэгээд нэг өрнөөс өрний хооронд л явж байгаа ийм зүйлүүд. Улаан буудайн гурилын үйлдвэр нь өсөлт хөгжил нь байна уу байна. Гэтэл яг түүхий эдийг нь тарьж ургуулж байгаа тариалан эрхлэгчид нь өөрөө ингээд өрнөөс өрний хооронд байж байдаг ийм зүйл.

Гуравт энэ зүгээр Улсын Их Хуралд аль ч шатны сонгуульд нэр дэвшиж байгаа хүн энэ зээл тэглэнэ гээд ингээд ярьж явдаг ийм эрх мэдэл байдаг юм уу үгүй юу? Монголбанк ийм эрх мэдэл олгодог юм уу? Би сая Булган аймагт ажиллаад ирлээ, сумдаар ажиллалаа. Тэгээд нэг зээл төлнө өө, тэглэнэ ээ гээд нэг Улсын Их Хурлын гишүүн сонгогдсон. Одоо зээлээ тэглүүлмээр байна гээд ингээд уламжилж байна. Парламентын танхимд энийг хэлж өгөөч ээ гэж байна. Тэгээд бид нар саналаа өгч дэмжсэн. Одоо ингээд зээлээ төлөхгүй баймаар байна тэр тэглэж өгнө гэсэн хүн тэглэмээр байна гэх юм. Энэ ийм эрх зүйн зохицуулалт байдаг юм уу? Монголбанк энэ дээр хариулж өгөөч. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулна аа.

Б.Лхагвасүрэн: Баярбаатар гишүүний асуултад хариулъя. Тийм ипотекийн зээл бол ерөнхийдөө ингээд Монгол Улсад бол 12 арилжааны банк ажилладаг юм. 11 нь бол яг хувийн банк байгаа. Нэг нь бол төрийн өмчийн оролцоотой төрийн банк. Тэгээд энэ ипотекийн зээл ингээд банкны сектороор дамжаад хэрэгжиж байгаа. Тэгэхээр бол ерөнхийдөө Монголбанкны хувьд банкнуудад өгдөг энэ хянан шалгалт буюу дээр дээрээс нь хянаж байгаа зохицуулалт бол ер нь олон улсынх нь тэр жишгийн дагуу олон улсын базлын хорооны тэр дүрэм журмын дагуу л зохистой харьцаа гэдэг үзүүлэлтээр л хянаж явдаг. Тэрнээс биш яг банкн дээр нь очоод танай бүтээгдэхүүн үйлчилгээ чинь ийм байх, ёстой, хураамж шимтгэл нь ийм байх ёстой, хүү чинь ийм байх ёстой гээд шууд оролцоод явдаггүй. Яагаад гэвэл энэ өөрөө хувийн сектор учраас. Зүгээр ерөнхийдөө нөгөө санхүүгийн тогтвортой байдлыг хангаж энэ банк өөрөө эрүүл саруул яг л санхүүжилтээ олгоод эдийн засгаа дэмжээд явах талаас нь л ингээд хяналт тавьдаг учраас шууд оролцоод байж болдоггүй. Тэр ипотекийн зээлийн хүү өмнө нь авдаг үндсэн өрийг нь хойно нь авдаг ч гэдэг юм уу энэ дээр бол яах вэ зохицуулалт хийж болох боломж байгаа юм. Яагаад гэвэл тэнцүү дүнгээр төлүүлэхээр зохицуулж болохоор ч гэдэг юм уу олон улсад байдаг жишгийг нь авчраад хэрэгжүүлчих боломж нь байгаа юм. Тэгэхдээ хөтөлбөр өөрөө ингээд амжилттай хэрэгжээд явж байгаа учраас хөтөлбөртөө янз янзын саад учруулчих вий гэдэг болгоомжлолыг л цуг бодоод байдаг.

Тэгэхдээ энэ дээр бол анхаарч ажиллая гэж хэлье. Инфляцтай холбоотойгоор инфляц өөрөө Үндэсний статистикийн хорооноос тооцож гаргадаг ийм үзүүлэлт байгаа. Үндэсний статистикийн хороо Монголын дундаж өрхийн авч хэрэглэдэг бараа бүтээгдэхүүн 420 бараа бүтээгдэхүүнийг ингээд нэг багц болгоод энэ 420 бараа бүтээгдэхүүнийг үнийн хөдөлгөөнөөс энэ инфляцын дүнгээ гаргаад явж байгаа. 420 бараа бүтээгдэхүүн дотор бол ерөнхийдөө дотоодын бараа нь 50 хувь. Гаднаас импортолж байгаа нь ингээд 50 хувь байгаад байгаа юм. Тэгэхлээр ерөнхийдөө ер нь олон улсад инфляц тогтворжиж байгаа, тээвэр ложистикийн

саатаж байсан асуудлууд нь гайгүй болсон учраас ерөнхийдөө гаднаас орж ирж байгаа инфляцын дарамт нь багассан.

Өнөөдөр Монгол Улсын инфляцыг тодорхойлж байгаа ерөнхийдөө хүнсний ийм 20 бараа бүтээгдэхүүн байдаг. Хүнсний 20 бараа бүтээгдэхүүн дотроо сүү, мах, гурил гэсэн 3 бүтээгдэхүүн бол бараг 30 хувиар ингээд төлөөлөөд яваад байгаа юм. Тэгэхлээр инфляц нэлээн ийм огцом савладаг үед бол энэ 3 бүтээгдэхүүн юм уу эс үгүй бол тэр хүнсний багцыг бүрдүүлж байгаа 20 бүтээгдэхүүн дээр л гол асуудал нь байгаа юм.

Тэгэхээр Монголбанкны хувьд бол Ерөнхийлөгчийн санаачилсан Үндэсний Хүнсний хувьсгал, тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтраад нөгөө хүнс тариалж байгаа ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл өгөх олгож байгаа энэ хөтөлбөрийг бол хамтраад, хянаад зохицуулаад ингээд явж байгаа. Тэгэхдээ ер нь бол инфляц бол сүүлийн үед нэлээн сайн тогтворжиж байгаа ийм зүйл байгаа.

Гурав дахь асуултын хувьд бол одоо зээл тэглэх асуудал бол тийм эрх зүй байхгүй. Монгол Улсын түүхэнд бол анх удаагаа тэтгэврийн зээлийг хууль гаргаж.

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна аа.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Монголбанк та бүхний гаргасан энэ төрөөс мөнгөн мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл гэсэн энэ сайхан ном байна л даа.

Гишүүд маань нэлээн олон асуулт давхцаад асуучихлаа. Би тэгэхдээ ганц, хоёрыг нэмээд асуучихъя гэж бодож байна. Манай улсын инфляц хавсарсан шокуудын нөлөөгөөр 2022 оны дунд үе хүртэл эрчтэй нэмэгдэж, 16.9 хувьд хүрээд байсан. 2023 оноос тогтворжиж экспорт эрчимжсэний хэрэгцээ, мөнгөний бодлогын төлөв чанга түвшинд хадгалагдсанаар инфляц 2024 оны 7 сард 5.5 хувь хүрч буурсан. 2025 онд зорилтот түвшинд хадгалагдахад дараах хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэхээр байна гэж байгаа юм.

Нэгдүгээрт худалдааны түнш орнуудын эдийн засаг тогтвортой байж худалдааны эргэлтэд доголдол үүсгэхгүй байх.

Хоёрдугаарт улирлын шинжтэй үнэ нь өсдөг дотоодын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж үнийн хэлбэлзлийг бууруулах.

Гуравдугаарт төсвийн зардал огцом нэмэгдэж инфляцад үзүүлэх эрэлтийн дарамтыг нэмж өдөөхгүй байх гэдгийг инфляцтай холбож та бүхэн өөрсдөө энэ 3 үзүүлэлтийг гаргаж ирсэн байна л даа. Тэгээд энэ Монголбанк маань ярихаараа арилжааны банкнуудын бодлогод бид нар оролцохгүй, хувийн банк, хувийн бизнес гээд яриад байдаг. Нөгөө талдаа та бүхний энэ инфляцтай холбоотой асуудал дээр ч гэсэн хувийн ААН-үүдийн асуудал энд ихээр хөндөгдөж байгаа. Тэгээд цаашдаа Монголбанк өөрөө ийм байдлаар хувийн хэвшил өөрийн бодлого гэдэг хэлбэрээр явах юм уу эсвэл Монголбанкныхаа бодлогыг барих юм уу? Саяын 3 үзүүлэлтийг та бүхэн маань өөрсдөө яг хангаж чадна гэж үзэж байгаа юу? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт та бүхний стратеги дээр жижиг, дунд бизнесийг санхүүгийн хүртээмжийг сайжруулах гээд биччихсэн байгаа. Яаж зээлийн хүү чинь буурахгүй байгаа шүү дээ. Яаж энэ хувийн хэвшил ААН-үүдийн санхүүжилтийг бизнесийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах юм. Цаашдаа бид нар жижиг дунд бизнесийг дэмжье л гээд яваад байдаг. Эдийн засгаа тэлье гээд л яваад байдаг. Энэ дээр Монголбанк яг ямар бодлого барьж байгаа юм бэ гэдгээ асуух гэж байгаа юм. Зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр сая Энх-Амгалан гишүүн асуучихсан учраас нэг их олон юм яриад яах вэ. Тэгэхдээ энэ зээлийн хүүтэй холбоотой асуудал дээр голчлон Монголбанк өөрсдөө тодорхой хэмжээний бодлогоо гаргахгүй бол болохгүй ээ болохгүй. Зүгээр энэ бол арилжааны банкнуудын өөрсдийн асуудал гээд хаячихдаг ийм хэлбэр байж болохгүй байхгүй юу. Ипотекийн зээлийн хүртээмжтэй холбоотой асуудал. Орон нутагт бид нар өнөөдөр орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байж өнөөдөр бид нар хот хөдөөгийн сэргэлт, Засгийн газрын бодлого явагдана.

Дээрээс нь орон нутагт бид нар өнөөдөр орон сууцжуулах бодлогыг явуулахгүйгээр яг өнөөдөр орон нутагт ямар байна гээч. Багш байхгүй, эмч байхгүй. Өнөөдөр багшгүй болж байгаа сумдууд их байна шүү дээ. Тэгээд бид нар энэ ипотекийн зээлийн асуудал энэ хүртээмжтэй холбоотой асуудлуудыг цаашдаа яг бодлогын түвшинд нь барьж явуулахгүй бол бид нар зөвхөн бодлогын түвшинд Баялгийн сангаас орж ирж байгаа мөнгийг л гаргаж өгч байгаа гэдэг хэлбэр дээр байгаад баймааргүй байгаа. Ер нь бол ипотекийн зээл чинь бол яг ний нуугүй хэлэхэд дээрэм болчихоод байна шүү дээ. Сая Энх-Амгалан гишүүн хэлж байна. 80 саяыг аваад 300 саяыг төлж байна гээд. Тэгээд ийм дээрмийг Монголбанк хүлээн зөвшөөрөөд яваад байж болж байгаа юм уу. Энэ чинь яг ний нуугүй хэлэхэд дээрэм шүү дээ. Тодорхой түвшинд барих ёстой эрх зүйн хувьд ч тэр, ёс зүйн хувьд ч тэр тодорхой зарчимтай байх ёстой байхгүй юу. Энийгээ бид нар сайн бодох ёстой. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд татварын ялгамжтай бодлогыг хэрэгжүүлнэ ээ гээд заачихсан. Та бүхний стратеги дээр эдийн засгийг олон тулгууртай болгон төрөлжүүлнэ гэж байгаа юм. Энэ бодлого цаашдаа 2025 онд яаж явах юм?

Тэгээд тэр Салхитын мөнгөний ордоос ахмадын тэтгэвэр тэглэсэн яг энэнтэй холбоотой бүрэн мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Инфляц бол Монголбанкны үндсэн зорилго. Тэгэхээр инфляцыг өөрийн онилсон энэ тоо хэмжээндээ барих нь бол манай үндсэн үйл ажиллагаа байгаа. Тэгээд ирэх онд инфляцыг тогтвортой байлгахад ийм 3 хүчин зүйл байна гэж ярьж байгаа нь нэг дүгээрт гадаад Монгол Улсын экспортын бүтээгдэхүүн бол ерөнхийдөө бараг 90 хувь нь. Нэг улс руу гарч байгаа. Манай экспортын бүтээгдэхүүний дотор нь авч үзэх юм бол уул уурхайн бүтээгдэхүүн 93 хувь. Уул уурхайн бүтээгдэхүүний гол нүүрс, зэс, тэгээд төмрийн хүдэр, жонш ч гэдэг юм уу ингээд эдгээр бүтээгдэхүүн ерөнхийдөө 1 зах руу гардаг. Тухайн улсын эдийн засгийн өсөлт байдлаас бүх үнэ энэ түүхий эдийн үнэ ихээхэн хамаарч байгаа. Ялангуяа БНХАУ-ын эдийн засаг өсөлт саарч байгаатай нь холбогдуулаад нүүрсний үнэ ингээд буураад явж байгаа ч гэдэг юм уу ингээд энэ зүйл хамгийн чухал. Энэ маань өөрөө валютын нөөцөөрөө ханшаараа дамжиж байгаа. Би түрүүн бас Баярбаатар гишүүний асуултад хариулахдаа манай энэ импорт энэ хэрэглээний сагсны 420 бүтээгдэхүүний 50 нь

импортын бүтээгдэхүүн байгаа гэж байгаа. Импорт нь өөрөө ханш тогтвортой байвал импортын бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна л гэж харж байгаа. Тэр утгаараа энэ бол хамгийн чухал нөлөөтэй байгаа.

Хоёр дахь нь бол тэр улирлын шинжтэй ялангуяа ингээд зун бол сүүний үнэ ингээд нам түвшинд махны үнэ тогтвортой хэмжээнд байдаг бол өвөл хаврын үед эргээд өсчихдөг хомсдолд ороод. Тэгээд энэнээс хамаараад бас инфляц өөрөө ингээд савлаад байдаг. Тэгэхээр нийлүүлэлтийн тогтвортой сүлжээтэй байх үнийг нь тогтвортой байлгах, нөөц нь хангалттай хэмжээнд байх нь бол маш чухал байгаад байгаа. Тэгээд энэ утгаараа энэ зүйл маш чухал байгаа гэж ярьж байгаа юм.

Гурав дахь нь бол таны хөндсөн тэр төсөв байгаа. Мэдээж өнгөрсөн онд ыол цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн. Тэр утгаараа энэ онд бол өрхийн хэрэглээ бол нэлээн сайжирсан. Өрхийн орлого нь сайжрахын хэрэгтэйгээр өрхийн хэрэглээ нь нэмэгдээд байгаа юм. Тэгэхлээр өрх хэрэглэнэ гэдэг маань өөрөө бас зах зээлийн эрэлтийг бий болгож үнийг дээш нь гаргах нэг шалтгаан болж байгаа. Тэр утгаараа төсөв өөрөө бүр их огцом тэлэхгүйгээр тогтвортой хэмжээнд байх нь мөнгөний манай инфляцын зорилтод нэмэртэй гэдэг талаасаа ингэж тайлбар байгаа. Дараагийн санхүүгийн хүртээмжтэй холбоотой асуудал дээр нь Монголбанкны зүгээс бол нийлүүлэлтийн сүлжээг нэлээн идэвхжүүлэх гэж байгаа юм. Нийлүүлэлтийн сүлжээ гэдэг маань нөгөө кластер маягаар жишээлбэл одоо манай төвийн бүс дээр ялангуяа газар тариалан их байдаг газар бол үйлдвэр тэрний боловсруулах үйлдвэрүүд нь эндээ байх, ойрхон байх, тэгээд бэлтгэн нийлүүлэгч үйлдвэр 2 хоорондоо гэрээгээ байгуулаад тогтмол харилцаанд орох нь чухал гэдгээрээ энэний асуудлыг ярьж байгаа юм. Тэгээд тэр утгаараа ялангуяа тэр хоршооны зээл гарч байгаа ч тохиолдолд бусад ЖДҮ-ийн зээл дээр ч гэсэн аль болохоор тэр нийлүүлэлтийн сүлжээ нэг нь түүхий эдээ нийлүүлдэг, нөгөөдөх нь дараагийн хагас боловсруулалтыг нь бүтэн боловсруулалтыг нь хийдэг энэ процессыг гинжин маягаар болгох л энийг Монголбанканд дээр, ялангуяа ЖДҮ-ийн зээл дээр идэвхжүүлж ийм зорилгыг.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Ээлжит мөнгөний бодлого орж ирж байна. Тэгээд мөнгөний бодлого уг нь Монголын эдийн засгийн энд санхүүгийн захын бараг ерээд хувь нь Монголбанканд мөнгөн дээр мөнгөний бодлогоос хамааралтай байдаг. Гэтэл яг Монголбанкны хувьд нөгөө нэг хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага шиг ард түмний хүсэл нэг өөр байдаг. Өөрсдийнх нь мэргэжлийн байр суурь өөр байдаг.

Дээр нь нэмээд Засгийн газрын оролцоо гэдэг зүйлийн дунд үнэхээр эрх чөлөөтэй бие даасан бодлогоо явуулах боломжгүй нэг ийм байгууллага л харагдаад байдаг. Улс төрийн нөлөө, дахиад дээрээс нь нэмэгдээд одоо жишээ 2025 онд энэ төсвийн хэт их тэлэлтийн дараа хэт их тэлэлт дотор Монголбанканд өөрт нь мөнгөний бодлогоо явуулах орон зай асар ихээр хумигдчихсан, асар ихээр хумигдчихсан ийм л нөхцөл байдалтай бие даасан байдал, бие даасан байгууллагын тэр ажил үүргээ явуулах боломж бололцоо нь асар их хумигдмал ийм л нөхцөл байдалд л жил бүхэн л нэг ийм бодлого орж ирдэг л нөхцөл байдалтай болчихож байна. Сая жишээ нь 2025 онд эдийн засаг асар ихээр төсвөөр дамжиж тэлнэ ээ гэж байхад мөнгөний бодлогын хүү буурна гэж байгаа. Энэ одоо яг ямар утга учиртай шийдвэр вэ? Сайн мэдэхгүй. Тэгэхдээ бас энэ нь яг ингээд уншихаар

жаахан зальтай. Мөнгөний бодлогын хүүгээ сулруулж байгаа юм шиг мөртөө арилжааны банкнуудад байгаа заавал байлгах нөөцөө нэмэгдүүлчихсэн. Зүгээр л энэ ингээд нэг тийм цаанаа зүгээр улс төрийн шийдвэр л энэ дээр гарчихсан л байгаа байхгүй юу. Мөнгөний бодлогын хүү бодитоороо буураагүй. Цаана нь арилжааны банкны заавал байлгах нөөцөөр нь асуудлаа хязгаарлаад барьчихсан. Энэ нь зүгээр л энэ мэргэжлийн байр суурь гэхээсээ улсад Монголбанк өөрөө тийм улс төрийн шийдвэр гаргаж байна гэдэг нэг ийм л нөхцөл байдлууд дээр очиж байна л даа. Тэгээд бодлогын хүү буурч байгаа гэдэг. Энийг дагаад гадаад валютын нөгөө долларжих үйл явц, импортын өсөлт, нөгөө нэг жоохон валютын нөөц мөөц чинь юу болох юм. Тэгээд юу болдог байсан ч тэр чинь өөрөө чөлөөт зах зээлээрээ эрэлт нийлүүлэлтээрээ явна гэдэг бид нар дүрэмтэй журамтай. Гэтэл одоо энэний цаана магадгүй өмнөх сонгуулиудын дараа гарч байсан, сонгуулийн дараа тодорхой хугацааны дараа валютын ханш огцом савладаг яг энэ үзэгдэл хүлээж байгаа болов уу гэж би хувьдаа боддог. Магадгүй 20-оос 30 хувиар валютын ханш, валютын ханш ч юу байхав төгрөгийн ханш савлах нөхцөл. Энэн дээр нэг ийм нөхцөл байдал бид нарыг хүлээж. Ер нь та бүхэн валютын ханшаа яаж 2025 ондоо таамаглаж байгаа вэ? Энэ төсвийн хэт тэлэлт, төсвийн тэлэлт гэдэг чинь бараг 70 80 хувь нь өнөөдрийн төсвийн тэлэлт, маргаашийн импорт. Импорт гэдэг чинь олсон жоохон валют нь гадагшаа л гардаг. Тэр төсөв дээр гарч байгаа тэр зардлууд төсөв дээр гарч байгаа тэр зүйлсүүд нь бүгдээрээ ойрд эргэж мөнгө болох боломжгүй баахан зүйлсүүд л тавьчихсан.

Дагаад тэндээс хөрөнгө оруулалт дагаад тэндээс валют орж ирдэг зүйл байхгүй. Тэгэхээр наад валютын нөөц болоод долларжих үйл явц доллар валютын харьцах төгрөгийн ханш гэдэг зүйл дээрээ 2025 он дээрээ нэг та бүхэн тайлбар, мэдээлэл, таамаглалаа болж өгвөл нэг бодитой зүйлсүүдийг бас өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Монголбанк 2022 оноос эхлээд ерөнхийдөө бодлогын хүүгээ өсгөөд эхэлсэн. Инфляцтай уялдуулаад. Тэгээд энэ оны эхнээс эхлээд бодлогын хүүгээ инфляц буурч ирж байгаа учраас бодлогын хүүгээ аажим сулруулаад ингээд явж байгаа юм. Оны эхэнд бол бодлогын хүү 13 байсан. 3 сард бид эхний Мөнгөний бодлогын хорооны хурлаараа 1 нэгжээр буулгасан. Дараа нь 5 сард дахиад 1 нэгжээр буулгаад тэгээд ингээд нэлээн 2 улирал явж байгаад сая 9 сарын Мөнгөний бодлогын хороогоор дахиад 1 нэгжээр буулгасан байгаа. Одоо ингээд бодлогын хүү 10 хувьтай, инфляц ингээд 6.6 хувь гэж, 6.7 хувь гэх юм бол ерөнхийдөө эерэг өндөр түвшинд хатуу төлөвтэй байгаа нь харагдаж байгаа юм. Яах вэ мэдээж зээлийн хүү бууруулах Монгол Улсын энэ сэргэж байгаа эдийн засаг дээр бизнесийг тогтворжуулах үүднээс бол зээлийг хүүг нь буулгах зайлшгүй ийм дохио шаардлага байгаа учраас бол мэдээж ингээд мөнгөний бодлогын төлөвөө сулруулаад явж байгаа. Нөгөө талдаа зээл бол өөрөө ялангуяа зээлийн өсөлт 30 гаруй хувьтай байгаа учраас бүүр их огцом бас цааш нь өсгөх тэрийг дэмжих зорилго байгаагүй учраас тэр заавал байлгах нөөцийг 2 нэгжийн хувиар. Энэ 2-ын хослол нь өөрөө нөгөө макро зохистой бодлогын хүрээнд явагдаж байгаа зүйл байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт бодлогын хүү өөрөө ямар сигналыг өгдөг вэ гэхлээр эх үүсвэрийн хүүн дээр бол хамгийн гол сигналыг өгч байгаа юм. Монголбанкны бодлогын хүү гэдэг маань Монголбанкнаас репо санхүүжилтээр эх үүсвэр гаргах

боломжтой. Тэр эх үүсвэр өөрөө өнөөдөр банкны харилцагчдаа амлаад өндөр хүү амлаж уралдаж байгаа тэр зүйл дээр энэ эргээд энэ буурах дохиог нь өгөөд тэгэхээр өнөөдөр хадгаламжийн хүү 11.5 гэдэг маань бодлогын хүүгээс өндөр байна гэдэг нь өөрөө энэ хадгаламжийн хүү доошоо орох эхний дохио ингээд очиж байгаа гэж төв банкны зүгээс харж байгаа. Нөгөө талдаа зээлийг нь бас хэт тэлүүлэхгүй байх үүднээс заавал ойлгох нэг нөөцийг ингээд нэмээд явж байгаа. Энэ жилийн манай төлбөрийн тэнцэл гадаад худалдааны нэг онцлог бол экспорт бол оны эхнээс хойш 8 сард 6 хувиар өсөж байхад импорт 26 хувиар өсчихсөн. Импорт бол нэлээн өндөр өсөлттэй ингэж явж байгаа нь төлбөрийн тэнцлийг алдагдалтай болгох энэ нөөц дээр дарамт учрах ийм л зүйл болж байгаа. Тэр утгаараа мэдээж энэ байдал цаашаа үргэлжлэх үү, үгүй юү гэдэг дээр мэдээж хамт судалгаа хийсэн. Ялангуяа сая ОУВС-ийн багтай хамт суугаад бидний тоо бол нэлээн ойролцоо байгаа.

Тэгэхээр ирэх онд бол манай валютын нөөц бол энэ одоо байгаа дундаж түвшнээсээ доошоо орохгүй. Цаашаа өсөх боломж нь байна гэж харагдаж байгаа. Яагаад гэвэл ирэх онд Оюу Толгойн бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэнэ.

Дээр нь ирэх онд бол манай экспортын ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний үнэ бүүр их огцом унах биш ер нь нэлээн тогтвортой байх ийм зүйл анзаарагдаж байгаа учраас бол нөөц хангалттай хэмжээнд байна гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Монголын мөнгөний бодлого дээр ер нь их улс төрждөггүй юм л даа. Энэ мэргэжлийн байх ёстой. Тэгэхээр улс төржсөний гор нь юу болж гардаг юм бэ гэхээр 2016 онд Баяртсайхан ерөнхийлөгч байхдаа 1 тэрбум долларын валютын нөөц байсаар байтал тэрийгээ огт байхгүй АН-ынхан идээд хаячихсан байна гэж мэдэгдэл гараад тэрнээс нь болоод нэг өдрийн дотор 400 төгрөгөөр ханш унаж байсан байхгүй юу даа.

Тийм учраас энэ улс төржиж ханш унасан гэдэг энэ шалтгаанаар би 2 ч удаа Баяртсайханыг огцруулах тийм Улсын Их Хурлын тогтоолыг өргөн барьж байсан. Ер нь бол мэргэжлийн байх ёстой. Өнөөдрийн Монголбанкны удирдлага бол мэргэжлийн байгаа. Ер нь Монголбанк 2 зорилтыг хэрэгжүүлэх ёстой. Нэгдүгээрх нь үнэ ханшийг тогтвортой барих, хоёрдугаарх нь санхүүгийн системийг тогтвортой байлгах ийм 2 үндсэн зорилттой. Тэгээд энэний үнэ дээрээ яах вэ яг танайхаас нэг их хамаарахгүй байгаад яагаад гэвэл ковид гээд баахан ложистикийн ханш уналт бий болсон.

Дээрээс нь одоо гадаадаас тэр тухайн улсын ханш унасан тэр бараа бүтээгдэхүүн оруулснаас болоод энэ дээр бүрэн барьж чадаагүй байх. Валютын ханшийн хувьд сүүлийн 2, 3 жил яг 3400 орчим дээр барилаа.

Дээрээс нь тэр үнэ дээр данхайсан төсөв бол үнэхээр энэ Монголбанкны бодлогод маш том нөлөө үзүүлж байгаа. Системийн тогтвортой байдал дээр бол нэг ч банк дампуурсангүй, ББСБ ч дампуурсангүй тогтвортой байна. Тэгэхээр 2, 3 зүйлийг анхаарч ажиллах ёстой гэж үзэж байна.

Нэгдүгээрт, зээлийн хүүг багасгах тал дээр маш анхааралтай ажиллаарай,

Хоёрдугаарт нь тэр заавал байлгах нөөцийг та нар бүх банкн дээр авах шаардлага байхгүй шүү дээ. Энэ дээр эргэж хар л даа. Та нар системийн 5 гол банк гэж байгаа шүү дээ. Тэд нар дээрээ л ав л даа. Тэр жижиг банкнууд дээр битгий ав л даа. Ингэхээр чинь нөгөө нэг том банкнууд чинь бүгд бусад жижиг банкаа залгих тэр бодлого чинь яваад байна шүү дээ. Энэ дээрээ та нар буцааж нэг шийдвэрээ эргэж харах хэрэгтэй.

Гуравдугаарт нь тэр оны эцсээр валютын ханшийг өсгөөд тэгээд ханш унагааж байгаад Монголбанк ашигтай гардаг. Дээрээс нь Сангийн яамтайгаа нийлж байгаад Сангийн яам төсөв ашигтай гаргадаг ийм юмаа битгий хийгээрэй жил болгон хийдэг шүү та нар. Энийгээ хийж болохгүй шүү гэдгийг хэлье. Тэгээд ер нь бол яах вэ засаг дээр хамтарсан. Тийм учраас Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Улсын Их Хурлын харьяа байгууллагын ажил дээр бид нар тодорхой хэмжээгээр хамтарч байгаа гэж үзэж байгаа. Тийм учраас харьяа байгууллагын хувьд бол та нарын оруулж ирж байгаа бодлогуудыг дэмжээд явна гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Пүрэвдорж гишүүний саналтай ер нь бол нэг байгаа зээлийн хүүг буулгах манай бодлогын хүү буурч явж байгаа нь өөрөө зээлийн хүүг буулгах эх үүсвэрийн хүүг буулгах дохио болж явж байгаа учраас энэнийхээ хэрэгжилт дээр анхаараад явна.

Заавал байлгах нөөцийг тэгш бусаар том банканд нь өөр, жижиг банканд өөр тогтоох боломж байгаа. Энэ бол угаасаа ер нь олон улсад ийм жишиг байдаг учраас бол таны энэ саналыг бид нар авч үзье гэж хэлж байна. Оны эцэс хүртэл ерөнхийдөө ханш бол нөөц хангалттай хэмжээнд байгаа учраас ханш бол их тогтвортой байх боломжтой. Ер нь бол ОУВС-тай ч тэр ирэх оны төлбөрийн тэнцэл гадаад худалдааныхаа статистикийг хараад үзсэн ч гэсэн ханш бол ер нь тогтвортой байх боломжтой гэж харж байна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна аа.

О.Батнайрамдал: Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэж байна. Тэгэхээр макро эдийн засгийн түвшинд нэлээн заавал авч үзэх ёстой хэдэн эрсдэлийн талаар асуулт асуумаар байна. Макро эдийн засгийн түвшнээр бид нар аваад үзэхээр ер нь бол эдийн засгийн нэлээн халалт үүсчихсэн индикаторууд аягүй ойлгомжтой байна л даа. Төсөв нэлээн тэлэлттэй 2025 онд ч гэсэн дахиад рекорд түвшний төсөв орж ирэхээр өргөн баригдсан байгаа. Мөнгөний нийлүүлэлт талаасаа яах вэ зээлийн олголт талаасаа харах юм бол түрүүн нэлээн яригдлаа. Зээлийн олголт 31.5 хувь. Тэр дундаа бас бидний заавал ойлгох ёстой нэг зүйл нь энэ дундаа иргэдийн зээлийн тэлэлт нь ингээд бараг 60, 70 хувийг бүрдүүлж байгаа юм. Нэг ёсондоо бизнесийн тэлэлт гэдэг нь өөрөө бизнесийн яг цэвэр өсөлт гарч ирж байгааг илэрхийлдэг. Гэтэл бизнесийн зээлийн тэлэлтээс иргэдийн зээлийн тэлэлт нь бараг 2 дахин өндөр ийм хэрэглээний зээлийн тэлэлт маш өндөр өсөлттэй ийм макро түвшин ажиглагдаж байна. Импортыг бас аваад үзэх юм бол импортын өсөлт нь яг оны эхэнтэй харьцуулахад 1.1 тэрбум доллароор

өссөн ийм үр дүн харагдаж байгаа. Тэгээд мэдээж импорт өсөөд хэрэглээний зээл тэлэх тусам инфляц дээр дарамт үүснэ инфляцыг ойлгох ёстой юм. Инфляцын 68 хувь нь эрэлтээс гаралтай шүү дээ. 68-аас 70 хувь нь эрэлтээс гаралтай. Тэгэхээр буцаад тэр импорт орж ирж байгаа буцаад зээл тэлж байгаа энэ нь инфляц руу өндөр дарамт үүсэх нь ээ. Мөн төлбөрийн тэнцэл дээр ч гэсэн экспорт улам цаашаага өсөөд рекорд хүрээд байдаг мөртөө гадаад валютын нөөц жишээлбэл сүүлийн 3 сар буцаад албан нөөц буураад байна шүү дээ. Яг хувиар нь аваад үзэх юм бол оны эхнээс хуваарь аваад үзэх юм бол сүүлийн 2024 оны 6 сараас хойш жил, сар болгон бууралттай ийм ажиглагдаж байгаа юм. Тэгэхээр энэ нь буцаад төлбөрийн тэнцэл дээр илүү эрсдэл, илүү гарахаар харагдаад байна л даа.

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт авмаар байна. Тэр дундаа бас нэг бидний авч үзэх ёстой зүйл бол яг түрүүн хэлсэн, нөгөө иргэдийн зээлийн тэлэлт. Нийт иргэдийн зээлийг аваад үзэхээр 27.8 их наяд төгрөг. Энэний 70 хувь нь банкны зээл Тэр зээлийн зориулалтын 53.3 хувь нь хэрэглээний зээл байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө энэ цалин, тэтгэвэр нэмэгдсэнтэй холбоотой эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор хэрэглээний зээл хамгийн их тэлэлтийг үзүүлсэн. Тэр дундаа одоо яг гарч ирж байгаа нэг бодит эрсдэл урьд нь бараг байгаагүй юм болов уу л гэж би хараад байна л даа. Энэ давхар давхар зээлийн эрсдэл байна.

Нэг ёсондоо арилжааны банкнаас авсан нийт зээлийн 37 хувь нь давхар зээл шүү. ББСБ-ын 61.6 хувь нь давхар зээл байгаа. Тэгэхээр өнөөдөр 350 мянган иргэд давхар зээлтэй. Тэгээд энэ зээлийн хэмжээ хэтэрсэн үү эсвэл хэмжээндээ байна уу гэдгийг өр орлогын харьцаагаар ингээд хараад байгаа юм л даа. Тэгэхээр өр орлогын харьцаагаар харахаар банкн дээр болохоороо өр орлогын харьцаа сүүлийн 5 жилд хамгийн бага буюу 50.4 хувьтай. ББСБ дээр болохоороо бараг 80 хувь гарчихсан ийм үр дүн харагдаад байгаа юм. Нэг ёсондоо банк хязгаарлалтаа чангаруулангуут буцаад хүмүүс банкнаас авч чадахгүй зээлээ банк бусаас аваад, бүр өндөр хүүтэй, бүр илүү ачаалалтай иргэд дээр очиж байна гэсэн үг байгаа юм.

Тэгэхээр энийг та бүхэн юу гэж ойлгож байгаа вэ? Ипотек бас нэлээн яригдлаа. Ипотекийг бас ингээд аваад үзэх юм бол Улаанбаатар хотод өгөгдсөн ипотекийн 40 хувь нь, 39.4 хувь нь зөвхөн Хан-Уул дүүрэг дээр байгаа. Сүхбаатар Чингэлтэйг аваад үзэх юм бол ерөөсөө 9.5 хувь. Тэгэхээр бүгдээрээ мэдэж байгаа. Хан-Уулд бол мэдээж хамгийн үнэтэй барилга баригддаг. Тэгэхээр энийг та нэг тайлбарлаадхаач. Яг бид нар зорилтот иргэддээ хүрч байна гэж дүгнэж байна уу та тэ?

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгье. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Яах вэ ерөнхийдөө эдийн засаг ковид энэ геополитикийн нөхцөл байдлынхаа ард гараад сэргэчихсэн явж байгаа гэдэг нь ойлгомжтой байгаа. Өнгөрсөн онд 7.6 хувь энэ оны хагас жилээр 5.6 хувь гээд өсөлт байгаа. Тэгээд энийг тогтвортой түвшинд хадгалъя гэдгээрээ ерөнхийдөө мөнгөний бодлого ингээд чиглэгдээд явж бай. Тэгэхдээ таны ярьж байгаа тэр халалтын сигналууд бол мэдээж байгаа. Тэр утгаараа мөнгөний бодлогын төлөв хатуу хэвээрээ л ингээд даваад явж байгаа. Зүгээр зээл дээр бол ерөнхийдөө зээл бол нэлээн хумигдсан байсан учраас тэр хумигдсан түвшнээсээ өсөлт бол ингээд өндөр гарч ирээд яваад байгаа юм. Нийт

зээл дотроо ялангуяа бизнесийн зээл нь сүүлийн үед нэлээн идэвхжиж байгаа. Одоо нийт зээлийн өсөлт 31.5 байгаагийн 29.6 нь иргэдийн зээл, 33 хувь нь бол бизнесийн зээл болж ингэж байр нь солигдсон. Өмнө нь бол хэрэглээ нь өндөр байсан учраас.

Тэгэхээр энэ дээр бол одоо мэдээж болгоомжтой хандах ёстой. Тэгэхдээ энэ бол зөв хандлага гэдгээрээ бид нар хараад явж байгаа. Импортын өсөлт өндөр байгаа. Импортын өсөлт дотор хөрөнгө оруулалт нь бас нэлээн хувь эзэлж байгаа. Хэрэглээ 2 хоёулаа огцом л байгаа л даа. Зүгээр яваандаа энэ импортынх нь тансаг хэрэглээн дээр тариф татвараа тавиад эхлэх юм бол энэ буурах боломжтой. Зүгээр энэ оны хувьд бол импортын өсөлтийн нэлээн бас эерэг тал нь гэвэл хөрөнгө оруулалт байгаа. Ялангуяа хөрөнгө оруулалтын уул уурхайн тоног төхөөрөмжүүд, үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд, ялангуяа уур уурхайн тийм том даацын машин вагоны зүтгүүр ч гэдэг юм уу ийм төрөл шинээр бий болж байгаа нь өөрөө зөв. Ирэх жилийнхээ бүтээн байгуулалтад илүү ашиглагдаад явах учраас гэдгээрээ Монгол банкны зүгээс болгоомжтой бас энэ дээр нь хараад явж байгаа. Инфляц бол ерөнхийдөө Монголбанкны зүгээс бид нар эрэлтийн гэхээсээ илүү нийлүүлэлтийн шинжтэй гэж харж байгаа. Түрүүн би асуултад хариулахдаа хүнсний 20 бараа бүтээгдэхүүн л хамгийн гол нөлөө үзүүлж байгаа. 20 барааны үнэ л өөрөө бараг энэ манай энэ инфляцын 50-аас 60 хувийг нь тодорхойлж байгаа учраас энэ 20 барааны үнэ дээр л зүйл байгаа.

Экспортын хувьд бол бас тантай санал нэг байгаа. Ерөнхийдөө бараа бүтээгдэхүүний үнэ дээр нэлээн анхаарч экспортдоо уур уурхайн биш салбарыг илүү явуулах. Тэр утгаараа Монголбанкнаас ирэх жилийн нөгөө нийлүүлэлтийн сүлжээ гэж яриад байгаа юман дээр бид хэд аль болохоор нөгөө экспортод гаргадаг мал аж ахуйн, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг илүү түлхүү энэ дээр дэмжиж ажиллахаар зорьсон байгаа. Зээлийн давхарлалт дээр асуудал байгаа. Ялангуяа сүүлийн үед тэр зээлийн скоринг өгдөг ийм үйлчилгээг нэвтрүүлж байгаа. Тэр утгаараа энэ давхардал багасах бас боломж нь гарч ирж байгаа. Яагаад гэвэл бүх зээлийн мэдээлэл нь дээр нь скоро өгч явж байгаа. АНУ-д ашигладаг Файко гэдэг системийг Монголд нэвтрүүлээд явж байгаа нь өөрөө яваандаа энэ давхардлыг илүү шийдэх ийм шийдэл нь гарч ирнэ ээ гэж харж байгаа. Ипотектой холбоотой зээл дээр яах вэ бүтээн байгуулалт нь ялангуяа тэр яармаг чиглэл рүү их бүтээн байгуулалт гарч байгаа учраас тэр зүйл рүүгээ ингээд явж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Та түрүүн хэлж байна л даа. Гэхдээ инфляцын хамгийн сүүлийн дүнгээр бол 68 хувь нь эрэлт гаралтай гэж гараад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ их тэгж буурахгүй болов уу л гэж хараад байна л даа. Тэр өр орлогын харьцаан дээр нэг ийм юм байгаад байна аа. Яг яалт ч үгүй зохицуулагч байгууллагуудын хоорондын уялдаа заавал байх ёстой байгаад байна. Энэ бол ОУВС-ийн сая 3 хоногийн өмнө гарсан зөвлөмж дээр ч гэсэн яг дэлгэрэнгүй туссан байна лээ л дээ. Бид нар банкн дээр арилжааны банкн дээр өр орлогын харьцаа 5 жилийн хамгийн доод хэмжээ нь 50.4 мөртөө тэгээд банк бус дотроо финтекийн зээлүүд дээр болохоороо 70 хувиар тавьчихсан. Уламжлалт зээл буюу нийт банк бусын 62.5-ыг бүрдүүлж байгаа уламжлалт дээр ямар ч харьцаа байхгүй байгаа юм. Тэгэхээр магадгүй зарим нь өр орлогын харьцаа нь 200 хувь даваад явчихсаныг ч үгүйсгэхгүй л дээ. Тэгэхээр энэ 3-ын хоорондын уялдаа хангахгүй бол яг асуудал үүсээд эдийн засаг удаашрах ч юм уу асуудал үүсэхэд бол яг энэ чинь хэрэглэгч талаасаа зээл нь.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Баярдаваа дарга. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Баярдаваа: Батнайрамдал гишүүний асуултад нэмж хариулъя.

Тантай эдийн засагт учирч болзошгүй эрсдэлийн талаар анхааруулж байгаад бүрэн санал нэг байна аа. Дотоодын эдийн засгийн нөхцөл байдлаас гадна гадаад орчинд нэлээн нөхцөл байдал төвөгтэй байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Ялангуяа Улаан тэнгисээр дамжаад тэнд үүссэн зөрчилдөөнтэй холбоотойгоор далайн тээврийн зам маш их уртассан байгаа. Энэ тээврийн зардал дээр жишээлбэл нөлөө үзүүлж байгаа. Тяньжиний боомт дээр контейнерын бөөгнөрөл 70, 80 хувиар нэмэгдчихсэн байгаа. Тэгэхээр энэ бүх зүйл бол нэлээн логистиктой холбоотой инфляцын дарамт үүсэх эрсдэлтэй байгаа. Инфляцын эрэлтийн шалтгаантай гэхээсээ илүүтэйгээр одоогийн инфляцын 50-аас 60 хувийг ерөөсөө хорьхон бараа бүтээгдэхүүн тайлбарлаж байгаа. Тэрний 10-аас 11 нь хүнсний бараа байгаа. Тэгэхээр энэ нөгөө нэг цэнхэр ном дээр ямар ямар бараанууд вэ гэдэг нь тодорхой байгаа учраас би танд хуудсыг нь хэлээд өгье.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна аа.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би өчигдөр Байнгын хороон дээр асуусан юм аа. Тэгээд өнөөдөр би энэ Ган-Очироос асууя. Лхагваа Ерөнхийлөгч хариулчихсан тиймээ. Тэгээд тодорхой биш байгаа учраас энэ 2022 оны 8 сард Монгол Улсын валютын нөөц түүхэн доод хэмжээндээ хүрсэн 2.8 тэрбум доллар болсон. Түүхэн дооддоо ч юу юм сүүлийн жилүүдийн. Тэгээд 2024 оны 5 сард 5.2 тэрбум долларт хүрээд түүхэн дээд хэмжээндээ хүрсэн. Гол нь бол наадах чинь тэгээд уул уурхайн юунууд бүтээгдэхүүнүүд биржээрээ зарагдсан шүү дээ Ган-Очироо? Импорт байсан уу импорт байсан, өсөлттэй байсан уу өсөлттэй байсан. Тэгээд тийм байхад наад валютын нөөц чинь тогтвортой өсөж байсан. Одоо тэгээд өнөөдрийн байдлаар 4.6 тэрбум доллар. Тэр Цогтгэрэл гишүүн 4.7 гэж байсан. Надад бол 4.6 болчихсон байна. Тэгээд энийг өсгөх боломж Монголд байна шүү дээ. Монгол Улсад мөнгө бол байгаа байхгүй юу. Тэгээд нөхцөл бололцоогоо сайн шахах хэрэгтэй байна. Тэгээд энэ доллар өсөж байсан гол шалтгаан бид уурхайн бүтээгдэхүүнээ бэлэн мөнгөөр зарж байсан энэ байдал үнэхээр байхгүй болсон байна аа. Санаатайгаар л ийм байдалд үүсгэж байна л даа. Хариулахдаа хүртэл буруу зөрүү. Тэгээд хэлсэн хүнийг нь бас нэг энэ сонин хэвлэлээр хусах юмаа. Янз янзын хүнээр юм яриулах юм. Би тэр хүн рүү нь ярих юм гэж бодоод байдаг юм уу яадаг юм. Хүн амьтан мууллаа гээд би тэр хүн рүү ярьж. Уучлаарай тийм юм бол байхгүй. Тэгээд нэг нүүрс ярихаар нэг баахан хүмүүс нэг янз янзын юм бичээд над руу дайрах юм. Тэгээд энэ гаднын Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль 2023 онд батлагдсан. Тэгээд өчигдөр Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулахдаа санал ирсэн байхгүй гэж хариулна лээ. Үгүй ээ энэ дээр тэгээд танайх ажиллах ёстой шүү дээ Ган-Очироо. Тэгээд яаж ажиллаж байна. Яагаад энэ хууль биелүүлэхгүй байна. Танайх биелүүлэх субъект нь шүү дээ.

Тэгээд санал ирэхгүй байна гээд сууна гэдэг чинь ажлаа яаж хийж байгаа чинь харагдаж байна шүү дээ. Энийг чинь тэгээд санал ирүүлэх энэ талаар хөөцөлдөх ёстой юм байгаа биз дээ. Тэгээд энийг чинь энэ одоо гишүүдийн ярьж байгаа тэр ипотекийг танайхаас гаргах, зээлийн хүүг бууруулах өрсөлдөөн бий болгох хамгийн гол зүйл гэж бид нар олон жил ярьсаар байгаад ийм банк оруулах

хуультай болсон. Тэгээд одоо санал ирэхгүй байна гээд сууж болохгүй. Тэгээд ямар ажил хийж байгаа талаар ярья.

Гуравдугаарт юу байна. Энэ үнэт цаасны үлдэгдэл Лхагваа Ерөнхийлөгч өө хэт их байна. Энэ зах зээл дээр эргэж байх ёстой мөнгө шүү дээ. 9 их наяд төгрөг. Энэ бол арай л одоо. Уул нь бол энэ чинь тэгээд танай дээр мөнгө их байгаа мөртөө бизнесийн зээл гаргалт нь мундаг тэ? Тэгээд бизнесийг ингээд хөхүүлэн дэмжих бодлого хэрэгжиж байгаа бол яая гэх вэ? Тэгэхэд чинь бизнесийн зээл 22 хувьтай байна шүү дээ Ган-Очироо 22 хувьтай. Тэгээд 22 хувийн бизнесийн зээлийг аваад цаана нь гарах боломж байхгүй л дээ. Төрийн тендерт л орвол болдог юм шиг байгаа юм. Тэгээд би мэдэхгүй тендер авч үзээгүй учраас мэдэхгүй юм байна. Тэгээд тэр тендерт ороод болдог л компаниуд л авдаг юм шиг байгаа юм. Түүнээс биш яг шударгаар явж байгаа бизнес 22 хувийг аваад мэдэхгүй шүү чадахгүй шүү тэр. Тийм учраас Монголд экспорт дэмжих тийм бодлого байхгүй байна гэж үзсэн.

Монголбанкны ажил бол тэр хэмжээгээрээ учир дутагдалтай байна. Би Эдийн засгийн байнгын хорооны дарга байхдаа нэг хяналт шалгалт оруулж байсан юм. Тэгээд одоо бол тэрнээс хойш бараг ороогүй байх шүү. Тэгээд орох цаг нь болсон байх.

Д.Амарбаясгалан: Ган-Очир микрофон хэд байна? 8 дугаар микрофон.

Д.Ган-Очир: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Эхний асуудал бол өнөө 9 дүгээр сарын байдлаар гадаад валютын нөөц 4 тэрбум 670 сая ам.доллар байгаа. Энэ бууралтад мэдээж экспортын өсөлт бага байгаа. Импортын өсөлт маш өндөр байгаа нь нөлөөлж байгаа. Экспорт талдаа бол мэдээж биет хэмжээ бол нүүрсний биет хэмжээ бол өсөж байгаа. Нийт экспортын 60 хувийг нүүрсний экспорт дангаараа тодорхойлж байгаа. Гэхдээ үнийн уналт маш хурдан байгаа. Тэр утгаараа экспортын нүүрсний орлого өөрөө дангаараа 7-оос 8 хувийн л өсөлттэй байгаа. Таны хэлж байгаагаар бол сүүлийн 3 сар дотор бол яг нүүрсний экспортын орлогын орж ирэх давтамж бол жоохон хойшилж байгаа, удааширч байгаа. Тийм зүйл байгаа. Энэ утгаараа бол энэ биржтэй холбоотой асуудал байна уу эсвэл гэрээ контрактууд нь өөрөөр хэлбэл оны сүүл рүүгээ нэмж орж ирэх тийм гэрээ контрактууд байна уу гээд олон асуудлууд байгаа байх.

Тэгэхээр энэ чиглэлээр бол Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс бол холбогдох байгууллагуудад сануулж анхааруулж валютын нөөцийн урсгал нэмэгдүүлэх урсгалыг сайжруулах чиглэлд авч ажиллах нь бол том төслүүдийг хэрэгжүүлэхээр зарлаж байгаа, төсвийн тэлэлт энэ өндөр байгаа энэ цаг үе дээр бол хүлээлтийг бол удирдах, валютын нөөцөд орж ирэх дарамтыг багасгахад маш чухал байгаа гэдэг таны энэ санал, дүгнэлттэй бол Монголбанк адилхан байгаа гэдгийг бол мэргэжлийн хувьд хэлье.

Хоёр дахь асуудал бол Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль батлагдсан. Энэ хуулийг дагуулаад батлагдах ёстой бүх дүрэм журмуудыг Монголбанк гаргасан. Бид бүхэн олон улсын жишгийн дагуу харж байгаад хамгийн хөнгөлөлттэй байж болох нөхцөлөөр бол дүрэм журмуудаа гаргасан гэж бидний хувьд дүгнэж үзэж байгаа. Үүнийгээ бол сурталчлах олон нийт Гадаадын хөрөнгө оруулагч нарт орж сурталчлах ажлыг бол өнгөрсөн жилээс хойш бол маш идэвхтэй хийж байгаа. Жишээ нь Хонконгод очоод дотоодод IPO гаргаж байгаа банкнуудыг дуалистинг

болгоод дахиад хөрөнгийн бирж дээр IPO гаргах хөрөнгө татах бусад тэр HSBC-ээс авхуулаад бусад гадаадын хөрөнгө оруулалттай банкнуудыг Монголд орж ирэх боломж нөхцөл байгаа тухай танилцуулах ажлыг хийсэн. Нью-Йоркт бас энэ өнгөрсөн оны 4 сард яг энэ оны 4 сард бас очиж яг хөрөнгийн бирж дээр нь ажилласан.

Дээрээс нь нэмэх нь хөрөнгө оруулагч нартаа бол яг л энэ хуулийнхаа ач холбогдол дагаж баталсан журмуудынхаа мэдээллийг өгч байгаа. Ирэх жилийн эхээр Лондон хотод очиж энэ арга хэмжээг хийхээр ажиллаж байгаа. Тэгэхээр уулзсан газар хөрөнгө оруулалтын форум арга хэмжээнд Монголбанкны төлөөлөгч нар оролцох болгондоо энэ тухай мэдээллийг өгч ажиллаж байгаа гэдгийг танд мэдээлэл болгож өгье.

Гурав дахь асуудал бол үнэт цаасны үлдэгдэл бол яг 9 дүгээр сарын байдал, өнөөдрийн байдлаар 8.7 их наяд төгрөг байна. Энэ бол 10 их наядасаа бууж байгаа. Өмнө хэлсэнчлэн Мөнгөний бодлогын хорооны шийдвэрүүд бол.

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Монголбанк ер нь наад валютынхаа нөөцийг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол тэгээд 2, 3 сарын дараа тэгээд л ахиад л зовлон яриад л импорт руу хамаг юмаа чихээд л ингээд сууж байх вий дээ. Лхагваа Ерөнхийлөгч өө. Нүүрсээ биржээр заруул л даа. Нүүрс биржээр зарахад 20 сая доллар 30 сая доллар дэнчин тавьдаг юм шүү дээ. 2 сая доллар биш шүү дээ. Наадах чинь. Нэг арилжаан дээр 20, 30 сая долларын дэнчин тавигдана. Тэгээд наад зэсээ биржээр зар л даа. Тэгээд наад валютын чинь нөөц нь нэмэгдэнэ. Та нарт байгаа дарамтууд багасна шүү дээ. Энэ ажлыг хийж чадахгүй бол тэгээд уучлаарай. Би бол зүгээр чимээгүй явж чадахгүй шүү. Бирж нүүрснийхэн чинь бол биржээр зарахгүй байх бүх л зүйлийг л үрж байгаа юм байна лээ. Бүх л зүйлийг л тэр хууль руу чихэж байгаа юм байна лээ. Тэгээд ярьж байгаа хүмүүсийг нь яаж буруутгах вэ энэ тэр гээд.

Д.Амарбаясгалан: Энэ Ганбаатар гишүүний хэлж байгаа асуудалтай холбогдуулаад ер нь Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын даргын захирамжаар энэ Монголбанк банк санхүүгийн орчин дахь хууль, эрх зүйн орчинд шинэчлэл шинэтгэл хийх зорилготойгоор ажлын хэсгийг байгуулахаар зорин ажиллаж байгаа. Зарим Улсын Их Хурлын гишүүдтэй уулзаж санал солилцоод явж байгаа юм. Тэгээд ер нь жоохон тодруулж цэгцэлж өгөх шаардлагууд байгаа харагдсан. Монгол Улсын системийн хамгийн том банкнууд нь богино хугацаатай хэрэглээний зээлдээ эргэлдчихсэн, ААН-үүддээ хөрөнгө оруулалтын эргэлтийн хөрөнгийн зээлүүд олдох боломж нь муудчихсан. Тэгээд сүүлийн жилүүдэд ер нь ганцхан гаднын хөрөнгө оруулалтын банк л гэж яриад байгаа болохоос биш дотоодод байгаа банк санхүү байгууллагууд маань өөрсдөө хөрөнгө оруулалт эргэлтийн хөрөнгийн чиглэл дээр урт хугацааны бага хүүтэй зээлийн олголт дээр яагаад анхаарал тавихгүй байна вэ гэдэг асуудал энд гарч ирэх нөхцөл үүсэж байгаа.

Тэгэхээр энэ дээр бол ажлын хэсэг байгуулж ажиллана гэдгийг хэлье ээ. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна аа.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр мөнгөний бодлогоо ярьж байна л даа бид. Тэгэхээр ирэх жилийн эдийн засаг нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд төсвийн бодлоготойгоо мөнгөний бодлого өөрөө уялдах л тухай л асуудал байгаад байгаа юм. Тэгээд эндээс юу харагдаад байна гэхээр зэрэг энэ тэргүүлэх зорилтууд төсвийн бодлого чинь өөрөө хөрөнгө оруулалт талаа их дэмжчихсэн ийм үйл явц байгаад байгаа юм аа.

Тэгэхээр энэ нь эргээд импортынхоо хөтлөлтийг нэмэгдүүлэх магадлал их өндөр байгаад байна аа. Та хэд ярихаараа зэрэг гадаад эх үүсвэрээ ахиу ашиглах тухай гол зорилт л яваад байна шүү дээ. Тэгэхээр энийг нэлээн нухацтай судалж энэ гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, валютын нөөц, мөнгөний, төгрөгийн ханш энэ тэрийнхээ зорилтот түвшнүүдээ харж зохицуулалт тохируулгынхаа зорилтот түвшнүүдийг их тодорхой болгомоор юм биш үү гэдэг ийм л асуудал байгаад байна л даа. Энэ талаар та хэд юу хараад байна вэ гэж. Тэгээд гадаад эх үүсвэр юмнуудыг ашиглана гэхээр хэдий хэмжээний юм ашиглаж байж энэ зохистой балансын чинь юм анзаарагдах ёстой юм гэдэг зүйл байгаад байдаг.

Дээр нь татварын бодлого гэдэг юмаа ер нь давхар авч үзэх ёстой юу үгүй юу? Бид хэд энийг бараг тансаг хэрэглээний гэж хэлж болмоор байгаа импортуудаа ер нь татварын бодлого талаараа зөв зохицуулахгүй бол жаал хэрүүлтэй уруултай оруулж ирсэн валютыг чинь гадагш нь чирч явчхаад байгаа юм энд л байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энүүнийгээ яая гэж хараад байна вэ гэдэг асуудал.

Хоёр 2 дахь зүйл. Зээлийн хүү бууруулах тухай хэдүүлээ их олон жил яриад нэг их олигтой үр дүн рүү орж чадахгүй л байгаад байна. Тэгэхээр зэрэг чөлөөт мөнгөн хөрөнгө гэдэг юм уу хуримтлалаа бид хэд банкны салбарын актив болгож ашиглагчаад байгаа улсууд.

Тэгэхээр энийгээ л их зөв бодмоор байна л даа. Энэ нэг баялгийн сан гэдэг юм уу, хуримтлалын сан гэдэг юм уу тэр ноднин НДШ-ийн 2 хувийг мөнгөжүүлэх энэ тэр тухай ярьсан. Энэ нэг жоол чөлөөт үлдэгдлүүдийг эдийн засгийн идэвхжил рүү оруулах тэр нь үнэт цаас хөрөнгийн зах зээлээрээ дамжиж орох тэр зохицуулалтын тухай л асуудал л байх гээд байх шиг байгаа юм. Батшугар өчигдөр ярьсан яриа нь бол активын удирдлагын компанийн тухай ярина лээ. Тэгэхээр ер нь үндсэндээ активын удирдлага менежментийн зөв системийн тухай л асуудал байгаад байгаа байхгүй юу. Энийг ер нь юу гэж харах юм бэ? Бид хэд жаал юмнуудаа аваачаад эх үүсвэр болгож ашиглаад буцаагаад банк гаргахаараа дандаа хэрэглээгээ дэмжсэн бодлого явчхаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь л энэ улс орны чинь хөгжилд нэлээн том нөлөө үзүүлээд байна л гэж би хараад байгаа шүү дээ. Энийг юу гэж үзээд байна. Тэр нэг тогтолцоот банкны систем байх үед хажуудаа бид хэд хөрөнгө оруулалтын хэлтэстэй, газартай байгаад том том хөрөнгө оруулалтуудаа дандаа үе шатын санхүүжилтийн зарчмаар явж байсан шүү дээ. Одоо бид нар чинь том төсөл санхүүжүүлнэ гэхээр зэрэг зээлийг нь бөөн гаргаад зориулалт өөр болгож ашиглуулаад ингээд өнөө том төсөл арга хэмжээ бодит ажил болж чадахгүй байгаад байна шүү дээ.

Тэгээд энийг ер нь бодлогын хувьд харсаар байж хэдүүлээ энэ зах зээлийн нөхцөлд ер нь яаж зөв зохицуулах ёстой юм бэ гэдэг зүйл байгаад байна л гэж би хараад байдаг юм. Энийг нэг зөв талаас нь харах зүйл байна уу? Энэ дээр ер нь ямар бодлого байна вэ гэж. Ипотекийн зээл их ярьж байгаа юм сайн. Орон сууцжих

ёстой. Гэхдээ эрэлт, нийлүүлэлт хоёроо зохистой дэмжих бодлого явахгүй дан эрэлтээ дэмжвэл метр квадратынхаа үнээр иргэд чинь ачааны хүндийг үүрнэ шүү.

Би бол ер нь сүүлийн хэдэн жилийн явчхаад байгаа үйл явцыг чинь яг ийм байдлаар явчихлаа гэж хараад байгаа шүү дээ. Тэгэхээр энүүнийг яаж ер нь зөв зохицуулна гэсэн төсөөлөл байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ирэх онд ерөнхийдөө энэ Засгийн газрын 2024-өөс 2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр гээд явж байгаа. 14 мега төсөл, дээр нь 2025 онд ингээд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэсэг нь нэлээн том явж байгаа. Монголбанкны зүгээс бол Сангийн сайдтай уулзсан. Тодорхой бас энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бас 2, 3 удаа уулзалт хийсэн. Тэгээд бидний авсан мэдээлэл бол ерөнхийдөө томоохон төсөл хөтөлбөрийг гаднын санхүүжилтээр төсвөөсөө гэхээсээ илүү гаднын эх үүсвэрээс санхүүжүүлнэ ээ.

Ялангуяа өмнө нь олон улсын санхүүгийн байгууллага болох Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкттай, өмнө нь байгуулчихсан гэрээ байгуулаад эх үүсвэрээ ашиглаагүй байгаа бас томоохон эх үүсвэрүүд байгаа гэж хэлсэн. 1 тэрбум орчим долларын. Тэгэхээр эдгээр эх үүсвэрүүдээсээ түрүүлж ашиглаад явна аа. Яагаад гэвэл олон улсын байгууллагуудын эх үүсвэр бол хугацаа урттай, хүү багатай ийм эх үүсвэр байдаг гэдгээрээ. Зарим төсөл хөтөлбөрөө бол гаднын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ. Ялангуяа яг Оюу Толгой шиг бүтээн байгуулалт нь шууд өөрсдөө мөнгөө авчраад босгоод явахаар гэдгээр ингээд тусгаад. Яг ирэх 2025 онд бол яг төсвөөс нь санхүүжүүлэх юм бол 4 их наяд гэж байгаа юм. 4 их наяд гэдэг бол өнөөдрийн ханшаар долларт шилжүүлэх юм бол 1 тэрбум орчим доллар л доо.

Тэгэхээр 1 тэрбум орчим долларын хэрэгцээ бол ирэх жил байх юм байна гэдгээр төсөөллөө хийсэн. Тэгэхээр 1 тэрбум долларын хэмжээний санхүүжилт бол ерөнхийдөө боломж юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ирэх онд Засгийн газар дээр өөрийнх нь өрийн төлбөрийн дарамт байхгүй. 2025 онд төлбөрийн дарамт байхгүй. 2026 оноос бага дүнгээр ингээд нэмэгдээд явахаар 600 сая. Тэгэхээр бол энэ утгаараа Засгийн газар өөрөө бонд босгоод энийгээ санхүүжүүлээд ялангуяа дахиад дараагийн шатын өнөөдөр АНУ-ын бодлогын хүү буурч явж байгаа нөхцөлд бол ингээд бондоор босгох хүүгийн зардал бол бага гарч ирэхээр ийм боломж байгаад байгаа юм.

Тэгэхээр ийм хэлбэрээр явах юм байна гэж харж байгаа. Улаанбаатар хот бол Сэлбэ бүтээн байгуулалтаа бас олон улсын зах зээлээс бонд босгож ирээд санхүүжүүлнэ гэж байгаа учраас Монголбанк дээр ялангуяа тэр төлбөрийн баланс дээр төлбөрийн тэнцэл дээр дарамт бага байна гэдгээрээ бид хэд л хараад явж байгаа. Зээлийн хүүгийн хувьд бол ингээд Монголбанкны бодлогын хүү буураад эхлэхлээр хүү буурах боломжтой гэж харж байгаа. Манай өмнөх жишээ байгаа.

Ялангуяа 2020 онд бол манай бодлогын хүү 6 хувьтай байхад, зээлийн хүү 12 хувьтай болж бараг сарын 1 хувьтай ийм түвшин рүү ирж байсан ийм жишээ бол

байгаа учраас бодлогын хүү рүү ингээд буугаад явахаар ирэх оноос зээлийн хүү өөрөө буураад энэ хандлага үргэлжлээд явна гэж харж байгаа. Яагаад өнөөдөр шууд бодлогын хүү буурахад өнөөдөр буурахгүй байна гэхээр бодлогын хүүгийн нөлөө өөрөө бараг нэг жил болно. Яагаад гэвэл өнөөдөр 11-ээс 12 хувиар авчихсан эх үүсвэр нэгэнт үргэлжлээд явж байгаа учраас.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад тодруулаад гүйцээгээд хариулахад ипотекийн зээлтэй холбоотой хэсэг дээр бол ерөнхийдөө ипотек энэ орон сууцын үнэ бол сүүлийн нэг жилийн хугацаанд 12 хувиар өсчхөөд байгаа. Ерөнхий бол эрэлтийг нь дэмжсэн ийм төрийн бодлого явж байгаа. Нийлүүлэлт нь өөрөө бас тодорхой хэмжээнд байгаа ч гэсэн эрэлтийн энэ бодлогоороо дамжиж орон сууцын метр квадратын үнэ 12 хувиар өсөж байна гэдэг маань өөрөө ийм юу байгаа? Гэхдээ ирэх оноос эхлээд бидний хувьд бол ялангуяа ийм өндөр олон давхартай орон сууцыг ипотекийн зээлээр яахаас гадна амины орон сууц буюу хашаандаа иргэн өөрөө эрчим хүчний хэмнэлттэй, агаарын бохирдол гаргадаггүй, хөрс бохирдуулдаггүй ийм орон сууц бариад тэрийг нь Барилгын тухай хуулиар энэ нь албан ёсоор баталгаажуулаад эхлэх юм бол ийм зээл ороод эхлэх юм бол орон сууцын үнэ тогтвортой байхаар эрэлт талыг нь дэмжсэнээрээ өсөхгүй байх ийм боломжтой л гэж харж байна. Тогтвортой байх.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тийм ээ бид нарын эх үүсвэрийн өртөг өндөр байгаад байгаа учраас зээлийн хүү өндөр байгаад байгаа. Тэгэхээр эх үүсвэрийн өртгийг яаж бууруулах вэ гэдэг юмыг бодож тодорхой шийдэл хийхгүйгээр энэ яриад л яваад байх гээд байгаа байхгүй юу. Ер нь тэгэхээр энүүн дээр ер нь энэ 2025 оноос тодорхой эхлэлүүд хийх юм биш үү? Тэгж байж энэ дэлхийн улс орнуудын энэ эх үүсвэрийн өртөгжил рүү ойртуулах чиглэл рүүгээ явах ёстой юм биш биз дээ гэдэг ийм санал байгаад байна. Энэ дээр ямар бодол байна гэж? Нэг ийм зүйл.

Хоёр дахь миний тодруулчихмаар байгаа зүйл энэ иргэдэд байж байгаа гэдэг юм уу энэ бизнесийн хуулийн этгээдүүд дээр байгаад байгаа нэг жаал чөлөөт үлдэгдлүүдээ банкны систем рүү биш бусад санхүүгийн зах зээл рүү оруулдаг тэр идэвхжилийг нь бид хийхгүйгээр энэ асуудлыг шийдэхэд үнэндээ төвөгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлийн юмыг.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эх үүсвэр бол эх үүсвэрийн хүүг буулгах нь өөрөө зээлийн хүүгийн 60 хувь 50-аас 60 хувь байгаа учраас маш том нөлөөтэй. Бид хэд бол олон улсын жишиг юуг бол судлаад явж л байгаа л даа. Олон улсад бол ерөнхийдөө арилжааны банкиг бол тэр суурь хүүгээ зарлахыг шаарддаг. Праймерэт гэдэг энэ хамгийн сайн харилцагчдадаа өгдөг зээлийн хүүг нээлттэй зарлаад явж байх ёстой гээд нэг тийм зүйл байгаа. Зарим нэг улс оронд бол яг зах зээлийн биш ч гэсэн захиргааны арга байгаа. Эх үүсвэрийн хүүгийн дээд хязгаарыг бол таазыг нь тавьж өгдөг.

Тэгэхээр бол ерөнхийдөө бодлогын хүүгээс тэдэн хувиас хэтэрч болохгүй ээ гэдгээр тааз тавиад явах юм бол бодлогын хүү буухад тэр тааз өөрөө доошлоод

яваад эх үүсвэрийн хүүг нэлээн тийм захиргааны шинжээр буурах тийм аргууд байгаа л даа. Тэгэхдээ энэ нь өөрөө яг зах зээлийнхээ тогтвортой байдалд хэр нөлөөтэй гэдгийг сайн судалж байгаад явна. Тэгэхдээ ийм аргуудыг ер нь хэрэглэхээр сонголтоо хийгээд явж байгаа. Ирэх оноос бол. Ийм аргаар явна.

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Хүн болгон л ярьж байгаа байх. Зүгээр бид нар энэ бизнесийн салбарыг дэмжинэ. Тэгээд хүүгийн хэмжээг бууруулна гээд л ярьсаар байгаад л орж ирж байгаа. Тэгээд Монголбанк энэ дээр гол хариуцлага үүрэх ёстой, ажиллах ёстой байгууллага мөн. Тэгэхдээ бас энэ Монголбанкны хэрэгжүүлж байгаа ажилд энэ Засгийн газраас хуулиуд хэрэгтэй байгаад байгаа болов уу л гэж хараад байгаа. Энэ 2 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт энэ Монголбанкнаас саяхан нэг мэдээлэл гараад байсан. Энэ кредит скорын Америкийн нэг систем аваад байна гээд байсан. Энэ их чухал юм байгаа юм шүү дээ уг нь. СӨХ-ийн мөнгөө төлдөггүй. Кредит картынхаа төлбөрийг төлдөггүй, зээлээ төлдөггүй, банктэй харилцсан зээл санхүүгийнхээ сахилга батыг сахидаггүй иргэн ААН-үүдэд оноо бий болгоод тэгээд сайн харилцагчид нь сайн санхүүгийн сахилга баттай байгаа хэсэгт нь бага барьцаатай, бага хүүтэй, муу байгаад нь өндөр эрсдэлтэй учраас өндөр хүүтэй өндөр барьцаатай байдаг энэ жишиг рүү бид нар шилжихгүй бол бүгдэд нь яг ижилхэн стандарт тавиад байгаа байхгүй юу. ААН хувь хүмүүс сайн хариуцлагатай, санхүүгийн санхүүгийн сахилга бат сайтай байсныхаа төлөө уг нь урамшуулал аваад ингээд явбал банкандаа ч хэрэгтэй, системдээ ч хэрэгтэй, сайн хариуцлагатай байгаа хүмүүстээ ч хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу. Энэ өөрөө банк санхүүгийн энэ системийн энэ хүүгийн өсөлтөд асар их нөлөөтэй болчихоод байгаа юм. Асар их нөлөөтэй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ кредит скор буюу нэг хүний тухайн иргэн ААН-ийн хувийн санхүүгийн хариуцлагын онооны энэ системийг хийхэд хууль, эрх зүйн хувьд бид нар яаж оролцох ёстой юм бэ? Монголбанк эсвэл өөрийнхөө эрхийн хэмжээнд Монголбанкны Ерөнхийлөгч журам гаргаад энийг бүрдүүлчхэж болдоггүй юм уу, болдоггүй юм уу тэ? Тэгэхгүй бол одоо бид нар ингээд бүгдийг нь нэг хавтгайлаад бид нар ингээд гэрээсээ гараад л лифтэнд суухад л эсвэл орцны үүдэн дээр хаа нэг газар зарим айл нь СӨХ-ийн төлбөрөө ерөөсөө төлдөггүй. Зарим нь байнга төлж байдаг. Энэ хүртэл санхүүгийн хариуцлага байхгүй юу. Тэгээд энэ болгон дээр нь хийдэг энэ санхүүгийн хариуцлагын оноо гэдэг юм дэлхийн улс орнуудад байж байгаа шүү дээ. Энэ чинь өөрөө хүүг асар ихээр бууруулна шүү дээ уг нь бол. Тэгэхгүй бол одоо манай банкнуудын боловсон хүчний бараг 50 хувь нь шахуу хуульчид тэгээд нөгөө эрсдэлтэй зээлийнхээ араас хөөцөлдөөд тэр хуульчдын чинь цалин, тэр хуульчдын чинь төлөө араас нь гаргаж байгаа зардал өөрөө дахиад хүү дээр очиж суучаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та нар ер нь яаж ажиллаад байгаа юм бэ?

Хоёрдугаарт, энэ нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангаас ингээд л баахан мөнгө аваад л алга болчихсон. Капитал банк гээд нэг банк. Энэний баахан активуудыг Монголбанк өөр дээрээ авчихсан байгаа юм. Одоо тэгээд дараачийнх нь энэ нөгөө Чингис Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк гээд банкнуудыг дампууруулж чаддаггүй ингээд байгаад байдаг. Энэ төрийн их том сангуудаас олон мөнгийг ямар аргаар юм мэдэхгүй авчихсан. Би энэний араас явж байгаа. Энэ

яамнаас нь мэдээллүүдийг нь авна хэн шийдээд оруулчихсаныг нь зарлана. Тэгээд энэ активуудыг ер нь та нар яаж зохицуулж байгаа вэ? Миний бодлоор бараг энэ Монголбанкнаас БЭТ-ээр банкн дээр очиж ажиллаж байгаа хүн шоронд явахаасаа айгаад энэ хөнгөлөлт чөлөөлөлт хийдэг эрх зүйн зохицуулалт нь байхгүй л байгаа байх. Тэгээд та нар энэ актив удирдлага дээрээ ер нь юу хийж байгаа юм? Актив удирдлага дээрээ Их Хурал Засгийн газраас ямар хууль оруулж ирэх ёстой юм? Одоо ингээд байгаа хуулийнхаа хүрээнд та нар шийдэж болохгүй байгаа бол энийг хэл л дээ. Тэгээд шүүхийн шийдвэрийн асуудал байгаа. Иргэний эрх зүйн асуудлууд байж байгаа тэ. Тэгээд энэ юмнуудыг чинь та нар шийдэж өгөхгүй бол Монголбанк гэж нэг баахан банкны бүтэлгүй зээлийн активыг нэг бол авна, нэг бол авахгүйн тулд нөгөө үхмэл банкнуудаа ингээд зомби шиг амьд байлгадаг нэг ийм газар болчихоод байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө хүнд нөлөөлж байгаа шүү дээ. Тэгээд энэ 2 асуултад хариулаад өгөөч. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Дамдинням гишүүний асуултад хариулъя. 2012 онд Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль гараад энэ хууль ингээд хэрэгжээд явж байгаа энэ хуулийн хүрээнд Сайн скор, Бүрэн скор гэдэг 2 компани бол энэ зээлийн оноо, зээлийн зэрэглэл тогтоодог ийм эрх аваад үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд Сайн скор гэдэг компани нь АНУ-д ашигладаг тэр Файко гэдэг аргачлалыг Монголд нэвтрүүлж байгаа. Дөнгөж сарын өмнө эхлээд явж байгаа. Тэгэхлээр АНУ-д бол иргэн өөрөө регистрийн дугаар, төрсөн он, сар, тэгээд нэг Файкогийн энэ оноо гэсэн ийм 3 оноог л цээжлээд явж байхад бүх бүх л үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ дээр энэ нөлөөтэй байдаг юм гэдгээрээ энэ дэлхийн ийм туршлага болчихсон зүйл.

Тэгэхээр ингээд 600 оноо хүртэлх ийм оноог өгч эхлэх юм. Өмнө нь зээлийн мэдээлэл гэдгээрээ манай Монголбанкн дээр байдаг мэдээллийн сан. Энэ дээр банкны зээлээс гадна банк бусын зээл үүрэн телефон үйлчилгээ үзүүлдэг цахилгаан, дулаан, усны мөнгөний төлбөр тооцоотой бүх мэдээлэл цуглаад бараг Монголбанкны хар жагсаалт гэдэг шиг нэлээн тийм хэллэгтэй болоод явж байсан бол одоо энэ онооны систем рүү шилжсэнээрээ саяын тэр жагсаалт гэдэг ойлголт байхгүй. Хувь хүн болгон дээр оноо өгөөд явах юм.

Тэгэхээр бол яг энэ зүйл хэрэгжээд ирэхлээр хамгийн өндөр оноотой нь хамгийн хөнгөлөлттэй сайн нөхцөлийн зээлийг авна. Муу оноотой байх юм бол бусад улсуудын жишгээр бол бүүр хил давах хүртэл нь хилийн байцаан өнгөрүүлэхдээ хүртэл энэ онооны систем үйлчилдэг ийм зохицуулалт байх жишээтэй байгаа юм. Тэгэхээр энэ одоо ингээд хэрэгжээд явж байгаа учраас ингээд явна. Би энэ хуучин 2012 онд орсон хууль маань өөрөө арваад жил болчихсон гэдгээрээ энийг хуулийг илүү сайн сайжруулах талаар бид мөнгөний гол бодлогын үндсэн чиглэл дотор өргөн барьчихсан байгаа. Тэгээд ирэх онд бол ер нь энэ Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн шинэчилсэн нэмэлт, өөрчлөлт оруулах найруулгыг бол ингээд Улсын Их Хуралд өргөн барина. Нийгмийн даатгал ЭМД-тай холбоотой ерөнхийдөө энэ 3 банкн дээр асуудал байдаг. Капитал банк, Чингис Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк. 2019 онд Капитал банкиг татан буулгах явцад эрүүл мэндэд нийгмийн даатгалын өглөг гээд 240 тэрбум төгрөгийн ийм өглөг байсан. Одоо өнөөдрийн байдлаар бол нийгмийн даатгалын сангийн 37.2 тэрбум төгрөг, ЭМД-ын 58.8 тэрбум төгрөг нь төлөгдөөд өнөөдөр нийгмийн даатгалын 67 тэрбум, ЭМД-ын 77 тэрбум төгрөгийн ийм авлага үүсээд ингээд явж байгаа. Капитал банкиг татан буулгаад Капитал банктэй холбоотой эрүүгийн хэрэг

үүсээд ингээд яваад бүх барьцаа хөрөнгүүд нь прокурорын битүүмжид байсан. Энэ оноос эхлээд ингээд суллагдаж байгаа. Тэгээд ингээд эргэлтэд ороод ингээд төлбөр төлөхөөр ингээд явж байгаа. Чингис хаан банк дээр бол ерөнхийдөө Чингис Хаан банкны үйл ажиллагааг л түдгэлзүүлээд хянагч тавиад ингээд явж байгаа. Нийгмийн даатгалын сангийн 100 тэрбум, ЭМД-ын 30.9 тэрбум төгрөг энэнээс бол 7 тэрбум төгрөг төлөгдөөд нийгмийн даатгалын 93, ЭМД-ын 30 тэрбум төгрөг хэвээрээ байгаа. Үндэсний хөрөнгө оруулалтын банк.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр тэр 2019 онд 35.8 тэрбум төгрөг, ЭМД-ын 30.9 тэрбум төгрөг байсан. Энэ бүх төлбөр төлөгдөөд дууссан. Одоо Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр ямар нэг нийгмийн даатгал, ЭМД-ын сангийн төлбөр байхгүй. Чингис Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр ерөнхийдөө хянагч тавиад явж байгаа. БЭТ тавьж ажиллахгүй байгаа нэг шалтгаан байгаа нь бол БЭТ хэрвээ томилчих юм бол энэ шууд л татан буулгах ажиллагааг эхлүүлээд явчихдаг учраас бол эргээд энэ нь эргээд одоо өнөөдрийн Капитал банктэй адилхан жишээ л давтагдахаар байгаа.

Өнөөдрийн гүйцэтгэх удирдлагаар нь энэ өр барагдуулах ажлыг зохион байгуулж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол дараагийн хөрөнгө оруулагч нь энэ банкиг худалдаж авах нь нээлттэй байдаг. Тэр утгаараа гаднын хөрөнгө оруулагч юм уу, дотоодын хөрөнгө оруулагч энэ төлбөрийг төлөөд энэ банкиг цааш нь авч явуулахад одоогийн байгаа зохицуулалтаараа ингэж явж байгаа.

Д.Амарбаясгалан: Дамдинням гишүүн тодруулж асууя.

Г.Дамдинням: Үгүй ээ яах вэ та бол одоо байгаа хуулийнхаа хүрээнд л хариулчих шиг боллоо. Ер нь яах вэ зүгээр би түрүүн асуугаад байна шүү дээ. Энэ их активуудыг Монголбанк өөр дээрээ ингээд аваад явах юм уу яах юм тиймээ? Энэ активын удирдлагыг чинь одоо тийм компани байгуулаад явах юм уу? Одоо бол миний бодлоор бол капиталын баахан өмч хөрөнгийг активуудыг танай дээр л явж байгаа байлгүй дээ тиймээ? БЭТ тавиа л авчихсан юм үгүй юу. Эсвэл өөр дээр нь явж байгаа байх. Өр барагдуулаад л ингээд л нэг юм тэгээд л 3 шатны шүүхээр явна шүүхийн шийдвэр дээр очно. 4, 5 жил болно. Тэрэнд нь баахан шүүхийн зардал гарна. Тэр нь эргээд банкны хүү дээр өсөлт болоод л яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг зүгээр багасгадаг богино хугацаанд шийддэг энэ эрх зүйн зохицуулалтыг би энэ Хууль зүйн сайдаас л асууя даа. Хууль зүйн сайд энэ Актив удирдлагын тухай хууль тэгээд л энэ Дампуурлын тухай хууль, тэгээд Иргэний хариуцлагын тухай хууль гээд энэ хуулиудыг засгаас ер нь оруулж ирэх бэлтгэл хангаж байгаа юу? Ялангуяа энэ хүү бууруулах дээр аягүй чухал хуулиуд байхгүй юу. Монгол банктэй хамтарч ажиллахад.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн сайд, Алтангэрэл сайд хариулъя. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Дамдинням гишүүний асуултад хариулъя аа.

АН-ын бүлэг дээр энэ орж ирж байгаа асуудлыг хэлэлцэх үеэр би Лхагвасүрэн захирлаас асуусан. Ер нь энэ Төв банкны тухай хууль батлагдаад энэ 28 жилийн өмнөх бараг хууль байгаа байх. Тэгээд энийг шинэчлэх үү гэсэн ер нь удаа дараалан нэмэлт өөрчлөлтүүдийг хийж яваа тэгээд дахиад энэ хуулийг шинэчлэх талаарх саналаа гаргая. ХЗДХЯ-тай хамтарч ажиллах юм байна гэж ойлгосон. Мөн таны ярьж байгаа энэ дампуурлын хууль бол маш чухал байгаа.

Цэнгүүн гишүүний зүгээс энэ Дампуурлын хууль дээр нэлээн анхаарал тавиад бид нар энэ хууль дээр ажиллаж байсан хүмүүс ажлын хэсэгтэй нэг уулзалт хийсэн. Ер нь таны хөндөж байгаа асуудлууд дээр Хууль зүй, дотоод хэргийн яам энэ дампуурлын тухай хууль дээр нэлээн идэвх оролцоотой ажиллана. Бас манай Сайнзориг гишүүн энэ дээр анхаарал тавиад явж байгаа. Бид бол зарчмын хувьд энэ хувийн эрх.

Д.Амарбаясгалан: Энэ арилжааны болон дампуурлын харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал гээд Улсын Их Хурлын даргын захирамжаар Сайнзориг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарсан. Энэ ажлын хэсэгт мэргэжлийн хуульчид эдийн засагчид орсон ажиллаж байгаа. Тэгээд ер нь бол бид энэ аливаа асуудлыг цогцоор нь хоорондын уялдаа холбоог нь бүрэн хангасан хэлбэрээр хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг дээр ярьж ажиллаж байна. Манай Хууль зүйн яам ч гэсэн бодлогын хувьд энэ Их Хурлынхаа стратеги бодлогыг бүрэн дэмжээд хамтдаа ажиллах тэр чиглэлийг хүлээж байгаа. Ер нь Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг бүх талын оролцоог хангах, удирдан зохион байгуулах, менежментийг нь хийх ийм үүрэгтэйгээр ингэж ажлыг хурдтай явуулах зорилготойгоор ингээд байгуулагдаад ажиллаж байгаа гэдгийг хэлье ээ.

Ингээд Сонгобайн Замира гишүүн асуулт асууна аа.

С.Замира: Баярлалаа.

Би нэг 3 асуудал асуумаар байна энэ Монголбанкнаас.

Нэгдүгээрт энэ нөгөө Монгол Улсдаа орж ирж байгаа энэ валют болгоноос 4 хувийн шимтгэл авна гэдэг нь үнэн үү? Энэ ямар учиртай юм? Тэгээд цаашдаа ер нь хөрөнгө оруулалт ийм байдалтай байвал орох нь уу үгүй юу? Монгол оронд.

Хоёрдугаарт бол ипотекийн зээл гээд одоо хэдэн жил болж байгаа шүү дээ. Тэрэнтэй холбоотой одоо нөгөө орон сууцны корпорац гээд 3 дахь нэг аж ахуйн нэгж байна даа. Энэ удаа бас тэр аж ахуйн нэгжийн оролцоотойгоор ингээд ипотекийн зээл өгөх юм уу эсвэл арилжааны банкаар шууд дамжуулан иргэддээ хүрэх юм уу?

Тэгээд 3 дугаарт болохоор одоогийн арилжааны банкнуудын хүүгээр энэ Монгол оронд ийм ЖДҮ хөгжих боломж байгаа юу? Ийм 3 асуулт асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Монголбанкны ерөнхийлөгч энэ саяын тэр 4 хувийн шимтгэл гээд энэ гаднаас орж ирж байгаа валют хөрвүүлэхэд Монголбанк дээр авдаг шимтгэл гэж нэг асуудал яригдаад байгаа юм. Ер нь тэгээд манай энэ процесс дунд авч байгаа энэ нэг олон давхар шимтгэлүүд өртөг өсгөдөг энэ байдлыг тодруулаад нэлээн сайн дэлгэрэнгүй хариулах нь зүйтэй байх. Гишүүд энэ дээр бас санал, асуулт их байна лээ. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Замира гишүүний асуултад хариулья.

Тийм яг ийм гаднаас орж ирж байгаа валют дээр бэлэн болгож гаргахаар юм уу эс үгүй бол хоорондын 2 харилцах дансны хооронд гүйлгээ хийхэд шимтгэл авах зохицуулалт байхгүй. Монголбанкнаас ийм зохицуулалт хийгээд, тэдийг ав, эдийг ав гэдгээр оролцдоггүй. Би түрүүн нөгөө гишүүний асуултад хариулж байхдаа энэ бол яг арилжааны банкны дотоод л өөрийнх нь авч байгаа үйл ажиллагаа байгаа. Тэгээд би сая Их Хурлын дарга хэлж байна. Энэ асуудлууд олон яригдаж байгаа учраас би зүгээр ямар санал байна вэ гэхээр Монголбанкнаас ерөнхийдөө энийг хянаж ямар ч байсан эхлээд дэлгэрэнгүй судалгаагаа авъя. Аль аль банканд дээр ямаршуу хэмжээнд ямар дээд доод түвшин ямаршуу байна гэдгээр ингээд аваад ингээд энэн дээр танд дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгье өө. Монголбанкнаас ав гэдэг зүйл байдаггүй. Гадна олон нийтэд бол ямар ойлголт байдаг вэ гэхлээр Монголбанкнаас ийм ийм юм тогтоож өгсөн юм байдаг юм байна гэсэн маягаар ойлгоод байдаг.

Тэгэхээр Монголбанкнаас яг шимтгэлийг ав, тэдэн хувиар ав тэгээд ерөөсөө тийм юу тогтоож өгсөн ийм зүйл байхгүй байгаа. Тэгээд дэлгэрэнгүй бүр судалгаа хийж байгаад танд ингээд өгье. Ипотекийн зээл бол өнөөдөр арилжааны банкаар дамжаад явж байгаа. Тэгэхлээр ТОСК орон сууцын төрийн орон сууцын корпорацаар дамжиж байгаа зүйл байхгүй. Ипотекийн зээлээр гаргаж байгаа зээл маань өөрөө эргээд мөнгөжих болохлоороо үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас болоод МИК руу ингээд шилжээд явдаг. Тэгэхлээр Монголын ипотекийн корпорац буюу тэр МИК гээд хувийн хэвшлийн компани. Энэ дээр ингээд үнэт цаасны зуучлал хийгээд явж байгаа.

ЖДҮ-тэй холбоотой яах вэ ерөөсөө ЖДҮ бизнес байна уу, ер нь ялгаа байхгүйгээр л зээлийн дундаж хүү тогтоод явж байгаа. Ирэх 2025 онд Монголбанкнаас бол ялангуяа тэр ЖДҮ-ийн нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой тийм кластер маягаар яах ийм бүтээгдэхүүнийг гаргаад ирэхээр ажиллаж байгаа учраас хэрвээ ялангуяа тэр том компанид бэлтгэн нийлүүлэгч маягаар ажилладаг ЖДҮ дээр гэрээг нь барьцаалж зээл олгох тэрэн дээр нь хөнгөлөлттэй байх маягаар ийм бүтээгдэхүүн гаргахаар зорьж байгаа.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууна.

Б.Энхбаяр: Манай сүүлийн 30 жилийн улс төр бизнесийн үйл ажиллагаанд гол оролцогч нөлөөлөгч болсон хүмүүс банкны эзэд байгаа. Банкны эзэд бол сүүлийн 30 жилд Монголын Улс төрд хэн байхыг ч тодорхойлж байдаг болсон. Монголын аль олигтой чөлөөт өрсөлдөөнд байж болох бизнесүүдийг эрхэлдэг болсон. Уул уурхай руу орсон. Одоо ийм болсон байна аа.

Хамгийн сүүлд эрчим хүч рүү орж байх шиг байна. Тэгэхээр энэ арилжааны банкнууд, банкнуудын эздүүд өөрсдөө бизнес эрхэлдэг явдлыг халъя гэж бид сүүлийн 3, 4 парламент дамжиж ярьж байгаа. 2018 онд Банкны тухай хуульд өөрчлөлт орж 7.4.1-д дангаараа болон бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох өөр хоорондоо эсвэл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах ийм үйл ажиллагаанд оролцохыг хориглосон байгаа. Энэ заалтын хэрэгжилт ямар байгааг Монголбанк хяналт шалгалт, дүгнэлт хийдэг үү? Улсын Их Хуралд танилцуулах уу?

Одоо ингээд өнгөрсөн хугацаанд Эрдэнэтийн 49-өөс үүдсэн асуудал нэлээн өндөр аваад банкны эздийг хязгаарлая гэдэг ийм асуудал яригдсан. Одоо улам өргөжөөд байна уу? Энэ Хөгжлийн банк болон нүүрсний сонсгол дээр бол банкны эзэд бүх зээлүүдийг өөрсдөө авсан нь тодорхой болсон. Төрийн мөнгөөр улам бүүр томорч байгаа асуудал нь тодорхой болсон. Улс төр дэх оролцоо нөлөөллийг нь багасгая гээд 2018 онд Банкны хуульд банкны эздийг улс төрийн намд хандив өгөхийг хориглосон. Одоо сүүлийн үеийн гарч байгаа мэдээллийг харахад 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд Улсын Их Хурлын гишүүдэд арилжааны охин компаниудаараа дамжуулж хамгийн их хандив өгсөн хүмүүс нь дандаа банкны эздийн компаниуд байна аа. Энэ дүгнэлт өгч байгаа юу? Өөрөөр хэлбэл одоо банкны эзэд хуулиар хориглосон биш нэгэнт энэ танхимын хэдэн хувийг нь санхүүжүүлж шийдвэр гаргаж байгаа вэ гэдэг асуудал дээр Монголбанк ажиллаж байгаа зүйл байна уу? Өнгөрсөн ковидын цар тахлын үед бол Монголбанк бол нэг дүрмийг бол мэдээж алдсан. Тэр нь бол улс төрөөс хараат бус байх буюу Засгийн газартай нэг хөнжилд дурлалцахгүйгээр үнсэлцэхгүй ээ гэдэг тэр алтан зарчим бол ковидын жилүүдэд зөрчигдсэн.

Одоо бид хэвийн горимд орсон байгаа. Тэгэхээр Монголбанк цаашдаа улс төрийн шийдвэр гаргалтаас хэр хараат бус байх боломжтой байна вэ? Тухайлбал томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх Засгийн газрын бодлого төгрөгийн тогтвортой байдлын ханшид яаж нөлөөлөх вэ гэдэг дээр тооцоо судалгаа хийсэн зүйл байгаа юу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Банкны тухай хуулийн 7.1 дээр банк ямар үйл ажиллагаа эрхэлж болох вэ гэдгийг ингээд хориглосон заалт нь байж байгаа. Тэгэхээр банкнаас бусад гээд. Тэгэхээр банк бол банк гэдгээрээ явж байгаа юм. Банк ААН-ээрээ, хуулийн этгээдээрээ. Тэгэхээр банк бол яг л санхүүгийн зуучлагчийнхаа үйл ажиллагааг эрхэлнэ гээд. Банкны эзэн буюу хувьцаа эзэмшигч гээд өнөөдөр нөгөө Хөрөнгийн бирж дээр 5 том арилжааны банк хувьцаа эзэмшигч хөрөнгийн хувьцаагаа гаргасан гээд 10 хувиа олон нийтийн эзэмшил болгочихсон. Ингээд 73 мянган хувьцаа эзэмшигчтэй болсон л доо.

Тэгэхээр таны ярьж байгаа нөгөө банкны эзэн буюу хамгийн том хөрөнгө оруулагч л хувьцаа эзэмшигчийн тухай л байх гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой заалт бол одоо яг манай энэ хууль дээр байхгүй. Тэгэхээр бол тэр банкны эзэн бол энэ банкныхаа тодорхой хувийг эзэмшиж байгаа. Дийлэнх хувийг нь уу, багахан хувийг нь уу гэдэг нь угаасаа л хуулийнхаа дагуу байж байгаа.

Дараа нь өөр бизнесийн хувьцаа, өөр компанийн хувьцаа эзэмшээд явах өөр бизнес рүү ороод явах уул уурхай байна уу, эрчим хүч, барилга, тээвэр өөр хүнс хоол хүнс ч байдаг юм уу, худалдаа хийгээд ингэхлээр энэ манай хуультай хамааралгүй болохоор Монголбанкны зүгээс яг энэ энэ дээр бол хяналт тавьж ажилладаггүй.

Өөр нэг нь хараат бус байдлаа төв банкны ер нь яах вэ дээ яг манай Төв банкны тухай хууль дээр бол төв банк хараат бусаар үйл ажиллагаагаа явуулна, хараат бусаар шийдвэрээ гаргана гэдгээрээ явж байгаа. Манай мөнгөний бодлогын

Монголбанкны гаргадаг хамгийн том шийдвэр бол бодлогын хүү байгаа. Тэгээд бодлогын хүүг өсгөх бууруулах энэ шийдвэр бол Их Хурлаас томилогдсон ийм 7 хүн энэ шийдвэрийг гаргаад явж байгаа. Тэгэхээр бол энэ шийдвэр өөрөө ингээд хараат бусаар гараад яг мөн тооцоо судалгаан дээрээ үндэслээд гараад явдаг учраас бол хараат бусаар байж байгаа.

Тэгэхдээ яах вэ макро эдийн засгийнхаа энэ байдлаасаа харах юм бол өнөөдөр ингээд төсөв тэлж байгаа үед бол мөнгөний бодлого тэлэх ямар ч орон зай байхгүй гэдэг утгаараа бол энэ дээр эдийн засгаа л тогтвортой байлгах тэнцвэртэй хадгалах үүднээсээ л өнөөдөр мөнгөний бодлого ингээд шийдвэрээ гаргаад явж байгаа. Одоо мэдээж ингээд хэрэглээний сагс гээд үзэхлээр Монгол Улсын дундаж өрхийн хэрэглэдэг бараа бүтээгдэхүүн тэр сагсанд байгаа 420 бүтээгдэхүүний 50 хувь нь импортын бараа бүтээгдэхүүн байгаа.

Тэгэхээр өрхийн орлого нэмэгдээд өрхийн хэрэглээ нэмэгдэнэ гэдэг маань тэр 50 хувиар дамжаад импортын бараа бүтээгдэхүүний хэрэглээ л өсөж байгаа гэж ойлгож болно. Мөн Засгийн газраас томоохон бүтээн байгуулалт хийж байгаа ААН-үүдийн бүтээн байгуулалт хийж байгаа эдийн засаг идэвхжиж байгаа энэ үед импорт бол оны эхнээс хойш 26 хувиар өсөөд явж байгаа нь л энэ эдийн засаг сэргэж байгаагийн төсөв нэлээн томоохон хөрөнгө оруулалт хийж байгаагаас л хамаарч байгаа учраас мэдээж ханш нь.

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүн тодруулъя, тодруулж асууя.

Б.Энхбаяр: Хууль нарийн зохицуулаагүй учраас банкны эзэд компани байгуулж бизнесийн үйл ажиллагаа хийх боломжтой байгаа гэж та хариулж байх шиг байна л даа.

Ер нь Улсын Их Хурал, гишүүд нэг зүйлд анхаарал хандуулах ёстой. Улсын Их Хурал өөрөө энэ журмаар дамжуулж маш их эрхийг байгууллагууд руу өгсөн. Одоо жишээлбэл бид нар энэ мөнгөний бодлого Улсын Их Хурал батална гэдэг энэ ажлыг хийж байгаа юм шиг боловчиг Монголбанк өөрөө мөнгөний бодлоготой холбоотой 33 журмаар энэ харилцаагаа удирдаж байгаа. Санхүүгийн зохицуулах хороо 66 журмаа өөрсдөө гаргаж Монголын санхүүгийн зах зээлийг удирдаж байгаа. Зөвхөн энэ 2 байгууллага 99 журмаар өөрсдөө санхүүгийн зах зээлийг удирдаж байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ дээр тодруулж хариулт өгөх үү, нэмж хариулах уу? Лхагвасүрэн Ерөнхийлөгч. Энэ нөгөө арилжааны банкнууд бас бүх салбарт бизнес эрхэлж байгаа байдал нь салбарт чөлөөтэй шударга өрсөлдөх боломж хумигдмал байна л гэдэг асуудал байнга яригддаг болчихоод байгаа шүү дээ. Өөрсдийнхөө эрхэлж байгаа салбартаа хямд хүүтэй зээлээр бусад хэсэг нь асар өндөр хүүтэй зээлээр бизнес хийж байна. Харилцан адилгүй байна өрсөлдөөн бий болж чадахгүй байна л гэдэг асуудал байнга яригддаг болчихоод байгаа юм.

Хоёр дахь нь энэ улс төр дагасан эдийн засгийн бодлого гээд зүйл. Монголбанк барьж ажилладгаа боль. Эдийн засгийнхаа нөхцөл байдалд тааруулсан улс төрийн бодлогыг гаргаж хэрэгжүүлдэг бол гэдэг зүйлийг яриад байгаа юм. Тэгэхээр ийм юман дээр Лхагвасүрэн Ерөнхийлөгч онцгой анхаарах хэрэгтэй. Ялангуяа төсөв их хэмжээгээр тэлж байна. Энэ Улсын Их Хурал, Засгийн газраас гаргаж байгаа бодлого шийдвэрүүд эрсдэлгүй алдаа дутагдалгүй байх тал дээр

Монголбанк яг өөрийн байр суурийг хатуу барьж байх ёстой. Өнөөдөр улс төрөө дагуулж асуудалд хандаж явсны дараа гарах эрсдэл үр дүнг ард түмэн үүрнэ. Тийм учраас аливаа асуудал дээр байр сууриа тодорхой илэрхийлж яваарай гэдгийг хэлье ээ.

Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд өнөөдөр бид нар 2025 оны Монголбанкны мөнгөний төрөөс баримтлах бодлогын үзэл баримтлалыг ингээд хэлэлцэж байна. Тэгээд яг энэ хэлэлцэж байгаа асуудлыг их сайхан хэвлээд ингээд оруулаад ирсэн. Бүр ийм боть ном болгоод. Тэгээд энэ бүтэц их зөв байна л даа. Ер нь бол зорилгоо хийгээд дэд зорилт руугаа хийгээд, стратегиудаа гаргаад тэгээд хэрэгжүүлэх арга хэмжээ гээд хийчихсэн. Гэхдээ агуулгын хувьд ерөөсөө зорилт нь дэд зорилтоо, тэгээд стратегиуд нь хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь ерөөсөө агуулгын хувьд яг адилхан. Тухайлбал энэ хэрэгжүүлэх арга хэмжээ гээд байгаа чинь шаардлагатай өөрчлөлт шинэчлэлүүдийн саналыг боловсруулна, мэдээллийг удирдах арга хэмжээнд зохион байгуулж эхэлнэ. Бодлогын арга хэмжээг тухай бүр авна гээд.

Өөрөөр хэлбэл одоо энэ 2025 оны улсын төсөв хэлэлцэгдэж байна. Улсын төсвөөр бол сангийн бодлого буюу энэ тэлэх асар их том бодлого яригдаж байгаа. Их хэмжээний хөрөнгө оруулалтууд хийх их хэмжээний зээл авч барилга зам барих, их хэмжээний томоохон төслүүдийг хэрэгжүүлэх гээд ингээд олон маргаантай яригдаж байгаа энэ тодорхой болчихсон үед энэ бодлогыг тосож валютын ханшийг тогтвортой байлгах, энэ бодлогуудыг тосож инфляцыг тогтвортой байлгах яг тодорхой саналууд бол орж ирээгүй. Дандаа нэг ийм онолын арга зүйн тэгээд яг хэрэгжүүлэх арга хэмжээ нь тухай бүр бодлого баримтална гэсэн байна. Би эндээс яг ямар арга хэмжээ авах гээд байгааг нь ерөөсөө олж харсангүй.

Тийм учраас энэ ялангуяа зам гүүр бариад их хэмжээний зээл авах гэж байгаа энэ валютын урсгал орж ирэнгүүтээ буцаад гарах гэж байна. Энэ манай мөнгөний бодлогод яаж нөлөөлөх юм. Үүнийг сөрсөн валютын ханшийг тогтоон барих инфляцыг буулгахгүй байх яг ямар тодорхой ажлууд арга хэлбэрүүдийг бодож байна вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Ерөөсөө манай Монголын Улсын маань зээлийн бүтцийг авч үзэх юм хэрэглээний зээлээ дэмжсэн, хэрэглээний зээл нь ихсэх юм бол нь импорт нь ихэсдэг. Импорт нь ихэсдэгээрээ валютын нөөц гадагшилдаг. Ерөөсөө энэ циклээсээ хэзээ гарах юм бэ? Яагаад энэ үйлдвэрлэл бизнесийн тохиромжтой нөхцөл зээлүүдийг бий болгож тодорхой хэмжээний үйлдвэрлэлийг дэмжиж байж дотоодын хэрэглээгээ дотоодоосоо хэрэглүүлэх буюу мөнгөний бодлогоо дотроо эргүүлэх ялангуяа валютын ханшаа дотроо барих ийм бодлогууд яг одоо энэ 2025 оны мөнгөний бодлого дээр хаана юу гэж туссан байна? Ямар үр дүнд хүрэх вэ?

Гуравдугаарт ерөөсөө энэ үзэл баримтлал гаргаж ирж байгаа чинь тодорхой зорилготой л байх ёстой. Ямар амжилтад хүрэх юм? Яг хэд дээр барих юм? Юу гэсэн арга хэмжээнүүдийг хувилбартайгаар төлөвлөж байгаагаа ингээд маш тодорхой тусгахгүйгээр дандаа ийм өгүүлбэр зүйн байдлаар зорилттойгоо бараг адилхан шахуу өгүүлбэрүүдийг тавьчхаад байна.

Гуравдугаарт, ерөөсөө энэ дампуурч байгаа банкнуудыг ярихаараа дандаа төрийн авах мөнгөнүүдийн тухай ярьж байна. Энэ дээр Дамдинням гишүүн нэлээн санаачилгатай ярьж байх шиг байна. Нэг талаасаа тийм. Нөгөө талаасаа одоо яг энэ Чингис Хаан, Капитал Үндэсний Хөрөнгө оруулалтын банкн дээр хадгаламж хэлбэрээр юм уу эсвэл мөнгөө байршуулчихсан авч чадахгүй байгаа хэдэн иргэд байгаа вэ? Тэд нарын хохирлыг хэрхэн барагдуулж байгаа вэ? Энэ цаг хугацааны төлбөрийг нь юу гэж үзэж байгаа вэ? Яагаад энэ банкнууд төлбөрийн чадваргүй болчихсон байхад өнөөдрийг хүртэл нэг талд нь багтааж шийдэхгүй ингээд гацаагаад байгаа вэ? Энд ямар хүмүүсийн нөлөөлөл ороод байдаг юм? Энэ талаар нэг тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна. Арилжааны банкны зээлийн хүүг бууруулах тухай.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут Түвшин гишүүнд өгье.

Б.Түвшин: Арилжааны банкнуудаа яг мөнгөний бодлогоор Монголбанк өөрөө бүрэн удирдаж чадаж байгаа юу? Энэ дээр ямар эрх зүйн зохицуулалтууд хэрэгтэй бай энэ вэ? Арилжааны банктэйгээ зэрэгцүүлээд Төрийн банк зэрэг яг төрийн өөрийнх нь 100 хувийн эзэмшдэг банкнуудыг оруулаад ирсэн. Эд нарын энэ давхцалыг яаж арилгах юм? Арилжааны банкнуудыг арилжааны болгож бодлогоор удирдах эрх зүйн зохицуулалтын талаар одоо энэ дээр баримталж байгаа үзэл баримтлал дээр яг ямар тодорхой заалтууд орж ирсэн бэ? Энэ 5 асуултдаа хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Түвшин гишүүний асуултад хариулъя.

Улсын төсөв бол 2025 онд татвараараа нэмүү өртгийн татвараараа ч юм уу, ашигт малтмал ашигласны татвараараа ч юм уу ямар орлого олох вэ тэрийгээ юунд зарцуулах вэ гэдгээ нэг жилээрээ угаасаа ингээд төсөв нь зохиогдоод ингээд явж байгаа. Тийм учраас яг яах вэ гэдгээ ингээд тодорхой хэлдэг. Эдийн засаг бол өөрөө ингээд динамик Монголбанкны мөнгөний бодлого өөрөө гарсан шийдвэр ингээд нэг жил 9 сарын 3 улирлын ингээд дараа нь нөлөөлөл нь гарч ирдэг гэдгээрээ ерөнхийдөө дунд хугацааны ийм бодлогын чиглэл явж байгаа.

Тэгэхээр энэ бол одоо төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл гэдгээрээ ингээд явж байгаа. Яг тийм нарийн тоо нь тийм байна, инфляц нь тэд байна ханш нь тэд байна, нөөц нь тэд байна тийм хэмжээний доллар яг орж ирнэ. Тэгээд тэр нь тийм төлбөрт явна гэдгээрээ тийм нарийн юмыг яг өнөөдөр шууд ингэж хэлэх боломж байхгүй учраас тухайн үеийнх нь нөхцөл байдалд нь тааруулаад ингээд шийдвэрээ гаргаад явж байгаа. Тэр ч утгаараа одоо ингээд олон улсын төв банкнууд АНУ-ын төв банк жилдээ 6 удаа хуралдаад бодлогын шийдвэрээ гаргах ч юм уу. Монгол Улсад манай өнөөдөр Монголбанкны хууль дээр бол улиралдаа нэг удаа ээлжит хурлаа хийнэ. Дунд нь ээлжит бусаар хуралдаж шийдвэрээ гаргаж болно гэдгээрээ ингээд явж байгаа.

Тэгэхээр яг л цаг үедээ таарсан тухайн үеийнх нь нөхцөл байдалд тохирсон ийм шийдвэрийг гаргаж байгаа. Бидний хувьд бол яг тухайн цаг үед нь таарсан тэр сценари шинжилгээнүүдийг бол байнга хийж явдаг. Яг өнөөдөр яг ямар шийдвэр гаргаад энэ нь өөрөө ямар үр дүнгээ өгч байна. Хаашаагаа явж байна, зөв байна уу,

буруу байна уу гэдгээ тухай бүрд нь ингээд шийдээд явдаг учраас бол энэ дээр энэ хийдэг ажлаа л ерөнхийдөө ингээд тусгаад өгсөн байгаа. Ерөнхийдөө тэр 2019 онд ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад активын чанарын үнэлгээг хийсэн байгаа. Европын Төв банкны аргачлалын дагуу. Тэгээд тухайн активын чанарын үнэлгээ хийхэд бол өнөөдрийн дурдагдаж байгаа энэ капитал Чингис хаан Үндэсний хөрөнгө оруулалтын банк дээр өөрийн хөрөнгийн дутагдалтай байна энийг нь нөхүүлье ээ гэдгээрээ арга хэмжээ авсан. Капитал банкны хувьд өөрийн хөрөнгө нэмэгдэж чадаагүй учраас бол тэр 2019 оны 4 сарын 8-ны өдөр бол энэ банкныг хаагаад ингээд яваад Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хувьд бол өөрийн хөрөнгийн дутагдал нь багахан хэмжээтэй байсан. Тэгээд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхээр ийм тогтворжуулах төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа тухайн 2 банк дээр бол хянагч ажиллаад явж байна. Энэ хугацаанд бол тухайн банкнуудын хувь хүмүүстэй холбоотой өр төлбөрүүд нь барагдаад явж байгаа. Чингис хаан банкны хувьд бараг хувь хүний өр гэж бараг байхгүй болсон. Зөвхөн одоо төрийн гэдэг юм уу тэр нийгмийн даатгалын сангийн, ЭМД-ын сангийн төрийн өмчтэй компаниудын өр л энд үлдчихсэн байж байгаа. Ингээд жижиг банкнууд дээр бол хувь хүмүүс, хувийн секторын өрнүүд нь ерөнхийдөө тухайн банктайгаа тохиролцоод актив хөрөнгөөр барагдуулдаг юм уу бэлэн мөнгийг нь орж ирсэн дарааллаар аваад явсаар байгаад ерөнхийдөө ингээд гайгүй болоод явж байгаа учраас.

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Тэгэхлээр төсөв хэлэлцэж байгаа яг энэ үед шинжилгээнүүд хийж байгаа гэж байгаа. Тийм байх. Магадгүй шийдвэрүүд нь 1-ээс 1.5 жилийн дараа дунд хугацааны дагуу зорьж байгаа нь үнэн байх. Гэхдээ яг одоо 2025 оны мөнгөний үзэл баримтлал хэлэлцэж байгаа үед энэ төсөв энэ чиглэлээр баримт батлагдах нь тодорхой болчихсон байгаа үед Монголбанкнаас оруулж ирж байгаа төрөөс баримтлах мөнгөний үзэл баримтлал нь энэ одоо сангийн тэлж байгаа бодлогыг сөрсөн инфляцыг хадгалах, валютын ханшийг тогтоон барих тийм чадвар чадамж бодлого энэ дотор би харагдахгүй байна гэж үзээд байгаа. Тэгээд магадгүй харж чадахгүй байж магадгүй. Тэгэхлээр одоо сангийн бодлогын хувьд тэлэх нь тодорхой болчихсон. Орлогоо маш өөдрөгөөр төсөөлчихсэн гэж бид нар яриад байгаа.

Гэтэл энэ түүхий эд материалууд буюу манай ялангуяа гол экспортлогч уур уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ ханш унаж байгаа.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч нэмж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Түвшин гишүүн асуултдаа энэ манай бидний тайлан болсон номыг дурдаж байсан. Тэгээд тэрний 89 дүгээр хуудсан дээр инфляцын зорилт түвшнээ бид хэд тодорхойлоод эрсдэлүүдийг тодорхойлсон байгаа. Тэр нэлээн ийм яг точный үзүүлэлтүүд нь зураасаар, тэгээд дараа нь цаашдаа ингээд ямар нэг нөлөөллөөр төсвийн өргөн барьсан дүнгээр батлагдах тохиолдолд цахилгаан дулааны үнэ өсөөд үнийн дам нөлөө орж ирсэн тохиолдолд нүүрсний үнэ буураад экспортын орлого буурсан тохиолдолд ерөнхийдөө ямар аль тал руугаа хазайгаад явах вэ гэдгээрээ биднүүс төсөөллөө л хийгээд явж байгаа. Тэгээд бидний хувьд бол 2025 онд инфляцынхаа зорилтот түвшнийг 6+ -2 хувьдаа барих боломж нь байна гэдэг нь манай энэ дүн шинжилгээний энэ тооцооллын хувилбаруудаас л харагдаад байгаа л даа. Тэгээд тийм утгаараа л ингээд зорилт болгоод ингээд гол нь инфляцынхаа зорилтыг тавьж байгаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна аа.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе ээ.

Би Монголбанкыг өмнөө тавьсан зорилтоо биелүүлж ажиллаж байгаа л гэж ингэж дүгнэх гээд байгаа юм. Тэр 2021 оны тэр хүнд үе, 2022 он энэ инфляц тэр өндөр байх үе энэ бодлогын хүүгээ хатуу байх зайлшгүй шаардлага байгаа талаар тайлбарлаж байсан. Тэгээд эргээд харахад бол одоо төгрөгийн ханш бас алдсангүй. Инфляц тодорхой хэмжээнд буугаад явж байна. Гадаад валютын албан нөөц бас түүхэнд байгаагүйгээр нэмэгдэж байгаа. Мэдээж олон хүчин зүйл нөлөөлж байгаа. Тэгээд Пүрэвдорж гишүүний хэлдэг Монголбанк бол тийм бас мэргэжлийн чиг баримжаатай ийм нарийн алба учраас би нэг тодорхой 3 асуулт асууя л гэж ингэж бодож байгаа юм.

14 хоногийн өмнө Монгол Улс 10 жилийн дараа буюу 2014 оноос хойш зээлжих зэрэглэл тааруухан дүнтэй явж байгаад 10 жилийн дараа нэг зээлжих зэрэглэл нь ахисан. Дагаад бас Монголбанк Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нь арилжааны банкнуудын зээлжих зэрэглэл өсөж байгаа гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгэхээр ингээд зээлжих зэрэглэл өсөөд ирэхээр ер нь эдийн засагт, банкны салбарт, мөн арилжааны банкнуудад гадаад зээлийн эх үүсвэрүүд яаж орж ирэх вэ? Ийм урсгал нэмэгдэж байгаа, гарц нэмэгдэж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Энэ нь зээлийн хүү рүү яг шууд яаж нөлөөлөх вэ? Энэ бизнес эрхлэгчдэд маш таатай нөхцөл бүрдэж байгаа гэж ингэж харж байгаа. Би тэгээд Монголбанкыг энэ талаас нь нэг тайлбар хэлж өгөөч ээ гэж ингэж 1 дүгээрт хүсэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт олон төсөл хөтөлбөрүүдийг энэ арилжааны банкнуудтай төр нийлж хэрэгжүүлж байгаа. Ялангуяа ХАА-н салбар дээр энэ хүнсний хувьсгал, энэ цагаан алт мөн энэ шинэ хоршоо гээд эд нарын эх үүсвэрүүд ирэх 2025 оны төсөв дээр тусгагдаад явж байгаа. Тэр дундаа шинэ хоршоо хөтөлбөр дээр 500 тэрбум төгрөгийн эх үүсвэр одоо шинээр тавигдаж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Тэгэхээр одоо он гараад энэ шинэ хоршоо хөтөлбөрийн энэ санхүүжилтүүд арилжааны банкнуудаар олгогдоод ирэхээр яг орон нутагт бол Хаан, Төрийн гэсэн 2 банкаар л олгогдоод байгаа. Тэгэхээр энэ одоо өнгөрсөн хугацаанд шиг бас нэг тийм хугацаа алдах шийдвэр удах ийм зүйлүүд гарах вий. Энэ дээр бас Монголбанк арилжааны банкнуудтай ямар хэлцэл юмнууд хийж байгаа вэ гэсэн 2 дахь асуулт.

Гурав дахь асуулт бол ипотекийн зээлийн асуудлууд их яригдаж байгаа. 2025 оны төсөв дээр 1.2 их наяд төгрөг тавигдаж байгаа гээд энэ бол анх удаа гарч байгаа юм. Би зарим нэг газруудаас гүйцэтгэл авсан. Өнгөрсөн хугацаанд өгч байсан ипотекийн зээлүүдээс бол хамаагүй ихээр олгогдож эхэлж байгаа юм билээ. Тэгэхээр энэ 1.2 гэдэг бол өшөө ч нэмэгдэнэ гэж ингэж харж байгаа. Тэр дундаа орон нутаг руу гээд ингээд аваад үзэхээр энэ чинь 600, 700-аад тэрбум төгрөгийн асуудлууд яригдана. Улаанбаатар хотод орон сууц руу олгоод, хөдөө орон нутаг руу тодорхой хэмжээг нь амины орон сууц руу олгох асуудлууд яригдаж байгаа. Энийг бол ялангуяа аймгийн төвүүд дээр ер нь хөдөө орон нутагт маш олон хүмүүс чих даран хүлээж байгаа. Тэгээд энэ яг ямар дүрэм журам боловсруулагдсан уу, хэзээ энэ үйлчилж эхлэх вэ гэдэг нэг ийм зүйлийг асуух гэж байгаа юм. Яагаад гэвэл инженерийн шугам сүлжээ нь тавигдчихсан хашааных нь хойд урдуур явж байгаа энэ хүмүүс заавал өндөр хүүтэй орон сууц руу орохгүйгээр өөрийнхөө хашаанд

өөрийнхөө орлогод нийцсэн тохитой орон сууцыг бариад амьдрах бололцоо энэ аймгийн төвүүдээр нээгдэж байгаа. Тэгээд би энийг яаж харж байна вэ гэхээр заавал орон сууцад орж тэр өндөр хүүтэй мөнгө төлж 40м², 45 метрийг авч байхаар тэрнээс бага үнээр хашаандаа сайхан амьдрах бололцоо л энэ барих бүрэн дүүрэн бололцоо байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол асар олон хүний бас хүлээлт байгаа юм аа.

Тэгэхээр энэ яг дүрэм журам нь бэлэн болж байгаа юу яаж байгаа вэ гээд.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын танхимд хүндэт зочин ирсэн байна. Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Өнөөдөр Монгол Улсад Монгол Улсын Их Хурлын ээлжит чуулганы хуралдаанд Австралийн Холбооны Улсын Парламентын Сенатын ерөнхийлөгч Сюзен Лаянс тэргүүтэй зочид хүрэлцэн ирсэн байна аа. Та бүхэндээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс чин сэтгэлээсээ талархал дэвшүүлж Монгол Улсад тавтай морилохыг урьж байна аа.

Австралийн Сенатын танхимын Ерөнхийлөгч таны Монгол Улсад хийж буй энэхүү айлчлал нь Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын хүрээнд манай 2 орны найрсаг харилцааг бататган бэхжүүлэх, улс төрийн яриа хэлэлцээг үргэлжлүүлэх, 2 улсын хууль тогтоох дээд байгууллага хоорондын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг цохон тэмдэглэхэд таатай байна аа.

Цаашид 2 улсын харилцаа хамтын ажиллагаа иж бүрэн түншлэлийн түвшинд хүрч бүхий л салбарт улам өргөжин хөгжиж иргэд хоорондын харилцаа улам бэхэжнэ гэдэгт итгэлтэй байна аа.

Эрхэм хүндэт Сенатын ерөнхийлөгч хатагтай Сюзен Лаянс танд болон энд хүрэлцэн ирсэн Австралийн парламентын эрхэм гишүүд, төлөөлөгч та бүхэнд дахин талархал илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье.

Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулья.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулья.

Тийм энэ 2012 оноос хойш буураад явж байсан зээлжих зэрэглэл ингээд сайжраад явж байгаа. Хамгийн эхлээд Фитч агентлаг сайжруулсан дараа нь SNBI сайжруулсан. Ингээд дэлхийд ер нь 3 том компани байдаг. Тэгээд ингээд энэ ондоо дүнгээ гаргачих байх. Тэгээд ер нь буцаад бид нар яг эдийн засаг бараг 17.5 хувь өсөж байсан тэр дүн дээрээ ингээд буцаад оччихож байгаа юм. Энэнээс цаашаа ч сайжрах боломжууд нь бол манай эдийн засаг цаашаа сэргээд явах юм байгаа. Тэгэхлээр угаасаа хувийн ААН-үүд дээр бол улсын зэрэглэлээс өндөр оноо ер нь тавигддаггүй. Тэр утгаараа улсын зэрэглэл өндөр болно гэдэг маань хувийн ААН-үүд оноогоо өндөрсгөх боломж гардаг. Тэр утгаараа манай арилжааны банкнууд бүгдээрээ улсын зэрэглэлтэй адилхан оноо авч байгаа. Зэрэглэл сайжрахын сайн тал нь гэвэл нөгөө эрсдэл багасаж байна гэдэг утгаараа хүү буурч эхэлдэг. Тэгэхлээр хүү ингээд буураад явж байгаа. Бидэнд авсан мэдээллээр оны эхэнд оны эхээр гаргаж байсан бондуудын өгөөжүүд зах зээл дээрээ буугаад нэг оронтой тоо руугаа орчихсон байна лээ. Тэгэхлээр бол ер нь удахгүй одоо Улаанбаатар хот

нөгөө бүтээн байгуулалтдаа бонд гаргах гэж байгаа. Тэгээд бондын тэр хүү бол нэлээн бага орж ирнэ гэдэгт Төв банкны зүгээс итгэлтэй байгаа юм. Тэгэхээр энэ мэдээж сайн нөлөөтэй. Тэгэхлээр эхнээсээ эх үүсвэрийн хүү бага ороод ирж байгаа учраас цаашаа гарах зээлийн хүү буурах боломжтой. Тэгээд ногоон бондууд байна. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгож байгаа зээлийн хүүнүүд бол ерөнхийдөө зээлийн дундаж хүүнээс доошоо орсон байгаа.

Тэгэхээр энэ нарийн нэлээн бүх банкны судалгаануудыг би танд тусад нь өгчихье. Хүнсний хувьсгал шинэ энэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой зээлүүд орон нутагт нэлээн гарч байгаа. Тэгэхдээ манай орон нутагт байгаа ерөөсөө үйл ажиллагаа явуулдаг хоёрхон л банк байдаг. Сум болгон дээр салбартай. Тэгэхээр угаасаа л тэр 2 банкаар малчны зээл ч гарч байгаа, хоршооны зээл ч гарч байгаа. Зарим банкнууд бол аймгийн төвүүд дээр салбартай байдаг. Тэгээд бидний хувьд бол шинээр тэр аймгийн төвийн салбараас нь зээл олгох энэ ажлыг зохион байгуулахаар болж байгаа. Сүүлд банкнууд 2 олгож байгаа банктэйгээ хийсэн уулзалтаараа энэ нийт зээлийн жишээлбэл хоршооны зээл дээр харахад бол нийт олгосон зээлийн 50 хувь нь мал худалдаж авахад зориулж байна лээ. Тэгэхээр энэнээс нь болоод гэрээн дээрээ үржлийн мал гэгчихсэн байсан. Тэгэхээр зөвхөн эцэг мал авахаар юм шиг ийм зохицуулалт байсан энийг нь өөрчлөхөөр тэгээд өөр өмнө нь авчихсан зээлээ дахин санхүүжүүлэх боломж олгооч гэж. Малчдаас гаргасан саналын дагуу ингээд өөрчлөөд явж байгаа учраас энэ хоршооны зээл энэ зээлүүд идэвхжиж явна л гэж харж байгаа юм.

Ипотекийн зээлд бол Монголбанк 10 сарын 9-нөөс эхлээд өөрийнхөө журам дотор амины орон сууцыг ипотекийн зээлд хамрагдахаар ингээд оруулчихсан байгаа. Тэгэхээр амины орон сууцтай холбоотой стандартыг нь БХБЯ-наас гаргах юм. Тэгэхээр би энэ дээр Батсуурь сайд нэлээн дэлгэрэнгүй бас юу өгөх байх. Монголбанк өөрийнхөө журам дотор амины орон сууц гээд оруулчихсан байгаа.

Д.Амарбаясгалан: Батсуурь сайд нэмж хариулъя.

Ж.Батсуурь: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Сая Лхагвасүрэн Ерөнхийлөгч ярилаа. Амины орон сууцыг ипотекийн зээлд хамруулах талаар бүх хүн хүсэж байгаа. Энэ дээр хэд хэдэн асуудлыг шийдэхгүй бол болохгүй байгаа юм. Барилгын тухай хуулийг ойрын хугацаанд өөрчлүүлэхээр бид нар ажилдаа ороод байна. Хот байгуулалтын тухай хуулийг мөн Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийг нийтэд нь бол Барилгын салбарын багц хууль гэж энэ хуулийг батлах юм бол эрх зүйн орчин нь нээгдэх юм байгаа юм. Дээр нь амины орон сууцад ипотекийн зээл өгөхөд бол нэг л зүйлийг анхаарах ёстой. Яагаад вэ гэхлээр газар хөдлөлтөд тэсвэртэй дулааны алдагдалгүй л байх ёстой.

Өнөөдөр Монголчууд олж байгаа мөнгөнийхөө ихэнх хэсгийг дулаандаа алдчихаж байна. Яагаад вэ гэхлээр амины орон сууц харахад гоё байшин суухад одоо зун намар байдаг. Өвөл яаж байна вэ гэхлээр шалаараа дулаан алддаг, 4 ханаараа дулаан алддаг, дээврээрээ дулаан алддаг.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Батсуурь сайд гүйцээж хариулъя.

Ж.Батсуурь: Тэгэхээр энэ талын стандартыг бид нар батлуулахаар ажлын хэсэг бий болж байна. Тэгээд саяын 3 хууль барилгын тухай багц хууль

батлагдахлаар яг амины орон сууцын стандартыг баталчих юм бол тэр стандартад тохирсон амины орон сууцууд ипотекийн зээл авах боломжтой л болно гэж ингэж ойлгох ёстой. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Монголбанк суурин инфляцыг 2025 онд ойролцоогоор 7.7 хувь байхаар төсөвлөжээ. Гэтэл эрсдэлийг тооцсон нэг дэх хувь буюу 2025 оны төсвийн зардал Улсын Их Хуралд өргөн барьсан дүнгээрээ батлагдсан тохиолдолд 1.3 хувь нэмэгдэж 9 хувь болно гэж байгаа. Тэгэхээр Монголбанкныхан яг энэн дээр энэ төсөв тэлж байгаа дээр бараг 21 орчим хувиар өмнөх оныхоос тэлээд орж ирж байгаа юм байна. Энэн дээр ямар байр суурьтай байна? Энэн дээр яг түрүүн Их Хурлын дарга хэллээ.

Монголбанк өөрөө бие даасан яг энэ дүгнэлтүүдийг Их Хурлын гишүүд болон нийгэмд ч гэсэн нэг хэлж байх нь зүйтэй байна. Энэн дээр ямар байр суурьтай байна? Нэгд асууя.

Хоёрт гэх юм бол энэ зээлийн хүүг бууруулах асуудлаар олон жил ярьж байна аа. Улсын Их Хурал дээр хүртэл энэ стратеги төлөвлөгөө ч билүү батлах нэг тийм юм гарч байсан. Зээлийн хүүг бууруулах стратеги батлах 21 дүгээр тогтоол гарсан. Энэ тогтоолын хэрэгжилт ер нь ямархуу байна. Засгийн газрын зүгээс болон Монголбанкны зүгээс анхаарал хэр тавьж байгаа вэ? Энэ талаар нэг товч мэдээлэл Монголбанкнаас авмаар байна.

Гуравдугаарт нь гэх юм бол Монголбанк ипотекийн зээлийн асуудлыг олон жил зохицуулж голлох санхүүжүүлэлтийг хийж явж байгаа. Энэ онд ч гэсэн ингээд 2025 он дээр 500 тэрбум төгрөг гаргахаар төлөвлөж байна. Энэ 500 тэрбум төгрөгийн эх үүсвэр хаанаас гарах вэ? Ер нь энэ өнөөдрийг хүртэл Монголбанкнаас ипотекийн зээлд хэчнээн төгрөг зарцуулаад хэдэн төгрөг буцаан эргэн төлөлт нь ямар явж байгаа юм бэ? Энэ талаар мэдээлэл авахгүй бол болохгүй байна.

Нөгөөтээгүүр энэ орон сууцын ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийг Монголбанкнаас Засгийн газарт 2023 оны 2 дугаар улиралд багтаан шилжүүлнэ гэсэн тогтоол гарсан байдаг. Энэ тогтоолын хэрэгжилт яагаад явдаггүй юм. Энэ нь юу болсон юм. Энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

Дөрөвдүгээрт гэх юм бол энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийн 2.1-д банкны салбар дахь гаднын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зохицуулалтын орчныг бүрэлдүүлэхээр заажээ. Энэ ер нь хуульд өөрчлөлт орчихсон байгаа. Яагаад гаднын хөрөнгө оруулалт орж ирэхгүй байгаа юм гаднын банкнууд Монголыг сонирхохгүй байна. Энэ дээр бас Монголбанкны Ерөнхийлөгч хариу өгөөч ээ.

Тавдугаарт нь мөн төслийн 3.2-т гадаад дотоодын хөрөнгө оруулагчид төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх суурь нөхцөлийг бүрдүүлэх талаар дурдсаныг тайлбарлаж өгөх хэрэгтэй байна. Яг төгрөгөөр хөрөнгө оруулалт татах гаднын дотнын хөрөнгө оруулалт татна гэсэн байна. Монгол Улс өөрөө экспорт, импортын байдал ямар байгаа билээ. Импортоос хараат орон. Тэгээд энэ дээр ямар зорилгоор энэ 3.2 дахь заалтыг оруулж ирсэн юм энийгээ нэг хариулж өгөөч гэж байгаа юм.

Хамгийн сүүлд гэх юм бол Монголбанк дээр бизнесийн орчныг хэрхэн яаж дэмжих гэж байгаа юм бэ? Өнөөдөр бизнесийн зээл 22.1 хувь гэдэг Монгол Улсын хөгжил бол гацаж байна л гэсэн үг. Татвар төлөгч нартаа бодлогоор Монголбанк дэмжлэг үзүүлэхгүй байгаа юм биш үү гэсэн ийм нэг үндсэн 6 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Баярдаваа дарга.

Б.Баярдаваа: Очирбат гишүүний асуултад хариулъя.

Чухал чухал асуудлуудыг хөндөж байгаа. 1 дүгээрт нь төсвийн бодлогын хувьд нэлээд мөнгөний бодлогын орон зайнд тийм дарамт учруулж байгаа гэдэг утгаараа төсвийн ийм нөлөөллийг бол энэ тооцоо судалгаандаа оруулаад таны түрүүний хэлж байгаа тэр хүснэгт дээр тодорхой харуулсан байгаа. Тэгэхээр инфляцад ирж байгаа ханшид ирж байгаа энэ дарамттай уялдуулаад ирэх жилийн мөнгөний бодлогын хорооны ээлжит болон шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлуудаар мөнгөний бодлогын тохируулгуудыг хийгээд явна аа.

Хоёр дахь асуултын хувьд тэр зээлийн хүүн дээр нөлөөлж байгаа гол гол хүчин зүйлүүд бий. Энэ дээр бол бид нар нэлээд их ярьж байгаа учраас системтэйгээр 2 ингэж хүчин зүйлийг ангилж авч үзвэл зүгээр юм болов уу гэж бодож байна.

Нэгдүгээрт нь зээлийн хүү буурахад тухайн улс орны макро эдийн засгийн тогтвортой байдал байж байж ер нь бол зээлийн хүү буурдаг. Тэгэхээр энэ нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг инфляц, валютын ханш, эдийн засгийн савлагаа, ийм зүйлүүдээр хэмжиж үзээд олон улсын энэ судалгаануудыг хийгээд үзэхээр бас яг энэ нь батлагдаж харагдаж байгаа.

Хоёрдугаарт нь 2 дахь хүчин зүйл бол санхүүгийн зах зээлийн өөрийнх нь хөгжилтэй холбоотой бас энэ том нөлөөллүүд харагдаж байгаа. Нэг ёсондоо санхүүгийн гүнзгийрэл гэдэг зүйл зээлийн хүүг өөрийг нь бууруулдаг юм байна гэсэн ийм зүйл харагдаж байгаа. Түүнтэй холбоотойгоор зохицуулалтын орчин дээр ээр энэ зээлийн хүүг буурахад нэлээд том өөрчлөлтүүд гарах ёстой байгаа.

Дамдинням гишүүний түрүүний хөндөж ярьж байсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуультай холбоотой чанаргүй зээлийг хурдан шуурхай барагдуулж үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр барагдуулахдаа энэ процессыг хурдлах юм бол зээлийн хүүн дээр нэлээд том нөлөө үзүүлэхээр байгаа. Өөрөөр хэлэх юм бол банкнуудын эрсдэлийн сантай холбоотойгоор зээл, сангийн зардал нь банк зээлийн хүүгийн 10-аас 17 хувийг бүрдүүлж байгаа гэж ийм тооцоо судалгаа гарсан байдаг.

Тэгэхээр энэ нь үндсэндээ барьцаа хөрөнгийг барагдуулах энэ барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах энэ үйл явц дунджаар 4 жил цаашил бүр 8 жилийн хугацаатай явж байгаа. Энэ зардлууд өөрөө бусад сайн зээлдэгч нарынхаа зээлийн хүүд зардал нь ингэж тусаж зээлийн хүүгийн дарамтыг нэмэгдүүлдэг.

Гурав дахь асуудлын хувьд ипотекийн зээлийн хувьд 1-ээс 1.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг ирэх ирэх жил төлөвлөж байгаа. Үүний 500 нь

Монголбанкнаас гаргаж байгаа эх үүсвэр гэж байгаа боловч энэ нь үндсэндээ өмнөх зээлдэгч нарын зээлийн эргэн төлөлтөөс эргүүлэн эдийн засаг руу ингэж нийлүүлж байгаа мөн эх үүсвэр байгаа. Нөгөө талаасаа хуримтлалын сангаас Баялгийн сангийн тухай хуулийн дагуу хуримтлалын сангаас 500 орчим тэрбум төгрөг энэ эх үүсвэрт нийлүүлэгдэнэ ээ гэж энэ тооцоо судалгааг хийсэн байгаа.

Нийтдээ бол олгосон зээлийн дүн 8.8 их наяд төгрөг. Үүнээс 4 их наяд төгрөг нь Монголын ипотекийн Корпорац руу шилжиж үнэт цаасжуулагдсан байгаа. Энэ үнэт цаасны эргэн төлөлт нь өөрөө дараагийн зээлийн эх үүсвэр болж ашиглагдаж байгаа. Одоо олгосон байгаа зээлийн үлдэгдэл бол 4.7 их наяд төгрөгтэй байгаа. Гаднын банкны хувьд бол өмнөх асуулт дээр хариулсанчлан ер нь нэлээн хэд хэдэн асуудлууд бий. Тухайлах юм бол Банкны тухай хууль дээр гадаадын тэр банкны тухай хуулийн хувь эзэмшлийн хувь хэмжээн дээр.

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Би бүүр тодорхой Монгол Улсын Их Хурлын тогтоолыг тогтоолын биелэлтийг асуугаад байгаа шүү. Ингээд тойруу хариулаад байх юм.

Энэн дээр бүүр зааснаар 2023 оны эцэс гэхэд зээлийн хувьд нэг хувьд хүргэхээр ингээд тогтоол гарчихсан байгаа. Энэн дээрээ нэг тодорхой хариулаадааа, нэг.

Хоёрт гэх юм бол дахиад би энэ Монгол Улсын Их Хурлын 65 дугаар тогтоолыг асуугаад байгаа. Орон сууцын ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагын дагуу бэхжүүлж хөтөлбөрийг Монголбанкнаас Засгийн газарт 2023 оны 2 дугаар улиралд багтаан шилжүүлэх гээд ингээд тогтоол асуугаад байгаа юм.

Гуравдугаарт гэх юм бол энэ тэр бизнесийн орчныг сайжруулах тал дээр хариултаа нэмээд авчихмаар байна.

Яагаад энэ бизнес буюу татвар төлөгч нар өнөөдөр 22.1-хэн хувийн зээл аваад байдаг юм? Энэ дээр ямар бодлогоор дэмжлэг үзүүлж байгаа юм? Монголбанк ямар бодлого барьж байгаа юм? Дахиад энэ татвар төлөгч нар чинь байхгүй бол энэ төсөв гэж байхгүй болно. Энэ улс эх орны хөгжил чинь гацаад зогсчихно шүү дээ. Тэгээд тодорхой хариулъя тэгэх үү?

Д.Амарбаясгалан: Баярдаваа дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Баярдаваа: Ипотекийн зээлийг Засгийн газарт шилжүүлэх энэ тогтоолын хэрэгжилттэй холбогдуулаад өнгөрсөн жилийн төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр тогтоол гаргахдаа Засгийн газарт шилжүүлэх хүртэл Монголбанк цааш нь үргэлжлүүлээд хэрэгжүүлээд яв гэсэн ийм тогтоол гараад тэрнийх нь дагуу Монголбанк ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Зээлийн хүү бууруулах стратегийн тогтоолын үр дүнд яг Ковид-19 цар тахал эхлэхээс өмнө сарын зээлийн хүү нэг хувь руу ерөнхийдөө бол дөхөж ирсэн. Зээлийн дундаж хүү жилийн дүнгээрээ 13 хувьтай ингэж болж ирсэн байгаа. Мэдээж дотроо нөгөө хэрэглээний зээл, бизнесийн зээл зээлдэгчийнх нь санхүүгийн чадавх гэдгээс хамаараад зээл харилцан адилгүй ийм байгаа. Дунджаар бол нэг 13 хувь руу бууж ирсэн. Энэ тогтоолын биелэлтийн

тайланг бол Эдийн засгийн байнгын хороонд улирал болгон Монголбанкнаас гаргаж хүргүүлдэг. Танд тухайлан бид нар хүргүүлье ээ.

Гадаадын банктэй холбоотой банкны хувь эзэмшилтэй холбоотойгоор олон улсын санхүүгийн байгууллагуудаас 20 хувиас гадна 30 хувь 33 хувь.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууя.

Э.Батшугар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Монгол Улсын эдийн засаг болон санхүүгийн өнөөдрийн нөхцөл байдал болон Банкны салбарын хууль эрх зүйн орчны хязгаарыг мэдэж байгаа болохоор та бүхэнд нэг зөвлөмж санал хэлэхийг бодсон юм аа.

Нэгдүгээрт бол зээлийн хүүгийн асуудал бол нэлээн яригдаж байна. Үүнийг бууруулахад хамгийн зохимжтой арга бол түрүүн Эдийн засгийн байнгын хороонд ярьсан.

Нэгдүгээрт Активын удирдлагын компанийг яаралтай байгуулж үүгээрээ дамжуулж нөгөө 20 хувиар бууруулна гэж бололцоотой гэж ярьж байгаа.

Хоёрт бол энэ кредит скоринг болон зээлжих зэрэглэлийг Монгол Улс даяараа нэвтрүүлснээр энэ бол яг зохистой зээлдэгч болон санхүү хариуцлагатай зээлдэгч нараа ялгаад үүгээрээ дамжуулж зээлийн хүү буурах бололцоотой юм. Хөрөнгө оруулалтын зээл гэж яригдаж байна л даа. Энийг нэмэгдүүлэх бололцоотой гэж харж байгаа юм. Яагаад гэвэл та бол Монголбанкны Ерөнхийлөгч. Тушаал гаргаад тэгээд хяналт шалгалтын газартаа үүрэг өгөөд тэр каналаараа дамжуулж банкнуудаа өргөжүүлэх бололцоотой. Яг одоо энэ хэрэглээний зээлийг хязгаарласантай адилхан хөрөнгө оруулалтын зээлийг нэмэгдүүлэх бололцоотой.

Ипотекийн зээлийн талаар бол яг зорилтот бүлэгт орж байна уу гэж ярьж байна. Ялангуяа одоо бараг 40 хувь нь Батнайрамдал гишүүн ярьж байна. Хан-Уул дүүрэгт очоод байна. Энэ ипотекийн зээлийн үндсэн зорилго нь бол анх удаа орон сууц авч байгаа иргэд болон залуучуудад зориулсан. Тэгэхээр ипотекийн зээлийн журам гэж байгаа та мэдэж байгаа.

Үүнийг дахиж хараад өөрчлөлт орох бололцоотой шүү гэж хэлмээр байна аа. Энэ одоо шинээр Мони Маркет Оперэйшн болон хүүгийн мөрийг та бас дурдсан байна лээ. Энэ бол маш чухал зүйл. Монгол Улсын эдийн засагт болон санхүүгийн салбарт.

Тэгэхээр энийг илүү идэвхтэй үргэлжлүүлээд шинээр нэвтрүүлээд тэгээд төв банкны үнэт цаас болчихсон байгаа 9 их наяд төгрөгийг бол яг зах зээлийн эргэлтэд оруулах бололцоотой. Дээрээс нь нэмээд энэ Монгол Улсын бусад ААН-үүд эх үүсвэр татахад нь том бенч марк болно, суурь хүү болно. Ялангуяа вак гэж ярьдаг энэ бүхнийг хийхэд бололцоотой гэж хэлмээр байна.

Энэ гадаадын банк болон бусад санхүүгийн байгууллагууд Монголд төгрөгийн зээл олгох ийм тогтолцоог бүрдүүлнэ гээд дурдсан байна. Энэ маш чухал. Ялангуяа зээлдэгч нар бол долларын зээл авчихдаг. Тэгэхээр эргэж төлөхдөө хүүгийн алдагдалд ордог.

Тэгэхээр бол ямар нэгэн байдлаар санхүүгийн үүсмэл хэрэгсэл болох Хэйжинг инстертментийг Монгол Улсад санхүүгийн салбарт нэвтрүүлэх цаг нь ирчихсэн. Үүн дээр нэлээн идэвхтэй ажиллаарай гэж хэлье. Жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан зээл бол нийлүүлэлтийн сүлжээг санхүүжүүлэх гэж сувгаар дэмжинэ гэж хэлж байна. Гэхдээ бас энийгээ бусад сувгуудаар бодлогын арга хэмжээ авах бололцоотой. Энэ бүхнээ та бүхэн анхаараарай.

Яагаад гэвэл өнөөдөр нийт бүртгэлтэй ААН-үүдийн 97 хувь нь дандаа жижиг, дунд бизнес эрхлэгч нар байгаа. Монгол Улсын ажлын байрыг үндсэн суурийг эзэлж байгаа. Энэ ийм нэг заалт байна л даа. Экспортыг нэмэгдүүлж байгаа импорт орж байгаа ААН-үүдийг хүүг ханшийн бодлогоор дэмжинэ гээд. Энэ чинь нэг ёсны долларын ханшийг чангалаад явахад төгрөгийн ханшийг сулруулна гэсэн үг л дээ.

Тэгэхээр үүгээрээ дамжуулаад эргээд импортын инфляц бол нэмэгдээд бодлогын хүүгээ ахиж чангалах тийм нөхцөл байдал үүсэж болзошгүй эрсдэл байгаа шүү гэж та анхаараарай. CBDC гэж байгаа Central bank digital currency гээд нийт дэлхийд зуугаад Төв банк хэрэгжүүлээд эхэлчихсэн байгаа. Энэ нэг ёсны дижитал төгрөг. Энэ шинэ үндэс дүрмүүдийг нэвтрүүлснээр Монгол Улсын мөнгөний бодлогын хэрэгжилт нь улам тэлж илүү сайжрах бололцоотой шүү гэж хэлье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үндсэндээ санал хэлчихлээ тийм ээ. Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ ирэх жил инфляцын түвшнээ бид нар 5 дээр + -2 хувьд барина гээд. Энэ өргөн баригдсан төсвийн хүрээнд ч тэр төсвийн зардал нэлээн тэлж байна тийм ээ. Тэгэхээр энийг дагаад бодлогын хүү чинь буурахгүй байх мөнгөний бодлого сулрахгүй байх ийм төсөөлөл байж байна шүү дээ. Тэгэхээр энэ нь өөрөө ийм өрөөсгөл дүгнэлт хийгээд та нар ямар арга хэмжээ авна гэж энэ дээр үзэж байгаа юм. Тэртээ тэргүй энд төсөв дээр тавигдсан төсвийн тэлэлт чинь бодлогын хүү бууруулахгүй байх тэр нөхцөлийг л бүрдүүлж өгнө шүү дээ. Тэгэхээр энийг чинь дагаад л хэрэглээний зээл тэр банкнуудын зээлийн асуудал чинь хүүгийн асуудал гэдгээ буурна гэдэг асуудал чинь ингээд л цаашдаа хэрэгжих боломжгүй болоод явах нь харагдаад байна л даа. Энэ арилжааны банкнууд одоо газар тариалан ХАА-г дэмжсэн зээлүүдийг хавар бид нар эргэлтийн хөрөнгийн зээлүүд олгоод байгаа.

Тэгээд гол төлөв банкнууд маань газар тариалангийн бүс нутгууд руу гаргаад ялангуяа баруун бүсүүд рүү энэ зээлүүд маань гарахгүй байна. Бид нар эндээс одоо ийм ХАА-г дэмжих зээлүүдийг, хөнгөлөлттэй зээлүүдийг гаргалаа гээд зарладаг. Тэр нь зөвхөн Дархан, Сэлэнгийн бүс нутаг буюу үйлдвэрлэлийнхээ цөм бүс дээрээ хэрэгжээд бүс нутгууд руу гарч өгөхгүй байна. Нөгөө талдаа бас нэг асуудал энэ ипотекийн асуудал. Ялангуяа аймгуудын төв чинь ялгаа байхгүй утааны асуудалтай болчихлоо. Тэгэхээр энэ дээр одоо иргэдийг өөрсдөө орон сууцаа барих юм бол тэр ипотект хамруулъя хөнгөлөлттэй зээлээр хангая гэж байгаа энэ бодлого чинь хэрэгжихэд бэлэн болсон уу? Бас л бид нар зарлачихсан. Иргэд энэ асуудал дээр мөн л ингээд л нэг намрыг алдаж байна л даа. Энэ өвөлжилтдөө хашаа байшингаа янзлах гээд энэ асуудлууд нь хаягдаад яваад байх юм. Тэгээд энэ дээр бэлэн байна уу? Арилжааны банкнууд дээр хөрөнгө оруулалтын зээл гэдэг зүйл ер нь гарахгүй

байна аа. Дандаа эргэлтийн хөрөнгийн зээл гарч байна. Ингэхээр нөгөө худалдааны эдийн засгаа дэмжсэн л зээлүүд маань цаашдаа тэлээд байдаг. Яг үйлдвэрлэл, экспортыг дэмжих, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын зээлүүдийг арилжааны банкнууд олгож чадахгүй байна. Энэ дээр Монголбанк ямар бодлого барьж байна аа? Тэр ХАА-г дэмжих ялангуяа хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих цагаан алт хөтөлбөрийн хүрээнд бид зээл гаргая гэж ярьсан. Одоо бол өнгөрсөн жилийн гаргасан ноолуурын эргэлтийн зээлээ л бид нар энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжлээ гээд л тайлагнаад явж байна. Тэгэхээр энэ эргэлтийн хөрөнгийн зээлийг ирэх жил мөн ялгаа байхгүй ингээд л нэг ноолуур руу хаврын түүхий эд бэлтгэл рүү гаргачхаад хөнгөн үйлдвэрлэлийг дэмжлээ гээд энэ нэг тойргоосоо гарахгүй бол болохгүй нь ээ.

Тэгэхээр энэ дээр Монголбанк маань хөрөнгө оруулалтын чиглэл рүү ямар бодлого баримталж байна аа? Одоо ААН-үүдийн зээлийн хүүг бууруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэл дээр эдгээр асуултуудад нэг хариулт авъя аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө ингээд төсөв тэлээд эдийн засагт төсвөөр дамжиж мөнгө орж ирээд мөнгөний нийлүүлэлт өөрөө энүүгээр өсөөд явахаар зөрөөд Монголбанкны хувьд мөнгө нийлүүлэх орон зай байхгүй л болчхож байгаа юм. Тэгэхээр тэр тэр утгаараа бага хүүтэй эх үүсвэр орчих боломжгүй зах зээлээсээ нөгөө төсвийн тэлэлтээр дамжсан харилцах хадгаламжаар ингээд энэ оны хувьд 5 их наядаар ингээд өсөөд явж байгаа. Тэгэхээр энэ 5 их наяд дундаж хүүгээрээ бодоход ингээд хадгаламжийн хүү дунджаар 11 хувь гэхлээр ийм эх үүсвэр л банканд дээр очиж байгаа. Тэгэхлээр энэ нь өөрөө зээлийн хүүг буулгах боломжийг нь ингээд бууруулж байгаа юм. Тэгээд зээлийн хүү буурахгүй болохлоор хувийн сектор буюу ААН дээрээ хүүгийн ингээд дарамттай л ингээд явж байгаа юм. Монголбанкны бодлогын хүү буурч байгаа дохиогоороо ирэх он руу зээлийн хүү буурна гэж бидний зүгээс бол харж байгаа.

Хоёр дахь асуултын хувьд газар тариалангийн бүс нутгийн хөгжил дээр яах вэ арилжааны банк бол зээл олгоод явж байгаа. Тэгэхдээ нөгөө яг хамгийн том хэсэг нь яг цөм бүс нутаг гээд байгаа энэ Төв аймаг Сэлэнгийн нутаг дээрээ л нийт зээл нь гарч байгаа. Тэгээд бидний хувьд бол яг таны саналын дагуу юу ч гэсэн арилжааныхаа банктэй уулзъя. Ялангуяа тэр баруун бүс дээр байдаг юм уу зарим бүс дээр байгаа тэр газар тариалангийн салбарыг нь дэмжих үүднээсээ ямар бүтээгдэхүүн үйлчилгээ гаргавал зөв бэ гэдгээрээ. Ингээд яриад явъя гэж бодож байгаа юм.

Аймгийн төвийн ипотекийн зээлийн хувьд Монголбанкны хувьд бол амины орон сууцыг ипотект хамруулах журмаа шинэчилчихсэн. Сая Батсуурь сайдын тайлбарлаж байгаагаар удахгүй хуульд өөрчлөлт ороод ирэхээр энэ асуудал өөрөө шийдэгдээд яваад эхэлнэ. Түрүүчийнх нь туршилт маягийн пассив хаус гэдэг дээр бол арилжааны банкнууд арай өндөр хүүтэйгээр зээлээ олгоод явж эхэлсэн тэгэхээр туршилт эхлээд явж байгаа гэж хэлж болно. Тэгэхлээр удахгүй ингээд хэрэгжих байх аа. Хөрөнгө оруулалтын зээлтэй холбоотой асуудал дээрээ хамгийн асуудал нь нэгэнт хүү өндөр байгаа нөхцөлд хүү нь өөрөө яг л хэрэглээ эргэлтийн

хөрөнгийн зээлд л таарсан л хүү болчхоод байгаа юм. Тэгээд хөрөнгө оруулалтын зээл рүү гарах тал руу нь угаасаа хэрэгжүүлэхээр зүйлүүд ярьж байгаа. Тэр нь бол бидний түрүүн яриад байгаа ялангуяа ЖДҮ дээр тэр нийлүүлэлтийн сүлжээ гэж ярьж байгаа юм.

Нийлүүлэлтийн сүлжээн дээрээ хаана нь тэр боловсруулах үйлдвэр хийгдэх юм тэнд нь ямар хөрөнгө оруулалтын зээл орох юм, тэрэн дээр нь ямар боломжтой гарах вэ гэдгийг 2025 оноос эхлүүлэхээр ярьж байгаа юм. Энэ онд хэрэгжиж эхлэх гэж байгаа хэрэгжээд явж байгаа Цагаан алт хөтөлбөрийн хувьд бол арилжааны банкнаас 1.5 их наяд, төрөөс 680 тэрбум гээд нийтдээ бараг 2 их наядын хэмжээний зээл гарахаар ингээд гэрээнүүд нь гэрээний төсөл нь хийгдээд явж байна. Одоо энэ нь өөрөө ингээд цаашаа та энэ Цагаан алт хөтөлбөр өөрөө 5 жилээр хэрэгжихээр ярьж байгаа.

Д.Амарбаясгалан: Өнөөдөр нийт 37 гишүүн асуулт асуухаар нэрс өгсөн 15 гишүүн асуулт асуусан байна. 3 цагийн хугацаанд 15 гишүүн. Тэгэхээр өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлуудаа орой ажлын цагтаа багтаахын тулд үдийн завсарлагагүйгээр хурлаа үргэлжлүүлж явъя. Дараачийн гишүүн асуултаа асууя. Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн хоол цайны цаг болсон ч гэсэн үлдээд хуралдаа идэвхтэй суугаад иргэдээ төлөөлж байгаа цөөхөн хэдэн гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Яах вэ дөнгөж сая нэлээн олон гишүүд цайндаа гарах шиг боллоо.

Би Монголбанкнаас 3 асуулт асууя гэж бодож байгаа. Тэгэхдээ тэр асуулт асуухаасаа өмнө Их Хурлын даргадаа нэг ийм зарчмын санал дэвшүүлмээр байна аа. Энэ чуулгантай холбоотой ирц дээр үнэхээр нэг хэлэхгүй болохгүй зүйлүүд байна дарга аа. Энэ нэг аргатай зальтай хэд хэдэн гишүүд байна. Хурууныхаа хээг уншуулчхаад гараад явчихдаг бүтэн өдөржин хуралдаа орж ирдэггүй. Үг хэлэх болохоороо орж ирж үгээ хэлж попорчоод, үгээ хэлэхээрээ гараад явчихдаг хэдэн хүмүүс байна. Энэ хүмүүс өнөөдөр parliament.mn дээр ирц нь ирчихсэн бүртгэлтэй байгаа мөртөө яг үнэндээ энэ танхимд суугаад иргэдээ төлөөлөх ажлаа хийхгүй байна. Энэ бол зөвхөн өнөөдрийн асуудал биш. Өнгөрсөн 7 хоногийн өмнөх 7 хоногт эхэлсэн ээлжит чуулганы 2 өдрийн хуралдаанд ч гэсэн ирцээ бүртгүүлчхээд гараад явсан. Ээлжит бусаар ч гэсэн тийм байсан.

Би одоо яг энэ их зөв позишнд суучихсан байгаа учраас бүгдийг нь ажиглаад байгаа. Энэ нөгөө би өөрөө Ёс зүйн хороогоор орсон учраас шаралхаад ажиглаад байгаа юм биш. Ер нь бид нар яах гэж ийшээ орж ирсэн юм. Иргэдээ төлөөлөх гэж орж ирсэн. Энд иргэдээ төлөөлөхийн тулд бусдыгаа сонсоод энэ бусад гишүүдийнхээ асуусан асуултад яам агентлаг ямар хариу өгөөд байна гэдгийг сонсохгүйгээр зөвхөн өөрийнхөө асуух асуултыг асуучхаад явчихдаг байх юм бол яаж энэ иргэдийг төлөөлөх ажлыг хийх гээд байгаад юм. Би үнэхээр гайхаж байна. Тэгээд парламент өчнөөн аягүй гоё, хүн төвтэй, иргэн төвтэй ийм парламентыг бий болгоно гээд өчнөөн ажил төлөвлөөд маш их цаг зав наргүй хэлэлцүүлэг хийгээд, судалгаа хийгээд, уулзалт хийгээд яваад байдаг. Нөгөө би төвтэй хэдэн гишүүд нь хуруугаа уншуулчхаад явуулчихдаг энэ байдлыг юу гэж ойлгох вэ?

Дээр нь ингээд ялангуяа МАН, АН, ХҮН нам бол ингээд ээд эвслийн Засгийн газар байгуулаад ирчихсэн. Нөгөө сөрөг хүчин болж байгаа наймхан гишүүнтэй

хоёрхон Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл байдаг. Гэтэл энэ 2 намын энэ 2 сөрөг хүчний дарга нар нь ерөөсөө хуралдаа суудаггүй. Ирцээ бүртгүүлчхээд явчихдаг. Би манай намын дарга Батбаатарыг гайхаж байна.

Сүүдрийн Засгийн газар байгуулна гээд л гайхуулаад л байгаа. Яаж энэ дотор юу болж байгааг мэдэхгүйгээр яаж хяналт тавих гээд байгаа юм. Тэгээд нэг худлаа ингээд л попроод л ингээд яваад байдаг. Би энэн дээр маш их эргэлзээтэй маш их бухимдалтай хандаж байна. Тийм учраас даргад өгөх санал бол энэ ирцээ бүртгүүлчхээд нэг цагаас илүү хугацаагаар хуралдаа суудаггүй хүмүүсийг буцаад тасалснаар авдаг болмоор байна гэсэн ийм саналыг дэвшүүлэх гэсэн юм.

Ингээд асуудалдаа оръё оо. Жоохон агрессив байсан уучлаарай. Тэгэхдээ ер нь энэ зөв шүү дээ. Иргэд нь ч гэсэн мэдэж аваг. Яах вэ дөнгөж саяхан нэлээн олуулаа байсан. 15 минутын өмнөөс хүмүүс гарлаа. Гэхдээ тэнд огт суухгүй байгаа хуруугаа бүртгүүлчхээд ирж суухгүй байгаа, өрөөнөөсөө телевизээ үзээд чуулганыг үзээд сууж байдаг тэр хүмүүст хандаж хэлж байгаа юм. Тэгээд өрөөнөөсөө үзэх гэрээсээ үзэх ямар ялгаа байна? Өрөөнөөсөө үзээд байж байдаг хүмүүс гэртээ хариад гэрээсээ энэ чуулган үзээд сууж байх хэрэгтэй.

Ингээд Монголбанкнаас асуух гэсэн юм. Төсвийн зардал 20 хувь орчим нэмэгдээд тэлээд ороод ирсэн байгаа шүү дээ.

Дээрээс нь эрчим хүчний суурь үнийг 30 хувь нэмэгдүүлэх тухай ингээд яриа маш эрчийг авч байна. Олон улсын байгууллагуудаас, Дэлхийн банкнаас өвөлжилт хүндрэх эрсдэлүүдийг ингээд онцгой тэмдэглэж өгч байна. Тэгээд энэ нөхцөлд тийм ээ 2025 онд энэ инфляцыг 5+ -2 интервалт барина гээд ингээд ороод ирчихсэн байгаа чинь хэр үндэслэлтэй байгаа вэ? Энийгээ ямар нэгэн эрсдэлт тохиолдол бий болоход энийгээ яаж барих ийм судалгаа та бүхэнд байна уу?

Хоёрдугаарт ипотекийн зээлтэй холбоотой маш олон.

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүнд нэмж нэг минут өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгээд асуулт давхацсан учраас энэ ипотекийн зээлийг зөвхөн орон сууц олгохоос гадна хашаандаа эрчим хүчний хэмнэлтийг дэд бүтэцтэй, хэмнэлттэй дэд бүтцээ шийдэх гэж байгаа, шийдэхээр оролдож байгаа энэ өрхүүдэд олгох боломж байдаг уу?

Дээрээс нь Монголбанканд орон сууцжуулах хөтөлбөртэй холбоотой нэг ийм юм ороод ирчихсэн байгаа төсөв дээр 2025 оны төсөв дээр 1.3 их наяд төгрөгийн зээлийн эх үүсвэрийг хуримтлалын сангаас 562 тэрбум, Монголбанкны эх үүсвэрээс 500 орчим тэрбум төгрөг гээд ингээд ороод ирчихсэн байгаа нь энэ Монголбанкны эх үүсвэр нь шууд мөнгө хэвлэх асуудал байна уу эс үгүй бол Монголын ипотекийн корпорацын эргэн төлөлтөөс орж ирэх мөнгийг ингэж ингэж тусгасан байна уу? Энэ дээр би ийм хариулт авмаар байна аа. Ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгнө өө.

Б.Лхагвасүрэн: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Тийм төсөв угаасаа ДНБ-ий 37 хувь гээд нэлээн ийм өндөр төсөв энэ ковидоос хойш ингээд явж байгаа. Ковидын өмнө бол улсын төсөв бол ДНБ-ий 27 хувьтай тэнцүү байдаг байсан. Тэгээд нэгэнт ингээд орлого нь өөрөө сайн бүрдээд ирэх онд 35.8 их наяд төгрөгийн зардал гарахаар төсөв орж ирж байгаа. Энэ оны 11 сарын 1-нээс эхлээд эрчим хүч дулааны үнийг тодорхой хэмжээгээр нэмэхээр ингээд яригдаж байгаа учраас эдгээр бүх зүйл дээр манай тооцоо судалгаа үндэслэгдсэн байгаа. Бүгдийг нь тооцсон байгаа.

Тэгэхээр ирэх оны инфляцыг 6+ -2 хувьд барих энэ тооцоолол маань манай энэ ном дээр нэлээн дэлгэрэнгүй байгаа. Дээшээгээ яаж савлах вэ доошоогоо ямар боломжийн хэмжээнд буурах вэ ч гэдэг юм уу. Энэ талаараа нэгэнт орсон учраас бидний хувьд ирэх оны инфляцыг манай зорилтын дээд түвшин хавьцаа буюу 7-оос 8 хувийн орчимд гарах болов уу гэдэг саяын нөлөөллийг тооцсон маягаараа ингээд хийсэн байгаа. Ипотекийн зээлийн хувьд амины хашаан дахь амины орон сууцыг ялангуяа эрчим хүчний хэмнэлттэй, агаар бохирдуулдаггүй, хөрс бохирдуулдаггүй маягаар шийдэгдсэн энэ орон сууцыг хамруулахаар Монголбанк өөрийнхөө журамд өөрчлөлт оруулсан. Түрүүн Батсуурь сайд хариулахдаа ялангуяа Барилгын тухай хууль, Орон сууцын санхүүжүүлэх тухай хууль дээрээ эдгээр заалтуудыг нэмж оруулахаар ингээд орж ирж байгаа гэдэг утгаараа энэ хамрагдахаар болоод явж байгаа.

Гурав дахь асуултын хувьд яг таны асуултад энэ эргэн төлөлтөөрөө орж ирнэ. Санхүүжиж байгаа учраас ирэх онд бол Монголбанкнаас энэ гаргаж байгаа мөнгө мөнгө нийлүүлж байгаа биш одоо эдийн засагт эргэлдэж байгаа мөнгө буцаж орж ирээд буцаж гарахаар ингэж төсөвлөгдсөн байгаа.

Тэгэхээр бол ерөнхийдөө хамгийн багадаа 1.2 их наяд төгрөгийн санхүүжилт явахаар бол одоо төлөвлөгдсөн байгаа.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуултаа асууя.

С.Бямбацогт: Мөнгөний бодлого хэлэлцэж эхэлж байгаа ирэх оны чухал асуудал аа. Тэгэхээр төсвийн бодлого, мөнгөний бодлого маань ер нь хэр зэрэг уялдаж байгаа вэ ирэх онд яаж уялдуулах талаар анхаарч байгаа вэ гэдгийг нэгдүгээрт нь асуумаар байгаа юм. Ерөнхийдөө бол одоо бид нар ингээд Монгол Улсын валютын нөөц нэмэгдлээ, валютын ханш тогтвортой байна. Экспортын орлого өсөж байна төсвийн орлого нэмэгдэж байна мөн эдийн засаг өсөж байна, инфляц тогтвортой байгаа, инфляц буурч байгаа гээд ингээд үндсэндээ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд бүгд сайн байна гэж яриад байгаа. Бүгдээрээ сайн байгаа гээд. Үүний үр дүнд эдийн засаг 2024 онд 6 хувь өсөх нь. 2025 онд ч гэсэн дахиад өснө өө гэсэн ийм төсөөлөлтэй байгаа.

Тэгэхээр харьцангуй ингээд ярих юм бол үндсэндээ энэ танхимд бидний ярьж байгаа мөнгөний бодлого зөв хэрэгжиж байгаа юм байна, төсвийн бодлого зөв явж байгаа юм байна, Монгол Улсын эдийн засаг өсөж байгаа юм байна гэдэг ойлголттой. Яг гадаа гудамд гараад иргэдтэй уулзаад, ААН-үүдтэй уулзаад асуудал яриад явахаар ер нь тийм сайнгүй байна аа. Иргэдийн худалдан авах чадвар сайн биш байна. Өрхийн бодит орлого нэмэгдэхгүй байна. Мөн урьд нь бид нар зах дээр суугаад тэдэнд гутал зардаг байсан ийм орлого олдог байсан, тэдэнд талх зараад ийм орлого олдог байсан, сардаа нэг машин зарчихдаг байсан зарагдахаа

больчихлоо. Худалдан авах чадвар жоохон сул байгаад байна гэж иргэд яриад байгаа юм. Тэгээд энэ юутай холбоотой байгаад байна вэ?

Яагаад ингээд эдийн засаг макро эдийн засгийн үзүүлэлтүүд маань өсөөд ер нь үр дүн сайн байгаад байхад яг бодит хөрсөн дээрээ иргэдийн орлого нэмэгдэхгүй байна. ААН-ийн орлого нэмэгдэхгүй байна, эдийн засаг маань тэлэхгүй байна, эдийн засаг маань томрохгүй байгаад байна аа. Энэ дээр ямар асуудал байгаад байна? Эс үгүй бол байгаа юмандаа нөхдүүд маань төсөөлөл нь өндөр байгаа учраас сэтгэл дундуур байгаад байна уу? Бодитоор орлого нь нэмэгдээд бодитоор худалдан авах чадвар нэмэгдээд байгаа нь өөрсдийн хүсэж байгаа мөрөөдөж байгаа хүлээлтэд хүрэх үгүй байхаар сэтгэл дундуур байгаад байгаа юм уу? Эс үгүй бол үнэхээр бодитой ийм болчихоод байна уу? Хэрвээ бодитой ийм байгаа бол ямар учир шалтгаанаас ийм байгаад байгаа юм оо? Энэ дээр манай Монголбанкныхан ямар дүгнэлт хийж байна? Үүнийг хэрвээ тийм юм байгаа бол цаашдаа бас бид яаж засаж залруулж болох вэ? Энийг нэгдүгээрт нь хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь бид хашаандаа сайхан амьдарцгаая гээд нэлээн гишүүд ярьдаг болсон. Энэ Улаанбаатар хотын утааг 21 аймгийн утааг бууруулахад ерөөсөө л утаагүй зуухны асуудал шахмал түлшний асуудал биш юм байна. Ерөөсөө л гэр хорооллыг орон сууцжуулах, амины болон нийтийн орон сууц барьж байж гал түлэхгүй болж байж шийдэгдэх юм байна гэж. Энийг шийдэх гээд өнгөрсөн жил мөнгөний бодлого дээр бид нар тусгасан. Амины орон сууцад 6 хувийн хүүтэй, орон нутагт 3 хувийн хүүтэй ипотекийн зээл өгнө өө гэсэн. Харамсалтай нь энэ зээлүүд өгөгдсөнгүй ээ. Энэ зээлийг авах бололцоо боломж бүрдэхгүй байх шиг байна аа. Энэ яагаад болохгүй байна? Энийг бүрдүүлж энэ хашаандаа инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой дэд бүтцийн цэвэр бохир усны шугамд холбогдох боломжтой айлууддаа орон нутагт нь 3 хувийн хүүтэй зээл, Улаанбаатарт 6 хувийн хүүтэй ипотекийн зээл хэзээнээс яаж олгож эхлэх вэ? Энэ ямар боломж бололцоо бүрдэх вэ? Энэ ингэх юм бол бид нар утааны асуудлаа бүрэн шийднэ ээ. Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Угаасаа төсөв ингээд тэлэлттэй ороод ирж байгаа учраас төсөв орлогоороо тэгээд орлого, зарлага алдагдлаа ингээд яг Төсвийн тогтвортой байдлын хууль энэ хуулийнхаа хүрээнд ингээд төсвөө оруулж ирж байгаа учраас ерөнхийдөө төсвөөр дамжиж ямар хэмжээний мөнгө эдийн засагт очих вэ гэдгээ ерөнхий төсөөллөө Монголбанк аваад нэгэнт ийм хэмжээний мөнгөний төсвөөр дамжсан ийм санхүүжилт очиж байгаа бол тэр нь тэр санхүүжилт өөрөө эдийн засгийнхаа бодит нөхцөл байдал хөрсөн дээрээ яаж буух вэ гэдгээрээ л мөнгөний бодлогоо дараа нь хийж байгаа юм.

Тэгэхээр эхлээд мөнгөний бодлого нь биш дараа нь төсөвтэйгөө уялдуулаад юмаа яаж байгаа учраас мөнгөний бодлого ерөнхийдөө орон зай хязгаарлагдмал ийм хатуу мөнгөний бодлого л явахаар болж байгаа юм. Тэгэхдээ тэр утгаараа ч гэсэн өнөөдрийн нөгөө бодлогын хүү хэдийгээр сая 9 сард нэг хувь нэгжээр буулгасан ч гэсэн 2 оронтой тоо буюу 10 хувьтай л ингээд л хүү явж байгаа.

Тэгэхээр мөнгөний бодлогын төлөв хатуу хэвээрээ явахаар байгаа. Яах вэ төсвөөр дамжиж нэгэнт эдийн засаг руу орж байгаа мөнгөнийхөө нийлүүлэлттэй

уялдсан. Дээр нь ирэх оны Оюу Толгойн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өсөлттэй холбоотойгоор ирэх оны эдийн засаг 7-оос 8 хувиар тэлэх ийм тооцоо судалгаа гарсан. Энэ нь бол зөвхөн Монголбанк Сангийн яамны хийж байгаа тооцоо судалгаа биш. Дэлхийн банк, Валютын сан, Азийн хөгжлийн бүгдээрээ бол ийм хэмжээний өндөр өсөлттэй байхаар төсөөлөл нь гарчихсан байгаа учраас ерөнхийдөө эдийн засаг бол ямар ч байсан ирэх онд нэлээн өсөлттэй ийм байна л гэж л төсөөлөгдөж байгаа юм.

Таны хөндөж байгаа хашаандаа сайхан амьдрах гэдгээрээ ерөнхийдөө ажлууд хийгдээд явж байна. Энэ онд нийт яг өнөөдрийн байдлаар 1 их наяд 130 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод 9693 ийм зээлдэгч ингээд орон сууцад ингээд ороод явж байгаа. Энэ 9693-ын 2613 нь хөдөө орон нутгийн яг таны хөндсөн нөгөө 3 хувийн зээл хөнгөлөлттэй зээл авсан иргэн байгаа юм. Энэ өөрөө ингээд бүр 2023 онд өмнөх онтой харьцуулах юм бол 2 дахиад өсөөд явж байгаа.

Тэгэхээр орон нутагт өндөр зээл явж байгаа. Ер нь бол одоо гэр хорооллоос ний нийтийн орон сууцад буюу том байшинд орсон зээлдэгчийн хэмжээ нь 37 хувь болсон. 37 хувь тэгэхээр одоо бол нэлээн энгийн яг амины байшин барьж байгаа иргэдэд зээл өгөхөөр ярьж байгаа. Өмнө нь бол энэ амины орон сууц яагаад банкны зээлд хамрагдаж чадахгүй байсан бэ гэхээр нийтийн орон сууцыг бол улсын комисс хүлээж авдаг. Улсын комисс хүлээж аваад инженерийн нөгөө мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн бүх баталгаануудаа гаргаад энэ амины орон сууц ингээд гэрчилгээ гаргаад явдаг учраас тэр гэрчилгээгээрээ дамжаад ипотекийн зээлд хамрагдах банкны барьцаа болох нөхцөл нь бүрдээд явж байгаа юм. Гэр хорооллын амины орон сууц нь өөрөө ямар хэмжээ материалаар.

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд тодруулж асууя.

С.Бямбацогт: Тэгэхээр яг эдийн засаг маань өсөж байна, валютын нөөц нэмэгдэж байна, төсвийн орлого нэмэгдэж байна гээд үндсэндээ макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайн байна сайхан болж байна өшөө сайн болох гээд байна гээд бид яриад байгаа. Энийг зөвхөн бид нар ч биш Дэлхийн банк, ОУВС гээд бүгд ингэж ярьж байгаа. Гэтэл яг бодит байдал дээр иргэдийн орлого нэмэгдэхгүй байна, иргэдийн амьдрал сайжрахгүй байна, ААН-үүдийн орлого нэмэгдэхгүй байна, бизнес тэлэхгүй байна гээд иргэд ААН-үүд маань хэлээд байна л даа. Яагаад Макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжраад байхад яагаад тэнд микро түвшиндээ үр өгөөж нь наалдахгүй байгаад байна вэ? Энийг л бид нар яг ям юунаас болоод байна олмоор байна л даа. Үнэхээр зээлийн хүүндээ хүүлэгдээд ингээд эд нарын тийм үү олж байгаа орлого нь тийшээ явчхаад байна уу, эс үгүй бол өөрсдийнх нь хүсэж байгаа хүлээлт нь өшөө өндөр байгаад өндөр хүлээлтэд хүрэхгүй байгаа учраас олж байгаа орлого нь хэдийгээр өсөж байгаа ч гэсэн нэмэгдэж байгаа ч гэсэн хүлээлт нь өндөр байгаа учраас сэтгэл дундуур байгаад байна уу? Энэний шалтгааныг та бүхэн маань судалгаа хийсэн үү? Энэ дээр л нэг бодитой судалгаа хийгээд нэг дүгнэлт гаргаад өгөөч ээ? Энэ байна уу хийсэн байвал энийг л хэлээд өгөөч.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Лхагвасүрэн Ерөнхийлөгч. Ган-Очир эдийн засагч. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Д.Ган-Очир: Бямбацогт гишүүн бол яг л манай эдийн засаг дээр тулгарч байгаа хамгийн эмзэг цэгүүдийг л асуугаад байна. Мэдээж яг өрхийн түвшинд очих юм орлогын тэгш бус байдал багагүй байгаа. Ядуурлын түвшин бол өндөр байгаа.

Энийг макро эдийн засаг микро түвшин рүү өрхийн түвшин рүү очиж чадахгүй байгаад байгаа энэ суваг бол 1 дүгээрт өсөлт маань яг тогтвортой, удаан тогтвортой байж чадаж байна уу? Нөгөө 2 жилийн өндөр өсөлт маань буцаад сөрөг болоод тэр маань өөрөөр хэлбэл тэр бизнес нь тэлэх өрхийнх нь орлого нь өсөөд тэр нь дараагийнхаа боловсрол гэдэг юм уу дараагийн орлогыг бүтээдэг тэр хэлбэр рүүгээ очиж чадахгүй байгаа биз дээ.

Хоёр дахь асуудал нь бол хүртээмжийн өсөлтийг маань хүртээмжтэй байна уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгээд манай дээр энэ үзүүлэлт маш сул гардаг. Шалтгаан нь бол эдийн засаг маань өөрөө хангалттай төрөлжиж чадсан юм уу гэдэг асуудал. Тэгээд энэ дээр манайх төрөлжилт муу. Яагаад төрөлжилтийн асуудал хөнддөг вэ гэхээр хүн энэ эдийн засгийн өсөлтөд өөрөө хувь нэмэр оруулаад тэр өсөлтөөс нь цалин орлого бизнесийн орлогоороо буцаагаад өгөөжөө хүртэх ёстой.

Д.Амарбаясгалан: Нэмж гүйцээж хариулъя.

Д.Ган-Очир: Манай дээр яг энэ үзүүлэлт бол илүү эдийн засгийн өсөлт маань зөвхөн тийм хөдөлмөр бага шингээдэг салбаруудаас бий болж байгаа юм. Уул уурхайн салбар байна, тээвэр байна яах вэ үйлчилгээ худалдаа бол харьцангуй гайгүй. Тэгэхдээ илүү ихэнх өсөлт нь бол нөгөө талаасаа бий болдог. Тэгэхээр эдийн засгийн төрөлжилтийн асуудал яригдана. Төрөлжилтийн асуудлыг шийдэхийн тулд 3 бодлого аягүй чухал болж байгаа. Энэ нь бол яг таны хөндөж байгаа мөнгөний бодлого төсвийн бодлого 2 маань эдийн засгийнхаа тогтвортой байдлыг жигд удаан хадгалж чадаж байна уу гэдэг асуудал.

Хоёр дахь нь бол бүтцийн бодлогын асуудал. Яагаад гэвэл инфляц маань 6.5 гэдэг бол харьцангуй өндөр үзүүлэлт олон улсын түвшинд. Тэгэхээр нийлүүлэлтийн тал маань эрэлтээсээ хоцроод байдаг асуудал. Тэгэхээр төсвийн бодлогын тэлэлтийг дагаад нийлүүлэлтийн бодлого буюу эдийн засгийн бүтцийг тэр бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нь сайжруулдаг бүтээмжийг нь дэмждэг бодлогууд маань хоцроод байгаа асуудлууд.

Тэгэхээр энийг яг л Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр таны энэ асуудлуудыг илүү тусгах ёстой болж байгаа.

Гурав дахь асуудал бол аж үйлдвэржилтийн асуудал.

Ялангуяа энэ түүхий эдүүдийг яаж боловсруулалтын шатанд.

Д.Амарбаясгалан: Их л чухал асуултад их л дэлгэрэнгүй хариулт өгөөд тэгээд гүйцээж чадахгүй л байгаад байна даа. Дараагийн хүн асуултаа асууна аа. Болдын Жавхлан гишүүн асуулт асууна. Алга байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Энэ арилжааны банкуудтай холбоотой тодруулах хэд хэдэн зүйлүүд байна. Ер нь өнгөрсөн хугацааг харахаар өнгөрсөн 30-аад жилийг харахаар энэ ААН-үүд ард иргэд бол нэг банкны зээлийн хүү төлөх гээд л өрөөс өрийн хооронд л амьдарч явж байгаа. Энийг нь яг энэ статистик тоонууд харуулж байгаа. Тэр банкууд нь болохоор санхүүгийн салбарынхаа 90 орчим хувийг дангаараа бүрдүүлж байна. Тэгээд хамаарал бүхий банк бусууд өөрсдийн бусад санхүүгийн

байгууллагаараа ингээд нийлэх юм бол бараг 95 хувийг дангаараа бүрдүүлж байгаа.

Тэгэхээр 1-д энэ банкны салбарын энэ монопол энэ бүх бусад салбарын бизнес рүү ордог байдал. Тухайлбал барилга байшин барихаас авхуулаад л төмөр зам, эрчим хүч, уул уурхай гээд. Энэ рүү орж байгаа байдал дээр Монголбанк ямархуу бодлого барьж энэ дээр ямар тооцоо судалгаа хийж ажиллаж байгаа вэ? Банкнууд ер нь өөрсдийнхөө хамаарал бүхий хэр их бизнесүүдийг энэ эдийн засагт орж хийж байна вэ? Энийг би яагаад асуугаад байна вэ гээд тэгэхээр банк өөрөө 2023 оны банкнуудын ашиг гэхэд 1.2 их наяд төгрөг.

Өнөөдөр иргэдийн ба амьжиргаа, ААН-үүдийн үйл ажиллагаа маш их зээлийн дарамтад байж байгаа. Зээлээ эргэн төлөх чадвар маш муу болж байгаа. Хэрэглээний зээл өсөөд байдаг, нөгөө талдаа бизнесийн зээл өсөхгүй хөрөнгө оруулалтын зээл өсөхгүй байгаа шалтгаан нь банкнууд богино хугацаатай зээл олгодог бизнесүүдэд маш өндөр шаардлага тавьдаг. Тэгээд богино хугацаатай зээл олгохоор яадаг вэ гээд тэгэхээр эхлээд үндсэн төлбөрүүдээ авчихдаг. Нөгөө 2-оос 3 жилийн хугацаатай зээл олгоод нөгөөхөөрөө бизнесээ үйл ажиллагаа эхлэх гэж байтал эргээгээд зээл олгосныхоо маргаашаас эхлээд үндсэн төлбөрүүдээ суутгаад аваад явчихаар нөгөө бизнесийнхээ үйл ажиллагааг ч явуулж чадахгүй банкныхаа зээлийг төлсөөр байгаад таарч байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь цаашдаа энэ бизнесийн жижиг дунд бизнесийг дэмжих асуудал дээр Монголбанк энэ бизнесийн зээлийн хугацааг уртасгах, үндсэн төлбөр төлдөг хугацааг хойшлуулах дээр ямар бодлого арга хэмжээ авах вэ? Тэгэхгүй бол энэ бизнесүүд чинь зээлээ аваад л маргаашаас нь үндсэн зээл хүүгээ төлсөөр байгаад л тэгээд үйл ажиллагаагаа явуулж чадахгүй ер нь хүүгийн дарамтад ороод дуусаж байна аа. Ийм 2 асуултыг асуумаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч ажлын хэсгийн 6 дугаар микрофон хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 30 гаруй жил болж байна. Анх зах зээлийн эдийн засагт шилжээд манай банк санхүүгийн салбарт хийсэн томоохон хувьсгал гэдэг юм уу өөрчлөлтүүд бол 2 шаттай банкны тогтолцоонд шилжсэн. Төв банк, арилжааны банк гээд тус тусдаа үйл ажиллагаа явуулаад өнөөдөр ингээд хүрч байгаа юм. Тэгэхдээ Монгол Улсын санхүүгийн зах зээлд бол яг таны хэлсэн ийм ерөөсгөл тогтолцоо бий болчихоод явж байна. 90 гаруй хувь нь банк, санхүү, банкнаас санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлээд үлдсэн 10 хувь буюу хөрөнгийн бирж, ББСБ, даатгал, үнэт цаас гээд энэ зүйл нь аравхан хувьтай, 10, 15 хувьтай л ингээд л байж байгаа.

Тэгэхээр өндөр хөгжилтэй орнуудын хувьд энэ бараг тэнцүү шахуу 50, 50 хувьтай байдаг. Тэгэхээр энд бол өрсөлдөөн бий болоод л явж байгаа гэсэн үг. Тэгээд зөвхөн банкны хооронд өрсөлдөөн биш 2 мөнгөний банкны зах, хөрөнгийн зах 2-ын хооронд ингээд өрсөлдөөн болоод явж байдаг ийм тогтолцоо бол одоохондоо манайд төлөвшиж бий болоогүй л явж байгаа учраас хамгийн их ачаа нь өөрөө ингээд банканд дээрээ л оччихоод л ингээд явж байгаа юм. Тэгээд Монголбанкны хувьд бол мэдээж банкны зохистой харьцаа санхүүгийн тогтвортой

байдлаа л хангасан ийм л бодлого л явуулаад явж байгаа. Яг шууд ингээд зээл олгож байгаа зээлийн хүүн дээр нь зээлийн нөхцөл дээр нь шууд оролцоод явах эрх бол байхгүй. Манай Банкны тухай хуулиар бол таны хөндөж байгаа тэр уул уурхай гэдэг юм уу барилга бусад янз янзын үйлчилгээний салбар руу ингээд банк нь өөрөө ороод явж байгаа юм байхгүй. Банк хуулиараа бол хориотой. Банкны хувьцаа эзэмшигч буюу холбогдох этгээд бол бас хуулийн зохицуулалттай.

Хэрвээ банкнаасаа зээл авч орох юм бол өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй ээ гэсэн ийм заалт байдаг. Тэгэхээр банкны яг холбогдох этгээд нь банкаараа шууд дамжаад бизнес хийж байгаа зүйл байхгүй. Банкныхаа эх үүсвэрийг хуулийнхаа хүрээнд аваад явж байгаа. Энэ дээр нь Монголбанк бол хяналтаа тавиад явж байгаа. Ялангуяа одоо энэ нийт банканд дээр байнгын газар дээрх шалгалтыг хийдэг. Банкны холбогдох этгээдүүд нь хэн хэн байна. Сонирхол бүхий этгээдүүд нь хэн хэн байна гэдгийг нь тогтоогоод явдаг. Тэрүүгээрээ дагаад бас өөрийн хөрөнгийнх нь шаардлагыг бол хэтэрсэн байна уу, хэтрээгүй байна уу гэдгээрээ шалгалтаа хийгээд явдаг. Яг өнөөдөртөө бол манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа 12 банкны бүх л холбогдох этгээд бүх мэдээлэл нь манайд байгаа. Хэдий хэмжээний зээл авснаа ч гэсэн банк өөрөө нийтэд ил тод веб хуудсаараа мэдээлээд явах ийм хуулийн үүрэгтэй байгаа.

Зээлийн хугацаатай холбоотой асуудал дээр бол Монгол Улсад нэлээн төвөгтэй. Яагаад гэвэл голцуу банкны эх үүсвэр өгдөг ч юм уу Хөрөнгийн бирж дээр оролцоод явж байгаа этгээдүүд нь дандаа хувь хүмүүс байдаг. Тэгэхээр хувь хүний хувьд бол нэг жилийн хугацаатай л хадгаламж хэлбэрээр байршуулдаг учраас.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн. Ганзориг гишүүн тодруулж асууя.

П.Ганзориг: Энэ банкнууд арилжааны банкнууд өөрсдөө бол үйл ажиллагаанаасаа асар өндөр ашиг олж байгаа. Бүгд мэдэж байгаа 2023 оны цэвэр ашиг нь гээд тэгэхэд чинь 1.2 их наяд төгрөг байж байгаа шүү дээ. Тэгээд хэрэглээний зээлийг банкнууд дээр тодорхой хэмжээнд хязгаарлангуут хувийг нь буцаад иргэд нөгөө аппликэйшнээр банк бусуудаас зээл авч эхэлж байгаа юм. Энэ чинь өөрөө цаагуураа банкны давхар өндөр хүүтэй бусад өөрсдийгөө хараат санхүүгийн бусад байгууллагуудаар өндөр хүүтэй зээл олгох ийм сонирхол яваад байх магадлалтай байгаа юм аа. Аль ч тохиолдолд банканд ашигтай байдаг. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ?

Энэ дээр ер нь ямар судалгаа тооцоонууд байна, хяналтууд байна уу? Энэ бодлого өөрөө зөв байна уу, үгүй юу?

Хоёрт, энэ бизнесийн зээл олгохдоо эх үүсвэр нь богино гээд хариулах гэж байх шиг байна л даа Лхагвасүрэн Ерөнхийлөгч. Тэгээд эх үүсвэр өөрөө хугацаа нь богино өртөгтэй байдаг гээд ингээд яваад байвал энэ бизнесүүд чинь босохгүй шүү дээ. Энийг яаж урт.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Ганзориг гишүүний асуултад гүйцээж хариулъя.

Тэгэхлээр ерөнхийдөө хамгийн сүүлийн асуултад зээлийн нөхцөл дээр ерөнхийдөө одоо зээлийн хугацаа ер нь нэлээн гайгүй уртсаад явж байгаа. Ялангуяа хөтөлбөрийн зээлүүд хэрэгжүүлж эхэлснээс хойш. Тэгэхээр ер нь бол банкн дээр байгаа зээлийг судалгаа хийгээд үзэхэд нийт зарим зээл нь бүр 5 жилээс дээш хүртэл хугацаатай зээл байгаа. 3-аас 5 жилийн хугацаатай зээл ч гэдэг юм уу ингээд ер нь нийт зээлийн дийлэнх хэсэг нь 2 жилээс дээш 2 жилээс 3 жилийн хугацаатай зээлүүд байгаа. Тэгээд нийтдээ ингээд харах юм бол 6 сар хүртэл хугацаатай зээл бол 2.3 их наяд, 7-оос 6 сар нь 2.7 их наяд, 2 жил хүртэл нь 2 их наяд, бүр 2 жилээс дээших нь 3.4 их наяд, бүр 2-оос 3 жилийн хугацаатай зээл нь.

Д.Амарбаясгалан: Бадрахын найдлаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Өчигдөр Байнгын хороон дээр асууж амжаагүй ганц хоёр асуулт байна аа. Нийлүүлэлтийн сүлжээг дэмжих гээд нэг төсөл яригдаж байсан даа. Нөгөө бараа материал эргэлтийн хөрөнгийг барьцаалдаг. Миний мэдэхээр энэ лав нэг 10 жилийн өмнө ярьж байсан төсөл. Энэ төсөл яагаад хэрэгжээгүй байгаа билээ. Юун дээр гацаад байгаа билээ. Ямар шийдвэр хуулийн төсөл хийж байж явах билээ.

Хоёрт нь төсөв бол тэлсэн байгаа та бүхэн мэдэж байгаа. Тэгээд төсвийн төсөлд зааснаар бол алдагдлыг Засгийн газрын үнэт цаас дотоодын зээлээр нөхөхөөр тусгачихсан байгаа. Өөрөөр хэлбэл Засгийн газар төсөв нөгөө хувийн хэвшилд очих ёстой мөнгийг бондоороо зээлээрээ татаад авчих нь байна шүү дээ. Тэгээд төсвийн зарлага болгоод хувиргачихна. Ингэхээр харин нөгөө хувийн хэвшлийг дэмжих ёстой түрүүн гишүүдийн яриад байгаа зээлийн хүү буурах тухай нөхцөл байхгүй болчхож байгаа юм аа.

Тэгэхээр хатуу бодлого явуулах нь зайлшгүй гэж ойлгож болох уу? Ингээд ингэж үзэх юм бол зээлийн хүү буурахгүй. Зээлийн хэмжээ өсөхгүй. Тэгээд сая гишүүдийн ч яриад байгаа иргэдийн хүлээгээд байгаа тэр нөхцөл байхгүй байгаа юм аа. Тэгэхээр та бүхэн энэ дээр тодорхой хариу хэлээч ээ. Төсвийн тэлэлттэй холбоотойгоор мөнгөний бодлого явуулах орон зай байхгүй байна аа. Ер нь мөнгөний бодлого бодитойгоор явуулах боломж байгаа юм уу байхгүй юм уу?

Гуравт нь инфляцын тооцоон дээр 2 зүйлийг тодруулж өгөөч? Энэ баримт бичигт цахилгаан дулааны үнийг нэмэхтэй холбоотой нэг ч өгүүлбэр нэг ч нөлөөллийн тухай байхгүй байна лээ. Тэгээд энийг яаж тооцож байгаа вэ? Хэр бодитой хэр нөлөө үзүүлэх вэ?

Хоёрт нь тээвэр ложистикийн зардал. Зөвхөн инфляц гэсэн үгэн дотор орчихсон байх шиг байна л даа. Яг энэ боомтуудын сэргэлт, боомтуудын нэвтрэх чадвар болон тээвэртэй холбоотой ложистиктэй холбоотой, агуулах савтай холбоотой. Энэ зардлын нөлөө инфляцад хэр их байдаг юм бэ? Хэрвээ төсөв нь ингэж тэлж байгаа бол мөнгөний бодлогын орон зай байхгүй байгаа бол ирэх жил инфляцыг нөгөө зорьж байгаа түвшиндээ барьж чадах уу? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон Баярдаваа дарга.

Б.Баярдаваа: Найдлаа гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нэлээд идэвхтэй банкнууд дээр энэ арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Хамгийн сүүлд Монголбанк банкнуудтай ажиллаад тэгээд зохицуулалт дээрээ нэг өөрчлөлт оруулсан. Зохицуулалт нь юу вэ гэхээр зэрэг одоо олгож байгаа зээлийн зохицуулалтын журмаар дандаа үл хөдлөх газар гэх мэт барьцаалбар шаардаж байгаа. Харин зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний шинэчилсэн нь журмаар 2024 оны 7 сараас эхлээд гэрээ барьцаалж болно гэдэг ийм заалт орж ирсэн.

Тэгэхээр энэ гэрээ барьцаална гэдгийн цаана бол гэрээ барьцаалсан тохиолдолд үл хөдлөх хөрөнгө шаардахгүй байж болно гэсэн ийм агуулга гэрээ гэдэг дотор нь борлуулалтын гэрээ, авлагын гэрээ энэ бүх зүйлүүд дотор нь орж байгаа учраас нийлүүлэлтийн сүлжээнд орж байгаа ААН бараа бүтээгдэхүүнийхээ борлуулалтын гэрээг барьцаалаад эргэлтийн хөрөнгийн зээл авах энэ бололцоо нь нээгдэж байгаа. Зохицуулагч байгууллагын зүгээс энэ орон зайг нь нээж өгсөн гэсэн үг.

Төсөв тэлж байгаатай холбоотойгоор мөнгөний бодлого дээр орон зай үүсэх үү гэвэл ер нь яг одоо ингээд харах юм бол орон зай бага гэдгийг Монголбанк хэлж байгаа. Гэхдээ орон зай үүсгэх хэд хэдэн боломжууд байгаа.

Нэгдүгээрт нь бол хэрэглээний сагсны 417 бараа бүтээгдэхүүнээс зөвхөн 20 нь нийт инфляцын 50-аас 60 хувийг тайлбарлаж байгаа. Энэ дотор юу байгаа вэ гэхээр зэрэг энэ 20 бараа бүтээгдэхүүний тал нь хүнсний нэрийн бараа бүтээгдэхүүн байгаа. Энэ хүнсний нэрийн бараа бүтээгдэхүүн дотор мах, гурил, хүнсний ногоо, сүү гэсэн ийм бараа бүтээгдэхүүнүүд нь өөрөө болон түүгээр үйлдвэрлэгдэж байгаа бараа бүтээгдэхүүнүүд байгаа. Тэгэхээр энэ бараа бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг нийлүүлэлтийн сүлжээг нь улирлын үнийн савлагааг бий болгохгүйгээр тогтвортой байлгахад энэ чиглэлээс ирж байгаа ийм нийлүүлэлтийн шинжтэй инфляцууд шийдвэрлэгдэх бололцоотой.

Энэ нийлүүлэлтийн шинжтэй инфляц шийдвэрлэгдэх юм бол инфляцад хариу үйлдэл үзүүлж мөнгөний бодлогын хүү чангарах ийм шаардлага багасна гэсэн үг. Инфляцын тооцоо судалгаан дотор цахилгаан дулааны үнийн нөлөөллийг оруулсан 30 хувийн үнийн өсөлт гэж оруулсан. Энэний нөлөө 2025 онд 0.8 дараагийн жилд нь бол 0.4 нэгж хувийн ийм инфляцын нөлөөтэй гэж тооцоо байгаа.

Гурав дахь асуулт нь тээвэр логистикийн асуудал маш том нөлөөтэй. 2021-ээс 2022 оны энэ цар тахал олон улсын харилцааны хүндрэлтэй нөхцөл байдлаас болоод тээврийн салбар дээр тэр доголдол үүссэнтэй холбоотойгоор 2022 оны дунд 16.9 хувь хүрч байсан инфляцын 4-ний 1-ийг энэ тээврийн зардал дангаараа тайлбарлаж байсан. Түүнээс хойш энэ салбар дээр арга хэмжээ авсны үр дүнд инфляцад тодорхой инфляцыг бууруулахад дэмжлэг үзүүлсэн гэж ойлгож болно. Гэхдээ асуудал ахиад бүрэн шийдэгдээгүй хэвээрээ байгаа гэдгийг одоо энэ олон улсын тээврийн энэ зах зээл дээр гарч ирж байгаа тээврийн дэд бүтэц дээр гарч ирж байгаа нөхцөл байдлууд олон улсын харилцааны тэр Улаан тэнгис дээр үүсэж байгаа нөхцөл байдал бол үүсгээд байгаа. Тэрний ул мөр нь бол Тяньжиний боомт дээрх асуудал контейнерын бөөгнөрөл бүрэн шийдэгдэхгүй хэвээрээ байгаад байгаа.

Жил гарны өмнөх санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмж дээр.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Олон гишүүд ярьж байна л даа. Энэ зээлийн хүүг бууруулмаар байна гээд. Би яах вэ энэ зээлийн хүү бууруулна гэхээсээ илүү зээлийн хүртээмж дээр илүүтэй анхаарч ажилламаар байна аа. Нийтдээ сая 800 мянган иргэн аж ахуйн нэгж ББСБ-аас 4.6 их наяд төгрөгийн зээл авсан байна. Дунджаар 3-аас 4 хувийн хүүтэй. Тэгээд бид нар энэ зээлийн хүртээмж дээрээ ажиллахгүй бол энэ чинь жижиг дунд бизнес бол банкнаас зээл авах ямар ч боломжгүй болсон.

Нэг ёсондоо жилийн 36 хувиас 48 хувийн хүүгийн хооронд энэ иргэд, ААН-үүд бизнесээ эрхэлж байна гэсэн үг. Энэ тал дээр анхаармаар байгаа юм.

Хоёрдугаар асуудал бол энэ хүүгийн татаас бүхий маш олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Яах вэ нийгэм, эдийн засгийн хувьд бол ач холбогдолтой байж магадгүй ээ. Энэ дээр яах вэ үр дүнгийн судалгаа тайлан эд нарыг нь бид нар харах ёстой байх. Энэ хүүгийн татаас гэдэг маань үндсэндээ бол яг татвар төлөгч нар тэр хүүг нь төлдөг гэсэн үг. Бусад татвар төлөгч нар. Тэр хөнгөлөлттэй зээлээсээ болоод зориулалтын дагуу ашиглагддаггүй байр болдог, машин болдог ийм төсөл хөтөлбөр олон байна. Энэ хүүгийн татаасыг нь энэ хүүг нь болж өгвөл мөнгөний бодлогынхоо бодлогын хүүтэй уямаар байгаа юм. Бодлогын хүүтэйгээ. Тэрнээс доош ордоггүй болгохгүй бол энэ чинь дан ерөөсөө хэрэглээний зээл болдог. Хэн нэгэнд давуу эрх олгогддог. Тэр зээл нь олдохоо больдог. Тэгээд тэр нь авлигал болдог. Тэгээд л энэ чинь Улаанбаатар хотод машин юм уу байр болдог ийм фракцыг бий болчихоод байна шүү дээ. Энэ дээр нэг анхаармаар байгаа юм. Мөн яг энэ тавигдаж байгаа шалгуур дээр нь тэр төсөл хөтөлбөр яг хэрэгжихээр шалгуур шаардлага нь өндөрсгөмөөр байгаа юм. Энэ дээр нэг анхаарчихмаар байгаа юм.

Мөн ипотекийн зээл ч ялгаа байхгүй. Үндсэндээ бид нар татвар төлөгч нарын нуруун дээр энэ ипотекийн зээлийн хүүгийн зөрүүг төлж байгаа гэсэн үг. Энийгээ ер нь болохгүй бол нэг бол арилжааны буюу тэр бодлогын хүүтэй нь уях байдаг юм уу энэ арга хэмжээг бодох ёстой. Цаашдаа ингэж 6 хувиар үргэлжлэх боломжгүй ээ. Ингээд банкнуудаар дүүрэн л ипотекийн зээлийн хүсэлт саналууд байна. Бодлогынхоо хүүтэй тодорхой хэмжээнд -2 ч байдаг юм уу, -2, -1 гэсэн байдлаар уяж явмаар байна аа. Энэ 2 дугаар асуудал.

Гуравдугаар асуудал. Засгийн газраас төв банк жоохон салж явмаар байна. төсөв тэллээ. Нэг бол төсвийн орлого нь бүрддэггүй юм уу яадаг юм. Ингээд л дагуулаад л бодлогын хүүгээ бууруулчихдаг. Тэгээд тэрний үр дүнд юу болж байна гэхээр ханш өнөөдөр яг тэр бодлогын хүү нэг хувиар буурснаар 70-аас 80 төгрөг суларчихсан байж байна. Яах вэ одоо энэ нөгөө төсөв бүрдүүлэхэд сайн байх л даа. Гэхдээ энэ чинь иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлнө. Инфляцад шууд нөлөөлнө. Тэгээд цаашдаа энэ төв банк маань бие дааж шийдвэрээ гаргадаг баймаар байна. Энэ дээр хэрвээ болохгүй байвал чуулган дээр ирээд бид нараар мэдээлэл өгдөг баймаар байна.

Төв банкныг хараат бус байх тал дээр нь бид нар ажиллах боломжтой. Тэгээд энэ тал дээр нэг анхаарчихмаар байна. Тэгээд энд саяын тавьсан асуултууд дээр нэг хариу авчихмаар санагдаж байна аа.

Д.Амарбаясгалан: Ган-Очир ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Д.Ган-Очир: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Түрүүн ч гэсэн Бямбацогт гишүүний асуултад хариулахад яг л Монголд нөгөө орлого нь хангалттай хүрэхгүй байгаа болохлоор зээл рүү очдог. Зээл дотроо ББСБ-ын зээл маань өөрөө таны хэлсэн энэ 36-аас 48 хувь руу хүрдэг энэ маань буцаад өрхийн санхүү дээр дарамт болдог асуудал бол яг л бодитоор нүүрлэж байгаа.

Тэр агуулгаар бид бүхэн ирэх жилийн энэ төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэхээр оруулж байгаа юм. Үүн дээр эхлээд хүүгийн дээд хязгаарыг тодорхой түвшинд энэ Солонгос, Япон зэрэг Азийн орнуудад тавьсан түвшин хүртэл дээд хязгаар тавих замаар энэ санхүүгийн дарамтуудыг бууруулах зохицуулалтыг оруулж ирэх гэж байгаа. Энэ нь 2 дугаар асуулттай холбоотой болж байгаа юм.

Яагаад ийм асуудал вэ гэхээр таны хэлсэн шиг бодлогын хүүтэй банкны хадгаламж гэдэг юм уу бусад зээлийн хүүнүүдийг уях гэхээр банк бус санхүүгийн байгууллагууд маань ОТС маркетаа маш өндөр хүүтэй бонд гаргадаг болоод тэр бондоороо өндөр хүүтэй авсан эх үүсвэрийгээ өндөр хүүтэй гаргаад байгаа юм. Одоо тэгэхээр Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах тухай хуулиар дээд хязгаар тогтоочихвол эх үүсвэр авах тэр бонд гаргадаг хүүнүүд маань өөрөөр хэлбэл буугаад ороод ирээд бодлогын хүү гэдэг юм уу банкны хадгаламжийн хүү рүү дөхөж ирэхээр нь тэр үед нь харин бодлогын хүүтэй уяад явах ийм бололцоо гарч ирэх гэж байгаа.

Тэгэхээр энэ эрх зүйн зохицуулалтыг бол та бүхэн дэмжиж хамтарч ажиллаач ээ гэдэг хүсэлтийг тавих гэсэн юм.

Гурав дахь асуудал бол мэдээж энэ зориулалтын бусаар ашиглагдаж байгаа татаастай хүүний хөтөлбөрүүдийг шалгах ажлыг эхлүүлж байгаа. орон нутаг дээр буюу яг эхнийх нь бол энэ хүнсний хувьсгал дээр энэ шалгалт энэ анхны тавьсан зорилгодоо нийцтэй байна уу, нийцтэй болгохын тулд ямар асуудлууд дээр анхаарах ёстой вэ гэдэг асуудал дээр бид бүхэн онцгой анхаарч байгаа. Шалгалтын дүн гарах үед мэдээж энэ тайлан дүгнэлтээ та бүхэнтэй хуваалцана аа.

Зээлийн хүү дээр яг адилхан байр суурьтай байгаа Монголбанк тантай яагаад гэвэл яг тэр зорилтот бүлэг дээр нь 6 хувийн хүүтэй байг. Харин одоо бүсчилсэн хөгжил гэнэ үү, хотын зах дээр байгаад байгаа орон сууцууд маань бүсчлэлээсээ хамаараад хүү нь өсдөг. Тэр нь зах зээлийн хүүтэй байдаг. Тэр нь болохоор ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны хүү маань бро өндөр. Тэгээд хотын захдаа илүү бага хүүтэй, хотын төвдөө магадгүй 10 хувьтай, 12 хувьтай байхаар тэгээд тэр нь зах зээлийн хүүн дээр оччих юм бол энэ 2 дахь зах зээл маань эргэдэг буюу яг анхны тооцсон энэ ипотекийн зээлийн энэ зорилтот зах зээл маань ажиллах бололцоо бүрдэнэ ээ гэж харж байгаа.

Гурав дахь асуудал мэдээж энэ төв банкны хараат бус шийдвэр гардаг асуудал бол мөнгөний бодлогын хорооны л хараат бус байдлыг хангах ёстой асуудал болж байгаа. Одоо энэ ханш суларч байгаа асуудлууд мэдээж маш олон хүчин зүйлсээс хамаарч байгаа. Импортын өсөлт байна, экспортын өсөлт бага байгаа импорт өндөр байгаа дээрээс нь нэмэх нь энэ том төсвийн тэлэлт мега төслүүд маань урьдчилан зарлагдаад яг санхүүжүүлэлтүүд маань гадаад валютаар

орж ирээгүй маань зах зээлийн хүлээлтэд тодорхой түвшинд нөлөөлж байгаа асуудлууд байгаа.

Д.Амарбаясгалан: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: 2 асуудал байгаад байна. Хүүн дээр хязгаар тогтооно гэдэг маань зээл олдохоо болино л гэсэн үг, тэгээд нөгөө банк бус руугаа явдаг болно л гэсэн үг. Сая уг нь бодлогын хүүгээ оролдох биш харин тэр банканд байх тэр нөөцийг нь багасгах тал дээр заавал байх нөөцөө л багасгах тийм шийдвэр гарсан бол иргэд маань банкнаас зээл авах боломж нь илүү нэмэгдэх байсан байхгүй юу. Зээл авах боломж бизнес эрхлэх боломж нь нэмэгдэх байсан. Бодлогын хүүгээ бууруулангуутаа бид нар зөрүүлээд л нөгөө нөөцөө ихэсгэчихээр чинь яаж байна гэхээр нөгөө хүмүүс чинь зээл нь олдохгүй болохоор яах вэ нөгөө банк бус руугаа явна, нөгөө жилийн гучин хэдэн хувьтай, дөчин хэдэн хувьтай хүүтэй зээл рүүгээ л явах энэ юу руу л хийчхээд байна л даа. Би энийг л хэлээд байгаа. Одоо энэ бодлогын хүүгээ ер нь жоохон эдийн засгийн нөхцөл байдлаа хардаг. Хэр эдийн засаг тэлж байна, хэр халж байна гэдгээ харж бодлогын хүүг оролдоо.

Тэр нөөцөө бид нар нэг жоохон хөдөлгөж өгөхгүй бол банкнууд нэг бол эрсдэлгүй гээд л очоод л төв банканд дээр мөнгөө байршуулчихдаг. Тэгээд нөгөө банк бусаараа өөрийнх нь хамаарал бүхий банк бусаараа зээл гаргадаг тохиолдол их байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Сэддорж гишүүн асуулт асууя. Алга байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Хэд хэдэн асуултыг би асуу асууя гэж бодоод байна.

Нэгдүгээрт төсөв мөнгөний бодлогын уялдаа гэдэг асуудлыг бид нар их олон жил ярьсан. Одоо ингээд төсөв нь нэг талдаа тэлээд алга боллоо. Түүхэндээ байгаагүй магадгүй хамгийн том төсвийг эд нар хэлэлцэх гэж байна. Тэгээд энэ хэмжээгээр ер нь зардал нэмэхийг чинь энэ эдийн засаг нь даах юм уу даахгүй юм уу гэдэг асуудал байгаа. Монголбанкныхан энэ дээр юу гэж үзэж байгаа юм. Тэгээд бид нар нэг талдаа юу гэдэг юм төсөв мөнгөнийхөө бодлогын уялдааг ер нь яаж хангах ёстой байдаг юм. Нөгөө онгоцны мотороор авч үзэх юм бол нэг мотор нь цохичих юм бол эсвэл ачаалал их авах юм бол нөгөөдөх дээрээ л ачаалал их ирэх байх даа. Тэгэхээр Монголбанканд дээр ирэх ачаалал бол илүү хүнд бус болов уу гэж бодоод байдаг. Инфляцынхаа асуудлыг ирэх жилүүддээ барьж чадах юм уу, чадахгүй юм уу? 6 хувь дээр нэмэх нь 2 хувь гэдэг асуудал дээшээ доошоо гээд байгаа. Энэ өөрөө бодитой юм уу гэдэг асуудлыг би асуух гээд байгаа юм.

Яг үнэндээ бол энэ яг мөнгөний бодлого дээр чинь орон зай үүсэх юм уу? Хэрэв үүсэхгүй бол энэ хувийн хэвшил чинь бол орон зайгүй болох л ийм асуудал үүсэх гээд байна гэдэг асуудал байгаа. Энэ дээр та хэд нэгдүгээрт юу гэж үзэж байгаа юм?

Хоёрт зүгээр би иргэдээс хамааралтай асуудлыг нэг асуучихъя аа. Өнгөрсөн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд бизнес болоод хэрэглээний зээлийн хүү хамгийн өндөр байгаа. Ер нь яг манайх шиг ийм 20 хувиас дээш давсан зээлийн хүүтэй улс орон ер нь хэд байдаг юм. Тэрэн дээр та хэд нэг судалж үзсэн зүйл байна уу гээд нэг их олон ч улс орон байхгүй байх гэж бодоод байгаа юм. 10, 20 улс л

байдаг байлгүй дээ. Тэгэхээр үндсэндээ зээлийн хүү 22-оос 28 хувьтай байгаад байна. Зээлээс зээлийн хооронд ард иргэд ААН байгууллагууд яваад байдаг. Засгийн газар нь ч ард иргэд нь ч өрийн хавханд гацаад байдаг. Тэгээд бид нар уг нь өртэй хүн өөдөлдөггүй гэж явдаг. Гэтэл өнөөдөр үндсэндээ зээл аваагүй хүн гэж байхгүй болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр энэн дээр яах юм бэ? 22-оос 28 хувийн хүүтэй бизнес болон хэрэглээний зээлийн хүү өндөр байгаад байдаг. Ард нийтээрээ хүүлэгддэг хувийн хэвшил өөрөө ширгээд байхгүй боллоо. Өрхийн болон хэрэглээний зээл чинь өөрөө бас гарахаа больчихлоо. Тэгэхээр хэрэглээний зээлээр нэг талдаа би бол харж байгаа зүйл бол банкнууд өөрсдөө хүүлээд эргээд өөрсдийнхөө бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлдэг, цаана нь дагаад банк бус байгууллагуудын чинь үйл ажиллагаа өргөжөөд байдаг асуудлууд байна. Яг энгийн жирийн очих ёстой хүн дээрээ бизнесийн зээл нь өөрөө олдохоо больсон. Эцсийн дүндээ очдог ганцхан цэг нь ББСБ болчихдог. Тэр нь тэгээд магадгүй 30, 40 хувийн хүүтэй болдог. Ийм зүйл л байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр яах юм Монголбанк ер нь юу гэж бодож байна. Энэ арилжааны банкнууд дээрээ ер нь ямар дүгнэлт хийж байгаа юм. Ер нь яах ёстой юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм.

Хоёрдугаарт сая бид нар бас төрөөс хэд хэдэн ч яг ер нь очих ёстой хүнд нь бодлого, зээл, санхүүжилтийг нь очуулъя, хэрэгжүүлъя гэдэг бодлогоор хэд хэдэн бодлогын асуудлууд явуулж үзсэн. Эцсийн дүндээ банкн дээр очихоор банкны шалгуур шаардлага гэдэг зүйлийг давж чадахаа больж байна аа жирийн иргэдийн хувьд. Дотоод дүрэм журам стандарт гэдэг асуудлаараа тавиад эргээд магадгүй тодорхой хэмжээнд цаг хугацаанд тодорхой мөнгө дээрээс олгосон санхүүжилт, татаас, урамшуулал, дэмжлэгийг гацаадаг. Энэ асуудлууд байгаад байгаа. Энэ дээр Монголбанк хяналтаа тавьж чадаж байна уу үгүй юу? Ер нь бид нар яаж ер нь цаашдаа энэ зээлийн хүүг бууруулах юм? Иргэдээ хэт энэ өндөр зээлийн хүүгээс хамгаалах юм? Зах зээлийнх нь жамаар бууруулах энэ ажлыг хийх ёстой юм бэ? Уг нь төр тодорхой хэмжээнд зохицуулалт хийх ёстой. Тэр дундаа Монголбанк энэ зах зээлийнх нь жамаар бууруулах, хүүг бууруулах, иргэдээ хамгаалах энэ бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэж хараад байгаа юм. Энэн дээр та хэд маань юу гэж үзэж байна? Сая Банкны тухай хуулиуд дээр бид нар холбогдох өөрчлөлтүүдийг хийсэн.

Эргээд үр дүн гарч байгаа зүйл бол байхгүй байгаад байна. Магадгүй цаашдаа бид нар тэр мөнгө хүүлэлтийн эсрэг хууль гаргах ёстой юм уу? Хуулиа өөр ямар байдлаар чангаруулах ёстой юм. Эдийн засагт энэ эрүүл өрсөлдөөнийг яаж бий болгох юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Энэн дээр нэг хариулт өгөөч ээ л гэдэг асуудал байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. Баярдаваа дарга.

Б.Баярдаваа: Яг одоогийн байдлаар зээл эдийн засагт 30 хувийн өсөлттэй байгаа. Тэгэхээр зэрэг олон улсын байгууллагууд, зээлжих зэрэглэлийнхэн, валютын сан гэх мэт хөндлөнгийн судалгаа хийдэг шинжилгээ хийдэг байгууллагууд зээлийн чинь өсөлт хэт өндөр болоод байна шүү. Цаашдаа энэ зээлийн хэт өндөр өсөлт инфляцыг араасаа дагуулж магадгүй шүү гэсэн ийм дүгнэлтийг өгч байгаа. Энэ утгаараа бид нар их болгоомжилж байгаа. Зээлийн хүүг бид нар ингээд нэг богино хугацааны арга хэмжээ аваад бол нэг тодорхой хэмжээнд буурах боловч эргээд л өсчихнө. Тэгэхээр яаж зээлийн хүү буурах вэ гэхээр энэ бусад улс

орнуудын судалгаанаас харахаар 2 хүчин зүйл, 3 хүчин зүйл их чухал байдаг юм байна.

Нэгдүгээрт ерөөсөө инфляц бол маш бага түвшин рүү бууж ирэх ёстой. Инфляц бага түвшин рүү бууж байж хадгаламжийн хүү нөгөө нэг бодит үнэ цэнээрээ үнэ цэнээ алдахгүй байхын тулд хадгаламжийн хүү бууна.

Хоёрдугаарт нь валютын ханш тогтвортой байх ёстой. Валютын ханш тогтвортой байхын тулд гадаад валютын нөөцийн хүрэлцээ нэмэгдэх ёстой. Энэ 2 үзүүлэлт хэлбэлзэл буурч байгаа, буурсан тохиолдолд зээлийн эх үүсвэрийн суурь өртөг өөрөө тогтвортойгоор бууж ирнэ. Энэ нь өөрөө эдийн засгийн тогтвортой байдлыг хангадаг гэсэн ийм дүгнэлт байгаа. Энэ улс орнуудын судалгаанаас харахаар зээлийн хүү 10-аас дээш хувьтай энэ улс орнуудын дундаж инфляц сүүлийн 10 жилд 7.9 хувь байгаа бол зээлийн хүү нь 10-аас бага байгаа улс орнуудын хувьд инфляц сүүлийн 10 жилд 2.8 хувь. Үндсэндээ 3 дахин бага инфляцтай байгаа. Валютын ханшийн хэлбэлзлийг нь авах юм бол яг ийм үзүүлэлт байгаа. 10 хувиас дээш зээлийн хүүтэй улс орнуудын валютын ханшийн өөрчлөлт 7.3 хувь, 10-аас бага зээлийн хүүтэй улс орнуудын валютын ханшийн өөрчлөлт 2.3 хувь бас 3 дахин бага.

Тэгэхээр Төв банканд энэ инфляцыг бууруулах Засгийн газарт валютын нөөцийг нэмэгдүүлэх нийт нийлүүлэлтийн гадаад худалдааны хөрөнгө оруулалтын бодлогыг тууштай хэрэгжүүлэх энэ зүйл оногдож байж энэ нь тогтвортой хэрэгжиж байж энэ нөхцөл биелж энэ бизнесийн зээлийн хүртээмж зээлийн хүү улс орон даяар тогтвортойгоор ийм буурах бололцоо буух юм билээ. Одоогийн байдлаар банкны энэ систем дээр бол хэрэглээний зээлийг хэт өсөлтийг хязгаарлах бизнесийн зээлийг нэмэгдүүлэх чиглэлээр өнгөрсөн жилийн үндсэн чиглэлийн тогтоолын төсөл дээр Монголбанканд бол үүрэг өгсөн. Энэний дагуу тодорхой арга хэмжээ бол авсан. Хэрэглээний зээлийн хувь хэмжээ бол бага зэрэг буурч эхэлж байгаа. Эргээд бизнесийн зээлийн өсөлт бол нэлээд их хэмжээгээр бол энэ жилийн хувьд 2 дугаар улирлаас эхлээд нэмэгдсэн ийм дүр зурагтай байгаа. Энэ бодлого ирэх жил рүү энэ үр дүн нь илүү гарах байх гэсэн ийм хүлээлттэй байгаа. Яагаад Монголбанк хэрэглээний зээл дээр шалгуур үзүүлэлтүүд тавиад байгаа вэ гэхээр зэрэг банкны систем санхүүгийн системийн 90 хувийг тодорхойлдог. Ийм байгууллагын хувьд бол хөрөнгө оруулалтын төслийн бизнесийн зээлийн гол эх үүсвэр нь банкны систем өөрөө байх ёстой гэдэг үүднээс банкны зээлийн эх үүсвэрийг дийлэнхийг нь бизнесийн зээл рүү ажлын байрыг нэмэгдүүлдэг энэ зээл рүү чиглүүлэх л ийм санаа том макро.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Баярдаваа даргад баярлалаа.

Би яах вэ зүгээр нэг талдаа яах вэ улс төрийн маягтай асуултууд асуусан байх. Та жоохон онлайн маягтай хариулаад байна. Би зүгээр хэлээд байгаа нь энэ ирэх 4 жил чинь улсын төсөв чинь тэлж байна, зардал нэмэгдэж байна. Энэ эдийн засаг даах юм уу? Монголбанк энэ зургаа дээр нэмэх нь 2 хувиа даах юм уу гэдэг асуудлыг асуугаад байгаа юм.

Дээрээс нь манайх шиг 20 хувиас дээш нь банкны зээлийн хүүтэй улс орон хэд байдаг юм гэдэг асуудлыг асуугаад байгаа юм. Та хэд бас л ер нь энэ талаар мэдээлэлтэй л байгаад байгаа.

Дээрээс нь ер нь яах юм бэ? Бид нар энэ эдийн засаг чинь эрүүл өрсөлдөөнийг бий болгомоор байна. Банкны чинь салбараас өөр энэ юу гэдэг юм даатгал болоод хөрөнгийн зах зээлээ хөгжүүлмээр байдаг. Хөгжүүлдэггүй 20, 30 жил болчихдог. Бид нар нэг санаачилга гаргаад ганц нэг хууль хийгээд даатгалын тогтолцоо бий болгоё. Барьцаа баталгаа шаарддаггүй болъё гэхээр ингээд хөдөлгөж өгдөггүй. Магадгүй банкныхаа доор нь бүх энэ санхүүгийнх нь салбарууд нь өөрөө доороо орчихсон. Ингээд нэг ийм юу гэдэг юм яг л мөнгө хүүлдэг л ийм систем л хөгжчихөөд байна л даа. Тэгэхээр энэ дээр та хэд маань яах гээд байгаа юм бэ? Ер нь яг юу гэж бодож байна? Яаж бид нар төр зохицуулах юм?

Д.Амарбаясгалан: Баярдаваа дарга ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Баярдаваа: Тэмүүлэн гишүүний асуултад тодруулж хариулъя.

Төсөв мөнгөний бодлогын уялдаа маш чухал. Ер нь бол энэ сүүлийн үеийн энэ Монгол Улсын энэ бодлогын түүхээс харах юм бол мөнгөний бодлого бол дандаа л төсвийн бодлогын бодлогын үр дагаврыг зөөлрүүлэх зорилгоор ингэж хэрэгжиж явж байгаа. Ирэх жилийн төсвийн зардал ч гэсэн том байгааг та дурдаж байна. Энэнтэй холбогдуулаад мөнгөний бодлого дээр тодорхой хэмжээний зохицуулалт тохируулгууд хийгдэх шаардлага үүсэж магадгүй. Гэхдээ мөнгөний бодлого дээр хатуу арга хэмжээ авахгүй байх бололцоо нь түрүүний хэлсэн тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээс үүдэлтэй инфляцын дарамтыг нийлүүлэлтийнх нь тогтвортой байдлыг хангах замаар бий болгов. Сөрөг нөлөөлөл бол зөөлрөх болов уу гэсэн ийм хүлээлттэй байна, саналтай байна. Өндөр зээлийн хүүтэй улс орнууд бол Узбек, Киргиз, Тажик гээд энэ Монголтой ойролцоо улс орнууд бол бас байгаад байгаа. Эрчимтэй хөгжиж байгаа улс орнууд гэвэл Перу тэгээд Армен гэх мэтчилэн энэ улсууд бол Монгол Улсдаа хөгжлийн.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Төв банкнаас асуулт асууя. Энэ 2025 оны энэ төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл түрүүлж батлагдах ёстой байдаг юм уу эсвэл төсөв нь түрүүлж батлагдах ёстой байдаг уу энэ дэс дарааллын тал дээр байр сууриа илэрхийлээч гэж ямар хамгийн зөв зүйтэй нь ямар дэс дараалалтай байх ёстой юм. Тэрийг яг нэг тодорхой хариулаач ээ гэж хүсэх байна.

Хоёрдугаарт энэ Лхагваа даргатай энэ баг хамт олон олон жил ажилласан гэж ойлгож байгаа. Таны энэ ажиллаж байх хугацаанд энэ бичил бизнесээс жижиг рүү жижгээс дунд руу хэчнээн ААН дээшээ хөгжив өө? Өнгөрсөн 2022 оноос хойш өнөөдрийн өдрийг хүртэл макро эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарч эхэлж байгаа юм. Эергээр явж байгаа юм. Гэтэл нөхцөл байдал юу байгаа билээ. 500 орчим банк бус байгууллага, 12 банк үндсэндээ яг банкныхаа ажлыг хийхгүй байгаа шүү дээ. Банктай байгууллагууд өнөөдөр уул уурхайтай байгууллагууд өөрсдөө бараг өнөөдөр ресторан ажиллуулаад байна шүү дээ. Энэ жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ үйл ажиллагаа руу нэвтэрч орж байгаа юм бүр тодорхой жишээгээр нь ч хэлж болж байгаа юм.

Энэн дээр төв банк энэ зээл энэ мөнгөний бодлогоороо дамжуулаад ямар эерэг үзүүлэлт үзүүлсэн юм бэ. Ялангуяа танаар ахлуулсан энэ баг өнгөрсөн 4 жилийн хугацаанд юу хийв гэдгийг асуумаар байна.

Гуравдугаарт, энэ иргэдээс маш олон ийм тодорхойгүй зүйлүүд байгаад байгаа юм. Иргэд зээл авахаараа зэрэг үндсэн төлбөрөө төлж чаддаггүй дийлэнхдээ хүүгийн төлбөр төлөөд өрийн дарамтад байгаад байна гэж байгаа юм. Танай баг хамт олон үүний эсрэг тал дээр ямар арга хэмжээ аваад ямар үр дүнд хүрэв ээ? Ер тодорхой юм алга. Тэгээд дээрээс нь энэ 2025 оны төсвийн төсөөлөлтэй танай баг хамт олон танилцсан байх гэж бодож байна. Энэ төсвийн төсөлтэй танай үйл мөнгөний үндсэн чиглэл зөрчилдөж байгаа зүйл байгаа юу. Аль зүйл заалт нь зөрчилдөж байна эсвэл нам төвтэй 100 хувь дэмжиж ажиллаж байгаа юу? Төв банк үндсэндээ төсвөөс хараат бус. Одоо энэ Засгийн газраас хараат бус байж чадаж байна уу? Үүнийгээ маш тодорхой илэрхийлмээр байна. Ийм 4 асуулт асуулаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Энэ мөнгөний бодлогыг Улсын Их Хурал дээр батлах, төсвийг батлах энэ өөрөө ингээд хуулийн зохицуулалттай. Ямар ч байсан тухайн оны 10 сарын 1-нээс өмнө мөнгөний бодлогыг өргөн барьсан байх ёстой. Энэ жил Төсвийн хуульд өөрчлөлт оруулаад 9 сарын 1-нээс өмнө өргөн барьсан байх ёстой гээд. Төсвийн хувьд батлах хугацаа нь байдаг. Их Хурал ийм хугацаанаас өмнө батлах ёстой. Энэнээс хойш баталбал дараагийн зохицуулалтын өөр зүйл рүү ордог гээд. Мөнгөний бодлогын хувьд бол Монгол Улсын Үндсэн хууль дээр Улсын Их Хурал мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батална гээд ингээд Үндсэн хууль дээр ингээд заачихсан байдаг учраас ингээд мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ өргөн бариад жил болгон ингээд батлуулаад явдаг байгаа. Тэр утгаараа бол ер нь бол яг төсвийнхөө өмнө батлагдах, төсвийн хойно батлагдах дээр зарчмын бараг ялгаа байхгүй. Зүгээр Төв банкны хараат бус байдал гэдгээрээ угаасаа өргөн бариад явж байгаа учраас хэзээ ч батлагдсан өмнө нь ч батлагдсан байсан адилхан гэж Төв банкны зүгээс харж явдаг аа. Ер нь бол энэ өнөөдөр энэ Монголбанкны удирдлагын баг хамт олон маш тогтвортой байдаг. Яагаад гэвэл нэлээн тийм мэргэжлийн баг хамт олон байдаг учраас мэргэжлийн ажлаа хийгээд явж байгаа. Яах вэ үр дүн гээд та асуулаа. Ямар ч байсан сүүлийн 4 жил бол дэлхийн өнөөдөр ч гэсэн дэлхийн ихэнх улс орон, төв банкнууд, эдийн засаг судлаачид бүгдээрээ л хэлж байгаа. Ковид гээд дэлхийд 100 жил болж байгаагүй ийм цар тахал дэлхийд хамрагдсан. Урьд нь глобалчлагдсан дэлхий гэж ярьж хамтын ажиллагаа маш их идэвхтэй байсан бол одоо геополитикийн нөхцөл байдлаас болж туйлуудад хуваагдаж байна. Дэлхийн эдийн засаг улс орнуудад янз янзын туйл руу ингээд хуваагдаж байгаа. Хоорондоо бие биеийнхээ эсрэг хориг арга хэмжээ авч байгаа. Хамтын ажиллагаа бараг байхгүй болж байгаа ийм төвөгтэй цаг үе байгаа. Тэгэхлээр ийм төвөгтэй цагийн үе ард бол Монгол Улс бүрэн гарч чадсан гэж Төв банкны зүгээс харж байгаа.

Яагаад гэвэл 2020 онд эдийн засаг 1.4 хувиар унаж байсан бол сүүлийн 2 жил гэхэд өнгөрсөн онд 7.6 хувийн өсөлттэй энэ жил бол 6 хувийн өсөлттэй гарахаар, дараа жил 2025 онд 7-оос 8 хувийн өсөлттэй гарахаар ингээд олон улсын байгууллагууд хүртэл ингээд төсөөлөөд явж байгаа учраас бол ямар ч байсан мөнгөний бодлогын энэ баг хамт олны хийж байгаа гаргаж байгаа шийдвэр үйл ажиллагаа бүр дүнд хүрээд явж байгаа гэж хэлж болохоор байгаа. Зүгээр зарим нэг тоонууд дурдах юм бол Монгол Улсын валютын нөөц оны эхэнд 5.2 тэрбум доллар гэдэг түүхэн дээд хэмжээ байгаа. Мөн нийт банкны системийн актив хөрөнгө бол 66

их наяд үүнээс нь гаргаж байгаа зээлийн хэмжээ 34 их наяд төгрөгт хүрсэн. Энэ бол бас л өмнө нь байгаагүй ийм тоон хэмжээнүүд байгаа. Инфляц бол өөрөө зорилтот түвшний хүрээнд байна. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд энэ зорилтот түвшнийхээ хүрээнд явж байгаа. Ирэх жил ч гэсэн энэ хүрээндээ.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Нэгдүгээр асуултын дэс дараалал Монголбанк хариуцлагагүй байна. Хууль дээр чинь заачихсан байна. Төсвийн төсөл мөнгөний бодлоготойгоо уялдана гээд. Тэр 27.1 дээр нь байна уу хэд дээр нь байна 10.1 ч байна уу. Тэрэн дээр заачихсан байна. Танай байгууллага яах ёстой вэ гэхээр төсөв өргөн баригдахаас өмнө мөнгөний бодлого батлагдсан байх ёстой тэрэндээ нийцэж төсөв боогдсон байна гээд хуульчилчихсан байна шүү дээ. Энэ хуулийнхаа орчныг өөрчлөх тал дээр санал санаачилга гаргаагүй.

Хоёрдугаарт бичил бизнес эрхэлдэг, жижиг, дунд бизнес эрхэлдэг нөхдүүд хэд нь ингээд үе шаттай ахисан юм бэ? Тоо хэлээдэх гэхээр зэрэг шал өөр юм яриад байх юм. Энэ банкнууд чинь бизнес эрхлээд байна. Банкныхаа ажлыг биш. Энэ жижиг дундтайгаа өрсөлдөөд байна гэж хэлээд байна шүү дээ. Та бол яг энийг хорлосон хүн байхгүй юу. Энэ ковидын араас эдийн засгаа босгох ёстой энэ эдийн засгийн чинь цусны эргэлт болж байгаа жижиг дундынхныгаа дэмжих.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Байна уу? сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе. Юм уншаад сууж байсан чинь цаг болчихсон байсан.

Нэгдүгээрт нь банкны салбарын тойм гээд энэ Монголын банкны холбооноос гарсан энэ тоймыг харсан юм. Бид нар Эдийн засгийн байнгын хороогоор бас өчигдөр хэлэлцсэн. Өнөөдөр энэ чуулганаар нэлээн олон гишүүд өчигдөр өнөөдөр ингээд давхацсан байдалтай асуултууд асууж байна. Аль болохоор давхцахгүйн тулд асууж байгаа юм.

Тэгэхээр нэгдүгээрт та бүхэн юу гэж бодож байна? Энэ арилжааны энэ тоймоос харахад тухайлбал бусад улстай харьцуулахад 100 мянган хүнд оногдож байгаа банкны салбар нэгжийн тоогоороо Монгол Улс нэлээн өндөр байгаа байхгүй юу. 62. Гэтэл бусад төстэй улсуудад 20, 30, 37 энэ тэр гэсэн тоонууд байна. Энэ тойм дээр. Тэгэхээр энэ нь зүгээр би хөндлөнгөөс бодоход тухайлбал магадгүй тухайн банкнуудын ашигт ажиллагаа өндөр байна гэсэн гэсэн ийм илэрхийллийг хэлж байна гэж үзэж болох уу? Ер нь банк байгуулахад тавигдаж байгаа шаардлага шалгуур ямар байгаа вэ? Өнөөдөр Монголд мөнгөтэй гэсэн хүн болгон л хүн болгон гэнэ ээ уучлаарай мөнгөтэй хүмүүс, хөрөнгөтэй хүмүүс банк байгуулах ийм боломжтой байгаад байна уу? Гэтэл банк санхүүгийн салбар чинь өөрөө маш их ийм эмзэг харилцагчид болон хадгаламж эзэмшигчдийн итгэлцэл дээр тогтдог ийм онцгой салбар мэдлэг маш их чухал.

Тэгэхээр энэ дээр та бүхэн юу гэж бодож байна? Өмнөх 3 удаагийн дампуурсан 3 банк байгаа. Одоо 2 банк. Өмнө нь гишүүд ч гэсэн хөндөж байсан асуудал. Ингээд үйл ажиллагаа нь гагцхисан мөртөө яг юу болж байгаа нь бүү мэд ингээд байгаад байгаа 2 банк бас та бүхэн мэдэж байгаа.

Дараагийн нэг асуудал нь ингээд сонсоод байхад өмнө нь би эдийн засгийн клуб 8, 9 жил ажиллуулсан. Манай энэ Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрэн болон бусад хүмүүс удаа дараалан очиж, иргэдтэй нээлттэй, ил тод ярилцаж байсан. Ийм хүмүүс энэ эдийн засгийн клубийг сайн мэднэ. Тэгээд аливаа бүх асуудлыг ярихаар Монголд ер нь хамгийн гол асуудлын учир шалтгаан нь улс төржчихсөн байдалтай холбогдоод явчихдаг. Тэгэхээр бас бид нар Монголбанкны Төв банкны бие даасан байдлыг олон жил ярьж байна. Ер нь энэ байдлыг та бүхэн өнөөдөр хэр түвшинд байгаа гэж үнэлж байна? Улс төрөөс хамааралтай байна уу? Энэ гишүүдийн асуусан асуултад ерөнхий юм уу тодорхойгүй байдлаар хариулаад байгаа нь эргээд үүнтэй холбоотой байж болох уу? Энэ тал дээр бие даасан байдлыг нэмэгдүүлэхийн тулд та нарын гол тавих хүсэлт санал юу байж болох вэ? Баярлалаа. Ингээд давхцуулахгүй 2 гол асуултыг асуучихъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө Монголын энэ банк санхүүгийн зах зээл дээр байгаа тэр орлого бусад улсуудын банк санхүүгийн байгууллагын орлоготой харьцуулахад яах вэ жоохон зөрөөтэй байгаа нь тэр ер нь банкны орлого бол өөрөө нэг бол хүүгийн орлого, нэг бол хүүгийн бус орлого. Хүүгийн бус орлого гэдэг тэр шимтгэл хураамжийн л орлого байгаа л даа. Тэгэхээр өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд бол хүү угаасаа нам доор түвшинд байдаг. Тэр утгаараа өндөр хөгжилтэй улс орнуудын банкны хүүгийн орлого нь бага шимтгэл хураамжийн орлого нь бол маш өндөр байдаг. Жишээлбэл одоо тэр төлбөр тооцоо хийх, картын хураамж, карт, бэлэн мөнгө, машинаас гарахад авах хураамж, мөнгө сольж шилжүүлэхэд гарах хураамж гэдэг юм уу тэр орлого нь маш өндөр байдаг. Яагаад гэвэл энэ нь өөрөө нөгөө түрүүчийн бид нарын яриад байгаа нөгөө тэр мөнгөний зах, хөрөнгийн зах 2-ын өрсөлдөөнөөсөө болж гарч ирж байгаа юм.

Тэгэхээр хөрөнгийн зах өндөр хөгжилтэй улс орнуудад банк зуучлал дээрээ нэл нэлээн өндөр. Яагаад гэвэл хөрөнгө оруулалтын банкнууд олон байдаг. Банкны салбараасаа хөрөнгийн зах дээр хөрөнгө оруулалтуудыг их хэмжээгээр хийж хувьцаа бонд дээр ажилладаг гэдэг утгаараа тэр хүү шимтгэлийн орлого нь өндөр яваад байгаа. Манай улсын хувьд бол харин хүү шимтгэлийн орлого нь бага. Яагаад гэвэл хүү шимтгэл дээр нэлээн асуудал үүсдэг. Харилцагчийн зүгээс маш их гомдолтой байдаг. Одоо жишээлбэл зээл гаргасны хураамж ч гэдэг юм уу зээл олгохоос өмнө судалсны хураамж байхгүй байх ёстой ч гэдэг юм уу энэ маягаараа яригддаг учраас бол дийлэнх орлого нь бол хүүн дээрээ орлого олоод явж байгаа ийм зүйл байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд бол одоо түрүүн би гишүүний асуултад тайлбарлаж байсан. Ялангуяа тэр 2 нэлээн хүндрэлд орчихсон 2 банкны асуудал угаасаа тогтворжуулах төлөвлөгөө хэрэгжүүлээд явж байгаа. Хөрөнгө оруулагч ороод ирэх юм бол тэр банкнууд хэвийн байдалд орох бүр бүрэн боломжтой ийм банкнууд байгаа. Нөгөө талаар бол ялангуяа Монгол Улсын эдийн засаг сэргэж байгаатай холбогдуулан гаднын хөрөнгө оруулагч нар бол одоо бас банк санхүүгийн салбарт оролцох сонирхол нэлээн их байна гэдэг нь тухайн банкнуудаас ирж байгаа мэдээллээс харагдаад байгаа.

Тэгэхээр энэ утгаараа бол ерөнхийдөө гаднын хөрөнгө оруулагчид энэ 2 банк руу орох юм байна гэсэн ийм хүлээлттэй Төв банк байж байна.

Гурав дахь нь Төв банкны бие даасан хараат бус байдалтай холбогдуулаад хэлэхэд Монголбанк бол өнөөдөр хуулиараа бол мэдээж бие даасан хараат бус байдалтай ийм үйл ажиллагаа явуулах зохицуулалттай байгаа. Улсын Их Хуралд ажлаа байнга тайлагнадаг. Мөнгөний бодлогын хэрэгжилт гэж хавар орж ирдэг. Мөнгөний бодлогоо өргөн бариад явдаг улирал болгон тайлангаа ингээд өгөөд явдаг. Дээр нь Улсын Их Хурлаас Монголбанкны үйл ажиллагааны ялангуяа төсөв санхүүтэй холбоотой энэ хяналтын зөвлөлийг ажиллуулж ингээд хяналт тавиад явдаг байгаа.

Тэгэхээр бол ерөнхийдөө яг Засгийн газартаа бол яагаад өнөөдөр ингэж хараат байна уу үгүй юу гэж асуудал хөндөгдөж байгаа вэ гэхээр та бүхэн сайн мэдэж байгаа. Ковидын үед ялангуяа энэ геополитикийн хурцадмал нөхцөл байдалтай энэ үед бол яалт ч байхгүй Засгийн газар, Монголбанк үйл ажиллагаагаа уялдуулж явж байгаа. Ковидын үед.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Ковидын үед бол Засгийн газрын 10 их наядын хөтөлбөр хэрэгжүүлэхэд бол ажлын байрыг дэмжих ялангуяа түрүүн гишүүний бас гишүүний асуултад хөндөгдөж байсан тэр бизнесийг яаж дэмжиж байгаа вэ гэдэг дээр ялангуяа тэр ковидын үед бол Монголбанкны зохицуулалтыг бол маш хөнгөлсөн. Бүтцийн өөрчлөлт хийж болно. Бүтцийн өөрчлөлтийг журмаараа 2 дахин хийх байсан бол 2-оос илүү удаа хийхээр зохицуулсан байгаа. Ялангуяа жижиг дунд үйлдвэрт зээл гаргах асуудлыг дэмжих зүйл дээр би одоо тоо хэлэхэд 71100 ийм иргэн 3.5 их наяд төгрөгийн 10339 ААН 4 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлд ингээд хамрагдаад явж байгаа. Жишээлбэл өнөөдөр үлдэгдэл нь ийм байна.

Дээр нь одоо яг өшөө нэг нарийн макро том тоо хэлэхэд бол Монгол Улсын эдийн засаг хагас жилээр 5.6 хувийн өсөлттэй хэдий боловч хэрвээ уул уурхай ХАА салбарыг нь хасаад худалдаа, аж үйлдвэр, үйлчилгээ.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууна аа.

Б.Батбаатар: Энэ чуулган дээр орж ирж байгаа Монголбанкны мөнгөний бодлого оруулж ирж байгаа зүйлийг дотроос нь нэг их асуугаад байх зүйл алга даа. Нөгөө нэгдүгээр ангийн хүүхэд асуугаад хариулт нь тодорхой асуулт хариулт яваад байх тийм зүйл хиймээргүй байна. Иргэний Зориг ногоон намын Улсын Их Хурлын сонгуулийн үеийн мөрийн хөтөлбөрт БНХАУ-ын Ардын банк, Монголын төв банк хооронд байгуулсан своп хэлцлээр байгуулагдсан. Бараг 4 орчим тэрбум доллар дээр очсон гэсэн. Тэр своп хэлцлийг улс төр эдийн засгийн аргаар тэглэх хэрэгтэй. Энэ бол үндэсний аюулгүй байдалд чухал юм гэдэг байдлаар мөрийн хөтөлбөрт орсон. Мөн Иргэний Зориг ногоон намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгө хүүлэлтийн эсрэг хуулийг санаачлан батлуулж энэ мөнгө хүүлэлтийн дарамтаас иргэд сонгогчдыг гаргах чиглэл рүү энэ дарамтад өртүүлэхгүй байх чиглэл рүү ажиллана гэсэн. Алслагдмал бүс нутгууд нутгийн санхүүгийн үйлчилгээг сайжруулах энэ чиглэлийн ажлуудыг хийнэ гэсэн. Ийм зүйлүүд мөрийн хөтөлбөрүүдэд маань байгаад байгаа юм. Бид нар бол энэ ажлаа хийх ёстой. Ийм гэрийн даалгавар авч энэ танхимд орж ирсэн хүмүүс.

Тэгэхээр энэ чиглэлээр ажиллахад Монголбанкны хувьд дэмжих зарим зүйл дээр санал солилцох энэ чиглэлээр ажиллах ямар зүйлүүд байна вэ? Эрх зүйн орчинд нь энд хууль тогтоогч нар ажлаа хийх байх. Монголын мөнгөний бодлогыг барьж байгаа та бүхэн бид нарын энэ саналуудтай холбогдоод ажлууд хийх нийтдээ 20, 30-аад төрлийн санхүүгийн асуудлууд манай мөрийн хөтөлбөрт орсон зарим нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орчихсон зүйлийг би та бүхнээс асуухгүй орчихоод байгаа юм. Тэгээд хариултаас нь хамаараад дахиад нэг ганц хоёр зүйл тодруулъя.

Тэр гадаадын банкнууд орж ирэхгүй байгаа тэр тухайд ямар хязгаарлалт давж чадахгүй байна вэ?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Эхний асуулт бол энэ тэрбум 12 тэрбум юанийн своп хэлцэл байгаа. Ер нь Хятадын ардын банк төв банкнуудын хооронд своп хэлцэл байдаг. Энэ санхүүгийн механизм угаасаа түгээмэл олон улсын ийм сайн стандарт жишиг байгаа. Тэр хүрээндээ ч гэсэн Монгол Улс Монголбанк Хятадын Ардын банкттай 2011 оноос хойш ингээд своп хэлцлийг хийгээд явж байгаа. Своп хэлцлийн дүн бол эхлээд 3 тэрбум байсан. Дараа нь 5 тэгээд л 10, 15 тэрбум болоод ингээд өсөөд явж ирсэн. Тэрбум юанийн. Ингээд 2016 оноос хойш энэ 12 тэрбумын юанийн өр үүсээд ингээд явж байсан бол өнөөдөр энэ өр зургаа болж буурсан. 6 тэрбум юанийн өрийг өнгөрсөн онд 1.5, энэ онд гараад 4.5 тэрбум юанийн өрийг төлөөд ингээд явж байгаа. Таны яг хөндөж байгаа энийг тэглэх ч гэдэг юм уу улс төр дипломатын аргаар шийдэх асуудлыг бас хөндөөд л өмнөх урд жилүүдэд ингээд явж байгаа. Тэгэхдээ Хятадын талаас Хятадын ардын банк юу гэж хэлдэг вэ гэхлээр энэ бол олон улсад байдаг 2 банкнуудын хооронд, санхүүгийн байгууллагуудын хооронд хийдэг санхүүгийн механизм учраас энэ энэ бол улс төр дипломатын аргаар шийдэх тэр дээгүүрээ шийдэгдэж байж л доошоо эргэхээс биш 2 Төв банкны хооронд ийм тэглэх тухай асуудал байхгүй ээ.

Дээрээс бол чиглэл ирэх юм бол энэ асуудлыг хөндөж болох юм гэдгээрээ хариу өгөөд явж байгаа. Тэгэхээр тэр утгаараа ч тэр нөгөө Монгол Улсын эдийн засаг эдийн засгийн үндэсний аюулгүй байдлын хараат бус байдлыг хангах үүднээс ямар ч байсан өр буураад төлөгдөх ёстой гэдгээрээ Монголбанк бол энэ арга хэмжээг хийгээд явж байгаа. Ер нь бол Монгол Улсын валютын нөөц оны эхэнд маш өндөр болсон учраас бидний хувьд ингээд төлөөд явахад эдийн засагт ямар нэг дарамтгүй байх юм байна л гэж харж байгаа. Мөнгө хүүлэлтийн эсрэг юу дээр Монголбанкны хувьд бол Санхүүгийн харилцагчийг эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг бол бичээд явж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ хуулийг санаачлах ийм боломжтой юм гэдэг санал гарсан утгаар Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтраад ажиллаад явж байгаа.

Тэгэхээр энэ харилцагчийн эрх ашгийг хамгаалах хууль дээр бол мөнгө хүүлэлтийн дээд хязгаарыг тогтоох тухай ийм заалт байгаа. Тэгэхээр энэн дээр ямар тоо байх юм. Тэгээд энэ хууль Улсын Их Хуралд яаж өргөн баригдах вэ гэдэг дээр л асуудал байгаа. Ерөнхийдөө хууль бол өргөн барих ийм 3 субъект байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүн. Тэгэхлээр

Монголбанкны хувьд бол энэ 3 субъектийн алинтай нь ч хамтран ажиллаад энэ хуулийг өргөн бариад явахад бэлэн байгаа. Алслагдсан бүс нутагт санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх асуудал дээр мэдээж энэ Монголбанкны нэг хийх ёстой ажил үүрэг мөн. Энэ утгаараа банкнуудтайгаа бол ажиллаад явж байгаа. Гол нь энэ ажил бол нэлээн сайн явж байна гэж төв банкны зүгээс харж байгаа. Яагаад гэвэл санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ улам цахимжиж байгаа. Цахимжина гэдэг маань заавал.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Тэгэхлээр цахимжиж байгаа гэдэг утгаараа бол жирийн малчин иргэн ч гэсэн өөрийнхөө гэрт байж байгаад бүтээгдэхүүн үйлчилгээгээ ингээд цахимаар зарах боломжтой болсон. Гадаадын банк, санхүүгийн байгууллагын хувьд яах вэ Монгол Улсын багтаамжийг өөрөө жижиг гэж л хараад байгаа юм л даа 3.5 сая хүнд үйлчилнэ. Дээр нь энэ Монгол Улсад 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаа учраас нэлээн өрсөлдөөн өндөр байх юм байна. Гаднын банкны сонирхож байгаа хэсэг нь ерөнхийдөө томоохон төсөлд л хөрөнгө оруулах сонирхол байдаг. Тэр утгаараа Оюу Толгой шиг ийм томоохон мега төслүүд ажиллах үед энэ банкнууд орж ирэх боломжтой гэдгээрээ 1 дүгээрт хэлж байгаа. Өөр нэг зүйл нь гэвэл энэ санхүүгийн зах зээлийн ялангуяа бидний 2025 онд хийх гээд байгаа тэр мөнгөний захыг хөгжүүлнэ гэдэг энэ заалт өөрөө гаднын банк санхүүгийн байгууллага орж ирж Монгол Улсад энэ дотоодын энэ зах дээр төгрөгийн энэ арилжаан дээр нэлээн идэвхтэй оролцох боломжтой болов уу гэж харж байгаа юм. Энэний гол үндсэн нөхцөл нь бол Засгийн газрын бонд байдаг. Тэгээд 2017 оноос хойш Засгийн газар ерөнхийдөө бонд гаргаагүй учраас.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Давхардсан саналууд нэлээн гарсан. Тэд нарыгаа орхичихъё. Зээлийн мэдээллийн сан, ипотекийн зээлийн хүртээмжийн талаар тэгээд хэрэглээний зээлийг хязгаарлах чиглэлд хөрөнгө оруулалтын банк хүү бууруулах тал дээр ажиллах талаар бүлгийн хурал дээр Лхагва Ерөнхийлөгч хариулж байсан учраас орхиод давхардахгүйгээр үнэ буулгах бодлого гээд энэ ипотекийн зээлтэй холбоотой яриад байгаа учраас энэ иргэний саналыг асууж байгаа юм. Энэ иргэний асуулт гэсэн үг. Түрээслээд өмчлөх байрыг дэмжих тал дээр ямар бодлого байгаа вэ гээд ээж аав нь орон нутагт ажиллаад хүүхдүүд нь оюутан болоод Улаанбаатар хот руу явдаг. Тэгээд байрны түрээсэнд өгөөд байгаа мөнгөө өөрсдөдөө хөрөнгө болгож үлдээх талаар түрээсэнд төлөөд байгаа мөнгөө түрээслээд өөрийн орон сууц болгох талаас нь ийм санал гаргаад байгаа юм. Тэгээд бас дээрээс нь ипотекийн зээлийн нөхцөл дээр өөрчлөлт оруулах боломжийн талаар асуугаад байгаа юм. Одоо урьдчилгаа 30 хувь гэж яригдаад байгаа. Урьдчилгаа 30 хувийг шууд төлөөд орон сууц авах иргэд төрийн албан хаагчид маш цөөхөн байгаа учраас энэ талаар асууж өгөөрэй гэж санал ирүүлснийг уламжилж байна. Тэгээд ер нь энэ үнэ бууралтын талаар дахиад ярихаар уг нь Японд жишээлэхэд сүү бол яг л нэг үнэтэйгээ эсвэл Японы иен доллартой харьцахдаа л тогтвортой байгаад байгаа юм. Гэтэл Монгол Улс бүр яг эсрэгээрээ сүү нь ч үнэд ороод байдаг төгрөг нь үнээ алдаад валют нь үнэд ороод байдаг иймэрхүү асуудлууд дээр энэ засгаа сөрөөд гэх юм уу юу гэдэг юм Монголбанк яг хараат бусаар валютынхаа ханшийг тогтвортой

байлгах чиглэлд яг энэ бодлогын шийдэл зоригтой алхам хийх боломж хэр байдаг юм бэ?

Бид нар одоо миний мэдэхийн энэ доллар чинь мянган төгрөгөөс эхэлж өссөөр байгаад л 3380 дээр ирчхээд байгаа юм. Энэ буух боломж буугаад 2000 ч юм уу, 1000 ч юм уу болох боломжийн талаар та бүгдийн амбиц урт хугацааны бодлого юу байдаг вэ гэж. Тэгээд өнгөрсөн хугацаанд яах вэ энэ Монголбанк нэг сайн ажиллаад валютын ханш тогтвортой байна уу гээд байхаар нөгөө талаас нь харах юм бол нүүрсний хулгай нэг хагас дутуу илрээд тэгээд нэг хагас дутуу бирж рүү гараад байгаа учраас бас нэг валютын ханш тогтвортой байгаад байх боломжтой магадлалтай юм болов уу гэж би зүгээр бодоод байгаа юм.

Дахиад дараагийнх нь асуудал болохоор энэ шимтгэлийн асуудал байгаа юм. Банкнууд ашиг нэлээн өндөр олоод байгаа. Гэтэл зээлийнхээ шимтгэлийг болохоор харилцагчаар төлүүлээд байгаа юм. Тэгээд шүүх дээр ч гэсэн энэ нь буруу гэдэг шийдвэр гарсан. Тэгээд энэ Монголбанк болохоор энэ тал дээр санаачилгатай ажиллаад гэдэг юм уу банкнуудынхаа ашгийг зөвхөн хүүгийн зөрөөтэй холбох тал дээр банкнуудтайгаа ярина гэх юм уу та хэдийн санаачилга гаргаад ажиллах боломж гарцын талаар асуух гэсэн юм.

Тэгээд хамгийн эцэст нь болохоор энэ банкнуудын бас хяналт шалгалтын асуудал яригдана. Та хэд болохоор өөрсдийнхөө хуулийн хүрээнд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид нар хяналт шалгалтаа явуулаад байна л гээд байгаа юм. Та илүү хүчин чармайлт гаргаад сайн ажиллах юм бол уг нь боломж байна гэж харах гээд байгаа юм. Яагаад гэхээр энэ Чингис Хаан банк байна, Үндэсний хөрөнгө оруулалтын банк байна асуудал нь хүндрээд тэгээд араас нь аль банк нь орох юм болоо гээд бараг бараг айдас ч байж магадгүй болчихоод байна шүү дээ тэгээд.

Эсвэл энэ банкнуудынх нь эздийн хамаарал нь Монголбанкаар дүүрэн байдаг юм уу? Ямар нөлөөлөлд ороод ингээд толгойг нь илээд байдаг юм бүү мэд. Ямар ч байсан банкнууд руугаа хийгдэх энэ хяналт шалгалтыг илүү үр дүнтэй хүртээмжтэй байлгах тал дээр та бүгдийн бодлого юу байна гэж. Тэгээд дахиад энэ асуудал нь яригдахаараа Монголбанканд дээр хариуцлагын асуудал ярих гээд байгаа юм.

Монгол банканд дээр ер нь ажлын хариуцлагын асуудал яригддаг юм уу? Өнгөрсөн хугацаанд яригдаж байсан юм уу? Ажил хийхгүй хүмүүсээр дүүргэхээд банкнуудаа хянаж шалгахгүй байх тэгээд энэ банкнуудынх нь асуудал хүндрээд ирэхээр мэдээд байгаа юм уу? Монголбанк чинь бас цэцэрлэг биш л баймаар юм шиг санагдаад байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн болно гэсэн мөрөөдөлтэй Хунтайж нар цөөнгүй байдаг. Тэгээд ажил хийдэг, хариуцлага хүлээдэг, чадахгүй бол ажлаа өгдөг тогтолцоо.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ түрээслээд эзэмших орон сууцын энэ журам бол Монголбанк санаачлаад өнгөрсөн оноос хэрэгжүүлээд явж байгаа. Нийслэлийн орон сууцын корпорац гэж байгууллагаас орон сууцаа өөрөө бариад барьсан орон сууцаа төрийн албан хаагч

юм уу, нийслэлийн иргэдэд түрээслээд явдаг. Энэн дээрээ ингээд бонд гаргаад бондыг нь Монголбанкнаас санхүүжүүлээд одоо үлдэгдэл бол 145 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ингээд явж байгаа. Энэ бол өөрөө түрээслээд дараа нь тэр 6 хувиар түрээслээд тэгээд тэндээсээ эргээд нөгөө түрээслэгч нь өөрөө ипотекийн зээл болгоё гэх юм бол тийшээ ингээд шилжээд явдаг ийм хөтөлбөр явж байгаа. Тэгэхээр энэ бол ингээд туршигдаад хэвийн ажилд сайн ажилладаг энэ нэгэнт л нотлогдож байгаа учраас энийг бол орон нутаг руу чиглүүлж болох юм байна аа. Ялангуяа төвөөс орон нутаг руу шилжиж ажиллаж байгаа улсууд бол шууд очоод ипотекийн зээлд хамрагдаад явах нь төвөгтэй байдаг учраас орон нутаг хэрвээ ингээд нийтийн орон сууц шиг нийтийн сууц гэдэг шиг ийм сууцыг бариад тэгээд ирсэн улсуудад нь түрээсэлж байгаад яваандаа шууд ипотекийн хөтөлбөр явуулахаар энэ бол боломжтой хувилбар гэдгээрээ Монголбанк хэлж байгаа. Энэ бол сүүлийн үед ирэх 2025 онд үндэсний орон сууцыг хөтөлбөрийн хүрээнд энэ ажлыг хийхээр ингээд зохион байгуулж байгаа.

Валютын нөөц ерөнхийдөө бас хангалттай түвшинд байгаа. Гол нь өнөөдөр нөгөө эдийн засаг ингээд сэргээд явж байгаа учраас эрэлтээсээ хамаараад импорт асар их хурдтай өссөн. Энэ 26 хувийн өсөлт гэдэг бол ер нь өмнөх жилүүдэд байгаагүй өндөр өсөлт байгаа. Тэрэн дотроо ялангуяа тэр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээсээ гадна хэрэглээ асар их хүнд өндөр байгаа. Би өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлж байсан. Монгол Улс нийт суудлын автомашинд бараг 7 зуугаад сая доллар, тансаг хэрэглээ гэх юм бол архи тамхи гэхэд бараг 2 зуугаад сая доллар байх жишээтэй. Ер нь бол тэгэхдээ төлбөрийн тэнцэл дээр энэ худалдааны тэнцлээс гадна үйлчилгээний тэнцэл их томоохон байр суурь эзэлж байгаа. Алдагдал нь тухайлбал одоо нүүрсийг маш өндөр хэмжээнд өгч байгаа ч гэсэн нүүрс зөөж байгаа тээврийн компаниудын зардалд бараг 480 сая долларын алдагдалтай ажиллаж байгаа.

Тэгэхээр гаднын тээврийн компаниуд одоо энэ түүхий эд эрдэс баялгийг зөөгөөд явж байгаа нь өөрөө бас алдагдлын нэг том шалтгаан байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ тодорхой өөрчлөлт хийх юм бол энэ төлбөрийн тэнцэл эргээд сайжраад валютын нөөц эргээд нэмэгдэх ийм боломж нь бүрдэнэ ээ гэж харж байгаа.

Ерөнхийдөө бол одоо Монгол Улсад эдийн засаг сэргэж байгаатай холбогдуулан гаднын хөрөнгө оруулалтууд ихээхэн орж ирж байгаа утгаараа зүгээр Монголбанкны төсөөлөл ирэх онд хангалттай валютын нөөцтэй байна. Ханш бол тогтвортой байж чадна гэж харж байгаа. Таны зээлийн шимтгэлтэй холбоотой.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя, гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Таны асуусан зээлийн шимтгэлтэй холбоотой асуудал дээр Монголбанк бол бас эргээд энэ дээрээ өөрийн журам зохицуулалт дээр анхаарч ажиллаж байгаа. Ер нь бол Монголбанк бол энэ шимтгэлийг хэмжээ хязгааргүй байх үүднээс нь дээд хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг. Ялангуяа зээлийн хүү дээрээ бусад шимтгэлүүд бол үнийн дүн, зээлийн дүнгийнхээ нэг хувиас хэтрэхгүй байхаар гээд хязгаарыг нь тогтоосон байгаа. Тэгэхлээр энэ нэг хувийн хязгаар өөрөө бас их том байна гэж үзэх юм бол мэдээж энийг доош нь буулгах боломж нь байгаа.

Монголбанкны Хяналт шалгалтын газар бол 12 арилжааны банкаа хянаж шалгаад явдаг. Тэгэхээр жилдээ нэг удаа газар дээрх хяналт шалгалт хийнэ.

Зайнаас хянаад явж байгаа учраас нэлээн ийм тогтвортой хяналт шалгалт байгаа. Тэр ч утгаараа өнөөдөр банкны санхүүгийн тайлан манай Монголбанкны шалгасан шалгалтын акт дүн, банкны санхүүгийн тайлан дээр аудит хийсэн олон улсын санхүүгийн байгууллагын аудитын дүнгийн хооронд бол нэг их зарчмын зөрөө ялгаа байх гүй байна гэдэг маань Монголбанкны хийж байгаа хяналт шалгалтын чанар ямар.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуулт асууна. Уучлаарай Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулга, тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Энэ ипотекийн зээлийн нөхцөл нөгөө урьдчилгаа төлбөр нь 30 хувь гэж яригдаад байгаа. Энийг буулгах боломжийн талаар тэгээд тэр нөгөө валютынхаа ханшийг ч ер нь Монгол төгрөг цаашид чангарах боломжийн талаар та хэдийн амбицыг л асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 30 бол хувь ер нь энэ олон улсад байдаг жишиг байгаа. Угаасаа урьдчилгаа төлбөр нь 30 хувиас доошгүй байна гэдгээрээ бүүр ч дээшээгээ байдаг ийм жишиг байдаг. Тэр утгаараа энэ бол энэнээс доошоо буух нь өөрөө бас сөрөг нөлөө үзүүлж магадгүй. Яагаад гэвэл нөгөө угаасаа эрэлт нь өндөр байгаа учраас энэ урьдчилгааг буулгах юм бол эрэлт улам л нэмэгдэх боломжтой. Тэгэхлээр яах вэ тэр урьдчилгаа төлбөрийг бүрдүүлж чадахгүй байгаа иргэдэд зориулсан давхар үйлчилгээ нь тэр Зээлийн батлан даалтын сан.

Тэгэхээр орон нутагт бол бараг 10 хувь хүртэл нь 12 хувь хүртэл нь урьдчилгаа төлбөрийг буулгахаар Зээлийн батлан даалтын сан ажиллаж болж байгаа учраас энэ үйлчилж болно. Тэгэхээр орон нутагт бол нэгэнт ийм үйлчилгээ гараад ирчихсэн учраас бол энэний үйлчилгээг цааш нь хүргэх, зөвхөн Зээлийн батлан даалтын сан биш ердийн даатгалын компаниуд ч гэсэн энэ дээр оролцож болно гэдгээр дүрэм журмаа өөрчилсөн байгаа. Валютын ханшийн хувьд бол чангарна гэдэг маань өөрөө импортыг дэмжих экспортыг.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Би 4 асуулт асууя гэж бодож байна.

Эхнийх нь бол гишүүдийн тавьж байгаа асуулт ер нь иргэд ААН-үүдэд тулгамдаад байгаа асуудлуудад та бүхнээс шийдэл хүсээд байх шиг байна л даа. Гэтэл тэр нь яг одоо нөгөө авч байгаа хариултад жоохон сэтгэл ханамж бус байх шиг байна. Энэ дээр би нэг зүйлийг нэг онцолж магадгүй гогцоо асуудал болов уу гэж харж байгаа зүйлээ та бүхнээс нэг асууя гэж бодоод байгаа юм.

Манай Монголбанкны үндсэн зорилт бол ерөөсөө төгрөгийн тогтвортой байдал байдаг. Гэтэл бусад улс орнуудын хувьд жишээ нь өнөөдөр манай хүндэт зочин Австрали улс, АНУ-ын төв банк, Канад, Европын төв банк эдгээр улс орнуудын мөнгөний бодлогын үндсэн зорилтдоо ажил эрхлэлт эдийн засгийн тогтвортой өсөлт үнийн өсөлтийг барих ханшны бодлогоо ингээд оруулаад илүү

өргөн хүрээнд оруулсан байдаг. Тэгэхээр яг энэ бид нарын яриад байгаа асуултууд одоо ипотекой холбоотой байна уу, ААН-үүдийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, магадгүй хүүг бууруулах, хоршооны зээл ч юм уу эдгээр зорилтот хөтөлбөрүүдийн асуудал бүгд яг энэ Монголбанкны үндсэн зорилтод орохгүй байна гэж үзэж магадгүй. Одоо энэ дээр дорвитой ахиц гардаггүй юм болов уу гэдэг ийм асуулт байна. Тэгэхээр Монголбанкны зүгээс үндсэн зорилтдоо ер нь өөрчлөлт оруулъя гэсэн ийм бодол байдаг уу? Үүн дээр ямар нэгэн байр суурьтай байгаа юу? Одоо яг л жишээлж бүгдээрээ ипотекийг ярихад Монголбанк дотор ч гэсэн зарим байгууллагууд энэ бол Засгийн газрын ажил гэдэг зүйлийг хэлдэг. Гэтэл одоо хэрвээ хэрэгсэл нь бодлогын хэрэгсэл нь Монголбанканд байгаа юм бол яагаад бид нар энийгээ үргэлжлүүлээд хийж болохгүй юм бэ? Энэ бодит эдийн засгийн өсөлттэй холбоотой ажил эрхлэлттэй ч гэсэн холбоотой асуудал учир үндсэн зорилтдоо илүү өргөн хүрээгээр олон улсын жишгээр ажил эрхлэлтийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмж оруулах ийм бодол байдаг уу гэдэг эхний асуудал.

Хоёр дахь нь бол та бүхний оруулж ирсэн энэ ээлжит 2025 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлтэй холбоотойгоор энэ 1.2 дахь заалт дээр бол төгрөгийн гадаад валюттай харьцах энэ ханшийг илүү уян хатан байх энэ зарчмыгаа баримтална гэж байгаа юм. Гэтэл өнөөдөр бодит байдал дээр Монголбанк бол бүх ханшийг авч эргээд нийлүүлдэг ийм нөхцөл байдалд байгаа. Үүнийг ч гэсэн Дэлхийн банк морал хазерт үүсгэх эрсдэлтэй гээд сүүлийн тайландаа гаргасан байсан. Тэгэхээр энэ дээр яг энэ валютын зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх ийм бодитой дорвитой заалт оруулах боломж байгаа юу? Одоо энэ зарчмыг баримтална гэхээсээ илүүтэйгээр яг бодитой заалт оруулах боломжтой юу?

Гурав дахь асуулт нь болохоор эхнийхтэй холбоотой. Энэ үндсэн чиглэлийн төслийн хамгийн сүүлд орж ирсэн энэ ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх олон улсын сайн жишигт нийцүүлэх гэж энэ хамгийн сүүлийн заалт болж орж ирсэн байна л даа. Энэ нэлээн чухал асуудал. Эргээд нөгөө эдийн засгийн өсөлттэй, ажил эрхлэлттэй холбоотой. Гэтэл энийг өмнө нь Монголбанк хэрвээ зөв санаж байгаа бол хэдэн жилийн өмнө яг чуулганд энийг хийнэ ээ, эхлүүлнэ ээ гэсэн.

Тэгэхээр ахиад энэ төлөвлөгөөн дээр хийнэ ээ л гэхихсэн байгаа болохоос. Биш энийг мөн ажлын төлөвлөгөөг илүү боловсронгуй дорвитой эхлүүлэх тийм ямар ахицууд явж байгаа вэ гэдэг энэ асуулт байна.

Миний сүүлийн асуулт болохоор энэ үндсэн чиглэлийн төсөлтэй холбоотой гэхээсээ илүүтэйгээр бид нар одоо гадагшаа гарч байгаа валютын урсгал энэ мөнгөний бодлогын тогтвортой байдал дээр нэг зүйлийг та бүхэн ямар байр суурьтай байдаг юм бэ? Энэ гадагшаа явж байгаа гарч байгаа зардал олон нийт дунд залуучууд дунд зүгээр анзаарахад энэ one expert гэдэг платформоор багагүй хэмжээний валют гадагшаа урсаж байгаа юм болов уу гэдэг ийм зүйл байна.

Тэгэхээр энэ дээр та бүхэн дээр ямар нэгэн тооцоо судалгаа байдаг уу? Би энийг зөв буруу ч юм уу? Энэтэй холбоотой хуулийн талаас нь биш яг мөнгөний бодлого талаасаа энэ дээр.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Болормаа гишүүний асуултад хариулъя.

Тийм ер нь бол яах вэ бидэнд судалгаа байгаа л даа. Тэр нь бол олон улсын ялангуяа төв банкнууд яг юугаа зорилго болгоод юу нь үндсэн зорилго, юу нь давхар зорилго болоод явж байна гэдгийг бас үзэж байгаа. Ер нь бол бараг нийт төв банкны 95 хувь нь үнийн тогтвортой байдал гэж шууд л хэлж байгаа. Европын төв банк, Америкийн Холбооны нөөцийн банк ч юм уу эсвэл ерөөсөө л инфляшн тактинг буюу инфляцыг тэдэн хувьд барина тэрэнд зориулсан мөнгөний бодлого явуулна л гээд. Яах вэ АНУ-ын төв банкны зорилго дотор бол ажил эрхлэлт гээд цуг явж байгаа. Ер нь нэг 5 төв банк л яг л ийм юм яриад байгаа. Бидний ойрхон жишээ бол АНУ-ын төв банк, Туркийн төв банк ч гэдэг юм уу.

Тэгэхээр бол ер нь ерөнхийдөө Монголбанкны мөнгөний бодлого бол өөрөө яг энэ зээлтэй холбоотой, мөнгөний нийлүүлэлттэй холбоотой явагддаг учраас бол ажил эрхлэлт бол яг шууд утгаараа ажил эрхлэлт гэж заахгүй ч гэсэн бид хэд одоо бол энэ үзүүлэлтийг хянаад явж байгаа. Ер нь яг энэ 2024 оны өнөөдрийн байдлаар ажил эрхлэлтийн түвшин 58.6 хувь гэсэн ийм статистик тоо байгаа. Үндэсний статистикийн хорооны зарласан. Энэ бол сүүлийн 15 жил байгаагүй ийм өндөр тоо л гэж хэлж болно.

Тэгэхээр өнөөдөр бол Монгол Улсад ажил эрхлэлт түүхэн дээд хэмжээндээ байна л гэж харж байгаа юм. Тэгээд ер нь яг ажиллах эрхлэлт л гэж ярьж байгаа болохоос яг хөдөлмөрийн нөөцөөрөө Монгол Улс тийм багтаамжтай улс биш. Яагаад гэвэл одоо боловсруулах аж үйлдвэрийг олноор нь барих юм бол яг энд ажиллах хүчин нь хүрэлцэхгүй л болохоор л ийм л зүйл байгаад байгаа юм. Валютын захтай холбоотой, дэд бүтэцтэй холбоотой зүйл дээр бол Монголбанкны хувьд бол өнөөдөр Оюу Толгойн борлуулалтын орлого Оюу Толгой бол борлуулалтынхаа орлогоос гадна өнөөдрийн урсгал зардалдаа бол сар болгон 100-аас 120 сая долларыг оруулж ирдэг. Тэрнийхээ 50 хувийг л Монголбанканд өнөөдрийн албан ханшаар худалдаад, үлдсэнийг нь арилжааны банканд өгөөд явж байгаа.

Төрийн өмч давамгайлсан буюу шууд төрийн өмчтэй үйлдвэрийн газар гэх юм бол Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой бол Монголбанканд борлуулалтынхаа орлогыг валютаа зараад явж байгаа. Тэгэхдээ Монголбанк бол 7 хоногтоо 2 удаа банк хоорондын зах дээр бол бас энэ дуудлага худалдаа маягаар хэрвээ арилжааны банкны хүсэлт байх юм бол энэ валютыг нийлүүлж байгаа. Ялангуяа энэ нефтийн төлбөр тооцоог хийдэг банкнууд бол нефть импортлогчдынхоо валютын энэ зузаатгалыг Монголбанкнаас шууд худалдаж аваад л явж байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар нэг зах дээр оролцоод ч юм уу хаагдаад байгаа зүйл байхгүй л гэж Монголбанкны зүгээс харж байгаа юм. ЖДҮ-ийн нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой бидний энэ 2025 онд хийх гэж байгаа ажил аль болохоор нөгөө бүс нутгаар хөгжүүлэх гэдэг Засгийн газрын бодлогын юутай нийцтэй маягаар яаж байгаа. Тэнд нь кластер маягаар хөгжүүлэх тэнд байгаа кластер маягийн одоо жишээлбэл мах боловсруулах үйлдвэр мах нийлүүлдэг аймаг орон нутаг байх юм бод тэнд нь мах боловсруулах үйлдвэр арьс шир.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна. Лхагвасүрэн ерөнхийлөгч минутдаа багтаагаад тодорхой хариулъя.

Б.Лхагвасүрэн: Болормаа гишүүний асуултад тодруулаад жижиг дунд үйлдвэрийн тийм кластер маягийн хөгжлийг л яриад байгаа юм. Тэгэхлээр нэмүү өртөг шингэсэн тийм нийлүүлэлтийн сүлжээн дээр нь тэнд хөгжлийг гаргая л гээд.

Дөрөв дэх асуултын хувьд бол ялангуяа ковидын үед бол энэ тэр гаднын крипто валютад хөрөнгө оруулах маягаар 150 сая доллар гарч байсан бол одоо 300 сая доллар нэмэгдчихээд байгаа юм. Тэгэхээр эндээс Монгол Улсаас оролцож байгаа идэвх оролцоо нь маш өндөр байгаа. Энэ нь өөрөө нөгөө хувь хүн өөрийнхөө банкаар дамжуулаад арилжааны банкаар дамжуулаад шууд гүйлгээ хийгээд явчихдаг учраас бол Төв банкны зүгээс энд хянаж хязгаарлах ийм боломж байхгүй.

Д.Амарбаясгалан: Болормаа гишүүн тодруулж асууя.

Э.Болормаа: Эхний асуулт дээр би таны хариултыг ойлгож байна л даа. Миний асуулт ер нь энэ үндсэн зорилтоо өргөжүүлэе гэсэн бодол байгаа юу? Тийм төлөвлөгөө байгаа юу? Энэ дээр өөрчлөлт орох бусад улс орнуудын жишээн дээр саяын ажлын байр, эдийн засгийн өсөлт гэдгийг нөгөө тоо гэхээсээ илүү ер нь энэ бүх гишүүдийн яриад байгаа асуулт чинь ерөөсөө тэр байхгүй юу. Энэ яаж эдийн засгийн өсөлтөө энэ иргэдийн аж ахуйд нь нэмэгдүүлэх вэ гэхээр та бүхэн энэний шийдэл нь миний бодлоор үндсэн зорилтдоо өөрчлөлт оруулж эдгээр дээр илүү нэг дорвитой ажил хийх боломжтой юм уу гээд. Эхний тодруулга нь.

Хоёр дахь нь энэ бэтингийн гадагшаа явж байгаа энэ крипто валют байна уу энэ бэтинг дээр орж байгаа энэ дээр хязгаар тавих гэхээсээ илүү мөнгөний бодлогод үзүүлж байгаа нөлөөн дээр та хэд хариу арга хэмжээний ямар санал бодол байна? Яг мэргэжлийн хүмүүсийн хувьд.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч 6 дугаар микрофон.

Б.Лхагвасүрэн: Болормаа гишүүний асуултад хариулахад яах вэ ер нь нэмж ажил авахаар эргээд нөгөө ОУБ-аас Төв банкны хараат бус бие даасан байдал алдагдаж байна л гэж хэлэх гээд байгаа юм. Ялангуяа өнөөдрийн бидний хийж байгаа ипотекийн зээлийг бол энэ нийгмийн шинжтэй арга хэмжээ. Нийгмийн шинжтэй арга хэмжээ бол энэ Засгийн газар дээр байх ёстой ажлыг Монголбанк хийгээд явж байна. Энэ чинь өөрөө Засгийн газрынхаа хараат байдал руу орж байгаа юм биш үү л гэдгээр асуудал нь тавьж байгаа учраас тэр асуудлаасаа ингээд энэ дээр нь төвөгтэй зүйл байгаа. Ер нь 2 дахь асуудлын хувьд мэдээж бидний хувьд бол одоо нөгөө санхүүгийн боловсрол гэдгээрээ л ярьж байгаа. Энэ бол өөрөө яг ассет мөн үү биш үү гэдэг дээрээ та нар сайн бодох ёстой. Хөрөнгө оруулалтын яг сонголт хийж байгаа зүйл чинь биш ээ. Энэ цаанаа технологийн л нэг юу явж байгаа боловч энэ бол өөрөө нөгөө дамлах эрэлт маягаар л дээшээ доошоо савладаг ийм зүйл. Яг бодитой зүйл байхгүй ээ л гэж байна лээ.

Тэгэхээр санхүүгийн боловсрол талаасаа бол мөн.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Төрөөс мөнгөний талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах гэж байна. Чиглэл учраас маш ерөнхийдүү байгааг ойлгож байгаа. Тэгэхдээ энэ чиглэлийг оруулж ирж байхдаа энэ чиглэлийн дагуу

хэрэгжүүлэх ирэх оны төлөвлөгөөнийхөө ерөнхий төслийг бас танилцуулж баймаар байна. Жишээ нь олон нийтийн санхүү, эдийн засгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ л гээд байгаа юм. Ямар байгааг яах гээд байгаа юм. Ямар арга хэмжээнүүд хэрэглэх гээд байгаа юм? Ерөнхийдөө ийм нэг ёс төдий ийм бичиг баримтууд маш их баталж байна бид нар. Үр дүн нь хаана байдаг юм би мэдэхгүй. Яг л нөгөө жил болгон энийгээ ярьдаг. Ерөнхийд нь бөөрөнхийлөөд л одоо. Гишүүд нь ч ерөнхий асуулт асуудаг, хариулт нь ч ерөнхий. Ийм зүйлүүд байна. Тэгэхээр энийг зүгээр цаашдаа анхаараач ээ гэж байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь төв банкны энэ хараат болсон бие даасан байдал дээр ер нь эрх зүйн хувьд юу гэж бодож байна вэ? Үнэ тогтворжуулах хөтөлбөр ахмадын зээлийг тэглэх гээд ингээд ерөөсөө мөнгөний бодлого бол эдийн засагт дандаа сөрөг нөлөөтэй бодлогууд дээр ерөөсөө юм хэлж чаддаггүй. Хууль батлагдсан ч гэдэг юм уу тодорхой энэ арга хэмжээн дээр татагдаж ороод л үндсэндээ маш олон юмнуудуудыг санхүүжүүлэлтийг хийж явлаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ер нь цаашдаа яг цаашид яах ёстой юм бэ? Ямар гарц шийдэл байгаа юм? Ингээд л өнгөрсөн борооны араас цув нөмрөөд л нэг ийм юм болчихсон юм аа. Бид тухайн үедээ хууль гараад л хэрэгжүүлсэн юм гээд яваад байх юм уу? Эсвэл ямар горим хэрэгжүүлбэл болох юм бэ гэдэг зүйл байгаа юм.

Хоёрдугаарт би ний нуугүй хариулаасай гэж бодож байна. Төв банканд ер нь ажиллаж байгаа албан хаагчдын хэчнээн хувь нь Хадгаламж зээлийн хоршоо болон ББСБ-ын хувьцаа эзэмшигч байдаг юм бэ? Энийгээ ил тод зарламаар байна. Дээрээс нь бусад төрлийн мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа буюу ломбардын эздүүд бий юу? Хувь эзэмшиж байгаа хүмүүс бий юу? Энийг одоо ил тод зарлаж ерөнхийдөө төв банканд ажиллаж байгаа хүмүүсийн энэ хориглох шаардлагыг бий болгомоор байна аа. Өөрсдөө энд мөнгөний бодлого хяналт тавих, банк санхүүгийн сектор дээр ажиллаж байж өөрсдөө энэ төрлийн үйл ажиллагаануудыг хувьцаа эзэмшиж явна гэдэг бол хэцүү байгаа.

Хоёрдугаарт энэ түрүүн Болормаа гишүүний асуулт чухал асуулт. Энэ далд эдийн засаг буюу хууль бус мөрийтэй тоглоом бэтинг ер нь зүгээр мөнгө хүүлэлтийн энэ далд эдийн засгийн хариу арга хэмжээн дээр ирэх онуудын ямар төлөвлөлт байгаа юм бэ? Бид энэ далд эдийн засгийг л аль болохоор хумьж байж энэ бодит эдийн засгийнхаа багтаамжийг гаргаж ирнэ. Энэ дээр ямар бололцоо байгаагаа бид хэд олж харна. Тэгэхээр энэ дээр тодорхой ямар арга хэмжээнүүд энэ мөнгөний бодлоготой уялдуулж авч байгаа вэ гэдэг зүйлүүдийг хэлээч?

Хоёрдугаарт Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдсан. Яах вэ төв банкны хяналт тавих тухай хууль биш. Тэгэхдээ энэ бол тодорхой хэмжээний хэрэглээний зээл дээр хяналт тавих зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох. Бусад улс орнууд дээр хэрэглээний зээлийн дээд хэмжээг тогтоодог шүү дээ. Бизнесийн зээлийг зах зээлийн зарчмаар нь явуулдаг жишгүүд байна. Тэгэхээр энэ мэдээллүүдээ зөв өгч энэ хэрэглэгчдийнхээ буюу санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эргээд энэ хамгийн муу гэрээний санал тавьдаг банкнуудын гэрээг Солонгос шиг захиргаадальтын захиргааны аргаар хар жагсаалтад оруулах энэ тэр гээд аргууд байж болох уу? Ерөнхийдөө иргэний гэрээ хэлцлүүд чинь талуудын тэгш эрхийн зарчмаар явж байгаа гэдэг боловч банканд дээр очоод хэлэлцээр хийгээд гэрээ байгуулдаг хэрэглэгч нэг ширхэг ч байхгүй.

Манай нөхцөлийг авбал ав гэнэ авахгүй авахгүй гэж хэлнэ. Тэгэхээр энийг бол үндсэндээ Солонгос юм уу зарим Азийн орнууд чинь ялангуяа хэрэглээний зээлийн үйлчилгээ санал болгодог байгууллагуудын гэрээг муу, сайн хэрэглэгчид ээлтэй гэдэг байдлаар ингээд оноо өгдөг юм шүү дээ. Энэ арга хэмжээ энэ тэрүүдийг хэрэгжүүлж ингээд болохгүй юу?

Хамгийн сүүлийн асуулт. Монголбанк тусдаа цахим гарын үсэг гаргаж энэ санхүүгийн хэрэглэгчийн асуудлыг шийднэ гээд байгаа юм. Энэ тэгж болохгүй шүү. Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй цахим гарын үсэг олгож байхад банкны үйлчилгээ авдаг тусдаа цахим гарын үсэг хэрэглэнэ гээд танайх маш их хэмжээний тоног төхөөрөмжийг авчихсан агуулах чинь хэвтэж байгаа. Энэ хууль бус худалдан авалт хийсэн хүмүүстээ хариуцлага тооцоорой. Яахаараа ингэж хууль, эрх зүйн орчноороо.

Д.Амарбаясгалан: 6 дугаар микрофон Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэл бол ерөнхийдөө үндсэн чиглэл гэдэг ерөнхий ийм 3 бүлэг дээр макро тогтвортой байдал, санхүүгийн тогтвортой байдал, дэд бүтэцтэй холбоотой ийм 3 бүлэг асуудлаар л ерөнхий төлөвлөгөө орж ирж байгаа. Манай Монголбанкны өөрийн дотоод үйл ажиллагааны төлөвлөгөө гэж байдаг. Бараг 300-аад тийм зүйл заалттай ийм төлөвлөгөө, ялангуяа энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ яаж хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг дотоод төлөвлөгөө бас гараад ажилладаг. Үндсэн чиглэлээ батлагдсанахаа дараа энэ дотоод төлөвлөгөөгөө гаргаад явдаг юм.

Тэгэхээр энэ нарийн үйл ажиллагааных нь заалтууд бол тэндээ ингээд тусгагдаад явдаг байгаа. Ковидын үетэй холбогдуулаад ерөнхийдөө саяын тэр үнэ тогтворжуулах ч гэдэг юм уу тэтгэврийн зээлийг нэг удаа тэглэх гэдгээрээ ингээд хууль гараад энэ хуулийн хүрээнд л Монголбанк ажиллаж ирсэн.

Өнөөдөр эдийн засаг өөрөө ингээд нэгэнт ингээд тогтворжсон, сэргэчихсэн байгаа энэний өсөлтийг нь тогтвортой байлгах үүднээс бол одоо төв банкны бие даасан хараат бус байдлаар бодлого үйл ажиллагаагаа явуулах энэ макро нөхцөл нь бүрдсэн байна гэж харж байгаа учраас бидний хувьд бол одоо ингээд ажиллахад ямар ч асуудал байхгүй ээ. Өмнө нь би түрүүн тайлбарлаж байсан. 100 жилд нэг удаа тохиож байгаа цар тахлын үед бол төрийн бодлого нэгдмэл нэг байдлаараа л явах ёстой гэдгээрээ явж байгаа.

Мөн геополитикийн хурцадмал нөхцөл байдлын үед нэг төвөгтэй зүйл нь бол энэ геополитикийн энэ гадаад бодлого бол өөрөө нэг цонхны бодлого байх ёстой гэдгээрээ бас энэ асуудлууд ингээд хөндөгдөөд яваад байдаг. Энэ утгаараа ингээд явж байгаа. Тэр нь өөрөө гаднын хүмүүст бол Төв банк өөрөө бие даасан бодлого байхгүй ингээд Засгийн газартайгаа нэг бодлоготой явж байгаа юм шиг харагддаг байх. Тэгэхдээ би бол эдийн засаг нэгэнт ингээд сайн сайхан сэргээд явж байгаа учраас юм уу Төв банкны энэ бодлого илүү бие даасан байхаар гарч явна гэж харж байгаа.

ББСБ-тай холбоотой олон нийтийн социал мэдээллийн хэрэгслээр Монголбанкны захирлууд өөрсдөө ийм юмтай гэж нэлээн гардаг. Энэ бол аль 2017-2018 оны мэдээллүүд явдаг. Өнөөдөр бол Монголбанкны яг захирлын удирдлагын түвшинд шийдвэр гаргадаг түвшний хувьд бол ийм нэг ч ББСБ, Хадгаламж зээлийн хоршоонд одоо тийм хувь эзэмшээд ингээд удирдаад явдаг ийм зүйл байхгүй байгаа. Зүгээр таны өгч байгаа саналын дагуу бид хэд одоо яг нээлттэй ил тод байх үүднээсээ бүх ажилтнуудаасаа мэдээлэл аваад өөрийнхөө веб хуудсан дээр манай ийм ажилтан ийм ББСБ-тай холбоотой гэдэг мэдээллийг тавихад нэг их татгалзаад зүйлүүд байхгүй. Бид бол Санхүүгийн зохицуулах хороо руу хэдэн ч удаа захидал явуулсан. Баталгаажуулж авсан. Монголбанкны удирдлагын зүгээс ийм ББСБ танайд мэдээлэл байна уу гэдгээрээ шалгаад авсан байгаа. Тэндээс бол тийм зүйл байхгүй гэсэн мэдээлэл хариу ирсэн байгаа.

Ялангуяа тэр зээлийн гэрээтэй холбоотой энэ зүйл дээр бид гар Банкны тухай хууль дээрээ удахгүй өөрчлөлт оруулахаар ингээд төсөл өргөн барьж байгаатай холбогдуулаад иймэрхүү заалт.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Лхагвасүрэн Ерөнхийлөгч ямаар байна аа. Мэдээж бодлогоо хамгаалаад байр сууриа тодорхой хамгаалаад суух нь та бүгдийн өөрийн эрх зүйнхээ орчинд тодорхой гэж ойлгож байгаа юм. Гэхдээ өнөөдөр энэ гишүүдийн ярьж байгаа зүйл дотор энэ банкны хүүг яаж буулгах вэ л гэдэг асуудал хөндөөд байна шүү дээ. Тэгэхээр та бол яах вэ одоо байгаа нөхцөл дээрээ тайлбараа хийгээд яваад байна. Тэрийг чинь ойлгоод байна. Гэхдээ арилжааны банкны чинь хүү 20 хувь, цаашлаад ББСБ бусад зээлдүүлэгчийн зээлдүүлэгч байгууллагаар дамжуулаад авахаар 40-өөс 60 хувийн хүүтэй ард иргэд чинь хүнд байдалтай байна шүү дээ.

Системийн том банкнууд чинь хөрөнгө оруулалтын эргэлтийн хөрөнгийн зээл олгохоосоо илүүтэйгээр богино хугацаатай өндөр хүүтэй хэрэглээний зээл дээр төвлөрч ажиллаад байна шүү дээ. Энийгээ яаж өөрчлөх юм бэ гээд байр суурь асуугаад байгаа байхгүй юу. Энийг өөрчлөх тэр зорилгыг чинь Улсын Их Хурал дэмжээд хамтарч ажиллая. Өөрчлөлт шинэчлэлтийг хийе ээ гэдэг байр сууриудыг гишүүд хэлээд байна. Тэгэхээр энэ дээр маш тодорхой хариулт хийх нь зүйтэй. Нэмж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Сайнзориг гишүүний асуултад нэмж тодруулъя.

Тэгэхээр бол яг саяын энэ гэрээ хэлцэл дээр Монголбанк хамтраад ажиллахад бэлэн байгаа. Энэ дээр бол ороод явна. Тэр харилцагчийн эрх ашгийг хамгаалах хууль гараад хүүгийн дээд хязгаар мөнгө хүүлэлтийн хүү тогтоогоод ирэх юм бол хүү доошоо буух боломжтой байгаа. Тэр цахим гарын үсэгтэй холбоотой юун дээр танд тийм ташаа мэдээлэл очсон юм шиг байна. Монголбанк бол одоо энэ банкны энэ бүх үйлчилгээг цахимжуулах энэ тал руу үйл ажиллагаа хийгээд одоо нийт гүйлгээний 97 хувь нь цахимжсан байгаа. Энэнтэй холбогдуулаад манайд тэр цахим гарын үсэгтэй холбоотой программ хангамж нийлүүлэгдсэн.

Өнөөдөр энэ Харилцаа холбооны зохицуулах хорооноос 4 хувийн аж ахуйн нэгж энэ цахим гарын үсэгтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг юм байна лээ. Тэгэхээр Монголбанк нэгэнт өөр дээрээ ийм бэлэн программ хангамж, техник технологитой болсон учраас заавал энэ 4 компаниар дамжихгүйгээр өөрийнхөө энэ бэлэн энэ

хүчин чадлыг ашиглаж болох уу гэдгээрээ хүсэлт л тавьсан байгаа. Тэгээд болно гэвэл бид хэд.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Ойлголоо. Та яг үгэндээ хэллээ. Нэг ч удирдах албан тушаалтан Монголбанканд ажиллаж байгаа хүмүүс ББСБ-ын хувьцаа эзэмшил байхгүй гэдэг зүйлийг та яг та чуулганы энэ танхим дээр хэллээ. Энийгээ ер нь хуулиар ерөнхийдөө хорьж өгөх нь зүйтэй байгаа.

Хоёрдугаарт энэ зээлийн хүүг бууруулах ажлын бас нэг өнөөдрийн нөхцөл байдал дээр 4-өөс 5 хувь буулгах боломжтой юу? Нөхцөл байдал юу вэ гэхээр энэ бизнес эрхлэхэд тулгарч байгаа хууль эрх зүйн орчин Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль иргэн арилжааны хуулийг хийгээд өгч чадах юм бол энэ тодорхой хэмжээний зээлийн хүүг бууруулах энэнээс үүсэж байгаа банкнуудад үл үүсэж байгаа үйл ажиллагааны зардал буурах бололцоо байж байгаа.

Тэгэхээр бас Монголбанк маш олон зүйлүүд дээрээ бас жоохон санаачилгатай Засгийн газрынхаа холбогдох институц яг энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд жоохон эрчимтэй ажиллаач гэдэг зүйлийг би хүсэж байгаа юм. Уг нь бол одоо нэлээн боломжийн мэдээлэл датанууд танай дээр байдаг. Эндээ түлхүү ажиллаач ээ.

Хоёрдугаарт хэрэглээний зээлийн хувьд.

Д.Амарбаясгалан: Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Энэ төсөв мөнгөний бодлого энэ тэр гээд л чухал асуудал л даа. Нэг л юм энэ юм ярихад хаягдаад байх юм. Тоонууд их гоё сонсогдож байна л даа. Манай улс бараг л хөгжин дэвжчихсэн ч юм шиг. Баахан л мөнгө төгрөг олсон их нэмэгдсэн, валютын нөөц нь сайжирсан. Энэ айл өрх бизнесийг яаж дэмжих юм. Айл өрхийн ахуй амьжиргааг яадаг юм гэдэг юм л хаягдчихаад байх юм л даа. Энэ гишүүдийн асуугаад байгаа зээлийн хүү гэдэг чинь угаасаа тэр л юм байгаа юм.

Тэгээд нэгт тэгээд энэ төсвийн зарлага ийм их айхтар байхад инфляцаа барьж чадах юм уу? Лхагвасүрэн ерөнхийлөгч өө тэрэн дээр нэг хэлээрэй. Тэгээд Засгийн газар хажуугаар нь нэг баахан хөтөлбөр явуулаад байдаг. Би ер нь жаахан эргэлзэж байгаа шүү. Энэ ирэх жилийн энэ төсөв нь ийм их данхайчихсан байхад олигтой юм болохгүй болов уу гэж айж байна. Ипотек дээр 1.2, 1.3 их наяд төгрөг гаргана гэж. Яг хэдэн айл юм. 80-аас доош гэдэг маань хэвээрээ байна уу? Хэдэн айл ипотекийн зээлд хамрагдах юм бэ? Тоо хэлээч? Би энэ АН-ын бүлэг дээр асуусан. Капитал Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хааны эздүүдийг нэг энэ Их Хурал дээр нэг хэлээдхээч. Яагаад эд нарын толгойг илээд ингээд байлгаад байдаг юм бэ? Үхэх гэж байгаа бол үхүүлээд амьдрах гэж байгаа бол амьдруулаад явуулах хэрэгтэй. Яахаараа ингээд байдаг юм. Би энэ эзэдтэй нь холбоотой хуйвалдаад явдаг юм уу гэж хараад байгаа юм. Тэр нөгөө нийгмийн даатгал, ЭМД-ын мөнгө төгрөг ер нь аль зэрэг барагдсан юм. Одоо барагдах найдвар байгаа юм уу.

Дараа нь Хөгжлийн банк. Хөгжлийн банк гэж Монгол Улсын хөгжилд агуу чухал үүрэгтэй ийм банк байгуулсан. Батболд сайд Ерөнхий сайдын үед. Энэ Жавхлан гэдэг нөхөр 2017 онд өөрийнхөө бланк дээр энэ Хөгжлийн банкны хуулийг өөрчлөөд хяналтыг нь сайжруулах гэж байгаа. Танай мэдэлд аваачаад арилжааны банк маягийн болгочихсон. Монгол Улсын хөгжлийн банк нь алтны зээл өгөөд сууж байгаа шүү дээ. Жинхэнэ солиорч байгаа шүү дээ. Тэгэхээр одоо танайх ямар хяналт тавьж байна. Хөгжлийн банк гэдэг тэр нэрэндээ таарсан үйл ажиллагаа явуулж байгаа юм уу үгүй юм уу? Тэгээд орон сууцын зээл бас өгөөд сууж байгаа шүү дээ. Ийм юм хийж болохгүй ээ.

Дараа нь энэ Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой энэ тэр гээд Монгол Улсын эдийн засагсаад байх юм байхгүй болчихсон шүү дээ. Энэ 2 компани л бараг хамаг мөнгө л орж ирж байгаа юм. Энэ компаниудын данс нь хаана байдаг юм. Арилжааны ямар банк дээр байдаг юм. Ер нь Монголд бол та нарын хэлээд байгаа тоонууд том, тэгэхдээ хүндээ халддаггүй. Долоон буудлын Должин эмээгийн үүдээр ордоггүй юм бол бид нар энэ их гоё гоё тоонуудаар яах вэ дээ. Тэгэхээр энэ Монголбанк энэ хариуцлагаас зугтаж болохгүй шүү дээ. Одоо бид нарын үед бол Монголбанитайгаа хамтран ажилладаг байсан юм. Нэг л зорилгын төлөө. Айл өрхийн яаж ахуй амьжиргааг дээшлүүлэх юм. Тэр айлын хаалгаар ордог мөнгө төгрөг орсон мөнгө төгрөг нь тэндээ жаахан илүү хэрэгтэй үлддэг. Зарлагыг нь яаж багасгах вэ гээд ингээд их олон талаасаа ажилласан юм. Тэгж байж л нэг ахуй амьжиргааны тухай асуудал хөндөгдөх ёстой юм.

Бизнес дээр бас адилхан шүү дээ. Та нар ч гэсэн одоо энэ экспорт өслөө л гээд байна. Тэр нэг хэдэн нүүрс гаргаад л талыг нь цавчиж идээд л талыг нь гадагшаа гаргаад л тэгээд орж ирсэн хэдэн төгрөг нь л мөнгө болж валют болж үлдээд байгаа шүү дээ. Гэтэл танайд экспортыг дэмжих хөтөлбөр гэдэг юм дээр үед яригдаж байгаад л хаягдсан. Би нүүрсний тухай яриагүй шүү. Бусад уул уурхайн тус салбарыг яаж дэмжиж яах юм гэдэг дээр танайх энэ төрөлжүүлэх гэдэг дээр хөтөлбөр гаргаад явж л байсан юм. Нэг ийм хэдэн асуултад хариулт аваадахья аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Улсын Их Хурлын гишүүдийн үдийн цай дууссан. Танхимдаа дурдаарай.

Б.Лхагвасүрэн: Төсөв болон төсвийн зардал бол их тэлэлттэй байгаа учраас инфляцыг зорьсон зорилтынхоо түвшинд хадгалахад маш төвөгтэй байгаа. Хэрвээ одоо ингээд манай энэ инфляцын түвшин зорилтот түвшин маань 6+-2-ынхоо хүрээнд бол хэтрэхээр тэгээд л мөнгөний бодлогын төлөө хатууруулаад л явах л ийм л бодлого л баримтална л гэж Төв банкны зүгээс харж байгаа. Тэгэхдээ бидний хувьд бол ямар ч байсан төсөв тэлж байгаа.

Цахилгаан дулааны үнэ буюу суурь үнэ чөлөөлж байгаа юм нь манай инфляцад бол дээд түвшин хүртэл л нөлөөлөх юм байна. Ямар ч байсан бидний зорилтынхоо түвшинд хадгалах боломжтой юм байна л гэж харж байгаа юм. Өнгөрсөн оны мөнгөний бодлогыг батлуулж байхад төсвийн тодотгол 1.8 их наядаар нэмэгдэж байсан. Оны төгсгөлд энэ 2024 оны төсвийг ярьж байхад 30 хувиар өсөхөөр ийм тэлсэн төсөв орж ирж байна гэж яригдаад тухайн үед Монгол Улсыг Монголбанкийг инфляцаа барьж чадахгүй инфляц бол энэ 2024 онд 16-аас 15 онд хүрнэ ээ. Нэлээн олон эдийн засагчдын ийм судалгаа байгаа гэдгээрээ ингээд ярьж

байсан. Бидий бидний хувьд ч гэсэн мөнгөний хатуу бодлогоо нэлээн тууштай барьж явсны үр дүнд инфляц ингээд манай зорилтот түвшинд байгаа учраас бидний хувьд бол ирэх онд ч гэсэн энэ зорилтот түвшнийхээ түвшинд хадгалах боломж байгаа л гэж өөрсдөдөө итгэлтэй байгаа. Ипотекийн зээлийн зээлийн хувьд бол 1.2 их наядын эх үүсвэртэй болсон. Өнөөдрийн байдлаар 9.6 мянган одоо ипотекийн зээлд хамрагдаж ийм орон сууцтай болсон байна. Ерөнхийдөө энэ 1.2 их наяд төгрөг бол ингээд 100 саяар дундаж гээд бодох юм бол 12 мянган ийм өрх шинэ орон сууцад орох боломжтой гэж харж байгаа. Яваандаа бол 6 хувийн энэ хүүгийн хөтөлбөр хөнгөлөлттэй үнийн хөтөлбөр өөрөө олон янзын хүүтэй болоод нэмэгдэх юм бол энэ 12 мянга гэдэг тоо бол цаашаа нэмэгдэх боломж нь бүрдэнэ гэж харж байгаа.

Хөгжлийн банк бол хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны ийм үйл ажиллагааны зөвшөөрөлтэй. Тэр утгаараа яг арилжааны банканд тавьдаг ийм зохистой харьцааны шалгуураас гадна нэлээн нээлттэй хэд дахин өөрийн хөрөнгөө хэд дахинаар үржүүлсэнтэй тэнцэхээр ийм бүтээгдэхүүн үйлчилгээ гарах боломжтой байгаа. Тэр утгаараа Монголбанк бол одоо 2019 оноос эхлээд энэ манай хяналтад орж ирсэн. Ингээд үйл ажиллагааг нь хянаад ингээд явж байгаа. Тэгэхдээ сүүлийн үед бол Хөгжлийн банк бол ямар нэг зээл гаргаж, бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахаасаа илүү өмнөх муу өр авлагаа барагдуулах маягаар л ажиллаад ирсэн. Сүүлийн үед бол яах вэ Засгийн газраас бол энэ Хөгжлийн банкиг Эксим банкны хэлбэрт оруулж гадаад худалдааг дэмжих ялангуяа экспортод чиглүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахаар ингэж хуулийн төсөл өргөн барихаар яригдаж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ тал руугаа ингээд өөрчлөгдөөд явах байх гэж харж байгаа. Таны ярьж байгаатай би санал нэг байна.

Монгол Улсын экспортын 93 хувь нь бол одоо уул уурхайн бүтээгдэхүүн. Уул уурхайн бүтээгдэхүүн дотроо дөрөв, тавхан л ийм бүтээгдэхүүн байгаа. Хамгийн том нь бол нүүрс. Өнөөдрийн байдлаар 6 тэрбум долларын орлоготой. Дараа нь зэс байдаг. Эрдэнэт, Оюу Толгой гэсэн хоёр.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Тэгээд өнөөдрийн байдлаар 2 тэрбум гаруй долларын орлоготой ингээд ажиллаад явж байгаа. Тэр утгаараа мэдээж уу уурхайн бус салбарыг хөгжүүлж илүү их экспортод уул уурхайн бүтээгдэхүүн ялангуяа Монгол Улс бол хөдөө аж ахуй, мал аж ахуйн нэлээн их хөдөлмөрийн оролцоотой гэдэг утгаараа эдгээр ААН-үүдийн бүтээгдэхүүнийг зөвхөн түүхий эд гэдгээр нь биш угаасан ноолуур гэдгээр нь биш илүү самнасан ээрсэн, утас ээрсэн, сүлжсэн маягаар нь хөгжүүлэх тал руу нь Монголбанк бас энэ хөтөлбөр гаргая гэдгээрээ ингээд ажиллаад явж байгаа. Тэр дагуу бол ялангуяа ноолуур нэлээн идэвхэжсэн. Одоо ноос арьс ширэн дээр ийм хөтөлбөрийг гаргахаар ажиллаж байна. Энэ нь өөрөө нэгдүгээрт ялангуяа схем талдаа байгаа.

Гол нь бол нэгэнт инфляц өндөр байгаа төсөвт тэлэлттэй байгаа гэдэг утгаараа мөнгөний бодлогын мөнгөөр дэмжих орон зай бол маш бага гэж хэлэх гэсэн юм. Яах вэ халамжтай өрх гэрт энэ эдийн засаг.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Чингис хаан банкны хувьд ерөнхийдөө 3 хөрөнгө оруулагч байдаг. Чингис Хаан банкны эзэмшдэг нэг нь иргэн Батаа гэж байгаа Батхүү гээд

байгаа. Нэг нь Бүтэд гээд ийм 3 хувь хүний нэр дээр ер нь яах вэ эцсийн өмчлөгч гэдгээр нь хэлэх юм бол ийм 3 хүн байгаа. Тэгээд энэ 3 хүн бол өөрийнхөө хувьцааг гаднын хөрөнгө оруулагчдад заръя гэдгээрээ хэд хэдэн санал ирээд Монголбанк дээр хянагдаад тэгээд хөрөнгө оруулалтынх нь мөнгө нь орж ирэх юм бол ер нь энэ банкиг өөр хөрөнгө оруулагчтай болгоод босгоод явахаар байгаа. Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хувьд бол компанийн нэр дээр компани нь өөрөө хэдэн хүмүүст хуваагдсан байдаг. Тэрэн дотор Сумъяабазар гээд Долгорсүрэнгийн Сумъяабазар гэж нэр байгаа. Нэлээн том хувьцаа эзэмшигч. Өөр бас нэг.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Алтанхуяг гишүүн тодруулж асууна.

Н.Алтанхуяг: Үгүй ээ ингээд тодорхой хариул. Ерөнхийлөгч өө яг хэн хэн гэдэг улс төрчид тэр банканд нь байгаад та нар тэр банкиг ингээд үхдэг ч үгүй сэхдэг ч үгүй болгочоод байгаа юм. Эрдэнээс Тавантолгой, Эрдэнэтийн данс нь хаана байгаа юм гээд ийм тодорхой юм асуугаад байна шүү дээ. Та тодорхой хэлчихээч. Энэ иргэд мэдэх хэрэгтэй байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой гээд энэ хоёулаа төрийн өмчтэй аж ахуйн нэгж. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн данс бол хэд хэдэн банканд байгаа байх гэж бодож байна. Ямар ч байсан одоо төлбөр тооцоо хийж байгаа байдлаас нь харах юм бол Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хаан банк, Төрийн банканд дээр энэ данснудаас нь гүйлгээ хийж гадаад төлбөр тооцоо орлого нь орж ирээд яваад байгаа юм. Тэгэхээр яг нарийн энэ харилцагчийн мэдээлэл гэдэг утгаараа энэ аж ахуйн нэгжүүд нь өөрснөө ийм ийм банканд дээр данстай гээд явах нь зөв байх л гэж харж байгаа. Яг тэр хувьцаа эзэмшлийн хувьд бол уул нь яг хуулиараа яг эцсийн өмчлөгчийнхөө мэдээллийг банк өөрөө нийтэд ил тод зарлаад өөрийнхөө веб хуудас дээр тавих ёстой.

Тэгэхээр би энэ мэдээллийг тавиулъя гэдгээр эндээс үүрэг авъя.

Хоёрдугаарт би танд яг бүр нарийн хэд хэдэн хувьтай хэчнээн төгрөгийн хувьцаа эзэмшдэг энэ мэдээллийг танд гаргаж өгье өө.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна аа.

Б.Жаргалан: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. сүүлийн 3 сар бид улс орон даяараа сонгуульдлаа. Тэгээд сонгууль дууссан Улсын Их Хурлын сонгууль дууссан, орон нутгийн сонгууль дууссан. Одоо тэгээд бид хэд үнэтэйгээ нүүр тулж байна л даа. Тэгэхээр ямар үнэтэй нүүр тулж байна вэ гэхлээр өнгөрсөн 8 жилийн хугацаанд бол амьжиргааны өртөг бол маш ихээр өссөн. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ бол дунджаар 2-оос 3 дахин өссөн байж байгаа.

Тэгээд энэ цаг мөчид болохоор ирэх жилийн төсөв болон ирэх жил төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл ямар байх вэ? Өөрөөр хэлбэл энэ инфляц хэд байх вэ энэ тэр гэдгийг өнөөдөр бид нар яриад сууж байна. Тэгээд

яг энэ цаг мөчид бол төв банк орж ирээд их хариуцлагагүй зүйлүүд ярьж байна гэж харж байна. Яагаад вэ гэхээр Төв банкны бие даасан хараат бус байдлыг хуулиар зохицуулдаг. Мөн одоо Төв банк банкны удирдлагыг Улсын Их Хурлаас томилдог ийм маш онцгой эрх бүхий субъект.

Гэтэл өнөөдөр Мөнгөний бодлого хэлэлцэж байхад инфляцын хүлээлтийг ярилцаж байхад энэ улсын төсөв ерөнхийдөө маш их тэлэлттэй орж ирж байгаа учраас бид нарт бол мөнгөний бодлогын орон зай байхгүй ээ. Бид цаашид ханшаа яахаа сайн мэдэхгүй байгаа энэ тэр гэсэн тийм зүйл өнөөдөр яриад сууж байна л даа. Гишүүдийн асуултад тэгж хариулж байна. Тэгэхээр бол манай төв банк илүү бие даасан хараат бус байдлаар ажилламаар байна. Түүнээс биш Засгийн газрын нэг санхүүгийн хэлтэс шиг тийм ээ төсөв ингээд ороод ирчхэж байгаа юм чинь бид нарт бол орон зай байхгүй ээ. Мөнгөний бодлогоо бид нар яаж ч чадахгүй ээ гээд яриад сууж баймааргүй байна. Тэгээд яагаад вэ гэхээр хэрэв төв банк мөнгөний бодлогын орон зай байхгүй гэж үзэх юм бол одоо энэ гишүүдийн асуугаад байгаа зээлийн хүү буурах эсэх асуудал бол тэгээд л дашийн шог болно. Яагаад гэхээр та хэд хатуу мөнгөний бодлого баримтлаад явлаа гэхэд бол ахиад л ингээд л зах зээлээс мөнгөө татаад л эхэлнэ тийм үү? Тэгэхээр энэ зээлийн хүү бол буурахгүй.

Тэгэхээр бол юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр Монголбанкны удирдлага ерөнхийдөө засагтайгаа ч гэсэндээ жаахан тулаад илүү зангаргатай ажилламаар байна. Ирэх жил бид эдийн засгаа ингэж удирдмаар байна аа. Төсвийн бодлогын хүрээнд та хэд ийм хөрөнгө оруулалт энэ тэр хийх гээд байгаа бол бид нар мөн мөнгөний бодлого талаасаа ингэмээр байна ч гэдэг юм уу даа тэгээд нэг тийм илүү идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай гэж харж байна аа.

Түүнээс биш зүгээр ингээд хатуу мөнгөний бодлоготой явлаа одоо зээлийн хүү буурахгүй ээ л гэсэн ийм л хүлээлт үүсэх гээд байна. Тэгээд зээлийн хүүгийн асуудал дээр илүү дэлгэрүүлж ярихад ерөнхийдөө өнгөрсөн хугацаанд бид бол маш олон зах зээл дээр ийм давхар зах зээлийг үүсгэхээд байна аа. Аливаа нэгэн салбарыг дэмжинэ гээд л тэгээд л тэндээ тэгээд л янз бүрийн хөнгөлөлт татаасууд явуулаад энэ нь болохлоор зээл дээр ч мөн ялгаа байхгүй. Өнгөрсөн хугацаанд энэ эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын төлөвлөгөө гээд л явсан. Үүн дээр бол ингээд л баахан татаастай зээлүүд олгогдоод явсан. Сая шинэ хоршоо гээд л баахан зээлийн хүүгийн татаастай зээлүүд гарчихсан гэж ж байна. Тэгэнгүүт ингээд ийм давхар зах зээл үүсээд байхлаар цөөн тооны мэдээлэлд ойрхон буюу эсвэл бараг улс төрд ойрхон эсвэл сонгуулиар саналыг нь худалдаж авах зорилготой тийм этгээдүүдэд ийм бага хүүтэй зээл олгогдоод бусад бор зүрхээрээ аж ахуй эрхэлж байгаа хүмүүст нь болохоор яг л нөгөө нэг 20, 30 хувийн тийм өндөр хүүтэй зээл аваад яваад байхлаар энэ манай зээлийн хүү ч буурдаггүй, эдийн засаг ч яг сонгодог утгаараа хөгждөггүй ийм л нөхцөл байдалд бид ороод байна. Ерөөсөө ингээд тэлэх боломж бид нарт алга. Тэгэхээр нийт зээлийн ер нь хэдэн хувь нь ямар нэгэн ийм хөнгөлөлт тийм татаастай хэлбэрээр олгогдож байгаа тал дээр та хэдэд тодорхой мэдээлэл өгнө үү? Тэгээд ер нь цаашдаа хэдүүлээ ийм элдэв янзын хөнгөлөлтөөс татгалзаад.

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүнд нэмэлт нэг минут.

Б.Жаргалан: Тэгэхээр нэгмөсөн зээлийн хүүгээ тэнхлэгээр нь бууруулах бодлого баривал яасан юм бэ? Ингэснээрээ бараг засаглал сайжирна. Компаниудын дотоод үйл ажиллагаа ч сайжирна, зах зээл дээрх өрсөлдөөн ч

сайжирна гэж хараад байгаа. Тэгээд энэ тал дээр бол Монголбанканд ямар нэгэн бодлого байна уу? Тэгээд эцэст нь Монгол Улсын гадаад өр 35 тэрбум ам.доллар байгаа. Засгийн газрын өр 7.6 тэрбум ам.доллар байгаа гэж байна. Энэ улсын төсөв дээр ирэх жилийн төсөв дээр бас ингээд гадаад өр тэлэх ийм хүлээлт орж ирж байгаа. Үүн дээр ер нь цаашид Монгол Улсын гадаад өрийн дарамт дээр Монголбанкны байр суурь ямар байна гэж асуух байна аа? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 6 дугаар микро микрофоныг өгье. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол тийм ерөнхий гэхээсээ илүү уг нь бид нар их нарийн тоонууд л хэлээд байгаа. Ялангуяа инфляц бол 6+ -2 гэдэг бол ерөөсөө л маш нарийн тоо. Энэ дэлхийн Төв банкнуудын цөөхөн ингэж инфляцыг онилсон буюу ингэж нарийн тоо ярьдаг. Тэгэхээр Монгол Улс энэ арга руу ороод ингээд 5-аас 6 жил шахуу явж байгаа учраас бол ерөнхийдөө бид нар нэлээн ингээд нарийн болчихлоо гэж өөрсдийгөө хараад байгаа юм. Тэгээд бодлогын хүү буураад инфляцын зээлийн хүү буурах гэдэг дээр бид нар нэлээн итгэл үнэмшилтэй байгаа. Яагаад гэвэл өнөөдөр байгаа зээлийн дундаж хүү бол 17 хувь. Энэ 17 хувь бол өнгөрсөн оноос урьд түрүүний өмнөх жилээс ингээд үргэлжлээд явж байгаа. Тухайн жилүүдэд манай бодлогын хүү 13 хувь байсан. Тэгэхлээр 17.3 хувьтай байхад бодлогын зээлийн дундаж хүү 17 байна гэдэг маань өнөөдөр бодлогын хүү 10 болж байна гэдэг маань зээлийн дундаж хүү ирэх жилүүдээс буураад явна аа. Дунд хугацаандаа бол яг бидний зорьж байгаа бараг энэ 3 хувийн бууралтын энэ түвшин рүү зээлийн хүүг доош нь татах байх гэж найдаж байгаа.

Тэгээд түрүүн Батшугар гишүүний ярьсан бас Активын удирдлагын компани, Сайнзориг гишүүний ярьж байгаа муу зээлийг барагдуулж байгаа энэ шүүхийн журмаар хийж байгаа энэ хууль эрх зүйн зохицуулалтуудыг нь оруулаад ирэх юм бол зээлийн хүү улам сайн буух байх гэж бодож байгаа.

Дээр нь Монголбанк бол эх үүсвэрийн хүүгийн дээд хязгаар дээр тодорхой арга хэмжээ авах гээд зорьж байгаа учраас ер нь зээлийн хүү буурах байх гэж харж байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд бол нийт Монгол Улсын гадаад өр бол 35 тэрбум доллар. Үүний 7.6 нь Засгийн газрын Монгол банкны өр бол 1.1 тэрбум доллар гээд ерөнхийдөө ингээд бараг хуучин бол 30 хувьтай тэнцэх төрийн өр байдаг байсан бол одоо ерөнхийдөө бараг 20 хувь руу ингээд ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр бусад өрүүдийн хувьд бол Оюу Толгойн өр бол өөрөө Оюу Толгойн орсон хувьцааны хөрөнгө оруулалтын өр байгаа. Оюу Толгой бол яаж төлөх вэ гэхээр одоо энэ зэсийн олборлолтоосоо гарч байгаа борлуулалтын орлогоосоо өр нь төлөгдөөд явах учраас энэ компани өөрөө энийгээ хариуцаад явна. Зарим нэг Шангрилла зочид буудал ч гэдэг юм уу манай томоохон гадаад хөрөнгө оруулалтын өрнүүд бол 2 компанийн хоорондох зээлийн өрнүүд байдаг. Энэ утгаараа бол энэ өөрөө бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ барагдаад явна. Энэ бол олон улсад байдаг л жишиг. Одоо зүгээр ирэх оны бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалтдаа 10 их наяд гэж ярьж байгаа. 10 их наядын 3 их наяд нь төсвөөс, үлдсэн 7 их наяд нь гадаадын зээл тусламж болон санхүүжилтээр явна, шууд хөрөнгө оруулалтаар явна гэдгээрээ 1 тэрбумын л ачаалал ирэх байх л гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Бид нар Мөнгөний бодлогоо ярьж байна аа. Яах вэ ерөнхийдөө 1 ур чадварын индекс гэдэг юмаар 67 улсыг оруулсан байна лээ. Тэгээд Монгол Улс 67-д хамгийн сүүлд нь л байна лээ л дээ. Тэгээд ийм байхад манай энэ Засгийн газар яг л тийм л байгаа юм л даа. Ур чадваргүй л байгаа юм. Харин Монголбанкыг би харин ёстой ер нь боломжийн удирдлага нь их аятайхан зөв ажиллаж чадаад байна гэж бодоод байгаа шүү. Ийм хүнд нөхцөлд төсөв ийм тэлэлттэй байна. Энэ бодлогын хүү, энэ валютын нөөц, ялангуяа энэ Хятадын свопын 50 хувийг нь төлсөн. Энэ үзүүлэлт энэ тэрээс харж байхад боломжийн байна. Яг одоо хүнд хэцүү үе энэ 2025 онд эхэлнэ ээ. Байдал бол тодорхойгүй байгаа.

Тэгэхээр яг өнгөрсөн жилүүдэд ажилладаг шигээ яг ингэж ажиллах хэрэгтэй байна аа. Гэхдээ хэд хэдэн зүйлийг та нараас тодруулмаар байна. Монголбанкны захирал, удирдлага чинь хэдэн жилээр томилогдож яаж ажилладаг билээ? Энэ удирдлагаа бид нар нэг тогтвор тогтвортой байлгах нь зөв байх, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол энэ нэлээн валютын нэлээн хэсэг нь бол хэдэн хувь нь алтаар байна вэ? Жилдээ хэд хэчнээн хэмжээний алт авч чадаж байна вэ? Би байхдаа алтны нөгөө татварыг багасгаад Монголбанканд тушаавал 2.5 хувийн рояалти төлье. Тушаахгүй бол 10 хувийг нь үлдээгээд хүнд хэцүү байх үед Монголбанкны алт валютын нөөц нэлээн сайжирсан байх аа. Энэ хэвээрээ байгаа юу? Ямар байгаа? Тэгээд Оюу Толгой бол алтаа та бүхэн тушааж байна уу, үгүй юу? Нөгөө 5 хувийн рояалти төлдөг байх. Энэнээс бага рояалти манайх төлөөд алтаа бол уг нь тушаах ёстой.

Хэрэв тэрийг нь аваад байсан бол өнөөдөр алтны үнэ 2, 3 дахин нэмэгдчихлээ шүү дээ. Нөгөө талаар та бүхэн одоо тэр янз бүрийн Засгийн газрын хийж байгаа энэ үйл ажиллагаа энээ тэрээ юманд хамтарч оролцохгүй байх ёстой. Хуулиараа ч тийм. Одоо оффтейкийн гэрээнээс тэрнээс гарах ёстой. Та нар энэ ажлыг хариуцдаг юм шиг л энэ гишүүд асуугаад байна л даа. Та нарын үүрэг зорилго өөр шүү дээ. Тэрийг ч энэ хүмүүс ойлгох хэрэгтэй. Сүүлийн арваад жил долларын ханш явж өгсөн. Сүүлийн харин 2, 3 жил тогтвортой байна. Миний мэдэхийн нэг 10-аад жилийн өмнө бол энэ вон яг төгрөгийн ханштай ойролцоо л байдаг байсан шүү дээ. Доллартой харьцах нь. Солонгосын бонд 2.5 болчихсон. Манайх ямар байгаа билээ. Төгрөгийн ханш доллартой харьцуулахаар Сингапурынх ямар байгаа билээ. Тухайн үед яг адилхан л ханштай байсан. Тэгэхгүй л бол тэр ханш нь одоо энэ 2 орон дээр бол яг адилхан байдаг. Би нөгөө Азид байдаг улсаар жишээ аваад байна л даа. Манайх бол ингээд яваад өгсөн.

Тэгэхээр 50 мянгатын дэвсгэрт гаргах уу? Энэ ханшийн уналт чинь ийм болчихсон байна. Энэ дээр ямар байгаа вэ? Нөгөө талаар бол энэ АТМ гээд машинууд байдаг аа. Та бүхэн энэ үйлчилгээг иргэдэд амар хялбар байлгахын тулд тэр уг нь нэг л жишигтэй байвал зүгээр байгаа. Тэгэхгүй бол яг зэрэгтэй зэрэгцээд л банк болгон өөр өөрсдийн машиныг зоочихсон байдаг. Тэрийг нэг стандарттай болгооч ээ. Энэ тал дээр бас ямар ажил хийж болохоор байна вэ гэсэн ийм хэдэн зүйлүүдийг асууя.

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатад баярлалаа. Тэгэхээр Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ намрын чуулганаар 2025 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2025 оны улсын төсөв зэрэг олон олон чухал арга хэмжээнүүдийг хуулиудыг батлах ёстой. Энэ ажилд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Ингээд Дашдондогийн Ганбат гишүүний асуултад 6 номер Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн хариулна аа.

Б.Лхагвасүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын валютын нөөц түүхэн дээд хэмжээндээ энэ онд хүрээд ингээд явж байгаа. Нэлээн ийм тогтвортой байх боломжтой. Нөөцийнхөө тодорхой хэсгийг алтаар барьдаг. Ерөнхийдөө 600-аад сая долларын нөөц бол алтаар ингээд байршаад явж байгаа. Тэгэхлээр одоо жилдээ Монголбанк бол 20 орчим тонн алтыг бод худалдаж авдаг ийм манай өмнөх жишээ байгаа. Энэ оны хувьд алт олборлолт алт худалдан авалт бол өмнөх онуудаасаа 10 хувиар доогуур яваад байгаа. Тэгэхлээр бол энэ онд 20 тонн алт руугаа хүрэхгүй байх магадлалтай гэж төв банкны зүгээс харж байгаа. Тэгэхдээ алт бол үнэ нь маш сайн өсөөд явж байгаа. Тийм 2600 гараад явчихсан. Энэ бол бараг түүхэнд сүүлийн үеийн түүхэн дээд хэмжээ болчхоод байгаа юм. Тэгээд бид нар аль болохоор Оюу Толгойн алтыг авъя гэдгээрээ санал тавиад явж байгаа. Тэгэхдээ Оюу Толгой бол өөрөө манайд өгч байгаа тайлбар нь юу байна вэ гэхлээр ингээд баяжмал шороо хэлбэрээр гараад явчихдаг. Тэр шороон дотор алт байна, зэс байна, мөнгө байна ч гэдэг юм уу олон металл байгаа. Гэхдээ яг алт нь тэд байна гэдгийг нь тодорхойлж чадахгүй байгаа учраас бол төвөгтэй гэж ярьдаг. Бидний хувьд бол яах вэ энэ алтыг буцаагаад оруулж ирэх юм бол Монгол Улсын валютын нөөц нь дээр нэмэртэй гэж хардаг.

Ерөнхийдөө тэр баяжмал дотор гарч байгаа зэс, алтны ерөнхийдөө АМНАТ-ын татвар яг ижилхэн 5 хувь байдаг байдаг учраас бол ерөнхийдөө гааль дээр тэр хэмжээгээрээ авдаг байх гэж Монголбанкнаас харж байгаа.

Том дэвсгэртэй холбоотойгоор ерөнхийдөө Монголбанк сүүлийн ер нь мөнгөн тэмдэгтийнхээ бүтэцтэй холбоотой судалгааг байнга хийгээд явдаг л даа. Тэр утгаараа анх одоо Монгол Улс хамгийн анх том дэвсгэрт нь 20 мянган төгрөг байгаа. 20 мянган төгрөгийг гарч байхад хэдэн америк доллартой тэнцэж байсан бэ гэдгээрээ харах юм бол ингээд өөр харьцаанууд ингээд яваад байгаа юм.

Тэгэхээр бол Монгол Улсад том дэвсгэрт гарахад бол манай судалгаагаар бол одоо ер нь боломжтой. Том дэвсгэрт гаргаснаараа ямар нэг эдийн засгийн болон санхүүгийн салбарт сөрөг үр дагавар бол бараг гарахааргүй байна гэдгээрээ манай дүгнэлт байдаг. Тэгэхдээ энэ том дэвсгэртийг хэвлүүлж гаргах энэ мөнгөний бүтцийг өөрчлөхийг нь Монголбанк өөрөө Их Хурлаар оруулж шийдүүлдэг байгаа. Тэгэхээр Их Хурал дээр хэрвээ санал оруулбал Их Хурлаас энэ шийдвэр нь гараад явах юм аа. АТМ буюу банкны пос машинууд дээр бол олон нэг худалдааны цэг дээр олноороо байх энэ бүх юмыг цэгцлэх энэ ажлуудыг хийгээд явж байгаа.

Тэр ч утгаараа ялангуяа энэ манай сүүлийн үеийн техник технологийн дэвшил нь өөрөө орж ирээд аль ч банкны пос машин бай аль ч банкны гаргасан аппликэйшноо бие биедээ хүлээн зөвшөөрөхөөр ийм бүтэц рүү ороод явж байгаа. Сүүлийн үед бол зөвхөн карт картаар биш, гар утсаараа ч гэсэн төлбөр тооцоо хийгээд явж байгаа учраас гар утасны энэ QR код тэр NAC технологи буюу зайнаас уншдаг энэ үйл ажиллагаа нь бүх банкнууд руу нэвтрээд явж байгаа учраас таны саяын тавьж байгаа энэ бол ингээд шийдэгдээд явна аа.

Б.Пүрэвдорж: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Ерөнхийдөө бол ажил явж байгаа юм байна. Зөв тал руугаа л явж байгаа юм байна гэж ойлгож байна. Энэ оффтейкийн гэрээнээс гарах юм уу, үгүй юу ямар бодолтой байгаа юм. Тэрийгээ та хариулаарай. Уул нь ОУВС бусад байгууллага ч гэсэн зөвлөж байгаа шүү дээ. Ер нь төв банк ийм ажилд оролцох ёсгүй ээ. Та нарын тэр бодлого хараат бус байх энэ юманд нийцэхгүй ээ. Та бүхэн энэ ажлаас гарах ёстой.

Дараагийн шатад тэгж байж ирж байгаа ажлыг юм хумаа хийх боломжтой болно шүү. Дараагийн нэг нь энэ банкны хувьчлал байна. Банкны хувьчлалын тэр 10 хувь хүртэл хувьчилсныг олон нийтийн хяналтад оруулах. Энийг бол та нар амжилттай хийсэн. Дараагийн шат гэж үргэлжлэх үү яах вэ? Бараг 34 хувийг л эзэмшиж байж олон нийтийн хяналт тогтооно шүү дээ. Тэр боломж нь тэгж бүрдэнэ. Нөгөө талаараа энэ олон банкнуудын эцсийн өмчлөгч нь хэн юм бэ? Тэрийг олон түмэнд мэдэгдэх хэрэгтэй. Хэний ямар банканд бид нар мөнгөө хадгалуулдгаа ард түмэн мэдэж байх ёстой.

Б.Пүрэвдорж: Дашдондогийн Ганбат гишүүн үг хэллээ.

Хариултыг Лхагвасүрэн Ерөнхийлөгч 6 номер.

Б.Лхагвасүрэн: Түрүүн Ганбат гишүүний нэг асуултад хариулалгүй өнгөрчихсөн байсан. Төв банкны тухай хуулиар Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Их Хурлаас томилдог. Хуулийнх нь хугацаа Ерөнхийлөгчийн хугацаа 6 жил гэж байдаг. Тийм, тийм байгаа.

Ипотекийн хөтөлбөртэй холбоотойгоор ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүл гэдэг чиглэлийг Улсын Их Хурлаас өгсөн байгаа. Засгийн газартай яриад явж байгаа. Тэгээд Засгийн газраас Үндэсний орон сууцын корпорац буюу Үндэсний орон сууцжуулах хуулийг өргөн бариад явна гэсэн. Тэгэхээр энэ хууль гарч ирээд энэ шилжих ажил эхлэх байх аа.

Банкны эцсийн өмчлөгчийг ерөнхийдөө хууль дээр 5-аас дээш бүхий хяналтын багцыг эзэмшсэн хувьцаа эзэмшигчдийг банк өөрөө нээлттэй ингээд өөрийнхөө веб хуудсан дээр зарлах ёстой. Зарим банкны веб хуудсан дотор энэ эцсийн өмчлөгчдийн нэрс байж байдаг. Би өнөөдөр ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмээд, нэмээд хариулчихъя.

Б.Лхагвасүрэн: Тийм, эцсийн өмчлөгчдийг Монголбанк банкнуудтайгаа нийлээд, энийг албан ёсоор, ингээд бүр 5-аас дээш хувьцаа эзэмшигчдийг нь нэр устай нь ингээд эцсийн өмчлөгч, хувь хүний, иргэнээр нь ингээд мэдээллийг байршуулъя гэдэг ийм ажлыг зохион байгуулъя. Банкны хувьцаа эзэмшигчийн дээд хязгаар нь 20 хувь гээд хууль дээр байж байгаа. Тэгэхдээ ОУБ гаднын хөрөнгө оруулагчид танай компанийн тухай хууль дээр 34 гэдэг тоон заалт байна. Энэ 34 гэдэгтэйгээ нийцтэй байж болдоггүй юм уу гэдгээр асуудлыг хөндөөд байгаа.

Тэгэхдээ энэ хувь Банкны тухай хууль дээр орох өөрчлөлт учраас хууль яригдах үед л энэ тооны тухай яригдах байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн босож зогсож байгаад асуулт асууна аа.

С.Ганбаатар: Та бүхний амар амгаланг айлтгая аа. Монголбанкны бодлого дээр 2022 онд инфляц 16.9 хувь байж байхад, энэ оны 7 сард 5.5 болсон. Энэ дээр юм хийсэн. Засаж залруулах хэдэн зүйл байгаа. Энэ 5.5 хувийг яаж тогтвортой барих вэ гэдэг дээр нэг 3 асуулт асууя.

1 дүгээрт, Монголын төрөөс барих мөнгөний бодлого нь мөнгө хүүлэлтийн бодлого болчихоод байна аа. Өнөөдөр Монгол орон тэр чигээрээ мөнгө хүүлэгчдийн диваажин болчихоод байгаа. Жишээ нь та нар ингээд ард иргэдийн зээл үндсэндээ нийт зээлийн өсөлтийн 22.3 хувь нь иргэдийн зээл байгаа. Бизнесийн зээл нь 9.2.

Тэгэхээр өнөөдөр мөнгө хүүлэгчдийн эдийн засаг болчихоод байна. Энийг яаж зогсоох вэ? Экспортыг дэмжсэн зээлээ хэзээ өгөх вэ? Импортыг орлосон зээлээ хэзээ өгөх вэ? Ингээд ард иргэдийн мөнгө хүүлэлтийг вампир гэж хэлээд байгаа шүү дээ. Германы эдийн засагч. Монголын мөнгөний бодлого вампир. Өөрөө юу ч хийхгүйгээр хүмүүсийн хөлс цусыг сорж амьдарч байвал вампир гэдэг шиг ийм байдал үүсчхээд байна.

Өнөөдөр банкны системийн цэвэр ашиг нь 24 оны 2 дугаар улиралд 909 тэрбум төгрөг болчихоод байна. 1 их наяд. Энэ бодлого хэзээ өөрчлөгдөх вэ. 1 дүгээрт миний асуулт.

Мөнгө хүүлэлтийн эдийн засаг маань цаад утгаараа та нар энэ дээр инфляцыг бууруулна л гэж яриад байгаа. Иргэдийн худалдан авах чадварыг хамгаална л гэж яриад байгаа, туйлын зорилгоо. Үгүй ээ, та нар бод доо. 100 төгрөгийг Монголбанкны буянаар ард түмэн 120-150 төгрөгөөр худалдаж авч байна. Тэгэхээр ард иргэд 100 төгрөгийг 130 төгрөгөөр худалдаж аваад тэр боорцог, талх хийж байгаа бүх бүтээгдэхүүндээ шингээж зарна. Яаж инфляц 5 хувьд хүрэх вэ? Яаж инфляц нэг оронд байх вэ? Миний 2 дугаар асуулт. Энэ ямар боломж байх вэ?

Толгой дараалан бүгд зээлтэй. 100 төгрөгийг 124 төгрөгөөр худалдаж аваад хийж байгаа талх, боорцог болгондоо 24 төгрөг нэмж зарна. Яаж инфляц нэг оронтой тоонд байх вэ, тайлбарла даа. Ийм мөнгө хүүлэлтийн бодлого хэзээ дуусах вэ, хэзээ зогсох вэ? Энэ аймшигтай сэтгэл өвдмөөр байдал зүгээр Ширэндэв гуайн ном дээр байгаа шүү. Нэн шинэ түүх гээд ном дээр. Манжийн үеийн мөнгө хүүлэлт 22.3 хувь байсан. Энэ мөнгө хүүлэлтээс болж Ардын хувьсгал гарсан шүү дээ. Ардын нам сүүлийн 8 жил толгойлохдоо мөнгө хүүлэгчдийн диваажин болгочихлоо. Та нарын хариулт бол эх үүсвэрийн зардал их байна гэж байгаа юм. Хадгаламж эзэмшигчид зугтчих гээд байгаа. Монголоос өөр хаашаа зугтах гээд байгаа юм. Африк руу юм уу. Цаана чинь хадгаламжийн хүү зарим, Японд бол хасахтай байна шүү дээ. Энэ хариултаа дахиж өгөхгүй байлгүй дээ, арай.

2 дугаар миний асуулт цахилгаан, дулааны үнэ энэ 25 оны төсөвт цахилгааны үнэ 30 хувиар нэмэгдэж орж ирэхээр орж ирж байна. Дулааны үнэ 50 хувиар нэмэгдэхээр орж ирж байна. Та нар энэ инфляцад нөлөөлөхгүй гэсэн тооцоо хийсэн байна. Яагаад энэ нөлөөлөхгүй гэж? Энэ талаар та нар хувилбар 2 гээд гаргасан байна л даа. Энийгээ надад тайлбарлаад өгөөч?

3 дугаар асуулт. Тэр Оюутолгойг түрүүн асуучих шиг болсон гишүүд. Оюутолгой ер замаа алдлаа. 17.6 тэрбум долларын өртэй болчихлоо. Энэ ер энэ манай, чиний энэ та нар энд зээлд орсон уу, гадаад зээл гэдэгт орсон уу.

4 дүгээр асуулт. Брикс гээд биднийг тойроод бүгдээрээ мөнгөний бодлогодоо өөрчлөлт оруулж байна. Би Брикст орёе гэж яриагүй шүү. Зүгээр биднийг эргэн тойрон бүгд мөнгөний цоо шинэ бодлого барьж байна. Энэ ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний 4 асуултад 2 номер хариулна аа. Хэн билээ?

Б.Баярдаваа: Гадаад өрийн статистик дотор Оюутолгойн өрийн хэмжээ, хөрөнгө оруулалтын зээл, зээлийн хэмжээ орчихсон явж байгаа. 34 тэрбум доллар дотроос 16 гэсэн компани хоорондын зээл энэ байгаа. Үүний ихэнх нь Оюутолгой байгаа.

Цахилгаан, дулааны үнийн өсөлтийг инфляцад бид нар нөлөөлнө гэж үзсэн. Инфляцын нөлөөллийн тооцоо судалгаа нь үндсэн чиглэлийн нөгөө цэнхэр ном дотор тооцоолол нь орчихсон байгаа.

Цахилгааны үнийг 30 хувиар нэмэгдүүлэх юм бол инфляцыг 0.8, ойролцоогоор 1 нэгж хувиар нэмэгдүүлнэ гэсэн ийм тооцоо байгаа.

Дараагийнх дээр нь Ганбаатар гишүүнтэй бид нар тэр зээлийн хүү өндөр байгаа гэдгийг бүрэн санал нэг. Энийг ер нь Монголын энэ банк санхүүгийн систем Монгол Улсын Засгийн газар, Их Хурал бүгд ер нь энэ яаж зээлийн хүүг бууруулах вэ гэдэг юмыг маш олон жил ярьж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа. Ковидын өмнө нэлээд амжилт гарсан. Өөрөөр хэлэх юм бол 20 хувьтай байсан дунджаар 20 хувьтай байсан зээлийн хүү 13 хувь болж, 19 оны байдлаар 12.3 хувь болж 19 оны байдлаар буурсан. Гэсэн хэдий боловч энэ ковидын дараа ковидоос улбаалаад эргээд зээлийн хүүгээ бид нар дээш нь одоогийн 16, 17 хувь руу ингээд алдсан байгаа. Энэ дээр нөлөөлсөн олон хүчин зүйл байгаа. Жишээлэх юм бол гаднаас авч байгаа санхүүжилтийн хэмжээ нөгөө гадаад зах зээл дээр 0-1-ийн хооронд байсан долларын суурь хүү бол 5-6 хувь болж өссөн нь шууд нөлөөлсөн.

Дээрээс нь инфляц нэмэгдсэнтэй холбоотойгоор бодлогын хүү 6 хувь байж байгаад 13 хувь болж нэмэгдсэн. Энэ зүйлүүд ингээд зээлийн хүүн дээр ингэж орж ирж тусгалаа олоод байгаа.

Нөгөө талаасаа инфляцыг ингээд тогтвортойгоор ингээд цааш нь бууруулахын тулд инфляцыг бууруулах нь өөрөө эргээд иргэдийн бодит орлогыг хамгаалах, дээрээс нь бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэх, улмаар энэ нь цаашаа зээлийн хүү ингэж тогтвортой буурах ийм хамгийн суурь нөхцөл болно гэж үзэж байгаа.

Тэгээд энэ утгаараа ер нь энэ дэлхийн санхүүгийн зах зээл дээр бүхий л улс орнууд энэ инфляцыг бууруулах энэ ажлыг Төв банканд үүрэг болгож өгдөг. Энэний жишгээр ч гэсэн Монголбанк энэ инфляцыг цаашдаа бүр 5 хувь руу бууруулж ирье гэсэн ийм зорилтыг ингэж оруулж ирж байгаа.

Тэгээд үүнээс гадна төлбөрийн тэнцлийн тусгал болсон энэ валютын ханшийн хэлбэлзлийг багасгах нь өөрөө энэ инфляцыг цааш нь бууруулах, улмаар зээлийн хүүг бууруулах ийм суурь нөхцөл болно гэж үзэж байгаа. Харамсалтай нь валютын ханш Монгол Улсын эдийн засгийн хувьд төлбөрийн тэнцэл буюу нөгөө нийт хөрөнгө оруулалтын бодлого, экспорт, импортын харьцаа энэ бүх юмнаас ингэж хамаарч өөрчлөгдөөд байгаа.

Нөгөө талд нь ахиад энэ зээлийн хүүг цааш нь бууруулахын тулд энэ үндсэн чиглэл дээр хэд хэдэн зорилтууд тусгагдсан байгаа.

1 дүгээрт нь, энэ мөнгө хүүлэлтийн тухай буюу энэ санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай зарим төрлийн зээлүүд дээр энэ санхүүгийн систем зээлийн хүүгийн хязгаар тогтоох тухай асуудлыг үндсэн чиглэлд тусгаж оруулж ирсэн байгаа.

Дээрээс нь жижиг дунд бизнес эрхлэгчдийн нөгөө барьцаа хөрөнгө ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 2 номер Баярдаваа нэмээд хариулчихъя.

Б.Баярдаваа: Жижиг, дунд бизнест энэ санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор барьцаа хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө шаардахгүйгээр борлуулалтынхаа гэрээг, бизнесийнхээ гэрээг барьцаалаад зээл авдаг энэ тогтолцоог бүрдүүлэхийн тулд нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг бий болгоно гээд энэ зорилтыг оруулж ирсэн. Энэний хүрээнд Монголбанкнаас арилжааны банкнуудад гэрээгээ барьцаалсан зээлдэгч нар дээр үл хөдлөх хөрөнгө нэмж барьцаалбар байдлаар шаардахгүй байх ийм журмын зохицуулалтыг хийж өгсөн байгаа.

Дараагийн 5 дахь зүйл бол энэ чанаргүй зээлийг хурдан шуурхай барагдуулах тухай ийм асуудлыг бас зорилт болгож оруулж ирсэн. Түрүүн Сайнзориг гишүүн энийг нэлээн маш тодорхой хөндсөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотойгоор чанаргүй зээлийг барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг нь хангуулахад тэр 4-8 жил зарцуулаад байгаа хугацааг богиносгох. Энэтэй холбоотойгоор банкны баланс дээр байгаа тэр чанаргүй зээлийн эрсдэлийн сантай холбоотой зардлуудыг бууруулж өгөх ийм зүйлүүдийг энэ жилийн үндсэн чиглэл дээр тусгаж оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ 4, 5 энэ макро болон санхүүгийн зах зээлийн хөгжилтэй холбоотой, зохицуулалттай холбоотой энэ арга хэмжээнүүд ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмээд хариулчих. Дахиад. Жоохон, юм уншихгүйгээр шууд шууд хариулт яв л даа. 6 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Ерөнхийдөө ковидын дараа энэ олон улсын хурцадмал нөхцөл байдлаас болоод хүчний харьцаанууд ингээд энэ бүлэглэл болж ингээд хуваагдаад явж байгаа. Брекстэй холбоотой ерөнхийдөө ингээд брекст бол энэ ер нь дэлхий даяар нөгөө Энержи маркет гэдэг ийм том дэлхийн 7 том гүрнээс гадна өшөө хөгжиж байгаа орнууд, ялангуяа хөгжил нь нэлээн өндөр болж байгаа улсуудыг энэ брекст дээр ингээд ороод явж байгаа. Энэ дээр үндэсний мөнгөн тэмдэгтийг төлбөр тооцоонд ашиглах тухай ч юм уу ийм асуудлууд яригдаж байгаа

учраас Төв банкны зүгээс төв банк өөрөө Монгол Улсын гадаад худалдаа бол ер нь доллар 70 хувийг нь эзэлдэг. Тэгэхээр манай гадаад худалдааны доллар гэдгээрээ бүх төлбөр тооцоо Свифтийн сүлжээгээр дамжаад явдаг. АНУ-ын банкнуудаар ингээд банкаар хамгийн сүүлд банк Нью-Йорк Миллон гэдэг банк бол манай арилжааны банкнуудад данс нээгээд ингээд төлбөр тооцоог нээлттэй явуулж байгаа.

Тэгэхээр энэ утгаараа зүгээр Монгол Улс энэ өөрийнхөө сонгодог өнөөдрийг хүртэл хийж байсан үйл ажиллагаанаасаа ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Инфляц буурсан үр дүнгээ нэг номерт худалдааны түнш орнуудын эдийн засаг тогтвортой байсан гэж тайлбарлаж байгаа. Нөгөө түнш орнууд чинь тэгээд Дундад Ази тэр чигээрээ Брикст орж валют доллар шүтдэг бодлогоосоо өөрчилж цоо шинэ өөр бодлого барьж байгаа. Энэ дээр манайх ямар ч бодлогын бэлтгэл ажил байхгүй юм байна гэж би ойлголоо.

2 дугаарт, миний асуулт их тодорхой байгаа шүү дээ. Өнөөдөр мөнгө хүүлэлтийн бодлого яваад байна аа. Ард иргэдийн зээл, ард иргэдэд мөнгө хүүлж байгаа явдал бол 100 төгрөгийг та нар 120-150 төгрөгөөр зарж байгаа. Мөнгийг ийм үнэтэй зарж байгаа хүүлэгчдийн буянаар жилийн цэвэр ашиг нь банкнуудынх 909 тэрбум төгрөг болчихсон. Энэ бодлого дээр яаж экспортоо дэмжих вэ, яаж импортыг орлосон бодлого барих вэ, ямар барих вэ? Та нарын чинь ярьж байгаа юм бол банк мөнгө хүүлэгчдийн төлөөллийн байгууллага шиг л барьцааг нь яаж хураах вэ? Яаж баталгаатай хурдан шүүхээр ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 6 номер Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Ганбаатар гишүүний асуултад тодотгоод хариулъя. Ерөнхийдөө бодлогын хүүгээ буулгаад, мөнгөний бодлогын төлөвийг ингээд бага зэрэг сулруулаад явж байгаа энэ дохио бол өөрөө зээлийн хүүн дээр зах зээл дээр байгаа хадгаламжийн хүү, эх үүсвэрийн хүү, зээлийн хүү, бусад бүх л банкны санхүүгийн зуучлалын бүтээгдэхүүн үйлчилгээн дээр нөлөөлнө өө гэж Төв банкны зүгээс харж байгаа. Тэр утгаараа энэ бодлогын хүүний үр дүн бол ирэх оны ингээд манай бодлогын шийдвэр ерөнхийдөө 9 сараас 1 жилийн дараа үр дүн нь гардаг учраас дараа жил өдий үед зээлийн хүү энэ бодлогын хүүний нөлөөгөөр тодорхой хэмжээнд буураад ирнэ ээ. Түүн дээр Монголбанк итгэлтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намын бүлгийн хурал дээр асуусан байгаа. 2024 оны төсөв 27 их наяд, ингээд энэ жилийнх 35 их наяд болж байгаа юм. Ийм их нийлүүлэлт хийгдэх нь ээ. Мөнгөний ханш унах уу? Зах зээл энийг даах уу гэдэг дээр асуулт авсан. Юу гэж хариулж байгаа вэ гэхээр энэ үндсэндээ нэлээн хүндэрнэ ээ. Ер нь бид нар нэлээн хатуу бодлого барина гэж байгаа. Хатуу бодлого гэдэг нь хүүгээ өсгөнө өө л гэсэн үг. Үүнээс болж хэдэн ААН, ЖДҮ дампуурах вэ? Энэ дээр тооцоо судалгаа байна уу? 1 дэх асуудал.

Ер нь ингээд ийм их нийлүүлэлт хийгдэхээр асар их үнийн өсөлт явж байна л даа. 21 он, 22 онд хийгдсэн ажлууд ажлаа хийхгүй нэг жил өнжөөд л төсвөө

нэмүүлээд л 2, 3 дахин нэмэгдчихсэн. Тэгээд сая би л энэ тоонууд дээр харж байхад 5 их наядын хадгаламж нэмэгдсэн, өмнөх оныхоос 26.3 хувиар өсчихсөн байгаа. Нийт хадгаламж нийтдээ ингээд 22 их наяд. Энэ хадгаламж энэ яагаад нэмэгдчихэв ээ? Энэ юунаас болоод нэмэгдчихэв. 2 дахь асуудал.

3-д нь, энэ тогтворжуулах хөтөлбөр гэж явуулах уу? Яагаад энэ хөтөлбөр явахгүй байна вэ? 3 дахь асуудал.

4 дэх нь болохоор Төв банкны хууль дээр байгаа. 11 дүгээр зүйлийн 1.3 дээр хүүгийн нэгдсэн бодлого явуулна гээд ингээд байж байгаа юм. Тэгээд сая манай гишүүдээс бүгдээс нь бараг гарч байна шүү дээ. Нэг хүүгийнхээ энэ асуудалд анхаарахгүй бол Монгол Улсад чинь өргүй хүн гэж ерөөсөө байхгүй боллоо. Өрийнхөө дарамтаас гарч чадахгүй, энэ ядуурал маань өнөөдөр тартагтаа туллаа. Энэ дээр яагаад та хэд маань ажлаа хийхгүй байгаа юм бэ? Тэгээд л 1 ерөөсөө л нэг онол яриад байх юм. Амьдрал дээр чинь тэр хөдөөд чинь, суманд чинь ЖДҮ хувийн хэвшил гэдэг юм сүйрчихсэн шүү дээ. Ерөөсөө төсвөөр хийгдэж байгаа хэдхэн ажил л явж байна шүү дээ. Тэгэхээр манай орон чинь сүүлдээ ямар орон болох гээд байгаа юм. Хувийн хэвшилгүй, энэ чөлөөт зах зээл байхгүй, шударга өрсөлдөөн байхгүй ийм орон болох гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм бэ? Энэ дээр ямар бодлого, яаж явж байгаа юм бэ? Энэ дээр яг тодорхой хариулт авмаар байна аа.

Б.Пүрэвдорж: Жаргалсайхан гишүүний асуултад Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулна. 6 номер.

Б.Лхагвасүрэн: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Тийм. Тэгэхээр бодлогын хүү 13 хувь байхад зээлийн хүү, дундаж хүү нь 17 хувь байгаад ингээд ирсэн. Тэгэхээр бодлогын хүүг 10 болгоод явахаар зээлийн хүү буурах боломжтой л гэдгээрээ Монголбанк харж байгаа юм.

ААН-үүдтэй холбоотой ингээд ярих юм бол мэдээж яг нарийн микро түвшний аль салбарт хэчнээн ААН гэдгээрээ нарийн тоонууд яг манай дээр ерөнхийдөө байхгүй. Том нэгтгэсэн дүнгээр үзэх юм бол манай ДНБ энэ хагас жилээр 5.6 хувь өссөн. Хэрвээ ХАА-н салбар, уул уурхайн салбарыг тооцохгүй бол, тооцохгүй. Энэ тооцоонд оруулахгүй гэж үзэх юм бол ДНБ 10.3 хувиар өсөхөөр, тэр 10.3 хувийн өсөлт хаана байна вэ гэхээр худалдааны салбар, үйлчилгээний салбар, аж үйлдвэрийн салбар байгаад байгаа юм. Тэгэхээр худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэр гэдэг бол хамгийн их хүний нөөцтэй, хамгийн их ЖДҮ байдаг энэ хэсэг л дээ.

Тэгэхээр энэ утгаараа энэ 23, 24 он бол ЖДҮ, аж үйлдвэрүүд, жижиг ААН-үүдийн хувьд маш сайн бизнес нь тэлсэн ийм жил байна л гэж л бидний зүгээс хараад байгаа юм. Тэгэхээр өнөөдөр ингээд бодлогын хүүгээ буулгаад явах нь өөрөө эдгээр ААН-үүдэд илүү л сайн нөлөө үзүүлнэ ээ л гэж харж байгаа юм.

2 дахь асуудлын хувьд 5 их наядаар буюу иргэдийн харилцах хадгаламж өсөж байгаа нь та бүхэн сайн мэдэж байгаа. Өнгөрсөн онд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг тодорхой хувиар нэлээн өндөр хувиар ингээд нэмсэн байгаа. Энэ өрхийн өрхөд очиж байгаа энэ цалингаар дамжиж, тэтгэврээр дамжиж, очиж байгаа энэ орлого өөрөө хэрвээ хэрэглээ болж зарахгүй, зарцахгүйгээр хуримтлал болоод явах юм бол манай өнөөдөр манай санхүүгийн тогтолцоо чинь 90 хувь нь ингээд банк байна гэхээр банкн дээр л харилцах хадгаламж хэлбэрээр л ингээд оччихож байгаа.

Төсвөөр дамжаад мэдээж бүтээн байгуулалтууд хийж байгаа. Төсвийн энэ бүтээн байгуулалтад орж ирж байгаа ААН-үүдийн бүтээсэн худалдан авалт буюу төсвийн худалдан авалтынх нь мөнгө нь бас л банкны ААН-ийн данс дээр очиж байгаа учраас энэ ААН-үүдийн энэ банкны эх үүсвэрийн данс ингээд нэмэгдээд явж байгаа гэж.

Бодлогын хүү гэдэг маань өөрөө таны саяын хуулийн заалтын хүүгийн нэгдсэн бодлого гэдэг нь нэгдсэн бодлого гэдгээрээ Монголбанкны бодлогын хүүгээр дамжаад бусад хүүнүүдэд нөлөө үзүүлэх энэ бодлогын арга хэрэгсэл байгаа. Тэгэхээр хуулийнхаа дагуу бодлогын хүүгээ бид бууруулаад явж байгаа нь арилжааны банкны тэр зээлийн хүүг бусад хүүнүүдийг энэ дагуу буулгах л энэ бодлогын арга хэмжээ байгаа юм.

Б.Пүрэвдорж: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Тийм. Бидний хувьд нөгөө ийм л юм яриад байна шүү дээ. Арилжааны банк ойлгомжтой, тэр өөрсдийн зардал дундын ашгийн хүүгээ авч болж байна шүү дээ. Тэгэхэд бидний хувьд өнөөдөр харахад л хэдхэн хүн хадгаламжтай. Хадгаламжийн хүү өнөөдөр 16 хувь хүрчхээд байна шүү дээ, жилийн. Тэгэхээр ажил хийхгүйгээр, бизнес хийхгүйгээр, ЖДҮ хөгжүүлэхгүйгээр мөнгөө банканд хийгээд сууж байхад л ашигтай ажиллаж чадаж байна шүү дээ.

Тэгээд энэ хадгаламжийнхаа хүүг бууруулаач ээ. Энэ ЖДҮ-лэгч болгооч ээ гэсэн л гол санааг хэлээд байгаа шүү дээ. Энэ дээр ямар бодлого барих юм бэ? Энэ хадгаламжийнхаа хүүг яагаад буулгаж болохгүй байгаа юм? Хадгаламж гэдэг чинь нэг талдаа хасах бүр мөнгө өгөөд хадгалуулах ёстой биз дээ, ер нь утга санаагаараа бол. Тэгэхэд яагаад өнөөдөр яг ийм байдлаар ингээд хүүлэлт явагдаад байгаа юм бэ гэдэг ийм л асуулт асуугаад байгаа шүү дээ.

Б.Пүрэвдорж: Жаргалсайхан гишүүний асуултад Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулъя. 6 номер.

Б.Лхагвасүрэн: Ерөнхийдөө Жаргалсайхан гишүүнтэй бол Төвбанк ижилхэн байр суурьтай байгаа. Эх үүсвэрийн хүүг буулгая гэсэн ийм л бодолтой байна. Мэдээж яг л Төв банкны олон улсад байдаг жишгийн дагуу инфляцыг нам доор түвшинд байх ёстой. Тэрнийхээ төлөө бодлогоо явуулна.

2 дахь нь Жаргалсайхан гишүүний хөндөж байгаа эх үүсвэрийн хүүг яаж буулгах вэ гээд. Энэ дээр олон арга хэрэгсэл байгаа. Ялангуяа захиргааны гэдэг арга хэрэгсэл бол дээд таазыг нь тогтоож өгөх тухай байгаа. Энэ тэртээ тэргүй олон улсад мөрдөгдөөд хэрэглээд явдаг ийм арга хэрэгсэл учраас мэдээж энэ дээр санаа оноо байна.

Дээр нь ялангуяа банкаар нь өөрсдөөр нь дамжуулж хийх суурь хүүтэй холбоотой ийм заалтыг зохицуулалтдаа оруулахаар бид хэд ажиллаад явж байгаа. Тэгэхээр 25 онд тодорхой хэмжээний алхмууд хийгдэнэ. Тэр хийсэн алхмуудынхаа үр дүнгийн талаар Их Хуралд тайлангаа тавих болно.

Б.Пүрэвдорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: 3 асуулт байна. ОУВС-ийн дүгнэлтээр нэг хувьцаа эзэмшигчийн хувийн эзэмшлийн дээд хязгаарыг ер нь нэмэх нь зүйтэй гэж дүгнэсэн байна аа. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар арилжааны банкнууд 2026 оны сүүл гэхэд 20 хувийн хязгаартай хүрэх ёстой байгаад байдаг. Тэгэхээр энэ талаар Монголбанк ирэх 2025 онд ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ гэж. Энэ зөвлөмжийн дагуу.

2 дугаарт нь, болохоор ОУВС-ийн дүгнэлтээр санхүүгийн салбарын хяналт шалгалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Үүний тулд төв банкны ерөнхийлөгч хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд санхүүгийн салбарын хяналт шалгалтыг сайжруул гэж, сайжруулбал сайд сайн гэж дүгнэсэн байна л даа. Тэгэхээр яг энэ чиглэлээр 2025 оны энэ мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээр ер нь ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ гэж 2 дугаар асуулт.

3 дугаарт нь, болохоор энэ хадгаламжийн даатгалын хохирлын дээд хэмжээ, нөхөн төлбөрийн дээд хэмжээ 20 сая төгрөг байгаад байгаа. Тэгэхээр энэ 20 сая төгрөгийн хэмжээ нэлээн олон жил явчихсан. Энэ хэмжээг ер нь 2025 онд цаашдаа ер нь нэмэх ямар бодлого байгаа вэ гэж асууя.

Б.Пүрэвдорж: 6 номер Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Банкны тухай хуульд 2021 оны нэг сард орсон өөрчлөлтөөр хувьцаа эзэмшлийн төвлөрлийг оруулсан байгаа. Анх хуулийг өргөн барьж судалгаа хийгээд явж байхад анх энэ заалт өөрөө 30 хувь гэдэг тоо байсан. Тэгээд хууль болж батлагдахдаа 20 болоод ингээд явж байгаа. Тэгээд сая дахиад сунгагдаад 26 оны эцэс хүртэл ингээд сунгагдсан байгаа. Гаднын хөрөнгө оруулагчид, ялангуяа олон улсын байгууллагууд энэ тоог энэ 20 гэдэг тоог хаанаас ямар үндэслэлээр гаргаж ирсэн тоо вэ гэдгээр нэлээн асуудаг. Монгол Улсад үйлчилж байгаа өөр нэг хууль бол Компанийн тухай хууль байгаа. Компанийн тухай хуулийн тодорхой тоо заасан заалт бол энэ 34 хувь гэсэн ийм заалт байдаг. Хяналтын багц гэсэн маягаар.

Тэгэхлээр энэ Банкны тухай хууль, Компанийн тухай хууль 2 бол хоёулаа ингээд 2 өөр өөр тоотой ингээд яваад байгаа. Тэгэхдээ нэгэнт ингээд анх Монголбанкнаас оруулж ирсэн саналаасаа арай өөрөөр батлагдсан учраас Монголбанк хуулийн нийцтэй байдал гэдгээрээ энэ тоо хөдөлж ч болно, хөдлөхгүй ч байж болно гэсэн л байр суурьтай байгаа.

Ер нь зүгээр гаднын хөрөнгө оруулагчдаа ингээд дэмжсэн маягаар бодлогоо явах юм бол гаднын хөрөнгө оруулагчид 34 хувь байх нь зүйтэй л гэсэн тоог л хэлээд л байгаа. Сая сүүлд ОУВС л ингэж хөндсөн.

2 дахь асуудлын хувьд Монголбанк арилжааны 12 банкн дээрээ хяналт шалгалтаа ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Сүүлийн үеийн олон улсын жишиг сайн жишиг нь эрсдэлд суурилсан хяналт шалгалт гэдэг хэлбэр лүү нэлээн шилжээд байгаа. Тэгэхээр Монголбанкны хувьд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хэлбэр лүү шилжээд явж байгаа. Сая энэ онд, 24 онд банкнууд дээрээ хийж байгаа хяналт шалгалтаа эрсдэлд суурилсан хяналт шалгалтын загвар луу оруулахаар туршилт маягаар явуулсан. Ирэх жил энийг бүр яг хэрэгжүүлэхээр ингээд ажиллана аа. Тэгэхлээр эрсдэлд суурилсан хяналт шалгалт маягаар ингээд хяналт шалгалтаа хийгээд явах болно.

3 дахь асуултын хувьд Хадгаламжийн даатгалын корпорацын тухай хууль гэж байдаг. Мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль. Энэ хуулиар нэг хадгаламж эзэмшигчийн нөхөн төлбөрийн хэмжээ 20 сая төгрөг. Энэ хуулийг анх 2013 онд баталж байхдаа энэ 20 сая төгрөг гэж ярьж байсан. Үүнээс хойш дундаж хадгаламж эзэмшигчид, жижиг хадгаламж эзэмшигчдийн дүн нэлээн өссөн байгаа. Энэ өссөн дүнгийнхээ дагуу 50 сая хүртэл нэмэгдэх ер нь боломжтой л гэж харж байгаа.

Дээр нь Хадгаламжийн даатгалын корпорац энэ 10 гаруй жил ажиллахдаа нөөц сангийнх нь хэмжээ нь анх 50 тэрбум төгрөгийн нөөц сантай байсан бол одоо 800 гаруй тэрбум төгрөгийн нөөц сантай болсон учраас хадгаламжийн энэ нөхөн олговрын энэ хэмжээг дээш нь нэмэх боломжтой гэж харж байгаа. Тэгээд энэ талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээрээ яриад Хадгаламжийн даатгалын тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар асуудлыг оруулж ирж болно гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Нөгөө нэг хувьцаа эзэмшигчид ноогдох дээд хэмжээ 20 хувийг 34 хүртэл нэмэх талаар санал оруулах уу л гэж асуугаад байгаа юм л даа, 2025 онд.

Б.Пүрэвдорж: 6 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Соронзонболд гишүүний асуултад тодруулан хариулъя. Монголбанк дээр ажлын хэсэг гараад Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ингээд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Яг одоогийн бид нарын ингээд ажиллаж байгаа хуулийн төсөл дээр энэ тоог өөрчилье гэсэн санал байхгүй байгаа. Зүгээр энэ хууль хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах эрхтэй учраас ингээд энэ нь нээлттэй байж болох байх л гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Миний асуулт нэг их давхардахгүй байхыг хичээж байна. Монголбанкны үндсэн зорилго бол үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангахад оршино гээд маш тодорхой зааж өгсөн байгаа. 22 оны 9 сард мөнгөний нийлүүлэлт 27 их наяд төгрөг байжээ. Энэ жилийн 9 сарын байдлаар энэ мөнгөний нийлүүлэлт 41.8 их наяд төгрөг болж, сүүлийн 3 жилийн дотор 14 их наяд төгрөгөөр мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн байна.

Тэгэхээр мөнгөний нийлүүлэлтийг 1 их наядар нэмэгдүүлэхэд ханш болон инфляц ямар нөлөө үзүүлдэг юм бэ? Энэ дээр тооцоо судалгаа байна уу? Энэ графикаар үзүүлэх юм бол ингэж өсөлт хийсэн байна аа. Асар хурдацтай өсөлт хийж.

2 дугаар асуулт нь, Монголбанк инфляц ер нь хэцүүдлээ. Мөнгөний хатуу бодлого барья гээд төв банкны үнэт цаас бүрдүүлсэн. Энэ нийт мөнгөний нийлүүлэлтийн 4-ний 1 буюу 8.7 их наяд төгрөгийн төв банкны үнэт цаас бүрдүүлсэн байгаа. Жилдээ хэрвээ Монголбанкны хүүг 10 хувьтай гэж бодох юм бол бид нар энэ төв банкны үнэт цааст зориулаад 1 их наяд төгрөгийн хүү Монголбанк өгч байна

аа. Тэгэхээр энэ саяын өнгөрөгч 4 жил энэ жилдээ 1 их наяд юм бол 4 жилд ер нь хэдий хэмжээний энэ хүү төлөв өө, Монгол банк, энэ арилжааны банкнуудад. Цаашдаа энэ бодлогоо үргэлжлүүлэх юм уу? Энэ маш их хэмжээний хүү төлж байна. Татвар төлөгчдийн мөнгө шүү. Энэ ААН-үүдийн төлж байгаа татвар. Энийг ийм ААН-үүддээ бага хүүтэй зээл олгодоггүй мөртөө арилжааны банкнууддаа ийм хэмжээний хүү өгөөд баймааргүй байна. Энэ дээр ямар бодлого хэрэгжүүлэх вэ? Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Пунсалмаа гишүүний асуултад Лхагвасүрэн Ерөнхийлөгч. 6 номер хариулна.

Б.Лхагвасүрэн: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Тийм. Ерөнхийдөө олон улсад энэ мөнгөний нийлүүлэлт өөрөө эдийн засагтайгаа хэр уялдаатай байна гэдгийг л харж явдаг. Тэгэхээр таны хэлж байгаа 2022 оны жишээ өнөөдөр ингээд 2024 оны 8 сарын тоо гээд ингээд харьцуулах юм бол 22 онд мөнгөний нийлүүлэлт ДНБ-ий 54 хувьтай тэнцүү байсан, 55 хувьтай. Өнөөдөр ДНБ-ий 54 хувьтай тэнцүү. Ерөнхийдөө ингээд л нэг 54, 55 хувийн орчимд л байгаа юм. Тэгэхээр мөнгөний нийлүүлэлт өөрөө эдийн засагтайгаа яг нийцтэй байна уу гэвэл маш тогтвортой байгаа л гэж л Монголбанкны зүгээс харж байгаа юм. Яагаад. Хэрвээ мөнгө нь бага байх юм бол энэ эдийн засаг сэргэж хөгжихгүй, энэ санхүүжилт нь дутмаг хэвээрээ л байх болно. Тэгэхээр хэдийгээр ингээд тоон дүн нь өөрөө ингээд өсчихсөн юм шиг харагдаж байгаа боловч ДНБ тэр хэмжээгээр тэлээд томроод явж байгаа л гэсэн ийм Монголбанкны тооцоо судалгаа байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө ингэж яасан юм байхгүй. Хэрвээ бусад улсын жишээг харах юм бол жишээлбэл Японы жишээ. Хамгийн их жиш жишээ авах дуртай. Мөнгөний нийлүүлэлт нь ДНБ-ээсээ бараг 2 дахин их, 220 хувьтай ч юм уу ийм тоонууд байдаг. Тэгэхээр бидний хувьд ийм харин ч их аядуу, нам зөөлөн ийм тоо байгаа гэж харж байгаа. Тэгэхээр мөнгөний нийлүүлэлт талаасаа ямар нэг нэмэгдээд эдийн засгийг тэнцвэртэй байдлыг алдагдуулсан зүйл байхгүй ээ гэж хэлж байгаа.

Инфляцтай холбогдуулаад төв банкны үнэт цаасны тухай асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр ерөнхийдөө төсвөөр дамжсан мөнгө хаана ингэж эдийн засагтай тэнцвэртэй байдлыг бий болгож байна вэ гэхээр тэнцвэрийг хангадаг зүйл нь энэ төв банкны үнэт цаас байгаа. Жишээлбэл төсвөөр дамжсан тэр их эдийн засагт очиж байгаа мөнгө эргээд тогтворжуулах буюу стерлизац гэж мэргэжлийн нэр томьёо байдаг. Энэ ажлыг төв банк ингээд хийгээд явж байгаа. Тэр утгаараа төв банкны үнэт цаас ийм өндөр байгаа. Хэрвээ энэ үнэт цаасыг Төв банк өөрөө өөрийнхөө төв банкны үнэт цаасаар татаагүй байсан бол энэ 8,7 их наяд төгрөг эдийн засаг дээрээ өөрөө 1 дүгээрт, тэнцвэрийг алдагдуулна. 2 дугаарт, инфляцыг өнөөдрийн манай энэ зорилтот түвшнээс хамаагүй дээш нь өргөөд аваачиж байх боломжтой бас нэг ийм эрсдэлийг үүсгэх зүйл байгаа. Энэ нь өөрөө төгрөг байгаа учраас төгрөг нь өөрөө хэрвээ доллар луу хөрвөх юм бол энэ 8,7 их наяд төгрөг гэдэг өөрөө төгрөгт өнөөдрийн ханшаар шилжүүлэх юм бол бараг 2 тэрбум гаруй долларын ийм хэмжээний урсгал хөрвөлт үүсэх ийм л эрсдэлтэй зүйлүүд байгаа.

Тэгэхээр төв банкны өөрөө энэ дээр мөнгөний бодлогоороо дамжуулж эдийн засгийн тэнцвэртэй буюу балансажсан гэж ярьдаг, ийм зүйлийг л бий болгоод л энэ бодлого хэрэгжээд явж байгаа л гэж Төв банк харж байгаа.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Бум-Очир гишүүнээр тасаллаа.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Түрүүн асуултдаа хариултыг бүрэн дүүрэн авч чадаагүй. Тэгээд та хэд маань энэ инфляцтай холбоотой ялангуяа тэр 2025 оны та хэдийн өөрсдийн эрсдэл гэж үзэж байгаа, чухал гэж үзэж байгаа зүйлсүүд дээрээ их бат итгэлтэй байгаарай. Бид нар мэдээж жишээлбэл та хэд маань өөрсдөө ч хэлж байгаа. Эдийн засгийг гол экспортын бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүнүүд маань эзэлж байгаа гэж. Ганбаатар гишүүний хэлээд байгаа тэр биржээр арилжаалахтай холбоотой асуудал маш сайн анхаарах ёстой асуудлуудын нэг. Тийм учраас энийг 1 дүгээрт, сайн хараарай гэж хэлэх гэж байгаа юм.

2-т дугаарт, бүсчилсэн хөгжилтэй бодлоготой холбоотой, татварын ялгамжтай бодлоготой холбоотой асуудлуудыг сайн гаргаж ирэх шаардлагатай байна. Мэдээж Сангийн яам энийг дангаараа хийхгүй. Тэгэхээр энэ бодлогын хүрээнд та хэд маань энэ ялангуяа энэ эдийн засгийн олон тулгууртай болно гээд энэ хөгжлийн бодлогын баримт бичиг дээрээ оруулчихсан учраас, дээрээс нь сая 2024 оны Улсын Их Хурлын сонгуулиар бараг бүхий л улс төрийн намууд энэ бүсчилсэн хөгжлийн бодлого хөтөлбөрийн хүрээнд өөрсдийн мөрийн хөтөлбөрийг гаргаж, дэвшүүлж ажилласан сан. Ард түмэнд олон зүйлийг бид нар амласан. Одоо эргээд харахаар бид нар нэг талдаа хэрэгжих ч юм шиг, хэрэгжихгүй ч юм шиг энэ асуудлууд яригдахгүй байгаад байгаа юм.

Тэгээд энэ дээр энэ татварын ялгамжтай бодлогыг сайн хараарай гэж хэлэх гэж байгаа юм.

3 дугаар асуудал ер нь яах вэ, зүгээр манай улсын эдийн засгийн хувьд яг ний нуугүй хэлэхэд улс төрийн эдийн засагтай орон. Улс төрөө дагаж эдийн засаг нь хөрвөж байдаг. Тэрнээс биш эдийн засгийн гол баганаа болгоод тэрэн дээрээ аль аль талаасаа бодлогоо гаргаад явна гэдэг энэ ойлголт маш бага. Манай Монгол Улсад улс төрийн эдийн засаг ч хэд байдаг билээ гэдгээ бид нар бодох ёстой асуудал. Тэгээд цаашдаа энэ улс төрийн эдийн засагтай холбоотой асуудал дээр их сайн анхаарч төв банк маань Монголбанк маань энэ Монгол Улсын мөнгөний бодлогыг аливаа улс төржилтгүйгээр чиг шугамаа сайн барьж ажиллаасай хүсэж байгаа.

Мэдээж улс эх орны хөгжил гэдэг зөвхөн Улаанбаатараар хэмжигдэхгүй. Улаанбаатар хотод тулгуурласан бодлого явуулаад байж нөгөө талдаа болохгүй. Орон нутаг маш хэцүү байдалтай байгаа. Ажлын байр байхгүй, гарч байгаа зээл байхгүй, малчид нь зээлдээ баригдчихсан, хүмүүс нь хэрэглээний зээлдээ баригдчихсан, төрийн албан хаагчид нь цалингийн зээлдээ баригдчихсан. Ийм байдалтай ний нуугүй хэлэхэд байгаа. Тэгээд энэ бусад арилжааны банк гэдэг юм уу эсвэл зах зээлийн зарчмаараа явна, өрсөлдөөний зарчмаараа явна гээд байхаасаа илүүтэй бусад руу хандаад байхаас илүүтэй, Монголбанк маань өөрийн гэсэн бодлогыг явуулдаг, чиг шугамаа барьдаг, аливаа хараат бус хэлбэр дээр байдаг байгаасай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлнэ.

О.Батнайрамдал: Баярлалаа. 2 зүйл хэлмээр байгаа юм.

1 дүгээрт нь, түрүүн нөгөө асуулт асуусан. Ер нь давхар зээлтэй холбоотойгоор. Тэгэхээр санхүүгийн зах зээл дээр Монголбанк, СЗХ гээд 2 зохицуулагч байгууллага байгаа тийм ээ. Тэгэхээр энэ нэгэнтээ урьд нь ийм давхар зээлийн хэмжээ ийм өндөр байгаагүй байх тийм ээ. Тэгэхээр энэ финтек апп, зээл олгодог аппууд борооны дараах мөөг шиг олон болсноороо яах вэ, нэг талаасаа урьд нь хүрч чаддаггүй хүмүүст хэрэгцээтэй зээл авч байгаа. Гэхдээ нөгөө талаасаа яг нөгөө зохицуулалтын бодлого нь хоорондоо уялдахгүй болохоор зээл хэрэглэгч талаасаа нэг л зүйл байдаг учраас энэ нөгөө өр, орлогын харьцаанаас өгсүүлээд бусад нөгөө хязгаарлалтууд нь 2 зохицуулах байгууллага хоорондоо яг хамтарсан нэгдмэл яг нэг бодлогын уялдаа заавал байх ёстой гэж бодож байгаа юм.

2 дугаарт нь, сая маш олон гишүүд ярилаа л даа. Нөгөө банкны салбарт гадаадын банк оруулж ирнэ гэж зорилтоо тавьсан. 2023 оны, 24 оны зорилтыг харсан ч гэсэн уг нь тэр зорилт дээрээ бүр илүү ойлгомжтой гадаадын банкны салбарыг оруулж ирнэ гэж зорилго дээрээ тусгасан байна лээ л дээ. Тэгээд яг энэ номынхоо 55 дугаар хуудсан дээр байгаа, гадаадын банкны бие даасан салбар оруулж ирэх зорилгын хүрээнд 24 оны 1, 2 дугаар улиралд нэлээн том судалгаа хийсэн байна тийм ээ, судалгаа хийсэн байна. Тэр судалгааны дүн нь болохоороо банкны салбарын гадаад эзэмшлийн хувь өсөхөөр нэг ёсондоо гадаадын хөрөнгө оруулалт банкны салбарт орж ирэх юм бол бага орлоготой ангиллаас бусад ангилалд гэдэгт нь Монгол багтана гэсэн үг тийм ээ. Хувийн секторын зээлийн ДНБ-д эзлэх хувь буурна гэж байгаа юм. Нэг ёсондоо санхүүгийн салбарын өсөлт буурна гэдэг эсрэг анализ гарч ирээд байна л даа. Ингэж яг хамгийн сүүлчийн шинжилгээний үр дүнгээс харахад гээд. Тэгэхээр яах вэ, энэ сэдэв өөрөө яг корпэт финанс буюу тэр санхүүгийн зах зээл дээр нэлээн судлагдсан сэдэв байгаа шүү дээ тийм ээ. Ер нь гадаадын банк орж ирэхээр өрсөлдөөн нэмэгддэг, тэр чинээгээрээ илүү том ААН-үүд илүү ашиг шимийг нь хүртдэг ч гэсэн нийтдээ зээл бууруулахад буцаад макро эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг гэсэн үр дүнгүүд их байдаг юм байна лээ л дээ.

Тэгэхээр энэ түрүү жил гадаадын банкны бие даасан салбар гэсэн зорилт байж байгаад энэ жилийн зорилт өөрчлөгдөж орж ирэхдээ ер нь зүгээр л банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын орчныг бүрдүүлье гээд ерөнхий ороод ирж байна л даа. Тэгэхээр уул нь урдах зорилт нь маш ойлгомжтой банкны салбарыг оруулж ирнэ гэсэн бол одоо ерөнхий зохицуулалтад өөрчлөлт оруулна л гэхихсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ илүү нарийвчлаасай. Тэгээд гаднын банк оруулж ирэхэд өөрөө өрсөлдөөн нэмэгдэх хэлбэрээр буцаад макро эдийн засагтаа олон эерэг үр дүн гарах боломжтой гэж харж байгаа юм аа. Баярлалаа, болчихлоо.

Б.Пүрэвдорж: Гонгорын Дамдинням гишүүн үг хэлнэ.

Г.Дамдинням: Ирэх оны мөнгөний бодлого дээр бид нар ирэх оны төсвийг нэлээн сайн бодох ёстой байгаад байгаа юм. Ирэх оны төсөв дээр бид нар маш том төслүүдийг хийнэ ээ гэдэг ийм л төсөөлөлтэй явж байгаа. Энэ мөнгөний бодлогын дараа төсөв орж ирнэ. Төсөв орж ирэхээр энд ямар асуудал үүсэх вэ гэхээр маш их тэлэлттэй төсөв орж ирж байгаа, маш их тэлэлттэй төсөв. Тэгэхээр импорт ихэснэ. Тэгээд эндээс эдийн засаг халаад, инфляц явчихна шүү гэсэн ийм л айдас байгаад байгаа юм. Мөнгөний бодлого энэ дээр байгаа гол төсвийн зарлагын хяналт байгаа.

Тогтвортой байдлын зөвлөл, аудит энэ тэрээс өгч байгаа зөвлөмж ерөөсөө л тэр байгаад байгаа шүү дээ. Эрсдэлтэй байна шүү, ханшаа алдана шүү. Нэг төсөл нь л гацахад орж ирэх долларын хэмжээ буураад явчихна шүү гэдэг ийм л асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр та хэд маань нэлээн хатуухан бодлоготой, тодорхой байр суурьтай Монголбанк баймаар байна аа. Тэгэхгүй бол тэгээд ёстой түрүүний ярьж байснаар улс төр дагасан ийм байр суурьтай байгаад байвал ханш өснө. Ханш өсвөл тэгээд л инфляц өсөөд явчихна. Тэгээд ард иргэдийн нуруун дээр л очно шүү дээ, тийм ээ.

2 дугаарт, энэ зээлийн хүүтэй холбоотой асуудлуудыг бараг гишүүн болгон ярилаа. Гишүүн болгон ярьж байгаа энэ асуудал дээр түрүүний хэлж байгаа тэр Монголбанк уг нь тэр санаачилга гаргаад яваад байгаа тэр нөгөө нэг иргэн ААН-ийн үнэлгээтэй болох тийм ээ, тэр эрсдэлийн үнэлгээтэй болох тэр системээ нийтэд зарлаад, сурталчлаад хуульчлуулах ёстой бол хуульчлуулаад манай Батшугар гишүүн эд нар бид нар ингээд яриад л сууж байгаа. Энэ дээр хууль байгаа бол оруулаад, засгаас оруулдаг оруулаад, гишүүд оруулах ёстой бол оруулаад яаралтай хийчихмээр байна аа.

Санхүүгийн сахилга батыг бий болгох, арилжааны банкнуудын энэ зээлийн хүүг бууруулахад, зардлыг нь бууруулах тал дээр бодлогоор бид нар туслах ёстой ажлуудын хамгийн чухал ажлуудын нэг нь энэ байгаад байгаа байхгүй юу. Тэгэхгүй зээлээ сайн төлж байгаа, санхүүгийн хариуцлагатай байгаа нь ч ижилхэн, зээлийн хүү төлөөд, барьцаа байршуулаад, санхүүгийн хариуцлага муу байгаа нь ч гэсэн яг ижилхэн байгаад байхтай зэрэг бид нар энэ зардлыг чинь зээлийн хүү дээрээ суулгаад явахаар бүгдээрээ л төлөөд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр жоохон нэг шударга зарчим руу шилжүүлэхдээ энэ санаачилгын ажлаа эрчимжүүлмээр байна.

3 дугаарт, энэ олон гишүүн хэллээ. Би ч гэсэн сүүлд үед яриад байгаа. НДШ, ЭМД-ын шимтгэлийн энэ хэдэн 100 тэрбум төгрөгийг аваад залгичихсан байгаа энэ банкнуудаа зомби байдлаас нь гаргая аа. Та нар маань энэ банкнуудаа үхүүлэх гээд байгаа бол үхүүлээд, амьдруулах гээд байгаа бол амьдруулаад тэгээд 1 дуусмаар байна. Тэгэхгүй бол энэ хэтэрч байна шүү дээ. Хэчнээн ч жил юу нь ч мэдэгдэхгүй баахан ассетуудтай, баахан барилга байгууламж юу ч байдаг юм баахан юманд зээл өгчихсөн. Тэд нарыг нь аваад танай Монголбанкны БЭТ одоо бүрэн эрхт төлөөлөгч очоод ажиллаад бодит үнээр нь баланст байгаа үнээр нь зарж чаддаггүй. Хямдруулаад зарахаар шоронд орчих гээд байдаг. Шүүхийн шийдвэр дээр таг гацаагаад ингээд байлгаад байхтай зэрэг нөгөөдөх нь жилээс жилд үнэ нь унаад байдаг. Хадгаламж эзэмшигчид татварын ард иргэдээс хураасан энэ мөнгийг буцаагаад гаргаж авах гэхээр улам үнэ нь унаад байдаг. Ингээд л буцаад л энэ чинь төсөв дээр ороод ирнэ шүү дээ.

Тэгэхээр энэ актив удирдлагын чиглэлээр Монголбанк бодлогоо жоохон чангатгаж ажилламаар байна шүү. Тэгээд энэ банкнуудын эцсийн эзэмшигчдийг нэг хугацаанд хуулийг нь хэрэгжүүлээд, Монголбанк энэ Банкны тухай хуулиа хэрэгжүүлэх үүрэгтэй шүү дээ. Лхагва Ерөнхийлөгч өө. Та нэрийг нь зарлаач. Хэн эзэмшдэг юм. Тэгээд хэзээ, ямар мөнгөнүүд авчихсан юм, тийм ээ. Тэр хугацаанууддаа ил гаргаад тавьчихмаар байгаа байхгүй юу. Танайд бүх юм байгаа шүү дээ. Тэгвэл бид нарт ярихад амар байна. Эх үүсвэртэй болчихмоор байна. Энэ асуудлуудыг анхаараарай.

Б.Пүрэвдорж: Банзрагчийн Түвшин гишүүн үг хэлнэ.

Б.Түвшин: Ер нь төрөөс барих мөнгөний 25 оны баримтлах чиглэлийг ингээд харахаар яг энэ төсөвтэй ерөөсөө огт уялдаагүй байгаад байна л даа. Төсвийн хэлэлцүүлэг олон удаа явж байхдаа 2 том эрсдэлийг л яриад байгаа шүү дээ. Энэ гадна, дотнын их том зээлүүд орж ирээд, тэгээд буцаад дандаа гүйцэтгэгчээрээ гараад явчихна. Магадгүй 25 онд орж ирээд, 25 ондоо бүгдээрээ гараад явчихна. Эдийн засгийн бүтээмж өсгөдөггүй, барилга, зам, гүүр лүү ихэнх нь явах гээд байна гэж байгаа юм. Эргээд гараад явчхаж байгаа хэдий ч гэсэн энэ дээр валютын долларын өр нь буцаагаад Монголд үлдэгдэнэ.

Нөгөө талаасаа дахиад ДНБ-ий нэлээн өндөр хувьтай тэнцэх хэмжээний томоохон төслүүд явагдана. Төслүүд хамгийн багадаа 2-3 жил үргэлжилнэ. Их хэмжээний зээлийн өр нэмэгдэнэ.

3 дахь том эрсдэл бол төсвийн орлого, ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний үнэ энэ олон нийт дэлхийн зах зээл дээр буурч байгаа гэж байгаа үед орлого тасалдах магадлалтай. Ийм том эрсдэлүүдийг ингэж удаан хэлэлцээд ингээд яг явж байгаа энэ үед мөнгөний бодлого орж ирэхдээ яг энэ эрсдэлийн эсрэг чиглэсэн нэг ширхэг ч бодлого орж ирээгүй байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл яг одоогийн энэ байж байгаа, энэ оруулж ирж байгаа саналаар явах юм бол энэ эдийн засагт үзүүлэх сангийн бодлогын тэлэлтүүд, энд орж ирэх валютын томоохон зээлийн эрсдэлүүд, энд орж ирэх тэр импортын үнийн бууралтууд, валютын ханшийн өөрчлөлтүүдийг давж туулах бодлого энд алга байна гэж би хувьдаа үзэж байна.

Нөгөөтээгүүр ипотекийн болон энэ дотоодод байж байгаа зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх тодорхой зоримог шийдэл алга. Дандаа хэрэглээний арилжааны зээлүүд дээрээ явчихсан. Үйлдвэрлэлүүдийг дэмжих зээлийн шугамуудыг ерөөсөө гаргасан, бодлогоор үйлдвэрлэл, ажил эрхлэгчдийг дэмжих бодлогууд орж ирээгүй байна гэж ингэж үзэж байна.

Дээрээс нь энэ кредит скорин хийнэ гээд байгаа, зөв, энэ бол зайлшгүй хийх ёстой. Энийг бид нар банк бусын түвшинд байтугай бүр зээлдүүлэгч, даатгал, бараг тэр СӨХ-ийн түвшинд ч гэсэн энэ хариуцлагатай иргэнийг харин бий болгож, үүгээр нь харин иргэний үйлчилгээнүүдээ нэмэгдүүлэх ёстой. Зүгээр одоо энэ сошиал дээр явагдаад байгаа тэр хил гарах, хязгаарлах гэдэг бол тэр захиргааны арай жоохон бүдүүлэг арга шүү. Иргэнийгээ хариуцлагатай байж байгаа байдлаар нь иргэний үнэлэмжээ өсгөх, иргэнд үзүүлэх үйлчилгээнүүдээ нэмэгдүүлэх болохоос биш үүний төлөө захиргааны арга хэмжээ авах бодлого ер нь аль ч улсад байхгүй шүү.

Тийм учраас тэр Монголбанкнаас гаргасан байдаг юм уу, хаанаас гаргасан, тэр олон нийтэд яваад байгаа мэдээллүүдээ засах хэрэгтэй. Арилжааны банк банк бусуудаар явж байгаа Монголбанкны ашиг сонирхлын зөрчлүүдийн тухай яригдаж байгаа. Энэ нэр хүндээ цэвэрлэх хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд, ерөөсөө энэ мөнгө хэвлэлтийн болон инфляцын асуудал дээр хатуу бодлогоо барьж, наад мөнгөний бодлогын зөвлөлөө эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан ойрхон ойрхон хуралдуулдаг байхгүй бол 6 сарыг чинь

хүлээж явсаар байтал наад эдийн засгийн чинь тэлэлт яваад, инфляц ханш чинь гүйцэгдэхээ байх ийм эрсдэлтэй харагдаж байна.

Тийм учраас энэ оруулж ирж байгаа төлөвлөгөө дээр жоохон яг энэ эрс шийдэмгий хувилбаруудыг оруулж ирэхгүй бол энэ дээр байж байгаа шиг дандаа цаг тухайд нь бодлого гаргана, цаг тухайд нь шийдвэр гаргана, цаг тухайд нь хороогоо хуралдуулж шийднэ гэсэн иймэрхүү байдлаар энэ өнөөдрийн эдийн засгийн тэлэлт, халалтыг мөнгөний бодлогын хувьд шийдэж чадахааргүй байна шүү гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Энхбаярын Батшугар гишүүн үг хэлнэ ээ.

Э.Батшугар: Баярлалаа. Ер нь гишүүд Монголбанк шүүмжлээд байна л даа. Тэгэхдээ яг бид нар нэг юмыг нь ойлгох ёстой юм. Манай Төв банкны болон Банкны тухай хуулийн эрх зүйн орчны хязгаар гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дотроо л Монголбанк үйл ажиллагаа явуулж байгаа. Бусад банкнууд ч гэсэн үйл ажиллагаа явуулаад байгаа юм. Тэгээд бид нар давчихсан зүйлүүд асуугаад байна л даа.

Тэгээд энэ юу харуулж байна вэ гэхээр, түрүүн бас Их Хурлын дарга хэлсэн. Энэ Төв банкны тухай хууль болон санхүүгийн салбарын хууль дээр дүн шинжилгээ хийгээд ажлын хэсэг гаргая гэж. Энэ маш зөв гэж бодож байгаа юм. Бид нар өнөөдрийн байгаа хууль дотроо ажиллах биш, харин илүү тэлж, илүү дэлхийн хамгийн сайн жишгийг Монголд нутагшуулах нь зөв байгаа юм аа. Тэгээд үүнтэй холбоотойгоор жишээлбэл Төв банкны хараат бус байдлыг илүү тодорхой болгох ёстой юм. Улс төрөөс болон шийдвэр гаргах тэр зарчмын аль нэгэн нөлөөнд орохгүйгээр өөрсдийн мэргэжлийн түвшинд гаргах тэр зүйл заалтуудыг нь хуульд оруулах ёстой, илүү сайжруулах ёстой орон зай байна.

Мөн Төв банкны ил тод байдлыг нь ч гэсэн бас адилхан. Ялангуяа мөнгөний бодлогын шийдвэрийг яаж илүү ард түмэндээ нээлттэй байлгах вэ, яаж үүнтэй зохицож ард түмэн нь хүлээлтээ үүсгэх вэ гэдэг зүйлийг нь ч гэсэн сайжруулах тийм орон зай байгаа юм. Жишээлбэл, бид нарын сайн мэддэг юу гэдэг юм Шведийн Рикс Банк байна, Холбооны Нөөцийн банк байна, эд нар энэ ажиллагаа маш сайн явуулдаг.

Мөнгөний бодлогын хэрэгслүүдээ ч гэсэн улам хуульдаа суулгаад, уян хатан болгох ёстой юм. Зах зээлийн нөхцөл байдалтайгаа уялдаж шуурхай арга хэмжээ авдаг тийм байдлыг нь ч гэсэн үүсгэх нь зүйтэй гэж харж байгаа юм. Тэгээд би түрүүн хэлсэн энэ дээр Холбооны нөөцийн банк маш сайн хийдэг, энэ сайн туршлагыг нь бид нар нутагшуулах нь зөв гэж дотроо бодож байгаа юм аа.

Санхүүгийн тогтвортой байдал талдаа ч гэсэн Финландын болон Канадын төв банк маш тодорхой хуульдаа заачихсан байдаг юм. Ямар үйл ажиллагаа явуулах вэ, ямар хямралын үед ямар арга хэмжээ авах вэ гэдэг нь энийг ч гэсэн бид нар судлах ёстой.

Төлбөрийн системийг би ярьсан, түрүүн бас хэлсэн. Си Би Ди Си гэж. Энэ цахим төгрөг болон өнөөдрийн мэдээлэл технологийн салбар маш эрчимтэй хөгжиж байна. Үүнтэй холбоотойгоор Хятадын Ардын банк ч гэсэн цахим юань гаргаад энэ эдийн засагтаа болон хүртээмжийг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын хэрэгслээ ч гэсэн илүү шуурхай эдийн засагтаа нөлөө үзүүлэх тийм байдлыг нь үүсгэсэн, эд

нарыг ч гэсэн судлах ёстой. Мөн энэ байдлаараа ч гэсэн заавал журмаар зохицуулахгүй хуульдаа тусгах нь зүйтэй гэж харж байгаа юм аа.

Макро эдийн засгаа зохистой бодлого ч гэсэн дээрээс нь бид нар илүү тодорхой хуульчид зааж өгөх ёстой, хуульдаа суулгаач. Ялангуяа урьдчилан сэргийлэх тэр контра сикл гээд л ярьдаг. Мөчлөгийн эсрэг бодлогоо бид нар яаж баримтлах вэ гэдгийг нь. Тэгэхээр эргэж харахад энэ бүхнийг базахад бид нар хууль, эрх зүйн орчныг нь тэр орон зайг нь тэлж өгөх ёстой. Мөн маш тодорхой болгож өгөх ёстой юм аа. Ингэж байж Монгол Улсын төв банк, дээрээс нь нэмээд санхүүгийн тогтвортой байдал, макро эдийн засгийн тогтвортой байдал илүү ойлгомжтой болно. Төв банкандаа ч гэсэн илүү тийм бодлогын хэрэгслүүдийг нэмж өгөх тодорхой үр өгч тийм орон зайг нь өгөх юм. Тэгэхгүй бол наад захын жишээ гэхэд л төгрөгийн тогтвортой байдлаа хадгалах ёстой, хангах ёстой гэдэг юм уу Үндсэн хуульдаа заачихсан зорилт байгаа юм. Тэгэхдээ төгрөгийн тогтвортой байдал гэж юу юм гэж маргаан гардаг юм. Энэ нь ханш юм уу, аль эсвэл инфляц, үнийн өсөлт юм уу гэж худалдан авах чадварын юм уу гээд. Энэ бүхнийг нь тодорхой болгох ёстой юм аа.

Тэгэхээр түрүүн хэлсэн Их Хурлын даргын энэ эрх зүйн орчинд нь ахиж дүгнэлт хийгээд, дүн шинжилгээ хийгээд илүү сайжруулах орон зай байгаа юм гэж хэлмээр байна аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Дуламын Бум-Очир гишүүн үг хэлнэ.

Д.Бум-Очир: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Олон гишүүд зээлийн хүүг бууруулах тухай асуудал ярилаа. Монголбанк зовлонгоо тоочиж байна. Ер нь ойлгож байна аа. Орлого багатай иргэддээ зориулаад, нийгмийн зорилтот бүлгүүддээ хандаад, тэд нартаа зориулаад, хүү багатай зээл гаргах тал дээр цаашдаа ажиллавал яасан юм бэ. Жишээ нь орон нутагт ипотекийн зээл 3 хувьтайгаар яригдаад байгаа шүү дээ. Энэ дээр нэмээд жишээ нь цалин багатай, орлого багатай иргэддээ зориулсан, би бол тухайлбал багш нараа яримаар байгаа юм. Сая ярилаа. Ипотекийн зээлд хамрагдаж байгаа иргэд энэ дийлэнх нь Хан-Уул дүүрэгт байна гээд. Энэ олон 40 хэдэн мянган, 46 мянган багш нар чинь ихэнх нь зээлд хамрагдаж чадахгүй байгаа шүү дээ. Ипотекийн. Цалин нь хүрдэггүй. Ялангуяа залуу багш нар нөгөө олон нэмэгдэл авч чаддаггүй багш нар энэ орон сууцтай болж чаддаггүй. Бид сүүлийн нэлээд хугацаанд энэ багшийн дутагдлын хомсдолын асуудлыг ярьсан. Хэрвээ ипотекийн зээлд хамрагдаад 3 хувьтай ч юм уу тийм ээ, орон сууцтай болох боломж нь бүрдээд эхэлбэл, энэ залуучуудын багшийн ажлыг хийх багш болох сонирхол нэмэгдэх ийм ач тустай юм шүү. Энийг Монголбанкныхан маань сайн ойлгоорой. Би түрүүн уул нь асуулт дээр асууя гэж бодсон, амжсангүй. Энэ тал дээр цаашдаа хамтарч ажилламаар байна. Багш нараа 3 хувийн ипотекийн зээлд хамрагдах энэ нөхцөл бололцоог нээж өгөх, бүрдүүлж өгөхөд Монголбанк анхаарч ажиллаарай гэдгийг хүсмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Өнөөдрийн парламентад хамгийн олон сонгогдсон Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Энэ яагаад цоллоод байгаа юм. Би асуулт асуугаагүй. Яагаад гэвэл би хариултыг нь мэдэж байгаа юм. 10 хэдэн жил би энэ танхимд зээлийн хүү өндөр байна гэж сонслоо. Өөрчлөлт гарсангүй. Тэгээд энэ бол та нарын ажлын үр

дүн. Та нар сайн ажилласан л гээд байна л даа. Хэрвээ сайн ажилласан бол энийг юу гэж байна гээд л дахин дахин яриад байх юм. Тэгэхээр үр дүн муу байна гэж.

Өнөөдөр эдийн засгийн 2 тулгуур багана төсвийн бодлого, мөнгөний бодлого. Гэтэл төсвийн орлого экспортын орлого чинь дан ганц бүтээгдэхүүн нэг улс орноос хамаарч байна шүү дээ. Эдийн засгийн аюулгүй байдлын тухай бид нар огт ярихгүй байна шүү дээ. Хэрэв ямар нэг шалтгаанаар нүүрсний үнэ унах юм бол Хятад нүүрсний эрэлтээ бууруулах юм бол Монголбанк яаж ч сайн ажиллаад нэмэр байхгүй. Та нар сайн ажиллаж байна гэж байна. Та нарын сайн ажиллаж байгаа гэдэг нь гадагшаа нүүрс сайн гарч байна уу гэдгээс шалтгаалж байгаа байхгүй юу. 15 тэрбум долларын орлого олж байгаагийн чинь 9 тэрбум доллар нь зөвхөн нүүрс. Тэгвэл та нар эдийн засгийн аюулгүй байдал талаас ямар алхам хийсэн юм. Эдийн засгаа солонгоруулах чиглэлээр ямар алхам хийсэн юм. Экспортыг төрөлжүүлэх чиглэлд ямар бодлого явуулсан юм. Юу ч явуулаагүй байхгүй юу.

Тэгээд өөрсдийгөө энэ танхимд магтаад суугаад байгаа байхгүй юу. Би хэллээ шүү дээ. Зээлийн хүү өндөр, өндөр биз дээ. Ийм өндөр байхад ямар хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийх юм бэ, яаж үйлдвэр барих юм бэ, эдийн засаг чинь яаж солонгорох юм бэ, нүүрснээс хамааралтай хэвээрээ л байгаад байна шүү дээ. Өчигдөр Европын холбоо цэвэр эрчим хүчнийхээ асуудлыг улс орнуудыг нэгдэхийг уриалчихлаа. Нүүрсний эрэлт буурна гэсэн үг. Бидний амь зогоож байгаа юм энэ.

Хэрвээ нүүрсний нийлүүлэлт буурах юм бол бид эдийн засгийн шокт орно. 21 онд 11 их наяд байсан төсөв 30 их наяд болчихсон. Энэ чинь өөрөө эрсдэл дагуулж байгаа шүү дээ. Түрүүн тэнд хэн гишүүн хэлэв. Мөнгөний нийлүүлэлт чинь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 их наядаар нэмэгдчихсэн яваа. Хэрвээ нүүрс гаралт буурах юм бол бид маш том шокт орно. Цалингаа тавьж чадахгүй болно. Тэтгэврээ тавьж чадахгүй болно. Бүгдээрээ үхлийн байдал руу орно. Гэтэл та нар халамжийн энэ бодлого хавтгайрч байгаа дээр ямар ч шүүмжлэл хэлэхгүй байна шүү дээ. Хэдэн үйлдвэр бид нар жишээ нь жилдээ идэж байна вэ. Хөдөөгийн иргэд арьс ширний үйлдвэр барьж өгөөч гээд л гуйгаад л байна. 100 сая доллар. Гэтэл бид нар 6 ийм үйлдвэр барих мөнгийг жилдээ зүгээр халамждаа идчихэж байна шүү дээ, 6 ийм үйлдвэр барих мөнгийг.

Эрчим хүчний хомсдолд орсон уу, орсон. Энэ өвөл ингээд хязгаарлаад тог таслаад эхэлнэ. Та нар хараарай. 3 ДЦС барих мөнгийг идчихэж байгаа байхгүй юу. ТЭЦ 3 шиг. Юу ч босохгүй. Халамждаа идээд л байна. Ямар ч үйлдвэрлэл барихгүй, халамждаа идээд л байна.

Тэгэхээр бид нар ямар ч мөнгөний бодлого яриад, ямар ч төсвийн бодлого яриад, үйлдвэрлэлийн тухай юм ярихгүй юм бол экспортоо солонгоруулах тухай ярихгүй юм бол эдийн засгийн аюулгүй байдал, энэ нөгөө зээлийн хүүгээ ярьсаар л байна. Дахиад 20 жил ярина.

Б.Пүрэвдорж: Бадрахын Найдалаа гишүүн үг хэлнэ.

Б.Найдалаа: Үнэн, үнэн. Зүгээр яг сая өргөн барьсан байгаа төсвийн төсөл болон энэ мөнгөний бодлогын төсөл, дээр нь 2 өдөр хэлэлцүүлэг хийлээ. Ажиглах юм бол, дүгнэх юм бол бид нарын ярьж байгаа юм хэвээрээ л байгаа. Гэхдээ юм өөрчлөгдөхгүй юм байна. Бодлогын хүү бол буурахгүй, мөнгөний бодлого хатуу байх

нь ойлгомжтой юм байна. Төсөв тэлсэн. Засаг төсвийнхөө алдагдлыг эдийн засгаас мөнгийг нь татаж авна. Тэгэхээр зээл хомс байна. Зээлийн хүү буурахгүй.

Тэгээд эндээс ингээд үзэхээр яах вэ, бодит байдал ийм байх юм байна. Асуудал нь зүгээр миний бодож байгаагаар, энэ яг цаанаа, арай тэр углуургадаа байна аа. Зээлийн хүү яг энэ нөхцөлдөө буухгүй. Бид нар дахиад яг энэ чигээрээ байх юм бол 20 жилийн дараа ч гэсэн энийгээ ярьж байхаар, ярьсаар байх болно.

Тэгэхээр ямар ч байсан нөгөө нэг Монголбанк маань, Их Хурал бол уг нь Монголбанк бол Их Хурлын харьяа байгууллага гэхээсээ илүү Их Хурал Монголбанкны хараат байдлыг нь хадгалах ёстой, дэмжих ёстой байгууллага нь юм байгаа юм л даа. Тэгээд Монголбанк нь илүү хараат бус, илүү жоохон хүчтэй байгаасай гэж бодож байна. Засгаас үлдээсэн, эсвэл ингээд шаардсан юмных нь үлдэгдэл дээр нь мөнгөний бодлого явуулах гэж ядсан ийм байгууллага биш байгаасай гэж бодож байна аа.

Монголд яг үнэндээ бодит байдал дээр мөнгөний бодлогын орон зай бараг байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Байхгүй, зөвхөн ингээд тулсан үед л жоохон гал унтраах маягийн л ийм маш нөлөө багатай ийм бодлого санагдаад. Тэгэхээр зүгээр ингээд дүгнэлтийн хувьд эргээд харахаар яг энэ цаашдаа энэ Монголбанкны үйл ажиллагаа болон энэ санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг жоохон эргэж хармаар санагдаж байна. Санхүүгийн салбар гээд энэ салбарт банк болон банкны бус байгууллагууд байгаа. Тэгээд өмнө нь бид нар олон жил ярьж ирсэн. Банк давамгайлаад байна. Банкны бус нь зөвхөн хоёрхон хувь байна, нэгхэн хувь байна гэж ярьдаг байсан. Одоо бол нийт активынх нь нийт хөрөнгийнх нь 10 орчим хувь болчихсон байна лээ. Ашгийнх нь бараг 30 хувь ч байна уу, банкны бус салбар эзэлж байгаа.

Тэгээд ингээд харахаар нэг тогоог 2 гараар зохицуулах гэж оролдоод байгаа нь маш бүтцийн буруу алдаа байна гэж бодож байна. Энийг яваандаа аажим хууль, эрх зүйд нь өөрчлөлт оруулдаг юм уу, засахгүй бол ийм том эрсдэл, ийм зөрөө Монгол Улсын санхүүгийн зах зээл дээр гарчихсан байна аа. Энэ нь нөгөө бид нарын санхүүгийн зах зээл эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад цаашдаа асуудал болно гэж итгэлтэй байна.

Тийм болохоор яах аргагүй энэ Монголбанк болон СЗХ-ны зохицуулахын хүрээг нь тогтоож өгөхгүй бол нэг тоог 2 талаас нь хутгаад самраад байх юм бол энэ эрсдэл нь арилахгүй, дундаа бараг зээлээ шилжүүлдэг, яадаг, ийдэг иймэрхүү эрсдэл нь улам нэмэгдээд байгаа байхгүй юу. Тэгээд бодит байдал дээр ч гэсэн бараг бүгдээрээ мэдэж байгаа байх. Банкнууд, банкны байгууллагууд, банкны бус санхүүгийн байгууллагууд хоорондоо холбоотой, шууд болон шууд холбоотой зөндөө байгаа. Энэ чинь өөрөө том эрсдэлийн учиг нь. Хэрвээ энийг ингээд нэгдсэн байдлаар уялдуулж, зохицуулж байх, хянаж байхгүй бол энэ үнэхээр санхүүгийн зах зээл дээр том эрсдэл гарна аа.

Тэгээд зүгээр ингээд сая ингээд хэлэлцүүлгийг ажиглаад байхад бид нар зээлийн хүү ярьж байна. Ипотекийн зээл ярьж байна. Нэг харсан чинь Монголбанк мөнгөний бодлого барьдаг биш яг ипотекийн зээл олгодог, хүү тогтоодог газар мэт болчихоод байна аа. Тэгэхээр нь саяын энэ санхүүгийн салбарын зохицуулалт болон энэ зээлийн хүүтэй холбоотой зарим Монголбанкны үүрэгт хамаарахгүй холбоотой ажлыг Монголбанк маань шууд заримыг нь шулуухан мэргэжлийн хувьд ч гэсэндээ

хэлээд, биш гэдгийг нь хэлмээр байгаад байгаа юм. Тэгэхгүй бол бүгдийг нь аваад хариулаад байхаар бүгдийг нь хамсаар байгаад сүүлдээ яг нөгөө Хөгжлийн банк шиг нэг банк шиг, нэр нь ч банк юм даа. Иймэрхүү болоод буруу ойлголт төрүүлээд байна.

Тэгээд цаашаа тэр нөгөө зээлийн хүү дээр олон хөтөлбөрүүд гарсан, хэрэгжихгүй байгаа, хэрэгжихгүй байгаа шалтгаан нь яг үнэндээ энэ банкны ч асуудал биш Монголбанкны ч асуудал биш. Яах вэ, нөлөөлөх бодлого нь энд байгаа боловч цаанаа ерөөсөө л Монгол Улсын бид нарын байгаа эрсдэлтэй холбоотой юм аа. Тэгээд энэ дээр Их Хурлаас дахиад ажлын хэсэг ч юм уу, ямар нэгэн гаргаад ажиллах санал байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг үг хэлнэ.

Х.Ганхуяг: Би яах вэ, бүгдээрээ өнөөдөр Монголбанкийг буруутгаад л байх шиг байна л даа. Яах вэ, энэ өнөөдрийн зээлийн хүү буурахгүй байгаа ерөөсөө шалтгаан бид нар өөрсдөө шүү. НДШ буурахгүй байх шалтгаан нь бид нар өөрсдөө. Бид нар нийгмийн даатгалын, малчны нийгмийн даатгалын 50 хувийг төлнө гэдэг хууль баталснаасаа болоод нийгмийн даатгал, шимтгэл чинь буурдаггүй юм. Энэ янз янзын хөнгөлөлттэй, татаастай хүүний зөрүүг төлсөөр байгаад, өнөөдөр зээл нь олддоггүй, зээлийн хүү нь буурахгүй байгаа юм. Нийт зээлийн 44 хувь нь өнөөдөр Монгол Улсын нийт зээлийн 44 хувь нь, хэмжээгээр нь харвал банк бусын зээл байгаа. 3-3.5 хувийн хүүтэй, 56 хувь нь банкны зээл байгаа. Өнөөдөр бид нар зөвхөн банкны зээлийн хүүг л яриад байгаа. Гэтэл иргэд болон жижиг, дунд ААН-д чинь тэр банкны зээл чинь олдохоо болиод удаж байгаа юм аа. Зээлийн хүртээмж дээр бид нар гол анхаарлаа хандуулах ёстой. Тэр янз янзын хөнгөлөлтөө, татаастай, хүүгийн хөнгөлөлт үзүүлдэг энэ асуудлаа таслан зогсоох ёстой. Ингэж байж иргэд банкны зээлийн хүүгээр зээлээ авах боломжтой болно. Бид нарын өнөөдрийн идэж байгаа, ууж байгаа, хэрэглэж байгаа бүх юманд дунджаар 30 хувийн хүү шингэсэн байгаа шүү, 30 хувийн хүү.

Одоо цаашдаа энэ төсөв батлахдаа бид нар жилд дунджаар 1 их наяд төгрөгийн зээлийн хүүгийн татаас төлж байгаа. Ямар нэгэн хөтөлбөр батлахдаа дандаа л тэр татаас оруулж ирдэг. Одоо цаашдаа энэ тэр асуудлуудаа бүгдийг нь бодлогынх нь хүүтэй уях хэрэгтэй. Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө. Тэгэхгүй бол зээлийн хүртээмж банкнаас зээл олдохгүй л байвал бүгдээрээ банк бус руу явдаг л байна. Банк бус дээр очихоор 3, 4 хувийн хүүтэйгээр мөнгөө зээлсээр л байх болно. Ипотекийн зээл, тэр хоршооны зээл эд нарыгаа бүгдийг нь бодлогын хүүтэйгээ уя. Хүнсний хувьсгалын зээл гээд тэр олон сайхан нэртэй юмнуудаа бодлогын хүүтэй нь уяад, энэ хотоос зай алслагдлыг нь харж байгаад -1, +2 гээд иймэрхүү байдлаар бид нар хүүгээ тогтоовол ер нь зөв тал руугаа явна аа. Тэгж байж зээл чинь олдог болно.

Мөн ипотекийн зээл дээр цөмөөрөө нэг ганц юм гээд л ярья, тэгэх үү. Орон нутагт 3 хувь гэж өгдөг болж эхэлсэн цаг мөчөөс хойш энэ хотод чинь ипотекийн зээл нь олдохоо больсон. Бүх ипотекийн зээлээ 50, 60 хувийг нь орон нутаг руу явуулчихдаг. Тэгээд хотод өгч байгаа зээл нь 2 дахь, 3 дахь байр авч байгаа. Тансаг зэрэглэлийн байр авч байгаа иргэдэд зээл өгөөд байхад чинь яг тэр гэр хорооллоос барилгажуулж байгаа, анх удаагаа зээл авах гэж байгаа энэ иргэдэд чинь зээл олдохгүй байна. Танил талгүй, ипотекийн зээл авах гэж байгаа хүмүүс чинь олдохгүй байна. Энэ талынхаа журмаа цөмөөрөө чангалмаар байна.

Тэгээд өнөөдөр энэ чинь ингээд л Лхагвасүрэн ерөнхийлөгчийг бид нар ингээд л янз янзаар хэлээд л, зээлийн хүү чинь буурахгүй байна, ханш чинь алдаад байна гээд байдаг. Яг гол буруутан нь бид нар өөрсдөө өөрсдөө шүү. Одоо орж ирж байгаа хууль, дээрээ орж ирж байгаа төсөв дээрээ та нар өөрсдөө шаардлагаа тавь.

Б.Пүрэвдорж: Даваагийн Цогтбаатар гишүүн алга байна. Дараагийн Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе. Өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр та бүхний 25 оны мөнгөний бодлогын талаар нарийн сайн сонсоод, асуух зүйлүүдээ асуучихсан болохоор өнөөдөр зөвхөн үг хэлье гэж бодож байна. Монголбанкнаас баталж байгаа журмыг шинэчлэх дээр энэ олон улсын жишигт нийцүүлээд эрэлтийг дэмжих бодлогоосоо бас нийлүүлээд нийлүүлэлтийг дэмжих бодлого тийм ээ, бас яг оршин суугчид, иргэдийн яг хамгийн хэрэгцээтэй байгаа давхаргадаа хүрч болохоор ийм журмын шинэчлэлийг хийгээсэй гэсэн дээр та санал нэгдсэн болохоор их талархалтай хүлээж авсан. Түүн дээр жоохон тодруулаад хэдэн саналаа хэлье гэж бодож байна.

Өчигдөр хэлснээр бол орон сууцын бодлого гэдэг бол аль болох олон хүн орон сууцад амьдрах ёстой гэсэн тэргүүн зорилго нь тийм байх ёстой болов уу гэж бодож байна. Тийм учраас 2-3 хүүхэдтэй айлуудад тэргүүн ээлжид очер дараалалгүйгээр зээл олгох гэж ийм боломжийг шинэчилсэн журамд оруулах боломжтой юу гэсэн зүйл байгаа. Үүн дээрээс нь нэмээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон ээжүүд, өрх толгойлсон аавууд, өндөр настай хүмүүс ч гэсэн орон сууцын зээлд, ипотекийн зээлд, хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг нь нээж өгөөсэй гэж хүсэж байна.

2 дугаарт, яг нөгөө байршлын хувьд Улаанбаатар хотод олгож байгаа ипотекийн зээлийн 50-аас дээш хувийг нь дэд төвүүддээ олгооч ээ гэсэн ийм журмыг хувийн банкнуудтайгаа ярилцаад хэрэгжүүлэхийг хүсэж байна аа. Өнөөдрийг хүртэл энд Улаанбаатар хот ингээд ерөнхий төлөвлөгөөгөөрөө дэд төвүүдийг хөгжүүлнэ гээд Сэлбэ, Амгалан, Толгойт, 5 шар, Шар хад гээд иймэрхүү газруудыг дэд төв болгож хөгжүүлнэ гэж байгаа боловч орон сууцын бодлого нь өөрөө Хан-Уул дүүрэг буюу ингээд дэд төвүүдээ хөгжүүлэх биш, өөр хот төлөвлөлтийн бодлого нь орон сууцын бодлоготойгоо уялдаагүй байгаа энэ зүйлийг нь зөв аргаар, бүтээлч журмаар чиглүүлж, шийдэж өгөхийг хүсэж байна аа. Энийг яагаад чухалчилж байгаа вэ гэхээр жишээ нь Хан-Уул дүүрэгт орон сууцын үнэ зарим газар метр квадрат нь 6 сая төгрөгийн үнэтэй байгаа тийм ээ, хойшоогоо яг Сэлбэ дэд төв дээр баригдах ойр хавьд нь баригдаж байгаа барилгууд метр квадрат нь 3-4 сая гэж байгаа.

Тэгэхээр 1 хүн ипотекийн зээлд хамрагдсанаас дэд төвүүдээ хөгжүүлэхээр энэ бодлогоо чиглүүлснээр 2 хүн хамрагдах боломжтой гэсэн нэг зүйл байгаа. Сая Ганхуяг гишүүн хэлж байсан. Бас энэ нэг хүнд, хүн болгон ипотекийн зээлд хамрах боломжтой гэхээр яг яалт ч үгүй ингээд боломжтой айлууд нь түрүүлж тэргүүн ээлжид яваад 2 дахь байраа, 3 дахь байраа ав аваад ч юм уу тийм ээ. Тиймэрхүү нөхцөл байдал байгаа учраас өрхөд нэг удаа ипотекийн зээл олгоно гэсэн ийм байдлаар хэрэгжүүлэх юм бол Монголын ард түмэн бүгдээрээ орон сууцад орох боломжтой. Ийм зөв бодлого болох юм болов уу гэж бодож байгаа учраас энэ дээр хувийн банк нартай хэлэлцээд, ялангуяа дэд төвүүдийг хөгжүүлэхээр хөрөнгө

оруулахаар зорьж байгаа барилгын компаниудын саналыг тусгаасай гэж хүсэж байна.

2 дугаарт нь, дэд төвүүдийн ойр орчимд орон сууцад шилжихийг хүсэж байгаа, зорьж байгаа, авахыг хүсэж байгаа ийм бүлэгт олгохыг боломж олгоосой гэж хүсэж байна аа.

Дараагийн зүйл та хэлж байсан. Зөвхөн орон сууц гэлтгүйгээр эрчим хүчний хэмнэлттэй хаус, үүнд олгох боломжийг нь нээнэ гэж байсан. Үүнийгээ тэргүүн ээлжид хэрэгжүүлээсэй гэж хүсэж байна.

Мөн зэрэгцээд олон улсад байгаа уур амьсгалын өөрчлөлтийн сангаас маш их хэмжээний хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг татаж ирэх боломжтой учраас үүнийгээ гэр хорооллуудын айл өрхүүдэд хашаандаа сайхан амьдрах боломжийг нь бүрдүүлэх, утаа гаргадаггүй эрчим хүчний хэмнэлттэй ийм хаусанд амьдрах боломжийг нь бүрдүүлэхээр журмуудын шинэчлэлийг хийж өгөхийг, 2025 ондоо хийж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн алга байна. Үүний дараа 4 хүн үг хэлнэ. Одоогоор 1 гишүүн алга байна. Тэгэхээр 3 гишүүний дараа санал хураалт явуулна. Тийм учраас Их Хурлын гишүүд танхимдаа цугларахыг хүсэж байна.

Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Пүрэвдорж даргадаа баярлалаа. Үгүй ээ, бид нар чинь мөнгөний бодлого ярьж байна л даа. Тэгээд энэ манай улс орон чинь нэг болохоор сансрын гүрэн болчих гээд ч байгаа юм шиг тийм ээ. Хиймэл дагуул хөөргөнө гээд л ийм юм яриад байх юм. Тэгээд нөгөө талдаа 6 настай хүүхдийнхээ модон жорлонгийн асуудлыг шийдэж чадахгүй, ийм л нөхцөл байдалтай л байна л даа. Тэгээд Ази Зүүн Хойд Азидаа хамгийн ядуу орон л доо. Ядуугийн ядуу орон болчихоод байна. Тэгээд алтан дээр суусан гуйлгачид гэж нэрлэдэг байсан бол нөгөө алт маань хаашаа ч яаж ч үр ашиггүй урсаад байгаа юм. Юу ч болж байгаа юм.

Тэгээд энэ 14 мега төсөл гээд ингээд нөгөө яг социализм, коммунизмын үеийн юм шиг юм яриад байгаа л даа. Тэгээд энэ төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээд дундаа ороод ийм болох үед бол энэ улс орны эдийн засаг хүндэрнэ ээ. Гишүүд ярьж л байна л даа. Тэр нүүрсний үнэ ямар байх юм. Урд хөршийн манай эдийн засаг тодорхойгүй л байгаа шүү дээ. Уул уурхайгаас бид нар бүрэн хамааралтай байгаа, түүхий эдээс. Энэний үнэ өөрчлөгдөөд ямар нэгэн байдлаар ингээд эрсдэл үүсэх юм бол энэ бүх зүйл хүндэрнэ ээ.

Монголбанкыг миний мэдэхийн яг мэргэжлийн банкир хүмүүс, цөөхөн хүмүүс удирдаж байсан байна аа. Би Чулуунбат талийгаачийг мэдэхийн, маш сайн банкир байсан. 6 жил удирдаж байсан байх. Одоо сүүлийн 4, 5 жил үнэхээр энэ мөнгөний бодлого биелэгдээд, тогтвортой яваад, валютын ханш гайгүй тогтвортой байлаа. Нөгөө талаар тэр Хятадын свопын талыг нь төлчихлөө. Мөн валютын нөөц байж болох хамгийн дээд рекордыг тогтоолоо. Энэ 25, 26 онд маш хүндэрнэ ээ, магадлал маш өндөр байна. Бид бүхэн Монголбанкыг яг банк шиг, АН-ыг нам шиг байх үед бид нар 2 шатлалтай банкны системийг оруулж ирсэн юм аа. Яг олон улсын жишиг болгож. Яг Монголбанк тэр хуульд заасан бодлогоо барьдаг, бие даасан, яг АНУ-ын нэг Холбооны нөөцийн банк шиг ингэж л ажиллах ёстой л доо. Ямар нэгэн улс

төрийн хүчнээс хамаарахгүй, хэн нэгэн даргаас хамаарахгүй, ийм бодлого явуулах ёстой.

Тэр ипотекийн зээлийн тэр юунаас гар аа, 1 дүгээрт. 2 дугаарт, тэр Монголын ипотекийн корпорац гээд явж байгаа. Уул нь тэр чинь зөв хандлага шүү дээ. Яг олон улсын жишиг байгаа байхгүй юу. Ийм зүйлийг дэмжээд, ингээд ажиллах нь зүйтэй байх аа. Энэ шинэ юм бүтээгээд байх юм байхгүй. Яг тэр жишиг болсон зүйлийг л бид нар хэрэгжүүлээд явахад болох юм. Азаар харин манай Монголбанкыг мэргэжлийн удирдлага, мэргэжлийн баг авч явж байна. Өнөөгийн хууль, эрх зүй, өнөөгийн улс төрийн нөхцөл байдалд та нар боломжийн ажиллаж байгаа. Би байнга алдаа дутагдлыг хэлдэг ярьдаг хүн. Гэхдээ хааяа ажлаа хийж байгаа хүмүүст байгаа байдлыг нь болж байна, бүтэж байна гэж хэлэх ёстой.

Өнөөдөр бид нарын ярьж байгаа юм бол Засгийн газраас нэхэх юмаа л Монголбанкнаас нэхээд байгаа байхгүй юу. Монголбанк яг Засгийн газар шиг ажиллаж болохгүй ээ, тийм ойлголт ч байж болохгүй, ард түмэнд ч гэсэн тийм ойлголтыг өгч болохгүй.

Тэр зээлийн хүүг буулгахын тулд мэдээж хэрэг манай гишүүд ярьж байна. Бид нар сайн ажиллах ёстой. Засгийн газар сайн ажиллах ёстой. Энэ мөнгөний бодлогыг тогтвортой, инфляц ханшийг тогтвортой байлгах нь Монголбанкны бодлого оо. Энэ арга хэрэгслээ та нар, энэ юм чинь ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганбат гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Ганбат: Жинхэнэ ардчилсан талын хүн ингээд л хурал удирдахаар шал өөр юм даа тийм ээ, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх энэ юм. Гэхдээ манай Амарбаясгалан дарга ч сайн удирддаг, бас. Ийм юмнуудаа нөхөд өө, анхаармаар байна аа. Бид нар ойлголтоо зөв болгох шаардлагатай гэж үзэж байна.

Алт мэдээж хэрэг гадна, дотно байж нөхцөл байдал нэлээн хүнд байна. Тэр Оюутолгойн НӨАТ бол роялти байгаа шүү дээ. Роялти нь 5 хувь байгаа. Хэрвээ тэр хувьцаа эзэмших компаниуд нь хувьцаа эзэмшигчид нь шийдээд ингэх юм бол 5 жилийн хугацаатай тэр гэрээ нь дуусах юм байх ёстой. Монголбанканд алтаа тушаадаг байх хэрэгтэй. Тэд нарт өөрсдөд нь ч хэрэгтэй шүү дээ. Хэрэв Монголбанканд тушаах юм бол 2,5-тай л ийм роялти төлж байгаа шүү дээ. Энийг эдийн засгийн аргаа шийдье гээд урьдчилаад бодоод, төлөвлөөд ингээд хийж байсан ажил шүү. Тухайн үедээ миний манай Уул уурхайн сайд Ганхуягийг ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батжаргалын Заяабал гишүүн үг хэлнэ.

Б.Заяабал: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр Монгол Улсын эдийн засаг, эдийн засаг өсөлттэй, тэр нь хүртээмжтэй байх, эдийн засаг нь тогтвортой байх нь энэ Монголын нийт ард түмэн, бид бүхэнд, мөн бизнес эрхлэгчдэд энэ хамгийн чухал асуудал, хамгийн чухал асуудал. Эдийн засаг тогтвортой байхын тулд энэ макро эдийн засгийн үзүүлэлтүүд тогтвортой байх ёстой. Энэ дээр Монголбанкнаас хүлээдэг хэд хэдэн үзүүлэлтүүд байгаа. Энэний нэг нь энэ инфляцын асуудал байна. Мөнгөний ханшийн асуудал байна. Зээлийн хүүтэй холбоотой асуудлууд энэ бол яг Монголбанкнаас ард иргэд, бизнес эрхлэгчдийн хүлээдэг өнөөдрийн Улсын Их Хурлын, Улсын Их Хурал дээр яригдаад байгаа энэ

мөнгөний бодлогын үр дүнд иргэд, бизнес эрхлэгчдийн хүлээдэг зүйлүүд бол ерөөсөө Монголбанкнаас хүлээж байгаа гол 3 зүйл энэ. Энэ 3 зүйлийг ард иргэдийн хүлээлтэд авчрахын тулд маш их хэмжээний ажил цаана нь явагдаж байгаа. Манай Монголбанкныхан бол мэргэжлийн, яах аргагүй ийм нарийн мэргэжлийн ийм байгууллага.

Тэгэхээр би энэ ард иргэдийн хүлээгдэж байгаа энэ 3 асуудалтай холбоотой би саналаа хэлэх гэж байгаа юм аа. Өмнө нь намын бүлэг дээр нэлээдгүй дэлгэрэнгүй асуулт асууж, саналаа хэлсэн учраас би сая асуулт асуугаагүй. Тэгэхээр 1 дүгээр асуудал энэ инфляцын асуудал байгаа. Энэ инфляц гэдэг нь энэ барааны үнийн өсөлтийг зогсоосой гэж ард түмэн хүлээж байгаа. Энэний цаана. Монгол иргэдийн энэ гар дээр байгаа энэ орлого нь, худалдан авах чадвар нь хэвээрээ байгаасай, орлогынх нь чанар нь битгий буураасай гэдэг л ийм л хүлээлтийг Монголбанк энэ мөнгөний бодлогын ард хүлээж байгаа.

Тэгээд 25 оны энэ бодлогыг аваад үзэхэд, төсөв мөнгөний бодлогыг аваад үзэхэд үндсэндээ 25 онд эдийн засгийн эргэлт нэг 90 их наяд байхаар байна. Энэний өрхийн эдийн засгийг аваад үзэхэд нэг 60 орчим их наяд нь өрхийн эдийн засаг байгаад байгаа юм. Ингээд яг өнөөдрийн энэ өргөн барьсан энэ бодлогын хүрээнд аваад үзэхэд, инфляц 7 хувьтай гээд тооцоод үзэхэд, ард иргэдийн карманаас үндсэндээ 4 орчим их наяд төгрөг алга болчихоод байгаа юм, алга болчихоод байгаа юм. Хэрэвзээ энэ эдийн засгийг бид нар зөв авч явж чадахгүй бол эргээд энэ ард түмэн дээр ирэх ачаалал 4 биш өшөө нэмэгдэх 7, 8 их наяд болгох ийм эрсдэл байгаа. Эрсдэл байгаа. Инфляцыг тооцохын тулд нэг 410 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнээр тооцоолж байгаа, тооцоолж байгаа. Өнөөдөр энэ 410 нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг Монголын нийт өрхүүд хэрэглэж байна уу гээд тэгвэл, үгүй. Ялангуяа орлого багатай иргэдийн хувьд цөөхөн хэдэн төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийг хэрэглэж байгаа.

Өнөөдөр бид бүхэн мэдэж байгаа, нефть байна, мах, сүү, гурил гэх мэтчилэн хүнсний цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэж байгаа. Эдгээрийн гол бараа бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт үндсэндээ инфляцад голлох нөлөө үзүүлж байгаа юм аа. Сүүлийн 30 жил ингэж явж ирлээ. Өнөөдөр эдгээр бараа бүтээгдэхүүнүүдийг миний хувьд харахад энэ нийлүүлэлтийн бодлого дээр томоохон алдаа байна гэж ингэж харж байгаа юм. Хэд дахин дамжсан ийм ченжийн бодлого өнөөдөр энэ системийг авч явж ирлээ. Өнөөдөр энийг зах зээлийн систем рүү ложистикийн бэлтгэн нийлүүлэлтээс аваад тээвэрлэлт, хадгалалт, түгээлт эцсийн хэрэглэгч тэр гар дээр очих хүртэлх энэ системийг санхүүгийн хувьд зөв систем рүү оруулах тал дээр Монголбанк энэ дээр онцгой анхаарч ажиллах нь зөв юм болов уу. Ингэж байж инфляцыг бодитой бодлогынхоо хэмжээнд оруулж ирэх ийм боломжтой гэж ингэж харж байгаа юм.

2 дугаарт нь, ханшийн асуудал байгаа. Нөөц буурч байгаа. Сүүлийн 2, 3 жил дарааллаад энэ төсвийн тэлэлтийн бодлого явсантай холбоотойгоор инфляц нэлээн нэмэгдэх хандлагатай байгаа. Сүүлийн 3 сарын бараа импортын энэ дүн ч гэсэн өссөн байгаа. Өнөөдөр Монголбанкныхан 5 сарын нөөц байгаа гэж байгаа болов чиг энэ нь яг инфляц нөөцийг валютын ханшийг тогтвортой барих хэмжээний нөөц болж чадаагүй байгаа. Энэ дээр анхаарах ёстой шүү гэж. Ингээд цаг. 3 дахь нь энэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ. Алга байна. Жудагийн Баярмаа гишүүн үг хэлнэ ээ.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Ихэнхдээ ер нь санаанууд давхцаж байна. Тэгэхдээ би энэ нэр томъёоноос эхлээд жоохон гайхаад байгаа юм л даа. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах гээд. Тэгээд бодлого гэдэг чинь ингээд жил болгон өөрчлөгддөг юм болов уу гээд ингээд гайхаад л байна л даа. Бодлого гэдэг чинь жоохон урт хугацаандаа байж байж явдаг юм биш үү тийм ээ. Тэгэхгүй болохоор ингээд л нэг жил болгон нэг ийм юм баталдаг, тэгээд яах вэ, бид нар анх шинээр сонгогдсон гишүүд учир ерөнхий өмнөх энэ чуулгануудын энэ мөнгөний бодлогыг баталж байх үеийг харж байхад нэг иймэрхүү л юм явдаг байсан юм шиг санагдаж байгаа юм.

Тэгэхээр уг нь энэ бид нар Засгийн газрын үйл ажиллагааны 24-28 оны хоорондох хөтөлбөртөө ч тэр, одоо энэ ирэх жилийн 25 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөндөө ч тэр, бүхэлдээ л ингээд л төрийн хэвшлийг дэмжих, бизнес эрхлэгчдээ дэмжих гээд ерөөсөө бүлэг болгонд орчихсон байгаа юм. Гэхдээ харамсалтай нь яг төсөв дээр суугаад ирэхээрээ, төсөв дээр буугаад ирэхээрээ дандаа эсрэг. Тэгээд энд болохоор нэг ийм бөөрөнхийлсөн бөөрөнхийлсөн юмнууд оруулаад л, тэгээд л төсөв дээрээ болохоор дандаа эсрэг ингээд бичээд яваад байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн энэ Монголбанкнаас асууж байгаа асуулт, хариулж байгаа байдал яг л ингээд л нэг урьд урдах парламент дээр нэг жил болгон л нэг мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлах үед яригддаг байсан юм л сонсогдоод байна. Нөгөө л инфляц өндөр байх юм байна. Нөгөө л бодлогын хүү өндөр байх юм байна. Тэгэхээр чинь нөгөө арилжааны банкууд зээлээ бага болгох юм байна. Тэгээд л нөгөө бизнес эрхлэгчид нь зээлийн эрэлд хатах юм байна. Тэгээд л нөгөө өндөр үнэтэй ХЗХ, банк бусуудаас авах юм байна гээд л. Ингээд л ерөөсөө ямар нэгэн 1 тийм дорвитой шинэчлэл, нэг өөрчлөлт ерөөсөө л харагдахгүй байгаад байгаа юм.

Дээрээс нь миний санаж байгаагаар, ойлгож байгаагаар ковидын үед байх, энэ Монголбанкны яах вэ, бүгдээрээ л Монголбанк руу дайраад байгаа болов ч Монголбанкны бие даасан байдлыг алдагдуулах тийм хууль, эрх зүйн акт гарчихсан юм биш биз дээ. Ковидын үеэр. Тэгээд тэр нь тэр чигтээ жишиг болоод үлдчихсэн юм биш үү. Тэгэхээр сая Ганбат гишүүн ч гэсэн хэлж байна шүү дээ. Хэн нь хэлчхэв дээ, Засгийн газраасаа ангид бай гээд. Тэгээд ер нь Монголбанкыг ингээд Засгийн газрын харьяа ийм нэг ийм нэг банк юм шиг ч юм шиг, байгууллага юм шиг ч юм шиг ингэж ойлгодог. Гэтэл энэ чинь шал эсрэгээрээ, тусдаа бие даасан асар хараат бус байх ёстой байгууллага. Гэтэл бараг Засгийн газрын харьяат юм шиг, хамааралтай юм шиг ингэж байгаад байна. Тэгээд дахиад л эргээд л энэ бүх энэ бодлого төлөвлөгөө, хөтөлбөр төрд ээлтэй л ийм бодлого байна. Төрд ээлтэй. Хувийн хэвшил бизнес эрхлэгчдэд огт ээлгүй.

Тэгээд энэ нэг ийм бүр нэгдсэн 1 тийм процессын шинжтэй биш, бүр суурь реформын шинжтэй юм хийж болдоггүй юм болов уу, энэ Монголбанк. Жишээлбэл энэ гадаад ханш, гадаад ханш, гадаад ханш, рубль, доллар юу байдаг юм. Энэ гадаад ханшийг барих, энийгээ Засгийн газарт өгдөг ч юм уу. Тэгэхгүй болохоор Монголбанк чинь хоёуланг нь бариад байна шүү дээ. Инфляцыг нам доор байлгах, дээрээс нь гадаад ханшийг тогтвортой байлгах гээд. Тэгэхээр энэ хоёуланг нь авахаар энэ чинь ингээд бие биетэйгээ тэрсэлдээд байгаа юм биш үү. Нөгөө гадаад валютын тийм ээ, гадаад ханшийг барих тогтвортой байлгах гэхээр инфляц нь өсөж

таараад байдаг юм биш үү. Тэгэхээр энэ чиг үүргийг ер нь салгаж болдоггүй юм болов уу гэж бодох юм.

Тэгэхээр магадгүй Засгийн газарт тэр юуг нь гадаад ханшаа өгөх юм бол Засгийн газар чинь магадгүй нөгөө долларын төлөө, долларыг оруулж ирэхийн төлөө гадаадын хөрөнгө оруулалттай илүү их ач холбогдол өгөх юм биш үү. Тэгээд нөгөө гадаадын хөрөнгө оруулалтыг танах, хасах биш эсрэгээрээ нөгөө доллароо олж ирэхийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явагдана.

Санал хураалт явагдахаас өмнө ирцийн бүртгэлийн нэг санал хураалтыг явуулаадахъя. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалтыг эхлүүлье.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

56 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Дараачийн асуудалд оръё.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна аа. Индэрт урьж байна.

Зарчмын зөрүүтэй нийт 55 санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа бэлэн байгаарай.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 9 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 сарын 03-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 10 сарын 16-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар биржийн арилжааны тухай, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж говийн бүсэд ДЦС барих ажил удааширсан шалтгаан, цаашид эрчим хүч тасалдах эрсдэл үүсвэл хүлээх хариуцлагын талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Байнгын хороо 2024 оны 01 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганхуягаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Жаргалан, Лувсанжамц, Мөнхсоёл, Цэнгүүн, Энхтуяа, Энхтүвшин, Энхцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсэгт заасны дагуу ажлын хэсэг экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлого боловсруулах, бизнес эрхлэгчид болон хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зүй зохистой хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болох нэгдсэн сүлжээний дүрэм, түүнтэй холбоотой менежментийн тогтолцоог бий болгох, Улаанбаатар хотод 2 дугаар шатын ЭМТ байр, хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэд хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, Хөвсгөл аймагт Хөх баавгайн үүр төслийг хэрэгжүүлэх, улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулах асуудлаар зарчмын зөрөөтэй саналын томьёолол, тогтоолын төслийн хавсралд тусгагдсан бусад төсөл, арга хэмжээ, нэр томьёог жигдлэх, тоон үзүүлэлтүүдийн хувь, хэмжээг өөрчлөх зэрэг нийт 39 саналыг бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу бизнес эрхлэхэд өртөж буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх, Байтаг боомтыг ашиглалтад оруулж, байнгын ажиллагаатай болгох, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад нар, батарейн станц барих, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын норм дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин гадаадын жуулчдыг хүлээн авах чадамжийг зохистой хэмжүүрээр тооцоолох гэсэн зарчмын зөрөөтэй саналууд ирүүлснийг Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Туваан орон нутагт иргэдэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинэчлэх, ХАА-н бүтээгдэхүүнийг кластераар хөгжүүлэх, боловсруулалтын түвшнийг ахиулах төслийг хэрэгжүүлэх, газар тариалангийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хадгалах зоорь байгуулах, уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, сонгон шалгаруулалтын программ, техник хангамжийг хөгжүүлэх, Мандал сумаас Түнхэл

тосгон хүртэл 35км-тэй хатуу хучилттай төслийг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Батбаяр Дархан-Уул аймагт малын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүн боловсруулах болон дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл технологийн цогцолбор байгуулах, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Улаан-Уул, Баянзүрх, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдыг холбосон гүүрэн байгууламжийг шинэчлэх, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг, Сонгино, Дархан чиглэлийн 220квт ЦДАШ-ыг барих, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж Даланзадгад хотод 50мвт-ын хүчин чадалтай дулааны станц барих төслийг эхлүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц халаалтын урсгал засвар өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэж, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлтэй технологи шилжүүлэх, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох гэсэн зарчмын зөрөөтэй саналууд ирүүлснийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрөөтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн, санал хураалт явуулж, олонхын санал авсан, авахгүйгээр нь бүлэглэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын хөгжлийн 2025 төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг уншиж танилцуулъя.

Тогмидын Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээ Үндэсний хороон дарга, Буяагийн Тулга Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд “20 минутын хот” Үндэсний хорооны дарга, Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн, ХЗДХ-ийн сайд, Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Жамбын Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн, ХХААХҮ-ийн сайд, Цэндийн Баатархүү Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.

Сайд нараа дуудаарай.

Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пуушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Анандын Энхманлай Газар зохион, байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын даргын албаны үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Бат-Очирын Болд ГХЯ-ны Консулын газрын захирал, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн хэлтсийн дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Чулуунборын Гандирваа БХЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Найдангийн Цэвэлмаа БХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга, Зоригсайханы Тулга ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга гэсэн ажлын хэсгийн гишүүд ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Л.Энх-Амгалан сайд андуураад дарчхав уу. Д.Энхтуяа гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Энэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээр үндсэндээ энэ бизнесийн орчныг таатай болгох гэдэг асуудал дээр тодорхой зүүсэн, заалтууд ховор байна аа. Байхгүй байна. Засгийн газрын ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө үндсэндээ хуулаад тавьчихсан ийм байдалтай байгаад байгаа. Тэгэхээр өнгөрсөн жилийн бизнесийн орчны судалгаан дээр МУИС, ХАҮТ-аас хийсэн судалгаан дээр бизнесийнхэн, ААН-ийнхэн 2 асуудлыг л хамгийн хүндрэлтэй байна гээд байгаа юм.

Нэг нь, татварын дарамт.

Нөгөөх нь зээлийн хүү.

Тэгэхээр энэ эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана аа. Төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг барина аа. Аль болох төрийн зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж болохоор бол хувийн хэвшилд шилжүүлнэ ээ гээд энэ Засгийн газрын хөтөлбөр дээр заачихсан. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөө дээр орж ирж байна аа. Тэгэхээр 1-д, энэ дээр яг тодорхой ямар ажил, үйлчилгээнүүдийг гэрээгээр хэрэгжүүлэхээр оруулж ирж байгаа вэ? Би энэ төлөвлөгөөнөөс уншаад тодорхой зүйл харсангүй. Яг Засгийн газрын 4 жилийнхээ хөтөлбөрийг л хуулаад тавьчихсан байгаад байна.

2-т, энэ татварын дарамтыг бууруулах дээр тодорхой анхаарахгүй бол сүүлийн 3 жилийн татварын ачаалал, татварын ачаалал буюу ДНБ-д эзэлж байгаа татварын орлогын хувь хэмжээ 23 хувиас бараг 30 хувь болтол өсчихсөн. Өөрөөр хэлбэл, бид нар төсвөө бүрдүүлэхдээ гучаад хувиар нь татварын орлогоор бүрдүүлж байгаа. Татварын орлогоор бүрдүүлнэ гэдэг чинь энэ чинь эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж байгааг хэлж байгаа. Төсөв рүүгээ татаж аваад, буцаагаад төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлаараа ингээд эдийн засагт оролцож байгаа.

Тэгэхээр энэ хамтарсан Засгийн газрын хөтөлбөр дээр ч гэсэн гол яриад байгаа юм нь болохоор бизнесийн орчныг дэмжинэ ээ. Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гээд байдаг. Гэтэл энэ төлөвлөгөө, хөтөлбөр дээрээ болохоор яг энэнийхээ дагуу, энэ бодлогынхоо дагуу явж байгаа юм алга байна аа. Тэгэхээр энэ татварын ачааллыг ер нь цаашид бууруулах дээр, дотоодын төлөвлөгөөнд эзэлж байгаа хувийг бууруулах дээр ямар бодлогууд байх вэ? Энэ төлөвлөгөө дээрээ ингэж тодорхой заах боломж байна уу?

Энэ ковидоос хойш хувийн хэвшлүүдийн улсад нийт татварын хуримтлагдсан өр 1.2 их наяд орчим байсан бол одоо 3 дахин өсчихсөн. 3 их наяд гаруй төгрөг болчихсон байж байгаа. Энэ татварын ачаалал асар өндөр байгаа, татварын дарамт өндөр байгааг харуулж байгаа. Энэ дээр тодорхой хариултууд өгөөч ээ гэж хүсмээр байна, 1-д.

2-т, сая бид нар 2025 оны мөнгөний бодлого дээр нэлээн энэ банкнууд, арилжааны банкнуудын асуудлыг ярилаа. Ер нь сүүлийн 30 жил ашигтай байж болох бүх л зүйлүүдийг энэ арилжааны банкны эзэд хийж ирлээ шүү дээ. Бүх л бизнес рүү ордог. Ер нь Монголбанк хараат бус байж чадаж байна уу, үгүй юу. Арилжааны банкнуудаасаа. Эргэлзээтэй байхаар ийм нөхцөл байдалтай байж байгаа.

Тэгэхээр эргээд л бизнесийнхний хүсээд байгаа гол зүйл болох энэ зээлийн хүү яаж буурах юм бэ, хугацаа нь яаж уртсах юм бэ гэдэг асуудал дээр тодорхой зүйл огт алга. Энэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөөн дээр. Энийг тодорхой заачхаж болдоггүй юм уу. 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр шигээ ингээд ерөнхий тавьчихаар хэрэгжсэн хэрэгжээгүйг тодорхойлоход хэмжихэд ингээд хэцүү боллоо. Тэгээд энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна аа. баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг хариулна аа.

Х.Ганхуяг: 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд голцуу урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, суурь нөгөө зорилгоо бэхжүүлэх зорилгоор эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дийлсэн засаглал гээд энэ 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд энэ хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан байгаа. Энэ хүрээндээ бизнес нөгөө эдийн засгийн бүтээн байгуулалтын чиглэлээр 14 мега төсөл хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөний төгсгөлд 4 бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 28 зорилт, хөтөлбөрийн 63 зорилт, нийт 318 арга хэмжээний үр дүнд 364 шалгуур үзүүлэлтүүд тавигдсан байгаа.

Мөн тухайн юуны хөгжлийн төлөвлөгөөний 1.3.9 дээр бизнесийн орчинд цогц судалгаа хийж, мөн Лодойсамбуу гишүүний өргөн гаргасан саналаар Сток судалгаа хийсний үндсэн дээр саад тотгорыг нь арилгах, үүнтэй холбоотой бизнес орчныг шинэчлэх гэсэн гэх мэтчилэн ажлуудыг арга хэмжээнд оруулсан байгаа. Зорилт болгон арга хэмжээнд оруулсан байгаа.

Мөн ирэх жилийн төсвийн 2025 оны төсөв өргөн баригдсан байгаа. Үүгээр татварын бодлогыг шинэчлэх асуудлыг Засгийн газраас оруулж ирсэн. Тухайлбал боловсруулалтын салбарын татварын гаалийн татварыг тэглэсэн байгаа. Түрүүн мөнгөний бодлогыг ч гэсэн бид нар сая хэлэлцэж байхад нэг зүйл дээр цөмөөрөө анхаарал хандуулах ёстой юм. Энэ дээр гишүүд маань байр суурь нэгтэй цөмөөрөө ормоор байгаа юм. Бид нар аль нэг салбарын хөнгөлөлт үзүүлэх, эсвэл хүүгийн татаас үзүүлэх, эсвэл иймэрхүү юмнууд авч бид нар хуулиар оруулах тусам бид нарын бусад зардал байнга өсөж явдаг юм. Одоо юу гэдэг юм НДШ 20-23 хувь байгаа.

Яагаад нийгмийн даатгал шимтгэл буурдаггүй вэ гэхээр бид нар популистуудын хар гайгаар тэр малчны нийгмийн даатгал ч гэж ярьдаг. Тэгээд нөгөө сайн дураараа нөгөө нөхөж төлөх бололцоог нь олгосноор бид нар НДШ-ийн хувь хэмжээг нь бууруулж чаддаггүй. Өнөөдөр ингээд зээлийн хүү ерөөсөө буурахгүй байгаа шалтгаан нь банкны зээлийн хүртээмж нь байхгүй болоод зээлийн хүү буурахгүй байгаа юм. Хүртээмж нь. Тэрнээс ихэнх бизнесүүд 1.5-1.8-аар авахад хангалттай бизнес хийх боломжууд байна. Гэхдээ тэр хүүгээрээ зээл нь олдохгүй байгаа байхгүй юу. Тэгээд яаж байна гэхээр ихэнхдээ 2,5-3,5 цаашлаад бүр 4 хувийн хүүтэйгээр зээл аваад, банк бусаас зээл аваад яваад байгаа нь өөрөө эргээгээд банкны бизнесийн салбарын санхүүгийн өртөг өндөр болоход нөлөөлөөд байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бид нар яг мөнгөний бодлогыг хэлэлцэх үед ч тэр, мөн нийгмийн даатгалын энэ хуулиуд орж ирэхэд ч тэр, ямар нэгэн салбарыг дэмжсэн хуулиуд орж ирэхдээ энэ тал дээрээ бид нар яг санал нийлэлтэйгээр зарчмын байр сууриа хадгалаад л явж байж л энэ зээлийн хүү аяндаа буурах юм.

Мөн Банкны хуулийн хэрэгжилтийг бид нар хангуулж чадсанаар цаашдаа монопол нь задрах, тэгээд цаашдаа зээлийн хүү буурах ийм боломж нь бүрдэнэ. Мөн дараа жилийн энэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу. Ганзориг гишүүн тодруулах юм уу? Тодруулж асуулгая.

П.Ганзориг: Энэ төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримтална гээд. Тэгээд гэрээгээр гүйцэтгүүлж болох төрийн чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоонд шилжүүлнэ гээд тавьчихсан. Яг юу ямар ямар чиглэл байгаа юм бэ? Энийг тодорхой тавихгүй бол хэмжигдэхэд хэцүү, хийсэн гэхэд дараа нь хэцүү болно. Тэгэхээр энийгээ тодорхой оруулж болох уу. Эсвэл байгаа юу ямар зүйлүүд байна.

2-т, энд татварын ачаалал гэж чухал үзүүлэлт байгаад байна шүү дээ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа татварын орлого 20 онд 23 хувьтай байсан. Одоо ингээд 24 оноос эхлээд өссөөр байгаад 23, 26, 29 гэж өсөж байгаад 30 хувь болж байгаа. Энэ чинь өөрөө эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана гэдгийн эсрэг яваад байгаа байхгүй юу. Татварыг төсвийн орлого бүрдүүлэхдээ гол хэрэгсэл болгож ашиглаад, буцаагаад урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлээд явж байна гэдэг чинь төр өөрөө эдийн засагт илүү их оролцож байна гэсэн үг.

Тэгэхээр энэ нөгөө үндсэн бодлоготойгоо зөрчилдөөд байгаа. Энийг бууруулах дээр ямар бодлого байна вэ гээд. Тэгээд банкны хүү 3.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн нэмж хариулъя.

Х.Ганхуяг: 1 дүгээр асуултад хариулахад яг Улсын Их Хурлын даргын захирамжаар төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд судалгаа хийж, шаардлагатай бол хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийх ийм ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа.

Мөн Зөвшөөрлийн хууль дээр ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Тэгээд энэ дээр ямар ажлууд хийгдэх вэ гэхээр 1 дүгээр асуудал бол бид нар энэ зөвшөөрлүүдийн тэр тусмаа яг мэргэжлийн холбоод руу зарим мэргэжлийн холбоотой зөвшөөрлүүдээ шилжүүлэх ажлууд хийх ёстой гэсэн үг. Жишээлбэл тэр нөгөө мэргэжлийн инженерийн ч байдаг юм уу, тийм ээ, барилгын зөвшөөрлүүдийг шилжүүлэх, мөн хувийн хэвшилтэй холбоотой зөвшөөрлүүдийг аль болох мэргэжлийн холбоод руу буюу хувийн хэвшлийн ТББ-д шилжүүлэх ажлуудыг хийгээд явах юм. Энэ дээр ингээд ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Учрал сайдаар ахлуулсан Хэрэг эрхлэх дээр давхар ажлын хэсэг байгуулагдсаныг өнөөдөр бид нар нэгтгээд, мөн эрсдэлийн үнэлгээг нь хийгээд, эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр бид нар аль ажлыг нь төрийн эрх бүхий байгууллагууд нь зөвшөөрлийг нь өгөөд явах вэ. Аль ажлыг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: 25 оны төлөвлөгөө төсөвтэйгөө хэрхэн уялдаж байгаа вэ? Энэ төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил арга хэмжээнүүдийн хөрөнгийн эх үүсвэр яаж бүрдэх юм. Гаднын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл гээд л ингээд тодорхойгүй, эх үүсвэр тодорхой биш зүйлүүд нэлээн тавигдсан байгаа юм.

Тэгэхээр энэ эх үүсвэр энэ ажлууд чинь төсөвтэйгөө хэрхэн уялдах юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 14 мега төсөл байна. Түүний 10 нь говийн бүсэд, үүнээсээ 6 нь Өмнөговь аймагт хэрэгжихээр байна. Тэгэхээр энэ

төслүүд урт хугацаа шаардсан нэлээн томоохон ажлууд, хөрөнгө төсөв шаардсан ажлууд байгаа. Тэгэхээр 25 оны төсөвт хэчнээнийг нь оруулж эхэлсэн, хэчнээн нь эхэлж яг ажил хэрэг болж эхэлж явах юм бэ гэдэг асуудал, бэлтгэл ажлууд хангагдсан уу? Эдгээр томоохон бүтээн байгуулалт, том төслүүдэд хамгийн нэн түрүүнд шаардлагатай 2 зүйл эрчим хүчний асуудал байгаа. Хүрэлцээ байхгүй байгаа.

2 дахь асуудал усны асуудал байгаа. Тэгэхээр энэ 2 эн тэргүүний шийдэх ёстой асуудлуудаа яаж шийдвэрлэхээр 25 оны төлөвлөгөөнд тусгаж өгсөн бэ гэсэн ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар бид нар энэ хөгжлийн төлөвлөгөөг эхэлж баталдаг буюу хаврын чуулганаар баталчхаад, тэр баталсан төсөл дээр буюу төлөвлөгөө дээр төсөв орж ирдэг юм байгаа юм. Тэгээд энэ жилийн хувьд онцлог байлаа. Бид нар уг нь 25 оны хөгжлийн төлөвлөгөөг сая энэ хаврын чуулганаар батлуулахад 3 удаагийн хэлэлцүүлэг хийчихсэн байсан юм. Тэгээд юу, соёрхон батлахаас өмнө сонгууль болоод соёрхон баталж чадаагүй юм. Гэхдээ сая сонгуулийн үр дүнд хамтарсан Засгийн газар байгуулагдсан учир бол ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэхээс өөр арга байгаагүй.

Тэгээд энэ шинэчлэгдээд орж ирсэн байгаа. Гэхдээ энэ төсөвтэй уялдах албагүй. Яагаад гэхээр энэ чинь түрүүлж явах ёстой юм. Энэний үндсэн дээр төсвийг бид нар хэлэлцэнэ ээ л гэсэн үг. Тэгээд хэчнээн хамтраад ингээд хамт өргөн баригдсан байгаа ч гэсэн бид нар хөгжлийн төлөвлөгөө бол Засгийн газраас орж ирсэн санал болон гишүүдээс орж ирсэн саналыг нь яг л хөгжлийн төлөвлөгөөний тэр хуулийн дагуу, хөгжлийн нөгөө төлөвлөгөөний хуулийн дагуу төсөв, зураг, төсөл эд нар бүх ТЭЗҮ нь хийгдсэн юмнуудаа авсан байгаа, эрэмбэлж авсан байгаа. Тэгээд тэр бусад шаардлага хангаагүй юмнуудаа бид нар хасаад явсан байгаа. Ажлын хэсэг дээр. Тэгээд Байнгын хороон дээр дэмжигдээд явсан байгаа.

Мега төсөлтэй холбоотой асуудлуудыг манай ажлын хэсгээс Эдийн засгийн хөгжлийн яам нэмээд хариулчих уу.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: 25 оны хөгжлийн төлөвлөгөөний задаргаанууд яригдаж байна л даа. Энэ ингээд хэдэн 100 ажил байгаа. Ингээд баахан ажлыг тэр тэр хариуцаж хийнэ ээ, ингэнэ ээ гээд баахан зүйл. Энэ дээрээс асуух гэж байгаа гол зүйл нь энэ ажлуудыг яг эцсийн дүндээ хэн хийх гэж байгаа вэ? Хэн хийх гэж байгаа вэ? Бүр тодруулж асуух гэж байгаа нь Монгол Улс чинь ингээд явсаар байгаад хөгжил дэвшил, ажил төрөл, төр засаг гэж явсаар байгаад энэ төвлөрсөн улс болоод хувирчихсан. Бүх шийдлийг, бүх шийдвэр Улаанбаатар хотод гардаг болчихсон. Энэ хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгчид нь хэн байх вэ? Төвлөрөл эндээс хэрхэн саарах вэ. Энэ дээр яг ямар бодлогын асуудлууд тусаж байна вэ? Ганц жишээ хэлэхэд нэг аймагт 30-аад агентлаг ажилладаг. 3, 4-өөс бусдыг нь бүгдийг нь Улаанбаатараас санхүү, мөнгө, томилгоо, бүх юм Улаанбаатараас хийгддэг.

Тэгэхээр энэ хөгжил дэвшил гэдэг чинь явсаар байгаад хэн юугаа хариуцах юм. Эндээс чинь асуудал эхлэх байх л даа.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Бас эндээс нэг энэ ХАА-н сайд байхгүй байх шиг байна. Ажлын хэсгийн дарга нар хариулаад өгөөч. Төвлөрлийг саарна гэхээр энэ яамнууд нь хөдөө явахаар энийгээ хөгжлийг саарч байна гэж ойлгож байгаа юу? Уг нь яамд гэдэг чинь бодлогын яамд баймаар юм. Одоо Уул, уурхай яам нь удахгүй Өмнөговь аймаг явах юм уу. Боомтын яам нь боомт руу явах юм уу? Энд яг юу, ямар учиртай ийм бодлогын шийдэл эндээс ингэж гараад байгаа юм бэ. Магадгүй ХАА-н сайд маань Дарханаас ирж амжаагүй ч байгаа юм уу, бүү мэд. Одоо энэ хурал дээр энийг нь ингээд асуучихвал уг нь зүгээр л байгаа юм. Тэгээд жишээ нь би ойлгохдоо төвлөрөл саарна гэдгийг яам бодлогын яам байна. Аймагт байгаа тэр ХАА-н газрын даргыг, аймагт байгаа МАА-н газрын даргыг, аймаг нь өөрөө шийддэг, яам бодлогоо чиглүүлдэг, хяналтаа тавьдаг, энийг төвлөрөл саарах байна гэж бодож байгаа. Гэтэл төвлөрлөөс эс төвлөрлүү биш, төвлөрлөөс чирэгдэл рүү явж байгаа энэ бодлого яг одоо бид нарын ярьж байгаа энэ хөгжлийн төлөвлөгөө дээр энэ чигээрээ ингээд суучихсан байх юм бол наад нэг бодлого, чиглэл олон олон зүйлүүд чинь бүр зүг чигийн хувьд, философийн хувьд, зарчмын хувьд бүр эсрэг тийшээ л юм болчих гээд байна лээ. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Хөгжлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралт дээр авах арга хэмжээнүүд болон хэн хийх, ямар төсвөөр хийх, суурь түвшин, зорилтот түвшин, хүрэх түвшин гээд бүгдээрээ байж байгаа. Та тэндээс яг аль ажлыг хэн хийх вэ гэдэг хариулт тэндээс харж болох байх.

Шийдвэр Улаанбаатар хотоос гарч байна гээд байх юм. Бид нар нэгдсэн 1 л улс. Засгийн газраас шийдвэр гарч байгаа бол Засгийн газраасаа шийдвэр гараад л явна гэсэн үг. Улсын Их Хурлаас гарч байгаа улс орон даяар хэрэгжээд явна гэсэн үг. Тус тусдаа шийдвэр гаргаж явдаг тийм юм байхгүй шүү дээ. Та сайн өөрөө тэрийг нь мэдэж байгаа байх.

Томилгоо хотоос хийхээр хөгждөг үү? Орон нутгаас хийвэл хөгждөг гэдэг. Энэ өрөөсгөл ойлголт болов уу гэж бодож байна. Тэгээд энэ дээр та өөрөө тэр салбарынхаа хууль, ямар асуудал дээр ямар гацаа үүсчхээд байгааг та өөрөө сайн мэдэж байгаа байх. Тэгээд магадгүй тэр салбарынхаа хуулиа та өөрөө хөндөлт хийгээд, өргөн барих санаачлах эрх танд байгаа гэж ойлгож байна.

Төвлөрөлтэй холбоотой асуудлаар энэ жилийн төсвийн тодотгол ч тэр, ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөө ч тэр энэ түгжрэл, төвлөрлийг сааруулах дээр нэлээн олон арга хэмжээнүүд орсон байгаа. Тухайлбал Улаанбаатар хот бол “20 минутын хот” гээд. Засгийн газрыг хотоос гаргах. Сүхбаатарын талбайг тойрсон 1км радиустайгаа бүх төвлөрлийг хотоос гаргах. Энэ дээр хувийн хэвшилд нь Улаанбаатар хотоос байгаа зайнд нь хамааруулаад орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлж байгаа. Орон нутаг руу шилжсэнээр мөн ипотекийн зээлийн хөнгөлөлтийг үзүүлж байна. Мөн сая орлогын албан татварын 22.9-өөр бид нар хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийвэл нийгмийн хариуцлага гэдэг маань эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт гээд тэр чиглэлээр хөрөнгө оруулалт хийвэл тухайн ААНОАТ-аас нь хөнгөлөлт хийхээр оруулж өгсөн. Нэг ёсондоо ААН орон нутаг руу шилжвэл, өөрийнхөө оффисоо шийдэх, иргэдийнхээ орон сууцын асуудлыг шийдэх, үүнтэй холбоотой нийгмийн

үйлчилгээний салбаруудыг өөрөө хөрөнгө оруулалт хийгээд явах боломжийг нь татварын хувьд хангалттай сонгогдсон байгаа гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Монгол Улс нэгдмэл улсыг парламентын засаглалтай улсыг мэдэж байна, бүгдээрээ л мэдэж байгаа. Бодлого, шийдвэр угаасаа парламентаасаа хуулиар дамжигдаад гараад явж байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Тэр Үндсэн хуульд чинь өөрөө удирдах ёс гээд саяхан бид нар хэдхэн хоногийн өмнө сонгууль хийлээ л дээ. Тэр эрх мэдэл чинь тэнд байхгүй болчихоод байна л гэдгийг л хэлээд байна л даа. Тэнд эрх мэдэл байхгүй болчихоод байна.

Улаанбаатар хотод байгаа энэ гараад байгаа түгжрэл чинь Улаанбаатар хотод байгаа эрх мэдлийн түгжрэл энд л болчихоод байгаа шүү дээ. Хүний машины түгжрэл биш эрх мэдлийн түгжрэл болчихоод, тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөө дээр чинь наадхыг чинь бодлого болгож ярих. Жишээ нь татварын орлогыг тодорхой орлогууд нь тэндээ үлддэг, тэнд нь татвараа өөрөө бүрдүүлэхэд нь нэмүү өртгөө тэндээ бий болгоход нь хөшүүрэг болдог, халамж биш тийшээгээ боломж очиж байдаг энэ тогтолцоо л бид нарт өнөөдөр асар чухал болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөө дээр зарчмын хувьд, философийн хувьд бид нар өөр л бодлого барихгүй бол энэ шал өөр зүг чиг рүү яг л нэг ийм хуучны бид нарын төвлөрсөн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Ганхуяг гишүүн нэмж хариулъя.

Х.Ганхуяг: Бид нар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль өнгөрсөн хавар батлуулсан. Тэгэхэд орлогын албан татвар дээр нэг өөрчлөлт хийсэн байгаа. Тэр нь юу вэ гэхээр 2026 оноос байх аа, Дээгий. Тухайн орон нутагт байгаа ААНОАТ-ын 40 хувийг нь тухайн орон нутагт үлдээхээр тийм өөрчлөлт хийсэн шүү дээ.

Тэгэхээр цаашдаа тухайн орон нутаг төсөв бүрдүүлэлтэд тодорхой хэмжээний ач холбогдолтой болов уу гэж бодож байна. Тухайн орон нутагтаа ажлын байр бий болгоход, мөн тухайн орон нутаг нь өөрөө ажилладаг болох хөшүүргийг нь бий болгочихсон байгаа. Тийм, татварын хувьд бол.

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Хөгжлийн төлөвлөгөө дээр сая Цогтгэрэл гишүүний хэлсэн дээр зарим талаар санал нийлээд байгаа юм аа. Бид нар холбооны улс биш нэгдсэн улс. Тэгээд манай энэ зарим яамнууд аймгууд руу нүүгээд явчихаар яг үнэндээ ойлгохгүй л байгаад байгаа. Үндсэн хуулиараа болж байгаа юм уу. Эхлээд ядаж хуулиа янзалж хийчхээд явах ёстой болов уу л гэж хараад байгаа юм. Яам нь сайдаа дагаж яваад байгаа юм болов уу даа л гэж л харсан шүү дээ. Тийм. Тэгээд гайхаад л байна. Уг нь энэний тухай ярьж байхаасаа илүүтэй бид нар энэ Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дээр орчихсон яваад байгаа. Энэ Дархан арьс ширний цогцолборын асуудал яригдаад байгаа байхгүй юу. Дархан арьс ширний цогцолбор яригдаад байгаа юм. Дархан арьс ширний цогцолборын асуудал олон жил яригдаж байна. Энэ төсөл яаж явах ёстой вэ гэвэл том хэмжээний олон улсын стандарт норм, шаардлага, эрүүл ахуйг хангасан, мал гаргах хуучнаар Мах комбинат гэдэг байгууллага байгуулагдаад, тэрийгээ дагаад малын дайвар

бүтээгдэхүүнүүдийг цуглуулж, үйлдвэр хийдэг ийм жижиг үйлдвэрүүд дагаж явах ёстой ийм л цогцолбор баригдах ёстой юм, ХАА-н.

Тэгэхээр энэ саналыг уг нь энэ ирэх оны төлөвлөгөөнд тусгасан байсныг унагаагаад хаячихсан байх юм аа. Тэгээд би эрхэм гишүүдээс 1 дүгээрт, ажлын хэсгээс энийг яагаад унагаачхав. Олон жил яригдсан, бүр тэгж ярих юм бол 2020 онд баталсан 25 онд дуусах 5 жилийн үндсэн чиглэлд тусчихсан байгаа ажил шүү дээ. 5 жилийн үндсэн чиглэлд тусчихсан байгаа ажил. Эдийн засгийн хөгжлийн яамныхан.

Тэгээд энэ 5 жилийн үндсэн чиглэл чинь хугацаа нь дуусаагүй байна. 25 он болтол хэрэгжинэ. Тэгэхэд та нар ирэх оны ажлын төлөвлөгөө оруулж ирэхээрээ энийг унагаагаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Байхгүй болгочхож байгаа юм. Бодлого ингэж хөдөлгөөнтэй яваад байж болохгүй шүү дээ. Яагаад унагаачихсан юм та нар. Малын гаралтай бараа бүтээгдэхүүнээ үнэд хүргэе, олон улсын зах зээлд нийлүүлье гэдэг юм л ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг би яагаад унагаачихсаныг 1 дүгээрт асуумаар байна.

Дараа нь би нэг асуулт байна аа. Энэ сүүлийн үед энэ Учрал сайд л урдуур нь үсэрч орж давхиад байх юм даа. Тэгээд би гайхаад байгаа юм. Хуучин ажлаа хийгээд байгаа юм болов уу? Энэ Анар гишүүн энэ сансрын маш чухал юм яриад байгаа байхгүй юу. Хиймэл дагуул. Монгол Улсад нэн хэрэгтэй, маш чухал хэрэгтэй зүйл. Бид нар өөрийн гэсэн түрээсийн байргүй, өөрийн гэсэн энэ сатлайд сансрын ийм юмтай болох ёстой, ийм хиймэл дагуултай. Тэгээд энэ Цахим хөгжлийн сайд энэ дээрээ нэг хариулт өгөөдхөөч. Энэ яг нөгөө нэг төмөр замын төслүүд шиг юм л сонсогдоод байх юм. 1 ширхэг ийм үзгийг 4, 5 нугалаад л авчихсан юм шиг үнээр л оффтейк гэрээ хийгээд, баахан төмөр зам барьчихсан шүү дээ. Тэгээд төмөр замын хулгай гээд нэг нүсэр юм явсан. Бид нар өнгөрсөн парламентаар энэ ажлыг шалгасан, аудитын дүгнэлт гарчихсан, 4.5 дахин, 4 дахин их өндөр үнээр хэрэгжүүлсэн байна гэдэг ийм юм яваад байгаа байхгүй юу. Энэ сансрын станцтай болох нь зөв. Гэхдээ ямар үнээр вэ гэдэг асуултад та нар нэг энэ Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нэг ажлын эзэн юм бол бодитой хэлээдхээч. Асар үнэтэй байна гээд л энэ манай Анар гишүүн яриад байх юм. Та 2 энэ дээр нэг ойлголт өгчихвөл зүгээр байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн хариулъя. Ажлын хэсэг дээр энэ Байнгын хороо ажлын хэсэг дээр санал хураагдаж асуудлууд эцэслэн шийдэгдсэн учраас Байнгын хороо, ажлын хэсэг асуултад хариулна аа. Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Засгийн газрын төлөвлөгөө дээр аль яам хаашаа шилжих тухай төлөвлөгөө тусгагдаагүй ээ. Тэгээд надаас аль юм хаашаа шилжих асуухад хэрэггүй байх гэж бодож байна.

2 дугаарт, энэ Дарханы арьс ширний цогцолбор энэ 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй байсан. Зарчмын зөрөөтэй саналаар Батбаяр гишүүн мэдүүлсэн. Тэгээд яагаад тусаагүй вэ гэхээр энэ зураг, төсөв бэлэн байгаа эсэх, төсөл нь бэлэн байгаа эсэх дээр хариу өгөх хүн байгаагүй. Тэгээд зураг төсөв байхгүй гэдэг шалтгаанаар ихэнх саналууд, унасан саналууд бол ихэнхдээ зураг, төсөв байхгүй гэдэг шалтгаанаар л унасан байгаа. Яагаад гэхээр хэрвээ бид нар тэрийг авах юм бол Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, хөгжлийн

хууль гээд олон хуулиудыг зөрчих нөхцөл байдал үүссэн болохоор аваагүй байх шүү.

Хиймэл дагуултай холбоотой асуудлыг анхдугаар чуулган дээр би өөрөө хэлж байсан л даа. Энэ үнэтэй байна гээд. Тэгээд учир шалтгааныг нь сайн тодруулаад манай энэ сайдууд хариулж болох юм бол сайдууд хариулна биз. Би бодвол яг тэр тал дээр тодорхой мэдээлэл надаа алга байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газар дээр хариуцаж байгаа ажлын хэсгийн дарга нь Учрал сайд уу. Учрал сайд хариулах уу. Баатархүү сайд хариулах юм уу? Баатархүү сайд. Цахим хөгжил харилцаа холбооны сайд Баатархүү хариулна.

Ц.Баатархүү: Асуултад хариулъя. Та бүхэндээ энэ оройн мэндийг дэвшүүлье. Үндэсний хиймэл дагуулын асуудлаар олон талын хэлэлцүүлгийг, биднийг ажил авахаас өмнө хэлэлцээд, хиймэл дагуултай байх нь зөв юм байна гэдэг ийм шийдвэр гарсан. Ажил авсныхаа дараа мэргэжлийн өндөр орбитын хиймэл дагуулаар дамжуулж, интернэтийн үйлчилгээ авдаг ААН, хувийн хэвшлийнхэнтэй уулзаж ярилцаад, үндэсний хиймэл дагуул бол харилцаа холбооны бие даасан байдлыг нэмэгдүүлэх, Монгол Улсын тусгаар тогтнолтой холбоотой учраас сүүлийн жилүүдэд салбарынхны энэ мөрөөдөл юм. Хиймэл дагуултай болох нь зөв өө гэдэг дээр санал нэгдсэн. Одоо та бүхний ярьж байгаа энэ болгоомжлол, үнэ өртгийн асуудал бол интернэтээр үзэх юм бол бүх зүйл нь нээлттэй байгаа. Хамтран ажиллаж байгаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ц.Баатархүү: Францын компани бол өндөр орбитын хиймэл дагуул бүтээдэг 6 гол байгууллагын нэг юм байна лээ. Танин мэдэхүйн хувьд хэлэхэд дэлхий дээр 90 гаруй улс ямар нэгэн байдлаар өндөр болон нам орбитын хиймэл дагуулыг хөөргөсөн. Эдийн засгийн хэлэлцээр Сангийн яам яг гардаж хийж байгаа.

2-т, дахиад би нэг зүйлийг онцгой хэлье ээ. Энэ Сангийн яам ч юм уу, хэн нэгэн хүн энэ хэлэлцээрийг бие даагаад шийдэхгүй. УИХ үндэсний хиймэл дагуулын энэ зээлийн хэлэлцээрийг эцэслэн шийдэх учраас 126 гишүүн саналаа хураагаад үндэсний хиймэл дагуулыг эцэслэж шийднэ ээ.

Тэгэхээр Сангийн яам эцсийн байдлаар үнэ өртгийг оруулж ирнэ. Ер нь нэг тонн хиймэл дагуулын үнэ ямар байх вэ гэдэг интернэтээр Дамдинням гишүүн ээ, нээлттэй байж байгаа. Тэгэхээр одоо энэ хиймэл дагуултай холбоотой бүх ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дамдинням гишүүн тодруулж асууя.

Г.Дамдинням: Нөгөө арьс ширний цогцолборын асуудлыг асуусан.

Д.Амарбаясгалан: Сая Ганхуяг гишүүн хариулчихсан.

Г.Дамдинням: Үгүй ээ яах вэ, арьс ширний цогцолборыг бид нар заавал үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ёстой шүү. Эрхэм гишүүд 2 дугаар хэлэлцүүлэг дээрээ анхаараад энэ дээр нэг ажиллаад өгөөч ээ.

Баатархүү сайд аа, ажил авахаас өмнө, ажил авсны дараа ингээд Монголын төрийн ажил үргэлжлээд явна аа. Би интернэт рүү ороод харах надад боломж байна. Тэгэхдээ энэ чуулганыг ард түмэн харж байгаа учраас би зориуд асууж байгаа байхгүй юу. Та энэ дээр өөрөө ороод хараадах л гээд байх юм. Та энийг нь хараад ард түмэнд мэдээлж байх үүрэгтэй хүн нь байхгүй юу даа. Үнэнүүдийг нь хэлчхээч дээ. Анар гишүүний хэлээд байгаагаар бараг 4 дахин хүнтэй юм яриад байна лээ. Тэгээд бид нар мэдэхгүй байна. Нийтэд энэ үнийг нь хэлээд өгчих. Яг ямар байдаг юм. Хэрэгтэйг нь бүгд мэдэж байгаа. Маш чухал. Хэрэгтэй хэрэгтэй гээд ийм өндөр үнээр үү, үгүй юу?

Д.Амарбаясгалан: Засгийн газрын ажлын хэсгийн дарга, Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд хариулья.

Н.Учрал: 21 аймаг, 330 сум, бүх баг, бүх боомт, хөдөө орон нутаг, малчдад интернэт холбоо харилцааг хүргэхэд нийт 29 их наяд төгрөгийн санхүүжилт хэрэгтэй.

Тэгэхээр бид энэ төлбөр мөнгийг шийдэх бололцоо байхгүй. Цаашдаа 21 аймгийн хаана ч интернэттэй холбоо харилцаатай болмоор байна. Тийм учраас үндэсний хиймэл дагуулыг хөөргөө өө гэдгийг зарчмын хувьд гишүүд болоод мэргэжлийн экспертүүд ч гэсэн дэмжиж байгаа. Дэлхий дээр 6 гаднын хиймэл дагуулыг бүтээдэг орон байдаг. Түүнд Хятад, Орос, Энэтхэг, Америк, Франц гэсэн орнууд. Би ер нь энэ асуудлаар яриад байгаа гишүүнээс асуумаар байгаа юм. Яг ямар орны аль компани хямдхан байгаа юм. Шууд утгаараа хэлчихмээр байна. Яг Хятадаар хийлгэе ээ гээд байгаа юм уу гээд байвал шууд хэлчихмээр байна. Хятадаар хийлгэмээр байна, тэнд хямдхан гэвэл хийлгэж болно шүү дээ. Тийм юм яриад байгаа юм уу.

Д.Амарбаясгалан: Доржзодовын Энхтуяа гишүүн асуултаа асууя. Хурууныхаа хээг уншуулчхаарай, эхлээд. Нэр нь гарч ирэхгүй байгаад байна.

Д.Энхтуяа: Надад 2 асуулт байна. Би ажлын хэсэгт орсон гишүүний хувиар ажлын хэсгийн ахлагчаас биш ЗГХЭГ-ын сайд Учрал сайдаас асууя. Бид нар Тогтвортой хөгжлийн төлөөх зориг гээд энэ хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг баталсан. Ингээд 2025 оны хөтөлбөр, хөгжлийн хөтөлбөр орж ирж байна аа. Тэгэхээр энэ 14 мега төсөл гээд. Тэгээд 14 мега төслийг дагасан маш олон төслүүд хэрэгжинэ ээ. Тэгэхээр энэ төслийн чинь, энэ их бүтээн байгуулалтыг чинь бид нарт яах вэ, мөнгө хөрөнгө нь, гадаадын зээл тусламж нь олоод ороод ирдэг юм байж. Энийг хэн хийж гүйцэтгэх юм бэ?

Өнгөрсөн энэ 2, 3 жилийн хугацаанд ковидоос хойш Монгол Улсын нутаг дэвсгэрээс хөдөлмөрийн насны жилдээ 10-20 мянган залуучууд гэр бүлээрээ гарлаа гэсэн ийм статистик тоо байгаа. Түрүүчийн чуулган дээр би асууж байсан. Ер нь яг бодитой тоо байхгүй ч гэсэн 240 мянган хөдөлмөрийн насны залуучууд гадаадад амьдарч байна гэсэн ийм тооцооллыг Энх-Амгалан сайд надад хэлж байсан.

Тэгэхээр энэ бүтээн байгуулалтыг чинь хэн хийх юм бэ? Энэ дээр яг энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө ямар нэгэн бодлого сууж байгаа юу?

Дээрээс нь яг өнөөдөр Монгол Улсад хөдөлмөрийн насны иргэдийн 60 хувь нь хөдөлмөрийн бус насны хүүхэд болон ахмад насныхан, хөгжлийн бэрхшээлтэй

иргэд байгаад байгаа юм. Тэгэхээр 40 хувьдаа бид нар өнөөдөр гадаад руу энэ хөдөлмөрийн насны залуучуудаа алдаад байгаа учраас тэр залуучууд маань гадаадын хөгжлийн төлөө ажиллаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр тусгай бодлого гаргахгүй бол энэ 14 мега төсөл, энэ том ирэх 30 жилийн юу гэдэг юм, хөгжлийн Монгол Улсын хөгжлийг илтгэх энэ гарааны энэ жил дээр чинь бид нар яг ийм л асуудал яриад сууж байгаа учраас энэ дээр ямар нэгэн бодлого байгаа юу? Одоо энэ манай Монгол Улсын энэ гадаадад байгаа консулын газруудаараа дамжуулаад энэ залуучуудынхаа асуудлыг, тооцоо судалгаа аваад, эргэж тэд нарыгаа авчрах асуудал дээр ямар нэгэн бодлого байгаа юу гэсэн 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт бол 2025 оныг “Залуучуудыг хөгжих дэмжих жил” болгоод Засгийн газраас зарлалчсан байгаа. Энийг дэмжиж байна аа. Яг энэтэйгээ уялдуулаад одоо яг энэ залуучуудыгаа авчрах тал дээрээ бодлогоо уялдуулж явуулж байгаа ямар нэг энэ зүйл байгаа юу? Яагаад энэ олон залуучууд жил болгон 10, 20-оороо ингээд гадагшаа гараад байна вэ гэвэл ер нь асуудал нь энэ орон сууцын л асуудал байгаа шүү дээ. Ихэнх дийлэнх нь тийм ээ.

Тэгэхээр орон сууцын асуудал дээр энэ залуу гэр бүлийг дэмжих асуудал дээр ямар тусгай хөтөлбөр боловсруулж байгаа вэ? Энэ залуучуудын энэ орон сууцын асуудлыг шийдчих юм бол олон залуучууд эх орноосоо дайжихгүй байх ийм нөхцөл бололцоо ийм судалгаа ч байна.

Дээрээс нь Монгол Улсын хэмжээнд дахиад нэг судалгаа харахад ер нь энэ гэр бүлийн салалт бол гэр бүлээ бүртгэж байгаагаасаа, бүртгэл бүртгүүлж байгаагаасаа илүү байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ гэр бүлийн салалт чинь л энэ орон сууцтай холбогдож гарч байгаа ийм судалгаа байгаад байгаа юм.

Тэгэхээр яг энэ 2 асуудал дээр Учрал сайдыг хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Энэ хэлэлцэж байгаа асуудал маань Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуух ёстой байгаа гэдгийг та бүхэн маань анхаараад, тэгээд ажлын хэсэг, Байнгын хороо энэ дээр голчилж хариулт өгөх ёстой гэдгийг бүгдээрээ дэгийнхээ дагуу энийгээ ойлголцож явах нь зүйтэй.

Ингээд Хассуурийн Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн дарга хариулт өгье.

Х.Ганхуяг: Манай Энхтуяа гишүүн ажлын хэсэг дээр их идэвхтэй ажилласан гишүүн л дээ. Уг нь санал гаргах бүрэн эрхтэй байсан. Байнгын хороон дээр ч гэсэн мөн санал гаргах бүрэн эрхтэй байсан. Тэгэхдээ аягүй чухал асуудлыг хөндөж байгаа. Энэ дээр 2 асуудал байгаа. Ер нь бид нар цаашдаа энэ залуучуудын жилээ цаашид Зөгийн үүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өмнө бид нар чинь нэг хэрэгжүүлээд дутуу орхичихсон байхгүй юу. Яг нөгөө нийгмийн асуудлуудыг нь шийдэх гэх мэтчилэн. Энийг цогцоор нь шийдэх ёстой юм байна лээ. Энийг Энх-Амгалан сайд хэрэгжүүлэх талаар ярина лээ.

Хүний нөөцтэй энэ 14 мега төслийг хэрэгжүүлэхдээ хүний нөөцтэй холбоотойгоор Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй санал дэмжигдсэн байгаа. Тэр нь, тухайлбал, өндөр ур чадвар бүхий ажиллах хүчнийг гадаадаас

авахад нь квотоос чөлөөлөх, мөн түүнтэй холбоотой төлбөрийг чөлөөлөх гэсэн ийм асуудлууд зарчмын зэрөөтэй саналаар орж ирсэн. Энийг ажлын хэсэг дээр ч дэмжээд, Байнгын хороон дээр ч гэсэн дэмжсэн байгаа. Баярлалаа.

Сайд нэмж хариулах уу?

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд ажиллах хүчтэй холбоотойгоор хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Өнөөдөр Монгол Улс яагаад ингээд ажиллах хүчний хомсдолд орчихсон юм бэ гэдэг дээрээ бид нар нэг ийм тооцоо, судалгаа, шинжилгээ сайн хийж байж, бодлогын их тийм зөв бодлого гаргахгүй бол ингээд нэг ийм 208 мянга гэсэн тоо байгаа шүү дээ, Энхтуяа гишүүн ээ тийм ээ. Гадаадад ажиллаж байгаа, амьдарч байгаа залуучууд энд 240 биш 208 мянга байгаа.

Тэгэхээр энэ залуучуудаа бид нар авчирч болно. Тэгэхдээ энд гадаадад 2-3 мянган доллартой цалинтай байгаа ажилчид, залуучуудаа бид нар энд хүрч ирээд мянган доллар хүрэхгүй цалин дээр ажилла гэж хэчнээн ч уриад, хэчнээн ч уриад, хэчнээн ч хэлээд тэд нар ирэхгүй. Энэ бол ойлгомжтой, хамгийн энгийн логик байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар бодлого хэрэгжүүлэх ёстой. Өнөөдөр ер нь нэг Монгол Улсад энэ ажиллах хүчний хомсдолд орчихсон хамгийн гол шалтгаан бид нар энэ бага төрөлтийн үе буюу 1990-ээс ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Ер нь энэ ажиллах хүчний хомсдолд орчихсон гол асуудал бол цалин багатай байгаасай гэхээсээ илүү халамжаас болоод ажилд орохгүй байгаа гэхээсээ илүү бодитой Монгол Улсад нүүрлэсэн бодитой нөхцөл байдал яг юу болж өнгөрсөн юм бэ гэхээр энийгээ л бид нар их ойлгох ёстой юм байна гэж би ойлгосон. 1990-2009 оны хоорондох бага төрөлтийн үеэс болж бид нар 250-280 мянган яг ажлын хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах ёстой энэ залуучуудын тэр алдагдсан боломж гэж хэлье дээ. Ийм боломжоос үүссэн учраас бид нар ингээд 28 он хүртэл ингээд ажиллах хүчний хомсдол үүсэх юм байна. 280 мянга. 280 мянга.

Дахиад дээрээс нь гадагшаа 208 мянга явчихсан учраас манай хөдөлмөрийн зах зээл дээр үндсэндээ 500 орчим мянган ийм бодитой ажиллах хүчний энэ хомсдол үүсчихсэн учраас өнөөдөр яг Монгол Улсад үүсээд байгаа энэ нөхцөл байдлын чинь хамгийн гол язгуур, юу нь энэ асуудал байсан юм байна аа. Энийгээ бид нар яаж нөхөх вэ гэдэг энэ бодлогыг хөдөлмөрийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Оройн мэнд ээ. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, Эдийн засгийн байнгын хорооны дүгнэлттэй холбоотой нэг асуулт байна. Мөн яг энэ асуудалтайгаа уялдаад нэг асуулт байна аа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой биш ч гэсэн энэ миний асуусан асуулттай уялдах юм гэдгийг хэлж байгаа юм.

Тэгэхээр говийн бүсийн томоохон төв Даланзадгад хотын өвөлжилт энэ өвөл хүндэрч магадгүй ээ. Даланзадгад хот хөлдөхөд ойрхон байгаа гэж орон нутгаас, тойргоос сонгогдсон гишүүдэд хэлээд байгаа. Тэгээд уг нь орон нутаг нь нөгөө

50мвт-ынхаа ДЦС-ыг эхлүүлчихье ээ гэсэн, мөнгийг нь татаад авчихсан. Бид орон нутгаас санал яриад байхаар нь хөөцөлдөөд байсан. Ирэх оны улсын төсөвт суулгана гэсэн энд суулгасан юм алга байна. Энэ Даланзадгадын 50мвт-ын дулааны цахилгааны станцыг ирэх онд эхлүүлэх юм уу. Эхлүүлэх бол ямар хэлбэрээр эхлүүлэх юм бэ.

Дээрээс нь орон нутаг нь болохгүй бол хамаг мөнгө татчихлаа бонд гаргачихъя гэсэн. Сая орон нутгийн сонгуулийн үеэр улс төржөөд, дээрээс нь энэ улс төрөө даасан буюу орон нутгийнхаа одоо орон нутгийн сонгууль өнгөрлөө. Үүний ар дээр бонд гаргах зөвшөөрлийг нь олгох юм уу. Энэ Даланзадгадын дулааны станцыг ер нь ямар хэлбэрээр явуулах юм бэ гэдэг. Дээрээс нь дулааны станцтай холбоотой өмнө нь ч од бид алдаж онож байсан юм бий. Зураг гэж нэг бөөн лобби эрх ашиг явдаг. Ер нь энэ дулааны станцын зургийг нь гүйцэтгэх тэр үйлдвэрлэгч, дээрээс нь түлхүүр барих нөхцөлтэйгөөр хийчих талын энэ талын чиглэлээр бодож байгаа юм байгаа юу? Эдийн засгийн яам, ажлын хэсгээс энэ чиглэлийн асуулт байна.

Нөгөөдөх нь үүнтэй уялдаад ер нь Чойжоо сайд сууж байна. Эрчим хүчтэй холбоотой, энэ сошиал орчинд ч тэр энэ 11 дүгээр сарын 01-нээс эрчим хүчний үнэ нэмэх асуудал, дулааны үнэ нэмэх асуудал сошиал орчинд яваад байх юм аа. Энэ чиглэлээр бэлтгэл хангаж байгаа бололтой ч юм ярьсан байх шиг байсан. Яах вэ, аливаа юм өөрийнхөө өртгөөс хямд байх бол энэ бид нарын явж байгаа, зорьж байгаа нийгэм биш ээ. Гэхдээ үнийг нэмлээ гээд тэнд алдагдал байгаа шалтгааныг бууруулахгүй бол үнэ нэмлээ гээд ялгаа байхгүй ард иргэдийн нуруун дээр дарамт очих нь ээ. Сая орон нутгийн сонгуулийн үеэр тойрогтоо ажиллаж байгаад Шивээговь суманд очиход Шивээговийн уурхай гэж нэг дампуурчихсан газар байна. 16 оныг хүртэл ашигтай ажиллаж байсан уул уурхай өнөөдөр 172 тэрбум төгрөгийн алдагдалтай, 14 тэрбум төгрөгийн татварын өртэй, 7.3 тэрбум төгрөгийн НДШ-д өртэй. Нийгмийн даатгалынхаа шимтгэлд ажилчдаасаа мөнгийг нь хураасан мөртөө худалдан авах ажиллагаа зохион байгуулчихсан.

Тэгээд иймэрхүү компани ЗГХЭГ-ын даргын ярьснаар 99, би буруу санаагүй бол 99 ийм төрийн өмчит болон ийм компаниуд байгаа гэж ойлгосон. Энэ алдагдалтай ажилладаг энэ төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулах, дээрээс нь эхлээд энэ засаглалаа сайжруулаад, хувьчлахыг нь хувьчлаад, янзалсныхаа дараа үнээ нэмэхгүй бол төрийн өмчийн эрчим хүчний салбарт монопол болсон хэдэн компаниудын үнэ нэмлээ гээд ялгаа байхгүй. Тэд нарын олох ашиг л нэмэгдэхээс биш иргэдэд очих үнэ нэмэгдлээ гээд үйлчилгээ сайжрахгүй гэж би бодож байна. Энэ тал дээр Эрчим хүчний сайдаас тодруулга авъя гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганхуяг гишүүн эхлээд хариулъя. Араас нь Чойжилсүрэн сайд.

Х.Ганхуяг: Энэ удаагийн хөгжлийн төлөвлөгөөнд хугацаа яаруу сандруу байсан уу, эсвэл хамтраад юм хумаа эмхэлж цэгцлэх гээд алдсан, оносон юм байсан уу. Ер нь үндсэндээ санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй 26 төсөл, арга хэмжээ байгаа юм. Одоо энэ хөгжлийн төлөвлөгөөнд. 1.4 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ байгаа.

Өчигдөр болон уржигдар яг энэ Даланзадгадын 50мвт-ын энэ дулааны станцын энэ зарчмын зөрөөтэй саналыг Байнгын хорооны дарга Сэддорж гаргасан. Гэхдээ ажлын хэсэг болон Байнгын хороон дээр тухайн санал нь дэмжигдээгүй ээ, тийм, хэлэлцээд дэмжигдээгүй.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Даланзадгадын ДЦС 50мвт-ын хүчин чадалтай энийг эхлүүлэе гэдэг төсөв боловсруулах үед Засгийн газар дээр Сэддорж дарга, Сангийн сайд бид 3 уул нь тохирсон юм. Гэтэл манай энэ Төсвийн тухай хууль дээр заавал зураг, төсөвтэй объектыг төсөвт суулгана гээд ийм заалт орчихсон. Гэтэл энэ зураг, төсвийг хийх гэхээр заавал аль нэг цахилгаан станц гэх мэт ийм байгууламжуудын хувьд зураг, төсвийг хийх бололцоо байхгүй. Зураг, төсөв эцэслээд хийх юм бол заавал аль нэг технологи, аль нэг үйлдвэрлэгчийг сонгож хийчих давуу байдал үүсгэх гээд байгаа ийм төвөгтэй зохицуулалт хуульд байгаа учраас энэ удаа хойшлуулаад, хойшлуулчихсан байгаа юм. 25 оны төсвөөс. Ийм зүйл болсон. Сэддорж дарга энийг сайн мэдэж байгаа гэдгийг хэлье ээ.

Одоо юу үйл ажиллагаа явуулж байгаа 5 Даланзадгадын ДЦС бол 2000-аад оны эхэнд баригдсан. Үнэхээр үр ашиг муутай, алдагдал өндөртэй ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах юм уу. Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ийм байгаа, одоо байгаа Даланзадгадын дулааны станцыг. Одоо шинээр барихаас ондоо аргагүй гэсэн үг. Энийг цааш нь төгөлдөржүүлнэ, засна, сайжруулна гэдэг нь илүү өндөр өртөгтэй, илүү үр ашиг муутай болчихоод байгаа.

Цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүчний үнэ нэмэгдүүлэх шаардлагатай байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Эрчим хүчний тухай хуулиараа Эрчим хүчний зохицуулах хороо цахилгаан эрчим хүчний үнэ, тарифыг бие дааж Засгийн газраас тусдаа, Улсын Их Хурлаас тусдаа, бие дааж өөрчлөх ийм бүрэн эрхтэй байгаа юм. Өнөөдөр 17 цагаас Эрчим хүчний үндэсний хороо хуралдаж, энэ асуудлыг ярих ёстой байсан. Чуулган сунаж байгаа учраас хуралдаж чадах нь уу, үгүй юү, мэдэхгүй байна. Ойрын хугацаанд энэ асуудлыг Эрчим хүчний үндэсний хороонд танилцуулна аа. Түүний дараа улс төрийн шийдвэрүүд гарах байх. Шаардлагатай бол УИХ дахь суудалтай намын бүлгүүдэд энийг танилцуулна. Шийдвэр гаргахаасаа өмнө.

Ер нь алдагдалтай ажиллаад байгаа нь үнэн. Ийм л байна. Жишээ болгоод хэлэхэд 1 киловатт цаг эрчим хүчийг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: 1квт цаг эрчим хүчийг үйлдвэрлээд, дамжуулах, түгээх хангалтын зардалд нь орохоор 285 төгрөгийн үнэтэй байгаа. Айл өрхүүдэд ахуйн хэрэглээнд 140 орчим төгрөгөөр борлуулж байгаа ийм л байдалтай олон жил алдагдалтай явсан учраас энэ алдагдлууд нь өр төлбөр болоод хувирчихсан нь ийм хүнд байна. Тэгэхээр ойрын хугацаанд олон нийтэд болон Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэл хүргүүлнэ ээ.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: Миний асуултын агуулга, би бол яах вэ, эрчим хүчний үнэ яагаад алдагдалтай байгаа, үнийг нь тэр юуг мэдэж байгаа. Ер нь асуултын гол агуулга маань эрчим хүчний салбарт байгаа энэ их алдагдалтай ажиллаж байгаа энэ төрийн өмчийн компаниуд, би Шивээ овоо ХК-аар жишээ авч ярилаа. Ийм алдагдалтай байхад үнэ нэмээд ялгаа байна уу. Иргэдэд очих дарамт чинь ялгаа байна уу л гэж асуугаад байгаа юм. Өөрөөр хэлбэл эд нарыгаа эхлээд энэ төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулах, хувьчлах өөр ямар арга байна. Эхлээд тэр янзлахгүй болохоор энэ чинь цоорхой сав руу яг юм хийсэнтэй адилхан болчих гээд байна л гэсэн ийм агуулгаар асууж байгаа юм.

2 дахь нь тэр бондтой холбоотой. Хэрвээ төсөв дээр нь юу яахгүй юм бол орон нутагт нь бондын эрхийг нь өгөх юм уу? Өмнөговь аймаг өөрөө бонд гаргах чадамжтай аймаг шүү дээ. Энэ 2 дээр нь ахиад тодруулга авъя.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүн ээ. Энэ бүтцийн өөрчлөлт хийх ёстой, менежментээ сайжруулах ёстой, бүтээгдэхүүний өртгийг буулгах ёстой гэдэг дээр сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбар бүх боломжтой арга хэмжээг аваад явж байгаа. Засаглалыг яаж ч өөрчлөөд, өртгийнхөө 50 хувиар борлуулж байгаа үед хэн ч байсан энэ асуудлууд шийдэгдэхгүй ээ. Эхний ээлжид энэ үнэ тарифыг өртөгт нь дөхүүлж нэмэгдүүлсний дараа, дараагийн засаглалыг сайжруулах алхмууд хийгдээд явна аа. Энэ дээр нээлттэй байгаа гэдгийг хэлье ээ.

Бондын эрхийг өгөх үү, эс өгөх үү гэдгийг Засгийн газар улсын төсвийг нэгэнт өргөн барьсан учраас Улсын Их Хурал шийдэх асуудал. Улсын Их Хурлын бүрэн эрхэд шилжсэн гэсэн үг. 2025 оны Улсын төсөв.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Их Хурлын дарга, гишүүддээ оройн мэндийг хүргэе ээ. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хамтдаа хэлэлцэж байна аа. Байнгын хороо болон яамнуудаас хэд хэдэн зүйлүүдийг тодруулах саналтай байгаа юм.

2025 оноос эхлээд эрчимтэйгээр бүсчилсэн хөгжлийн асуудал явна гэж ингэж ойлгож байгаа. Тэр утгаараа зүүн бүс нутгийн тэргүүлэх чиглэл бол түүхийн аялал жуулчлалыг гол тэргүүлэх чиглэлээ болон ажиллана гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Тэгэхээр 2025 онд энэ хүрээнд зүүн бүс нутагт томоохон яах вэ төслүүд хэрэгжинэ ээ. Үүнтэй холбогдолтойгоор эдийн засгийн үр өгөөж, бусад чиглэлүүд нь аль түвшинд байх вэ гэдэг тал дээр Байнгын хорооны даргаас энэ юу Байнгын хороон дээр ямар байдлаар ярилцсан зүйлүүд байна уу гэж.

Нарийвчлаад салбарын яамнаас чиглэлийн яам өөрчлөгдсөн. Шинээр бүтэц зохион байгуулалтад ороод ажиллаж эхэлж байна. Сүүлийн бараг 8 жил Хэнтий аймгаас эхлүүлээд энэ түүхийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр ярьж эхэлж байна. Эхний 4, 5 бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж эхэлсэн. Зам, дэд бүтцүүд тавигдаад эхэлсэн. 2025 оноос хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, оролцоог нь нэмэгдүүлэх энэ бий болгосон дэд бүтэц, бүтээн байгуулалтуудаа менежмент,

зохион байгуулалтад оруулах чиглэлээр тодорхой ямар ажлууд хийгдэх вэ? Энэ ажлууд үр дүнгээ өгч эхлэх хугацаа болсон гэдгийг сануулж хэл асуумаар байгаа юм.

2 дахь нь Энхтуяа гишүүн чухал асуудлыг сая хөндөөд, гэхдээ яг тодорхой хариултуудыг авч чадахгүй өнгөрчхөж байна аа. Монгол Улсын Засгийн газар 2025 оныг Залуучуудын хөгжлийн жил болгон зарлана гээд. Ингээд зарласан. Хөгжлийн хөтөлбөрийг ингээд харахад бол яг залуучууд руугаа чиглэсэн ер нь 5 л заалт орсон байгаа. Бусад нь нэлээн ерөнхий агуулгаар. Тэгэхээр энэ Засгийн газрын бүтэн жилийн зорилго болж, уриа болж ингэж орж ирж байгаа энэ ажил нэг зүгээр нэг уриа лоозон байдлаар өнгөрчих вий дээ. 2025 онд энэ залуучуудын гадагшаа явж байгаа энэ урсгалыг зогсоох тухай, энэ залуучууддаа хандсан орон сууцын реформыг хийх тухай энэ ажлуудыг илүү сайжруулж, дараа дараагийн хэлэлцүүлгүүдээр ярилцах, хэрвээ ярилцсан тодорхой асуудлууд байгаа бол энийг маш тодорхойгоор ярьж шийдэж авах шаардлагууд байна аа. Ингэж байж бид бүхэн ирэх жилийг залуучууддаа тодорхой үр дүн гаргасан ийм жил болгож чадна гэдгийг онцолж тодруулах шаардлагатай байгаа юм аа.

Энэ өвөл нэлээн хүндрэх магадлалууд нэлээн байна. Шинэ хоршоо хөдөлгөөн болон ХАА-н салбарт тулгамдаж байгаа энэ асуудлууд үргэлжлээд явна гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Малчдыг малжуулах хөтөлбөр болон малчдыг сургах чиглэлийн ажлуудыг 2025 онд нэлээн тусгасан байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Тэгэхээр цахимаар малчдыг сургана энэ тэр гээд мэдээллүүд Засгийн газрын хурлаар ороод ингээд явж байх шиг байсан. Энийг нэг тодруулж, тодорхой ямар түвшний ажлууд 2025 онд хийгдэх вэ гэдгийг онцолж хэлээч ээ.

Мөн Боловсролын сайдаас яг 24-28 оны хөгжлийн хөтөлбөр баталж байхад би нэг зүйлийг тодруулж байсан. Малчдын хүүхдийг бага насандаа гэр бүлтэйгээ хамт байх боломжийг олгох энэ бага сургуулийн энэ хэлбэрийг цаашдаа хэрэгжүүлнэ ээ гэж хариулт өгч байсан. Тэгээд энэ ажил 2025 онд ямар байдлаар тусаж байгаа вэ? Энэ малчдын хүүхдийг сургах, бага сургуулийг дэмжих чиглэлийн ажлууд.

Мөн дээрээс нь хүүхдийн “сүү” хөтөлбөр гээд би яриад байгаа, байнга асуугаад байгаа. Энэ хөтөлбөр 2025 онд хэрэгжих үү, хэрэгжвэл ямар байдлаар ямар цар хүрээнд хэрэгжих вэ гэдэг энэ зүйлүүдийг тодруулъя.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн дарга хариулъя.

Х.Ганхуяг: Аялал жуулчлалтай холбоотой нийт 11 төсөл, арга хэмжээ энэ хөгжлийн төлөвлөгөөнд туссан байгаа. Энд нөгөө бүсчилсэн хөгжлөөс гадна аялал жуулчлалын бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх гэх мэтчилэн олон ажлууд тусаж байгаа. Ирэх жил манайх чинь нийтдээ сая таван зуугаад мянган жуулчин авна гэж төлөвлөж байсан гэж санаж байна. Тэгээд та яг хавсралтаас нь ер нь ямар ямар арга хэмжээ авахаар байна гэдгийг нь нэг харчхаж болно. Гэхдээ бид нар 3 сая жуулчин, уучлаарай. Тэгээд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үүнтэй холбоотойгоор Аялал жуулчлалын яам дээр төсвүүд нь тавигдаад явна гэсэн үг. Тэгэхээр улирал улирлаас нь хамааруулаад эвент болон юугаар жуулчдаа татах ажиллагаанууд хийгдэнэ. Мөн иргэний агаарын тээврийн либералчлалын асуудал

үргэлжилнэ. Та хэвлэл мэдээллээс харсан байх. Ирэх жилээс Америкаас шууд нислэг Японоор дамжаад ирдэг болно. Ирэх жилийн 10 сараас Сингапур луу шууд нислэгийн юу гаргаж байгаа. Гагцхүү яг зүүн бүсэд хэчнээн жуулчин авах вэ гэдэг яг зүүн бүс нутгийн аялал жуулчны кемпүүдийн хүчин чадалтай л холбоотой байх байх. Мөн тухайн бүс нутагтаа татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх шаардлагатай. Мөн кемпүүдийн хүчин чадалтай шууд хамааралтай байх болов уу гэж бодогдож байна аа.

Саяын тэр хүүхдийн боловсрол, сүү хөтөлбөртэй холбоотой асуудлыг Боловсролын сайд нэмээд хариулчих уу.

Д.Амарбаясгалан: Болсон уу, Ганхөлөг гишүүн. Энэ ажлын хэсэг ерөнхийдөө хариулах ёстой. Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр малчдын хүүхдийг ялангуяа алслагдсан сумдын хил орчмын ийм хүүхдүүдийг сургах, тэнд нь сургуулийн үйлчилгээг ойртуулах энэ ажлыг 25 оны төсөвт, жишээлбэл бид тодорхой хэмжээнд 500 сая төгрөгийг суулгахаар ингээд саналаа өргөн барьчхаад байгаа. Тэнд их хямд төсөр аргаар, тэгээд хүүхдийн нэлээн тийм чөлөөтэй ийм суралцах ийм боломжтой аргаар сургуулиудыг байгуулж, гэрээсээ ойрхон, ямар нэгэн байдлаар гэрээсээ хол байхгүйгээр ингэж сургах ийм боломжуудыг бий болгож байгаа. Энэ ажил та бүхэн мэдэж байгаа бол Дорнод аймгийн Матад сум бол хамгийн түрүүнд хэрэгжиж эхэлсэн. Ийм байдлаар бага сургуулиуд байгуулаад явах юм.

“Сүү” хөтөлбөрийн тухайд сургуулийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Сургуулийн “үдийн хоол” хөтөлбөрт, бага сургуулийнх нь хөтөлбөрт нэмэлтээр түүхий эдийнх нь зардал нэмэгдэж орж ирж байгаа. Энэ хүрээндээ сүү уулгадаг, энэ сүүгээр хангадаг энэ тогтолцоог оруулж ирэхээр өнөөдөр яригдаад ингээд явж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Оройн мэнд. 25 оны төсөв 35 орчим их наяд төгрөг зарцуулах гээд сууж байгаа. Тэгээд ингэхдээ болохоор энэ тойргийн гишүүдийнхээ нэг жилийг ер нь хулгай хийж авч байгаад түгжрэл, утаа, туннель, гүүр, дагуул хот гэх мэт нэг 14 мега төсөл ярих гэж байгаа юм. Тэгээд энэний наана дахиад ярих асуудал байна гэж бодоод байгаа юм. Хариуцлагын асуудал үлдчихээд байна. Өмнө нь бид нар улсын төсвөөр маш олон төрлийн хөрөнгө оруулалт хийсэн, хариуцлага ярьсан хүн нэг ч алга. Одоо энд жишээлэхэд энэ өнгөрсөн сард Баянхонгор аймгийн Баянговь сумд ажиллахад 5 жилийн өмнө шинээр ашиглалтад бариад оруулчихсан цэцэрлэгийн шал 2 удаа цөмрөөд, хана нь хагараад тэнд хүүхэд цэцэрлэгт хамрагдах боломжгүй болчихсон сууж байгаа юм. Энэ дээр ерөөсөө хэн ч хариуцлага хүлээсэн юм байхгүй. Барьсан компани нь 3 жил болсон гээд яваад өгсөн. Хүүхдүүд цэцэрлэггүй, сум цэцэрлэггүй хоцорч байгаа.

Өвөрхангай аймгийн Бүрд сум адилхан, нэг соёлын төв шинээр бариад 2 жил болж байгаа. Дээрээс нь ус гоожоод, шал, хана, цонхоороо дулаан алдсаар

байгаад паар нь цаад хөлдчихөж байгаа юм. Бас хариуцлага байхгүй. Барилгын яам хариуцлага хүлээх юм уу, эсвэл захиалагч нь Сангийн яам хариуцлага хүлээх юм уу, энийг уг нь шалгана гээд манай мэргэжлийн юу билээ, хяналтын үндэсний хороо гэж ажиллаж байгаа гэсэн. Тэр хороо маань ажиллах юм уу. Энэ дээр нэг тодорхой ажлууд хийхгүй бол бид нар зүгээр мөнгө үрнэ, зарцуулна, үнэ үнэтэй үнэгүй байна гэдэг юмаа л их яриад байна л даа.

Тэгээд нэг хариуцлагын асуудал байна. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг магадлангийнхаа шалгалтад 91 хувь авсан. Магадланг нь өгөөгүй, бүр хүчингүй болгоод бүр бүх эмч нараа амрааж, нэг сар болж байгаад одоо өрийнх нь асуудал нийт 800 орчим сая төгрөгийн асуудал яригдаад сууж байгаа. Энэ дээр хэн хариуцлага хүлээх бол.

10 аймагт дулааны станц Солонгосын Экзим банкны зээлээр барьж байгаа. Жишээлэхэд Баянхонгор аймгийн 2 дугаар хэлхээний зураг байхгүй гээд 2 дугаар хэлхээний ажил 2025 онд байхгүй болчхож байгаа юм. Энэ дээр ЭХЯ хариуцлага хүлээх ёстой юм уу. Баянхонгор аймаг хариуцлага хүлээх ёстой юм уу.

Тэгээд энэ ХААЯ-ны сайд энд өөрөө гараад явчхаж. Уг нь Монгол Улс энд зарим гишүүд сая хэллээ. Аялал жуулчлал ч гэж байна. Малчдаа яриад 1 сая таван зуун мянган км квадрат газар нутаг дээрээ эзэнтэй байя гэх юм бол бид нар малчдаа чиг, малчдаа дэмжсэн бодлого гаргамаар байгаа юм. Малчдынх нь тоо буураад байна, малчин өрхийнх нь тоо буураад байна гээд. Буцаагаад бид нар зах хязгаар нутгаа гэх юм уу, өргөн уудам нутгаа эзэнтэй байлгахын тулд хэдэн их наядыг үрээд ч барахааргүй хэмжээний тийм асуудалтай тулгарах байх. Тэгээд энийг наана нь зохицуулах энэ ХААЯ-ны бодлого юу байгаа юм бэ? Вьетнам, Малайз энэ орчмын улсууд болохоор матрын арьсыг мөнгө болгож, дэлхийгээр зарж болоод байхад Монгол Улс энэ малаас гарч байгаа арьс шир, дайвар бүтээгдэхүүнээ эцсийн бүтээгдэхүүн болгоод, экспортод гаргаад, малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх бодлого байхгүй болчхоод байгаад л гайхаад, уг нь энэ ХААЯ-аас хүн байвал энэ тал дээр бодлого байвал хариулаад өгөөч гэж бодоод байгаа юм.

Сая энд бас нэг гишүүн яриад байна. Энэ сайдаа дагаад яам нь Дархан руу явчих уу гээд. Бид нар яг энэ яамыг чинь уг нь бүр малчдаа малчид руугаа мал руугаа чиглэсэн бодлого гаргаадаа л гэж явуулаад байгаа. Тэгээд энэ дээр хариуцах эзэнгүй л болчхоод байх шиг байна л даа. Тэгээд энэ саяын асуудлууд дээр ЭХЯ, ЭМЯ, шаардлагатай бол Барилгын яам, шаардлагатай ЗГХЭГ хариулт өгөөч ээ гэж.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн ахлагч Хасуурийн Ганхуяг гишүүн хариульъя.

Х.Ганхуяг: Ер нь яах вэ, жоохон хариуцлагагүй мэдэгдэлрхүү л юм хийгээд байх шиг байна л даа. Энэ улсын төсөв рүү тойргийн гишүүдийн мөнгө төсвөө хулгайлдаг гэж яг юу гэсэн үг юм. Би наадхыг чинь нэг их сайн ойлгосонгүй. Архангай ч тэр, Баянхонгор ч тэр, Өвөрхангай ч тэр улсын төсвөөс татаас авдаг 3 аймаг шүү. Улсын төсвөөс татаас авдаг 3 аймаг, тийм. Та ерөөсөө буруу ойлгож байна. Улсын төсөв заавал ч үгүй авах ёстой гэж ойлгоод байх шиг байна шүү дээ. Наад 3 аймаг өөрөө үйл ажиллагаагаа явуулаад байхад тэр татвар нь тэндээ байж л байна, төсөв нь тэндээ байж л байна. Улсын төсөв рүү татахгүй байх боломжтой. Харин ч бүр нэмж өгдөг гэсэн үг.

Улаанбаатар хотын хувьд Улаанбаатар хот дахь төсвийг нь л улсын төсөв рүү татахаа л больчихгүй байхгүй юу. Тэгээд тэр юугаараа л бүтээн байгуулалтын ажлуудаа хийнэ гэсэн үг.

Таны ярьж байгаа хариуцлагын ажил дээр яг тантай санал нийлж байна. Энэ бүх хариуцлагын ажлууд бол тэр тендертэй холбоотой ажлууд бүгдээрээ салбарын хуулиудаар хариуцлагын асуудлууд нь хариуцлага тооцохоор орсон байдаг. Тэрэнд Сангийн яамны буруу гэхээсээ илүү тухайлбал таны ярьж байгаа сургуулийн асуудлаар Боловсролын яам хариу өгөх хэрэгтэй. Мөн тэр ярьж байгаа тэр цахилгаан тэр юу билээ ДЦС-д манай ЭХЯ хариулт өгөх болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. 10 аймгийн дулааны станц төсөл маань анхнаасаа төслийн бэлтгэл ажил буруу, муу хангагдаад, Солонгосын нэг компани 3 удаа зарлахад нь орж ирээд авсан. Энэ жил ажил нь үнэхээр явахгүй байгаа 1,5-хан хувийн гүйцэтгэл гарсан. Бид нар энийг нэг талд нь гаргахаар манай Эрчим хүчний Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Магадгүй энэ гэрээг нь цуцлаад, үлдэгдэл ажлыг нь дахиж магадлаад, магадлалаар оруулаад шинэ тендер зарлахыг үгүйсгэхгүй. Ойрын хугацаанд нэг талдаа шийдвэр гаргаж зарлана.

Яг үүнтэй адилхан энэ төслийн бэлтгэл ажил дутуу хийгдсэнтэй холбоотой Баянхонгор аймаг 2 дугаар хэлхээнийхээ шугам сүлжээг 2020 онд юу боловсруулчихсан. Сангийн яамнаас төсөвт суулга гэхээр сүүлийн 2 жилийн дотор магадалсан төсвийг төсөвтэй ажлыг төсөвт суулгана гэдэг ийм шалтгаанаар 2025 оны төсвөөс хасагдсан байгаа. Төсвийн 2 дугаар хэлэлцүүлгийн өмнө энэ асуудлыг бид нар дахиж ярихаар ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: 2, 3 асуулт байна. Сайдууд байдаггүй, яах вэ, ажлын хэсгийн ахлагч хариулах байх. Ер нь ипотекийн зээлийн асуудлыг өнөөдөр мөнгөний бодлоготой холбоод ч бас олон гишүүд ярьсан. Тэгэхдээ энэ дээр яг тодорхой нэг тоог хэлэх бололцоо байна уу? Ирэх жил 560-аад тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ипотекийн зээлд олгоно. 13 мянган айл өрхийг ипотекийн зээлийн эх үүсвэртэй болгох асуудал шийдэгдэж байгаа гэж ярьж байгаа. Үүний яг хэчнээн хувийг амины орон сууц буюу пассив ногоон эрчим хүчний эх үүсвэрээр ч гэдэг юм уу, ийм ипотекийн зээлд олгох тоо, хэмжээ гарсан уу? Энийг үндсэндээ Батсуурь сайдын яаман дээр тоо хэмжээг нь зохицуулалт хийж гаргана гэж яриад байгаа. Тэгэхдээ яг ирэх жилийн бодлогын хувьд энэ ямархуу байгаа вэ гэдэг зүйл 1 дүгээрт, хариулт хэлж өгөөч ээ.

2 дугаарт, энэ ажиллах хүчний квотыг чөлөөлж, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг нэг дорвитой яримаар байна. Яг энэ дээр нэг тодорхой салбарын хариултууд орж ирэхгүй юм. Эртээд би бас нэг хурал дээр асууж байхад ерөөсөө манайх стратегийн ач холбогдол бүхий салбаруудад чөлөөлдөг гээд төрийн нарийн нь ингээд хариулаад сууж байгаа байхгүй юу. Гэтэл жирийн нэг залуу энэ цехийн нэг хэдэн тоног төхөөрөмж оруулж ирээд, тэр цехийг жигдрүүлэх хүртэл нэг ганц инженер оруулж ирж чадахгүй байгаа шүү дээ. Квот нь ч тэр, дээрээс нь ажлын байрны төлбөрт 16 сая төгрөгийг жилд төлж байгаа, цалингаас гадна. Яаж

ийм том ААН байгууллагуудтай энэ жижиг, дунд үйлдвэрлэл чинь өрсөлдөх юм бэ. Тэгээд энэ шинээр тоног төхөөрөмж улирлын чанартай зарим юмнууд дээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нар гаднын нэг нарийн ур чадвартай ажилтан эсвэл инженерүүд оруулж ирж чаддаггүй. Тэд нар чинь бөөн бөөнөөрөө оруулж ирдэггүй. Ганц юм уу 2 хүн оруулж ирээд үйлдвэрлэлийн технологи, горимыг жигдэртэл ажиллуулж байгаад гаргадаг. Гэтэл энэ зүйлүүд нь олддоггүй. Энэ том хэмжээний компаниудад л олддог. Энэ байдлыг хэдүүлээ өөрчилмөөр байгаа юм. Энэ дээр ямар бодлого байгаа юм бэ гэдэг зүйлийг хэлж өгөөч ээ гэж бодож байна.

2 дугаарт, энэ газрын харилцааны асуудал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр томоохон суурь орж ирсэн. Энэ тусгай хамгаалалттай газар нутаг болон газрын менежмент дээр ямар өөрчлөлтүүд ирэх жил хийх гэж байгаа юм бэ? Хууль, эрх зүйн талаасаа ч тэр, ер бүртгэлжүүлэх талаасаа ч тэр. Ер нь Богд уул чинь үндсэндээ мөнгө угаах хэрэгсэл болоод дууслаа шүү дээ. Битүү хаус хороолол. Энэ эздүүдийг нь зарлах ёстой байхгүй юу. Ямар хүмүүс энэ хаус бариад тусгай хамгаалалттай газар нутаг буюу аялал жуулчлалын бүс дээр улаан цагаан зар тавиад байдаг юм бэ? Өндөр орон сууцуудыг зарна гээд. Энэ чиглэлийн реформ ирэх жил хийгдэх юм уу, хийгдэхгүй юм уу? Яриад л байдаг, яриад л байдаг, хамтраад энийг хийнэ ээ гэсэн. Ерөөсөө энэ төлөвлөгөө дээрээс ерөөсөө харагдахгүй юм.

2 дугаарт, энэ Алтангэрэл сайд байж баймаар байх юм, уг нь. Юу вэ гэхээр Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох, 28 он хүртэл боловсронгуй болох үндсэн чиглэлийг Засгийн газар өөрөө баталж байгаа. Энийгээ Улсын Их Хуралд танилцуулах ёстой. Ядаж энэ намартаа болон дараа хавар орж ирэх хуулиуд нь ийм байгаа юм гээд бид нарт мэдээллээ өгчихвөл төрийн албан хаагчдыг Улсын Их Хурлын гишүүд нь нэг байгуулсан ажлын хэсэг дээрээ дууддаг. Яамнууд нь дэргэдээ дахиад яг тэр ажлаар хуулийн төсөл боловсруулж, ингээд давхцаад боловсруулах хүмүүс маань нэг байхгүй юу. Нөгөө цөөн төрийн албан хаагчид. Энэ албан хаагч чинь бүүр стрессдээд туйлж байна.

Тэгэхээр бид нар энэ Засгийн газар Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг уялдуулах үүднээс яг энэ хууль тогтоомжийг боловсронгуй болгох 28 оны үндсэн чиглэлээ ойрын хугацаанд энэ Алтангэрэл сайд танилцуулаач ээ. Ингэчихвэл бид нар давхцалыг арилгамаар байгаа байхгүй юу. Энэ мэдээлэлгүйгээс чинь болоод алийг нь бид хийж байх юм, хийхгүй юм гээд энэ зүйлүүд ингээд байгаад байх юм аа. Энэ ажлууд ерөөсөө явахгүй байна. Энэ намрын чуулганд хамгийн түрүүнд танилцуулагдах ёстой. Энэ мөнгөний бодлого болон энэ ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж танилцуулагдах ёстой. Засгийн газрын үйл ажиллагаатай уялдуулж танилцуулах ёстой. Энэ ажлаа хийж байна уу, хийхгүй байна уу? Ядаж энэ 3 асуултад би хариултаа авч ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Ипотекийн зээлийн эх үүсвэр бол нөгөө хуримтлалын сан болон бусад эх үүсвэрээс бүрдүүлсээр байна. Ирэх жил 1.3 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эх үүсвэр байгаа гэж үзэж байгаа. Энэнээс 44 хувь нь орон нутагт хуваарилагдахаар байгаа. 56 хувь нь хотод олгогдохоор байгаа.

Энэ жил яг тэр эрчим хүчний хэмнэлттэй амины сууцын зорилгоор нэг 4-5 хувь нь олгочихсон гэж мэдээлэл ирсэн байгаа. Яагаад энийг ингээд их хэмжээгээр

олгож чадахгүй байсан бэ гэхээр энэ дээр нөгөө шаардлагатай стандарт нь гараагүй байсан гэж тайлбар байсныг одоо ингээд Барилга, хот байгуулалтын яам дээр стандартыг нь гаргаад, гэрчилгээжүүлэх ажил эхлэх юм байна лээ. Гэрчилгээ байхгүй болохоор нөгөө байрыг нь барьцаанд авах, хүлээж авах гээд ийм олон асуудлууд нь хаягдчихаад байсан болохоор нөгөө санхүүжилт нь олгох боломжгүй байгаад байсан юм байна лээ.

Мөн хөгжлийн төлөвлөгөөнд миний анхны байр ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажилд орсон байгаа. Тэр нь 8889 байсныг 9000 болгоно гэж туссан байгаа. Мөн миний сонголт орон нутаг гээд нэг орон нутаг руу шилжиж ажиллавал 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгоно гээд энийг ирэх жил 4762 иргэнд олгохоор туссан байгаа. Нийтдээ нэг хөгжлийн төлөвлөгөөнд 2 ийм арга хэмжээ туссан байгаа.

Богд уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хувьд тусгай хамгаалалтын хууль, нийслэлийн холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг нь хоорондоо нөгөө уялдаагүйгээс болоод асуудал үүсдэг. Тэгээд энэ дээр яг яалт ч үгүй хотоос болон Хууль зүйн яамнаас хариу өгмөөр байна.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Зарим асуултуудад ингээд хариулт авч чадсангүй ээ. Ажиллах хүчний асуудал. Энэ их бүтээн байгуулалтын явцад бид хийж чадах юм уу, үгүй юу гэдэг зүйл ингээд байгаа. Би нэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Ипотекийн зээл дээр маш олон гишүүд байр саналуудаа хэлж байгаа. Олон хувилбарууд хэлж байна. Тэгэхдээ Улаанбаатар хотын хувьд жишээ нь Улаанбаатар хотын бүсчлэлтэй уялдуулаад, ипотекийн зээлийн хүү болоод олгох эсэх шалгуурыг уялдуулмаар байна аа. Түрүүн гишүүд хэлээд байна шүү дээ. Нягтаршил ихтэй Хан-Уул дүүрэг дээр ипотекийн зээл чинь тэр чигтээ явчхаад байна. Энэ хэсгээ жишээ нь ипотекийн зээлийн бодлого дээр уялдуулж болох байхгүй юу. Хотын бүсчлэлтэй уялдуулаад. Энэ бодлогыг Барилга, хот байгуулалтын яам, нийслэлтэй хамтраад хийгээч ээ гэдэг нэг зүйл хэлмээр байна.

2 дугаарт, эцэст нь нэг зүйл байна аа. Бид ерөөсөө хувийн хэвшлийг дэмжинэ, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцохгүй гэсэн мөртөө өнөөдөр хамгийн чухал эдийн засгийн ирэх жилийн төлөвлөгөө дээр экспортын орлого, тэр дундаа нүүрс тээврийн асуудал асуудал байгаа. Нүүрс тээвэр дээр чинь өнөөдөр энэ С зөвшөөрлүүдийг компаниудад нь өгчихсөн байсныг буцаагаад авчихжээ. Ямар эргэж буцсан, ядаргаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганхуяг гишүүн нэмж хариулъя.

Х.Ганхуяг: Эрчим хүчний хэмнэлттэй амины сууц дээр санхүүжилт хангалттай босохоор байгаа. Цаг уурын тогтвортой сан гэж хөгжлийн сан гэж байдаг. Түүгээр нийтдээ 100 сая долларын хөрөнгө оруулалтын санг Монгол Улсад байгуулах ажиллагаа, хэлэлцээр явагдаж байна. Нийслэл Улаанбаатар хотын нийслэлийн захиргаа болон тэр сан 2 хамтраад энэ ногоон зээл буюу эрчим хүчний хэмнэлттэй амины сууцын зорилгоор хөнгөлөлттэй ногоон зээлийг олгох, ипотекийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тал дээр ажил нь явж байгаа. Энэ дээр яг хэлэлцээр эцэслэн батлагдаагүй байгаад ч гэсэн тэгэхдээ хойтон хаврын тэр барилгын сезон

эхлэхээс өмнө энэ эцэслэгдчих болов уу гэж найдаж байна. Тэгэх юм бол одоо бид нарын ярьж байгаа 1.3 их наяд төгрөгийн ипотекийн эх үүсвэр дээр нэмээд 350 тэрбум төгрөгийн ийм эх үүсвэр нэмэгдэх боломжтой.

Мөн цаашдаа ч гэсэн яг ногоон зээлийг эх үүсвэр нь нэмэгдүүлээд яваад байх боломжтой байгаа.

Ажиллах хүчинтэй холбоотойгоор 2022 оноос хойш гадаад хүчний ажиллах хүчний төлбөрийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж яриулъя.

Х.Ганхуяг: 2022 оноос хойш гадаадын ажиллах хүчний тэр төлбөрийг салбар харгалзахгүйгээр 50 хувь хөнгөлдөг болсон байгаа. Бүрэн чөлөөлөх, эсэх асуудал нь тэр тухайн салбарууд нь өөрсдөө шийдэх байдлаар явагдаж байна. Энэ хөгжлийн төлөвлөгөө дээр юу гэж оруулсан байгаа вэ гэхээр Энхтүвшин гишүүний зарчмын зөрөөтэй санал дэмжигдсэнээр, ажиллах хүчний квотыг чөлөөлөх, үүнтэй холбоотой төлбөрийг чөлөөлөх гээд зарчмын зөрөөтэй санал дэмжигдээд явж байгаа.

Тэгэхээр энэ дээр Засгийн газраасаа тогтоол гаргах асуудал үүснэ ээ гэсэн үг. Тэр нь мэдээж хэрэг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай бас холбоотой байдаг. Бид нар Үндсэн хуулиараа үндэсний аюулгүй байдлын зөвлөмжөөр бид нар чинь 1 хувиас хэтрүүлэхгүйгээр нэг орны иргэн авах боломжтой байдаг. Тэгээд тэр нь тусгай хяналтын байгууллагууд болон хууль хяналтын байгууллагуудын зөвлөмжөөр тэр юу нь гарах байх аа.

Д.Амарбаясгалан: Дэгээрээ явна. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

2 Гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглахыг хүсэж байна.

Цогтбаатар гишүүний асуусан 2 асуултад Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой асуудал биш учраас сайд нар тухайлж хариулт өгөөрэй. Дараа нь.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би энэ хөгжлийн төлөвлөгөөний хүний эрхийн дээдэлсэн засаглалын бодлого гэдгээс асуух гэсэн юм аа. Энэ Хууль зүйн сайд байхгүй юм. Тэгээд ер нь ирэх жил 25 онд хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөөнд хүний эрхийг дээдэлсэн чиглэлээр ямар ахиц өөрчлөлт гарах юм бэ? МАН-ыг л болохоор хүний эрхийг дордуулдаг, хааж боодог, жагсаж цуглах, хэвлэн нийтлэх, үгээ илэрхийлэх эрхийг л хааж буудаг л гэж ингээд яриад байдаг. АН болохоор хүний эрхийг дээдэлдэг л гээд яриад байдаг. Ингээд хамтарсан Засгийн газар байгуулагдлаа. Тэр дундаа Хууль зүйн яамаа АН-д өглөө. АН-аас Хууль зүйн сайд гарч ирлээ. Ирэх жилийн төлөвлөгөө дээр хүний эрхийг дээдэлсэн, хүний эрхийн чиглэлээр ямар ахиц өөрчлөлт гарах юм бэ. Ямар хууль, эрх зүйн орчныг сайжруулах юм бэ. Одоо тэр дордуулаад байсан асуудлыг ингээд хамтарсан дээрээ засаж залруулаад явах хэрэгтэй байна шүү дээ. Хүний эрхийг зөрчдөггүй байх хэрэгтэй байна шүү дээ. Энэ дээр ямар ахиц өөрчлөлт гарах юм бэ гэж, 1-д асууя.

2-т, мөн л энэ салбар дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал энэ орон нутагт хангалтгүй байна аа. Тэр дундаа иргэний хэргийн маргааны шүүхийн

шийдвэр хорин гуравхан хувьтай. Тэгээд 78, 80 орчим хувь нь ерөөсөө хэрэгжихгүй байна. 10 хүн тутмын 8 нь асуудлаа шүүхийн шийдвэрээрээ гүйцэтгүүлж чадахгүй байна. Ингээд энэний цаана шүүхэд итгэх иргэдийн итгэл эндээс улбаатай байна аа.

Тийм учраас энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах тал дээр ямар ахиц өөрчлөлт, хууль, эрх зүйн орчныг сайжруулах юм бэ гэж.

3-т, энэ 4.5.2 дээр засаглалын бодлого дээр сурлагын өндөр амжилттай бакалаврын сургалтын төгсөгчийг төрийн албанд дадлага хийлгэх тогтолцоог сайжруулна гэж. Төрийн албаны хүний нөөцийг бэхжүүлнэ. Яг энэ энэ чигээрээ цаашдаа энэ ажлыг хийвэл сайн байна. Үнэхээр энэ хөдөө орон нутаг, сум орон нутаг, төрийн хүний нөөцийн алба үнэхээр дутагдалтай байна аа. Энэ чинь энэ Төрийн албаныгаа хуультай зөрчилдөнө. Өнөөдрийн Төрийн албаны хуулиар ийм бололцоо боломж байхгүй. Маш олон тээг, маш олон сонгон шалгаруулалт, маш олон дүрэм журмууд байгаа. Гадаа гудамд ажилгүй залуучууд байгаад байдаг. Харамсалтай нь орон нутагт нь, төр захиргаанд нь, сургууль, цэцэрлэгт нь орон тоо байгаад байдаг. Тэгээд ажилд оръё гэхээр шаардлага хангахгүй ингээд байж байдаг.

Тэгэхээр энэ Төрийн албаны хуультай яаж нийцүүлэх юм, төрийн албаны хүний нөөцийг яаж бэхжүүлэх юм. Энэ сум орон нутгийн чинь төрийн албаны орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын энэ чадавх үнэхээр суларсан байна аа. Дөнгөж саяхан орон нутгийн сонгууль явагдаж дууслаа. Гишүүд минь, та нар бас орон нутагтаа ажилласан. Энэ иргэдийн хурал, иргэдийн хурлын сонгууль гэж үнэхээр нэг эмгэнэлтэй. Ард түмнийг талцуулсан, хуваасан, ах дүү, гудамж, найз нөхөд, нутаг улсаараа хуваагдсан ийм л иргэдийн хурал цаана чинь бүрдэж байна. Энэ л Монгол Улсыг талцуулж, сулруулж байна. Эв нэгдэлгүй болгож байгаа энэ сонгууль бол энэ.

Тэгэхээр энэ засаглалын бодлого дээр цаашдаа энийг бид нар харсаар байгаад, мэдсээр байгаад ийм байлгах юм уу? Энэ тал дээр ер нь Засгийн газар, Хэрэг эрхлэх газар энэ сонгуулийг цаашдаа энэ талцдаггүй байх, хэрэлдүүлдэггүй байх энэ чиглэлийн асуудал дээр ямар бодлого барьж байгаа юм бэ? Хүний нөөцийг бүрдүүлэх тал дээр яаж орон нутагт бодлого барьж ажиллах юм бэ? Энэ хөгжлийн хөтөлбөртөө. Ийм 3 асуултад хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Үндсэн 4 чиглэлийн нэг болж, энэ удаагийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд орж байгаа. Хүний эрхтэй холбоотой асуудал. Тухайлбал тогтоолын төслийн 1 дүгээр асуулт дээр эрх зүйн орчинд хүний эрхийг батлан хамгаалдаг болох, цахим орчинд цахим орчинтой ялгаварлал, хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулах, хүний эрх, хувийн эрх зүйн шинэтгэлийн реформыг хэрэгжүүлэх, төрөөс иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжих, төрийн шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй байх гэх мэт гээд нийтдээ 28 арга хэмжээ туссан байгаа.

Мөн Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурал дээр 54 ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ дээр миний санаж байгаа 3, 4 ажлын

хэсэг нь хүний эрхтэй холбоотой ийм ажлын хэсгүүд байгаа. Бизнесийн орчинтой холбоотой нэлээн олон тооны ажлын хэсгүүд байгаа. Тэгээд тэр болгон нь өөрөө эргээгээд хүний эрхийг баталгаажуулах ийм онцлогтой юм байгаа юм.

Тэгэхээр цаашдаа Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсгүүд нь мөн Засгийн газрын тухайн яамнуудтайгаа, салбарын яамнуудтайгаа хамтраад энэ хүний эрхийг илүү баталгаажуулах, тухайн хууль, эрх зүйн орчныг сайжруулах тал дээр ажиллах нь зүйтэй болов уу гэж бодож байна аа.

Шүүхийн шийдвэр яалт ч үгүй бид нарын ерөөсөө л толгойны өвчин болсон уу гэвэл болсон. Монгол Улсаас өөр бусад бүх оронд шүүхийн шийдвэр гэдэг өөрөө хууль байдаг. Тэгээд дээр Тэмүүжин гишүүн яриад байсан, хууль тогтоомж хуулийг биелүүлэх, хуулийг сахиулахтай холбоотой бид нар хууль, эрх зүйн орчноо чангаруулах, сайжруулах зайлшгүй шаардлага үүссэн байна аа. Бид нар хууль гээд л баталдаг, тухайн салбарын яамнууд нь журам гээд дураараа хууль, эрх зүйн орчин бий болгодог. Тэгээд хуулиа барьдаггүй, журмаа бариад явчихдаг. Энэ бол өнөөдрийн бидний тулгамдаж байгаа асуудлуудын нэг мөн.

Тийм ч учраас хууль өнөөдөр яг хөрсөн дээр очоод биелэгддэггүй. Тэрнээсээ болоод өнөөдөр шүүхийн шийдвэр будилаантай гардаг. Шүүхийн шийдвэр гарахдаа ерөнхий гардаг, тэр тусмаа, ерөнхий гардаг. Тэгээд тэнд болохоор шүүхийн шийдвэр хүртэл өнөөдөр биелэгдэх боломжгүй байдлаар гараад байгаа бас бид нарын асуудал байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр Алтангэрэл сайд л нэмж хариулах нь зүйтэй болов уу гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл орон нутагт сул байна гэдэг асуултыг Сандаг-Очир гишүүн асуусан байгаа. Ер нь зүгээр Засгийн газар шүүхийн шийдвэртээ хэдэн төгрөгийн өртэй вэ гэдэг асуудлыг энд нэмээд хариулах нь зүйтэй байгаад байгаа юм. Одоо Улсын Их Хурал ч гэсэн төсөв хэлэлцэж байгаа энэ цаг үе дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг төр өөрөө манлайлж хийж байх үүрэгтэй. Тийм ээ.

Тэгэхээр жил болгон улсын төсөвт бага хэмжээний мөнгө суулгачхаад, тэгээд тэр олон шийдвэр гүйцэтгэл дундаас заримыг нь сонгож шүүхийн шийдвэр гүйцэтгэж байгаа байдал нь өөрөө шударга бус байдлыг илтгэж байгаа юм шүү дээ. Тэгэхээр ер нь зүгээр яг энэ асуудалтай холбоотойгоор төсвийн тодотгол хэлэлцэж байх үед Сангийн сайдад хэлж байсан санал. Хэрвээ шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой мөнгө суулгаж байгаа бол нийт шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр Засгийн газраас авлагатай хүмүүсийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ижил хувь хэмжээгээр тэнцүү олгодог байх тэр зарчим руу шилжихгүй бол өнгөрсөн хугацаанд 10 шүүхийн шийдвэр гүйцэтгэл байхад дундаас нь 1, 2-ыг нь сонгож шүүхийн шийдвэр гүйцэтгэдэг ийм тохиолдол нийтлэг явж ирсэн байдаг.

Тэгэхээр энийг таслан зогсооход тэр Алтангэрэл сайд ерөнхий байр сууриа илэрхийлэх нь зөв байх аа. Нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал үнэн. Нэн ялангуяа иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудал маш хүнд байна. Улсын хэмжээгээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт ердөө 20 гаруй хувьтай байгаа. Сая Амарбаясгалан даргын хэлдэг зүйл дээр бол ер нь ингээд аль нэг компаниудыг нь урдуур нь ингээд очер дайруулах замаар олгож

байсныг Энхбаяр сайд байхдаа ер нь бүгдэд нь жигдхэн хуваарилах замаар өгсөн юм байна лээ. Тэгэхдээ энэ дээр нэг зүйл нь төсвөөс тавьж байгаа мөнгө нь энэ төрийн буюу Засгийн газрын төлөх ёстой төлбөрөөс хавьгүй бага, маш бага хэмжээний мөнгө. Ингээд нийт өртэй компаниуддаа хуваарилагдахаар 2 тэрбумын авлагатай компани дээр 20 сая төгрөг хуваарилагддаг. Тэгшитгэхээр ийм байгаа юм аа.

Тэгэхээр ХЗДХЯ-аас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, төсөл дээр ажиллаж эхэлж байна. Энэ дээр одоогоор бидний барьж байгаа концепц бол нэн тэргүүнд төрийн буруутай, төрд хохирол учруулсан этгээдийг төрийн буруутай албан тушаалтнаас гаргадаг энэ механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Би нэг зүйл тодруулъя. МАН зүүн төвийн нам гэж би ойлгож байгаа. Тэгээд өнөө өглөөжингөө ярьсан. Миний ярих гэж байгаа асуулт бол 15 дугаар зүйл шүү. Энэ зарчмын зөрөөтэй саналын 15 дугаар зүйлийн 1.7.1 тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэхтэй холбогдуулж би асуух гэж байна. Өглөөжингөө бид ярьсан шүү дээ. Монгол орон сүүлийн 8 жил эрх баригчдын буянаар, мөнгө хүүлэгчдийн диваажин болж хувирсан. Тэгээд Монголбанкны талаар би Монголбанкныхантай өглөөжингөө ярилаа. Хэвээрээ, мөнгө хүүлэгч хэвээрээ л байх юм шиг байна. Одоо ард түмнийг бүр нэг сөхрүүлж унах 2 дугаар юм энд ороод ирчихсэн байна. 1.7.1 дээр эрчим хүчний өртөг шингэсэн тарифын тогтолцоог хэрэгжүүлж, санхүүгийн алдагдлыг зохистой түвшинд хүргэх ээ гээд. Тэгээд хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг нэмэгдүүлэх хувь, 64 хувь гэж байгаа шүү. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг нэмэгдүүлэх хувь 28 хувь гээд ороод ирсэн байна. Би энэ төсөв дээр тооцоог харж байхад 27.6 тэрбум төгрөгөөр дулааны зардлыг нэмсэн. 189.9 тэрбум төгрөгөөр дулааныг, цахилгааныг бол 27 тэрбумаар энэ улсын төсвийг нэмсэн байгаа шүү.

Тэгэхээр энэ бодитой болж байна л даа. Энийг яг ард иргэд дийлэх үү? Би нэмэхгүй гэж хэлээгүй шүү дээ. Та нар зөөллөх бодлого барьсан уу? Одоо энэ ингээд 12 сарын 01-ээс эхлээд, 01 сарын 01-ээс эхлээд 25 ондоо цахилгаан, дулаан 30, 50 хувиар нэмэгдэх нь байна. Энэтэй холбогдуулаад миний асуух асуулт.

Өнөөдөр өмнөх онуудын дамжуулан зээлдүүлэх өрийн үлдэгдэл нь эрчим хүчний салбарт санхүүжилтийн талаар би мэдээлэл өгье, 1.1 их наяд төгрөгийг байна. Доллороор авсан зээл шүү. Зарим зээлүүд 93 онд авсан байна лээ, доллороор авсан. Тэгээд дараа нь богино хугацаат өр 381 тэрбум төгрөг. Энэ их 1.5 орчим их наяд төгрөгийг ард түмний нуруун дээр шууд тавьж байна аа. Энэ дандаа төрийн өмчит компаниуд голдуу авсан байгаа.

Би нарийвчилж хэлье. Төрийн болон орон нутгийн өмчит ААН-д олгосон зээл 766 тэрбум төгрөг нь үлдэгдэл нь. Хугацаа хэтэрсэн зээл нь 109. 109 тэрбум. Ингээд үлдэгдэл нь 892 тэрбум төгрөг. Энэ дээр дандаа төрийн өмчит компаниудын. Араас нь энэ том том тендерүүд байна. Өнөөдөр Улсын Их Хуралд сонгуулиар хамгийн их донор санхүүжилт өгдөг компаниуд бүгдээрээ эрчим хүчний тендерүүд рүү уухайлан дайраад байдгийн учрыг одоо л ойлголоо. Энэ дээр ингээд 58 компанид энэ тендерүүдийг өгсөн байна. Энэ асуудлаа нэг тийш нь болгоод, энэ дамжуулан зээлдүүлсэн энэ асуудлыг шууд ард түмний нуруун дээр зүгээр ингээд аваачаад

хаячих биш, зөөлрүүлэх, үе шаттай байх бодлого байж болох уу? Өнөөдөр та бүхний яриад байгаа өглөөжингөө ярьсан инфляц, үнийн хөөргөдөл, төгрөгийн худалдан авах чадварт энэ дулааны үнийг 50 хувь өсгөх, энэ цахилгааны үнийг 30 хувь өсгөх гээд орж ирсэн байгаа хуудас 9 дээр байгаа шүү. Энэ юм чинь тэгээд нөлөөлөхгүй юу? Энэ ард иргэдийн амьдрал аз жаргалтай болгоно гэж бид энд бүгдээрээ орж ирж суусан шүү дээ. Хэдхэн сарын өмнө жаргаагаад өгнө өө л гэсэн. Орж ирээд л бид дуу нэгтэйгээр 50 хувиар дулаан, 30 хувиар цахилгаан нэмэхэд болж байгаа юм уу? Тэд нар маань зүгээр гэж та нарт хэлээд байгаа юм уу. Энэ талаар надад тодруулж хариулт өгөөч ээ.

Хамгийн гол миний асуулт энэ олон дамжуулах өр төлбөрүүдээ яагаад шийдэх ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн, эрчим хүчний сайд Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүн ээ, зээл тусламж аргагүйн эрхэнд л улсын төсвийн хөрөнгө оруулалтын орон зай бага байсан учраас өнгөрсөн жилүүдэд зээл, гадаадын зээлээр төслүүд хэрэгжүүлсэн.

Яг өнөөдрийн байдлаар та зөв ярьж байна. Эрчим хүчний салбарын урт хугацаатай өр төлбөр 1.8 их наяд. Сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллаж байсан учраас энэ алдагдлууд өр төлбөр, богино хугацаатай өр төлбөр болж хувираад, 23 оны жилийн эцсийн байдлаар 370 орчим тэрбум төгрөг, 24 оны алдагдлаа нэмэхээр 540 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай, богино хугацаатай, өр төлбөртэй ийм нөхцөл байдалд байгаа юм.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах зардал нийлээд 1квт цаг эрчим хүчний өртөг өнөөдрийн байдлаар 285 төгрөг үнэтэй, өртөгтэй байна. Ард иргэдэд борлуулж байгаа үнэ нь 140 төгрөг байгаа.

2 дугаарт, энэ дамжуулан зээлдүүлсэн энэ зээлийг төслүүдэд нь эргэн төлөхгүй бол ондоо тийм юу төлөх субъект байхгүй учраас бид нар юу, Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг Хятад улсын Эксим банкны зээлээр хэрэгжүүлнэ гэж ярьж байгаа. 250 орчим сая долларын зээл авна. Энэ мөн ялгаагүй Эрдэнэбүрэнгийн УЦС төрийн өмчтэй компани ирээдүйд энэ зээлийг төлөхөөс ондоо аргагүй. Авсан бол төлж таарна.

Урьдын Засгийн газрын үед, түүн дотор би ч бас орно. Яг засгийг, улс төрөө бодсоор байгаад, эрчим хүчний үнийг нэмэгдүүлж чадахгүй явсаар байгаад ийм хэмжээний хүндрэлд орсон нь үнэн байгаа юм. Тэгэхээр эрчим хүчний үнэ, тарифыг ойрын хугацаанд нэмэгдүүлэх талаар хэлэлцээр тооцооллууд явж байна. Эрчим хүчний тухай хуулиараа Эрчим хүчний зохицуулах хороо хэнээс ч хараат бусаар Улсын Их Хурлаас ч тэр, Засгийн газраас ч тэр, ЭХЯ-наас ч тэр тусдаа эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргана аа. Өнөөдөр энэ эрчим хүчний асуудлыг хариуцсан үндэсний хороон дээр 17 цагаас танилцуулах ёстой байсан. Улсын Их Хурлын чуулган сунаж хуралдаж байгаа учраас энэ хойшлох болов уу гэсэн ийм байдалтай байгаа юм.

Ойрын хугацаанд ард иргэдэд энэ талаар үнэ тарифын өөрчлөлтийн талаар Эрчим хүчний зохицуулах хороо мэдээлэл хийх байх. Бодит байдал, бидний байгаа үнэ байдал нь энэ.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Эрчим хүчийг нэмнэ гэдэг дээр бүр улайраад шийдчихсэн юм шиг байна. Дулаан, цахилгааныг нэмсэн тохиолдолд ард иргэдийн ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэл, аж үйлдвэрлэгчдийн нуруун дээр энэ асар том ачаалал болж нөгөө өглөөжингөө яриад байсан инфляц энэ болгон чинь хүндэрнэ ээ. Та бүхний яриад байгаа ханшийн алдагдлыг, 93 оноос хойш доллароор авсан зээлүүдийн ханшийн алдагдлыг ард түмний нуруун дээр л тавих гэж байна гэсэн үг. Энэ олон тендерүүдийн булхайнуудын алдагдлыг л ард түмний нуруун дээр тавих гэж байна гэсэн үг. Энэ дээр зөөллөх, үе шаттай хэрэгжүүлэх бодлогууд байгаа юу. Хамгийн гол нь технологийн шийдлүүд яагаад гаргаж ирэхгүй байгаа юм бэ? Маш олон дэлхий дээр цахилгааны, эрчим хүчний, дулааны, технологийн шийдлүүдийн гарц гаргалгаа байхгүй байж байж, энэ асуудлыг шууд ингэж ард түмний нуруун дээр тавина гэдгээр ингэж амархан шийдэж болохгүй ээ.

2 дугаарт, экспорт. Янз бүрийн бизнесийг тэлэх бодлого яагаад барихгүй байгаа юм бэ? Өглөөжингөө ярилаа шүү дээ, иргэд дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Мэдээж бид нар 285 төгрөгт ахуйн хэрэглэгчдийг шууд хүргэж чадахгүй байх. Үе шаттай явах тооцооллууд хийгдэж байгаа юм. Уул уурхайн тарифыг 16 хувьд нэмэгдүүлэх байх. 291-ийг 342 төгрөг болох болов уу гэсэн ийм урьдчилсан тооцооллууд хийж байгаа.

Эрчим хүчний асуудал хариуцсан үндэсний хороон дээр асуудлыг эцэслэн танилцуулаагүй байгаа учраас би яг энэ мөчид та бүхэнд мэдээлэл өгөхөд эрт байна. Зохицуулах хороо энд энэ талаараа мэдээлэл хийх байх. Гэхдээ та өөрөө мэдэж байгаа. Эдийн засгийн юу мэргэжилтэй хүн, та. Авсан төлөх ёстой, эргэн төлөх хариуцлага ийм чадвартай байж байж эрчим хүчний салбар бол гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татна аа. Одоо нэмэгдүүлээд нэмэгдүүлээ гэхэд олон улсад мөрдөгдөж байгаа үнүүдээс нэлээд олон хувиар доогуур үнэ тогтох байх.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

18 цаг болж байна.

Байнгын хорооноос ирсэн зарчмын зөрөөтэй 56 санал хураалт явуулахаар байгаа.

Өнөөдөртөө санал хураалтаа дуусгаад, Эдийн засгийн байнгын хороонд эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлснээр 3 дугаар хэлэлцүүлэг маргааш үдээс өмнөх чуулганаар үргэлжлэх боломж үүснэ. 3 дугаар хэлэлцүүлгээ хийсний үндсэн дээр 2025 оны төсвийг хэлэлцэх нөхцөл бүрдэх юм байгаа юм.

Тийм учраас өнөөдөр 1цаг орчмоор сунгаж хуралдаад, санал хураалтаа дуусгая гэсэн ийм саналтай байна.

Гишүүд дэмжиж байна уу? Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл цагийг сунгаж хуралдууллаа.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураалт явагдана. Нийт 56 санал байгаа.

Улсын Их Хурлын гишүүд гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. Тэгээд санал хураалтыг тус бүр санал хурааж дүнг нь танилцуулаад явахаар байгаа.

Улсын Их Хурлын гишүүд 1 зүйл дээр анхаарах ёстой. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг санал хураалт дээр өмнөх ээлжит бус чуулганы үед зарим гишүүд маань будилж байсан тийм талтай. Тэгэхээр мэргэжлийн Байнгын хорооноос орж ирсэн саналын томьёоллоор санал хураагдана гэдгийг урьдчилгаад сануулаад хэлчихье ээ.

Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулаадахъя, ирцээ бүртгээдэхье. Бүртгэлийн санал хураалт.

Ирцэд бүртгэлтэй гишүүдийн 58,3 хувь нь танхимд байгаа юм байна. Бусад гишүүдийг танхимд орж ирж, санал хураалтад оролцохыг дуудъя.

Ингээд санал хураалтаа эхлүүлье.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төс төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томьёолол.

Нэг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг. Цаашид ажлын хэсэг гэнэ.

Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах. Саналын томьёоллоор санал хураалт.

56 гишүүн дэмжиж 58.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.52 дахь заалтын “төлөвлөлтийг баталж,” гэсний дараа “идэвхтэй болон идэвх багатай улирлаар ялгаатай бодлого” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтын “бизнесийн орчин,” гэсний дараа “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.10 дахь заалт нэмэх:

“1.3.10.Бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу.

Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.16 дахь заалтын “бэрхшээлийг арилгах,” гэсний дараа “хүний нөөцийн тулгамдсан асуудлыг гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлогоор дэмжиж, шаардлагатай” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.18, 1.3.19, 1.3.20 дахь заалт нэмэх:

“1.3.18.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгааны ажлыг зохион байгуулна.

1.3.19.Бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, тухайлсан салбаруудын татварын ачааллыг бууруулах бодлогыг боловсруулж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

1.3.20.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх чиглэлд хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” Энэ санал дээр санал гаргасан гишүүн Тэмүүжин үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Энэ санал маш чухал санал. Ардчилалыг бэхжүүлэх мөнгөний хамаарлуудыг багасгах чиглэл рүү гарсан. Гэхдээ энэ тогтоолын төслийн засаглалтай хууль эрх зүйтэй холбоотой энэ хэсэг Хууль зүйн байнгын хороогоор мэргэжлийн Байнгын хороогоороо ороогүй. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд явагдаж байгаа. Одоо энэ дээр ямар асуудал хөндөгдсөн бэ гэхээр өргөн барьсан Засгийн газрын зүгээс техникийн алдаа гаргасан гэдэг тайлбар хийсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгөөгүй санал бичилт хийж байх явцдаа энэ тогтоолын төсөл өөрөө сонгуулийн өмнө хийгдэж байсан учраас тэнд байсан текстийг шууд хуулаад тавихдаа алдаа гаргасан байна. Хууль зүйн яамны өгөөгүй саналыг бичсэн байна гэдэг агуулга гарч ирсэн. Сая ээлжит бус чуулганаар бид бол 2024-өөс 2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Түүнд 4.2.1.14 дээр иргэн төвтэй иргэний эрхийг хамгаалахад чиглэгдээд эрүү шүүлт болон энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хянах хохирлыг барагдуулах чиглэлийн үр дүнтэй нэг концепц батлагдсан. Хүн төвтэй иргэн төвтэй хууль дээдлэх чиглэл рүүгээ. Гэтэл энд тогтоолын төслийн 4.3.8 дээр дарга төвтэй эрх мэдэл төвлөрүүлэх зорилготой нөгөө баталсан концепцоос эсрэг концепцын текст бичигдээд ороод ирчихсэн. Энэ ямар учиртай юм бэ гэсэн. Хууль зүйн яам манайх ийм огт санал өгөөгүй гэж хэлсэн. Эдийн засгийн хөгжлийн яам бол ямар тайлбар хийсэн гэхээр энэ техникийн алдаа байна гэж хэлсэн.

Тэгэхээр 2 тогтоол зөрчилдөх гэж байгаа 2 тогтоол концепцын хувьд эрс тэс зөрчилдөх гэж байгаа учраас энэ зөрчилдөөнийг арилгах зорилготойгоор гүйцээн боловсруулах чиглэлээр 8 дугаар саналыг санал хураалгахгүйгээр шилжүүлээд Эдийн засгийн байнгын хороон дээр яг энэ саналтай холбогдуулаад энэ хүний эрхийн чиглэлийн дэвшилтэт үзэл санааг хангуулах өмнөх Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг зөрчилдөөнгүй болгохын тулд гүйцээн боловсруулах чиглэлээр.

Д.Амарбаясгалан: 8 дахь саналыг эцсийн хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэлийг өглөө.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг соёрхон батлуулах арга хэмжээний хэрэгжилт” гэсний “Суурь түвшин”-ний “-” гэснийг “10” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2.1 дэх дэд заалтын “Гоц халдварт өвчний голомт” гэсний “Суурь түвшин”-ний “100” гэснийг “128” гэж, 1.2.3.1 дэх дэд заалтын “бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт төслийг үргэлжлүүлэх” гэснийг “дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

Чойжилсүрэн гишүүний төхөөрөмжийг үзэж өгөөрэй.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.3 дахь дэд заалтын “төслийг хэрэгжүүлэх” гэсний дараа “/Дарханы арьс ширний цогцолбор болон бусад/” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Дамдинням гишүүний санал байна.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг ашиглалтад оруулж байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх. Уг саналтай холбоотойгоор Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: энэ дээр Булган сумын Байтаг боомтыг ашиглалтад оруулж угаасаа ашиглалтад байгаа юм. Тэгэхээр миний гаргасан юугаар Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох гэж өөрчилж найруулж 1 дүгээрт уншиж өгнө үү?

Хоёрдугаарт нь үндсэн хариуц хариуцагч нь хоёулаа, ЗТЯ биш Боомтын сэргэлтийн үндэсний хороо гэж найруулгын өөрчлөлт хийж уншиж өгнө үү гэж даргаас хүсэж байна. Аль эсвэл гүйцээн боловсруулах чиглэл өгөөч дарга аа?

Л.Амарбаясгалан: Эцсийн хэлэлцүүлэгт гүйцээн боловсруулах чиглэл өгье өө.

Монгол Улсын Үндсэн чиглэлийн 8.1.2 гэж товчилж бичсэн байна.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “15” гэснийг “30” гэж, “Зорилтот түвшин”-ний “20” гэснийг “55” гэж, 1.5.2.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “60” гэж, 1.5.2.6 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “30” гэснийг “20” гэж, 1.5.2.8 дахь дэд заалтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Бусад эх үүсвэр” гэснийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, 1.5.2.12, 1.5.2.13 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “75” гэснийг “35” гэж, 1.5.2.15 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж, 1.5.2.16 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “40” гэж, 1.5.2.18 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтад холбогдох мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.4.Эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх үндсэн бичиг баримт болох нэгдсэн сүлжээний дүрэм, түүнтэй холбоотой менежментийн тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нэгдсэн сүлжээний дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Бусад эх үүсвэр” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.5.Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нам хүчдэлийн стандартыг шинэчлэн боловсруулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилт”-д “600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын

ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “99,800.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг.

Санал хураалт.

59.4 хувиар санал дэмжигдлээ.

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.1.4 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “69” гэж, 1.8.3.2 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “40” гэж, 1.8.3.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.4 хувиар санал дэмжигдлээ.

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34.927,9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.4 хувиар санал дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.12.1.1 дэх дэд заалтын “GIS,” гэснийг “газар зүйн мэдээллийн систем,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх.с Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “2.1.2.7.Хөвсгөл аймагт “Хөх баавгайн үүр” төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилт”-д “3,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.23.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.24.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалгын ажлыг оршин суугчдын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх.с Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1.8 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “720” гэснийг “240” гэж, 2.3.1.10 дахь дэд заалтын “Санхүүжилт”-ийн “200,000.0” гэснийг “165,000.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.1.1 дэх дэд заалтын “Шинээр байгуулах нийгмийн эрүүл мэндийн төв”-д харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

26.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.11 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “90” гэснийг “0” гэж, 3.1.5.1 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “≥150” гэснийг “100” гэж, 3.2.1.1 дэх дэд заалтын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн барилга шинээр барих, ашиглалтад оруулах” гэснийг “Стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулах” гэж, мөн дэд заалтын “Ашиглалтад орох цэцэрлэг”-ийн “Суурь түвшин”-ний “34” гэснийг “35” гэж, мөн дэд заалтын “Шинээр баригдах цэцэрлэг” гэснийг “Цэцэрлэгийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “27” гэснийг “28” гэж, “Санхүүжилт”-ийн “35,616.1” гэснийг “38,189.4” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.1.2.13.Улаанбаатар хотод 2 дугаар шатны эрүүл мэндийн төвийг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “13,500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

28.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.4 дэх дэд заалтын “Ашиглалтад орох сургууль”-ийн Зорилтот түвшин”-ний “25” гэснийг “26” гэж, “Шинээр барих сургууль” гэснийг “Сургуулийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “36” гэснийг “41” гэж, “Санхүүжилт”-ийн “121,152.8” гэснийг “135,005.7” гэж, мөн заалтын “Шинээр барих дотуур байр” гэснийг “Дотуур байрны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “15” гэснийг “0” гэж, “Санхүүжилт”-ийн “21,734.9” гэснийг “25,414.8” гэж, мөн заалтын “Шинээр барих спорт заал” гэснийг “Спорт заалны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “0” гэж, 3.2.1.7 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “25,000” гэснийг “30.3” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

29.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.9 дэх дэд заалтад харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

30.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.4.1.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “23.7” гэж, 3.4.2.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “14.2” гэж, 3.5.1.3 дахь дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг

“Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.09” гэж, “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.5” гэж, 3.5.1.4 дэх дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.43” гэж, Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

31.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.5.1.5.Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн дэмжих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “8,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

32.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1 дэх заалтын “Зэвсэгт хүчний” гэсний дараа “үүрэг” гэж нэмж, 4.6.1.7 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “3” “гэснийг “2” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

33.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Шууд хөрөнгө оруулалт” гэснийг “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

60.4 хувиар санал дэмжигдлээ.

34.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Тэргүүлэх чиглэлийн үр дүн”-ийн 3 дахь заалтын “Үндэсний статистикийн хороо” гэснийг “Нэгдсэн үндэсний байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.4 хувиар санал дэмжигдлээ.

35.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-гийн 1.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “2.8” гэснийг “3.5” гэж, 1.9 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.2 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “11-13” гэснийг “12” гэж тус тус өөрчилж, 1.10 дахь заалтад харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.1 хувиар санал дэмжигдлээ.

36.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.1 дэх заалтын “Зүрх судасны өвчин, хорт хавдрын өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/”-нд харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо” гэснийг “Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /30-70 нас/” гэж, “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “973.9” гэснийг “41.8” гэж, “Зорилтот түвшин” “779.1” гэснийг “41.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

37.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж /Монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/”, “Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж” гэсэн шалгуур үзүүлэлтийн “Мэдээлэл цуглуулах давтамж”-д харгалзах мөр тус бүрийн “Жилд нэг удаа” гэснийг “Гурван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.2 хувиар санал дэмжигдлээ.

38.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж”-д харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшсэн 18 настай хүн ам”-ын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “77.1” гэснийг “81” гэж, “Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “60” гэснийг “48.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “66” гэснийг “50” гэж, “Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “71” гэснийг “50.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “76” гэснийг “52” гэж, 3.3 дахь заалтын “Хүүхдийн эрхийн индекс”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 3.8 дахь заалтын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

39.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 4.2 дахь заалтын “Суурь он”-ны “2017” гэснийг “2019” гэж,

“Суурь түвшин”-ний “63.1” гэснийг “64.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

40.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.2 дахь заалтын “хөрөнгийн өгөөж /ROA/” гэсний дараа “, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж нэмж, “Зорилтот түвшин”-ний “4” гэснийг “77” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

53.1 хувиар санал дэмжигдлээ.

41.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, Суурь түвшин”-ний “2.5” гэснийг “3.5” гэж, 1.4.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “50” гэснийг “229” гэж, “Хүрэх түвшин”-ний “100” гэснийг “200” гэж, 1.7.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “20” гэснийг “40” гэж, 1.8.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “2” гэж, мөн заалтын “Мэдээллийн эх сурвалж”-ийн “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэснийг “Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж, 1.9.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “13” гэснийг “17.8” гэж, 1.10.1 дэх заалтын “Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ”-ний “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “10” гэснийг “17” гэж, “Зорилтот түвшин”-ний “15” гэснийг “19” гэж, “Дахин хог хаягдлын эзлэх хувь”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “15.7” гэснийг “21.1”, “Зорилтот түвшин”-ний “19” гэснийг “27” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

42.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 1.8 дахь хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-ийн “Хүлээн авах” гэсний дараа “Идэвхтэй улиралд хүлээн авах” гэж нэмж, мөн хэсгийн “Суурь түвшин”-ний “0.6” гэснийг “0.38” гэж, “Зорилтот түвшин”-ний “1.5” гэснийг “0.9” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-д “Идэвх сул улиралд хүлээн авах гадаад жуулчид” гэж, “Суурь түвшин”-нд “0.22” гэж, “Зорилтот түвшин”-д “0.6” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Санал хураалт.

52.1 хувиар санал дэмжигдлээ.

43.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.11.2 дахь заалтын “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” гэснийг “Ашиглалтад өртөмтгий ургамлын ашиглалтын

нөөцийг тогтоож, амьтны ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ” гэж, “Ургамлын зүйл”-ийн “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “7702” гэснийг “5” гэж, “Зорилтот түвшин”-ний “7702” гэснийг “2” гэж, мөн заалтын “Амьтны зүйл” гэснийг “Сэргээн болгон сэлгэн нутагшуулсан амьтны зүйл” гэж, “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “756” гэснийг “7”, “Зорилтот түвшин”-ний “756” гэснийг “7” гэж, 1.11.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Зорилтот түвшин”-ний “10” гэснийг “5” гэж, 1.11.4 дэх заалтын “Мэдээллийн цуглуулах давтамж”-ийн “Жилд нэг удаа” гэснийг “Таван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

44.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 4.2.1 дэх заалтын “Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “21” гэснийг “20” гэж, мөн заалтын “Давтан шинжилгээ”-ний “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “549” гэснийг “916” гэж, “Зорилтот түвшин”-ний “440” гэснийг “800” гэж, 4.3.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “76.5” гэснийг “78.4” гэж, 4.6.2 дахь заалтын “Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газар”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “12”, “Зорилтот түвшин”-ний “6” гэснийг “10” гэж, мөн заалтын “Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэг”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “5” гэснийг “6” гэж, мөн заалтын “Хөрсний чанарын стандартаас давсан бохирдолтой цэгийн тоо”-ны “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

54.2 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн бүтэц, нэр томьёо, найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-

д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Туваан.

42.1 хувиар санал дэмжигдсэнгүй. Гишүүд 1 зүйлийг анхаарахгүй бол Хөгжлийн төлөвлөгөө, 2025 оны Улсын төсөв 2 хоорнодоо нийцэх ёстой.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан хөрөнгө оруулалтын саналуудыг мэргэжлийн Байнгын хороо дэмжээгүй байна гэдэг чинь өргөн баригдсан төсөвтэй нийцэж байгаа гэж ойлгоорой. Тэгэхгүйгээр энд саналууд унавал эргээд төсөв болон хөгжлийн төлөвлөгөөнд нийцэж гарахгүй гэдэг асуудал руу шилжих эрсдэлтэй.

Жангабылын гишүүн горимын санал гаргая.

Х.Жангабыл: Төхөөрөмж ажилласангүй дахин санал хурааж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Дэгийн тухай хуулиараа ирцэд орсон гишүүд санал хураалтад оролцоно. Гишүүд танхимдаа сууж санал хураалтад оролцох үүрэгтэй. Түр болон гарч орсон гишүүд санал хураалтад эсрэгээр санал нь гардаг гэдгийг гишүүд маань ойлгож байгаа байх. Жангабыл гишүүн төхөөрөмжөө ажиллуулж чадсангүй.

Санал хураалтыг хүчингүй болгож өгөөч гэсэн горимын санал гаргалаа. Жангабыл гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал нь унаж байна. Ганхүлэг гишүүн. Яагаад зүгээр явж байсан санал хураалт гэнэт дэмжээгүй саналыг дэмжье гэсэн чинь ажиллахаа болиод эхлэв. Ганхүлэг гишүүн горимын санал гаргаж байна.

Ганхүлэг: Сүүлийн 2 санал хураалт дээр хууль дээр нь төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хурааж өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Техникийн албанаас нэг минутын хугацаа өгье. Гишүүдийн төхөөрөмж дээр гацаа үүсээд байгаа учраас техникийн албанд нэг минутын хугацаа өгье. Саяын санал хураалтыг дүн зарлаагүй юм чинь хүчингүй болгож болно. Тийм ээ. Байж байгаарай. Аан тэгвэл 2 минутын завсарлага өгье.

Санал хураалтаа үргэлжлүүлье. Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэгийн гаргасан горимын саналаар Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хурааж байсан. Эхний санал хураалт явагдсан 42.1 хувиар унасан. Тэгээд энэ саналыг хүчингүй болгож өгөөч ээ төхөөрөмж ажилласангүй гэсэн горимын санал гарсан.

Тэгэхээр Ганхүлэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Санал хураалтыг хүчингүй болгоё тэр төхөөрөмж хүртэл ажиллахгүй байна гэж байна. Техникийн ажилтан очъё.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг хаая гэж бодож байна. Яагаад гэхээр улс төрийн намын бүлгүүд Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан ажлын хэсэг хоорондоо ярилцах шаардлагатай. Тэгээд өглөө 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*